


874-392
(082)
A 13K
mon

782

1
1
1
1
1
1
1



Number 19
Bavarian

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ЯАМ
МОНГОЛЫН ЗОХИОЛЧДЫН ЭВЛЭЛ
ОЛОН УЛСЫН ТҮРЭГ СУДЛАЛЫН ТӨВ

894.342 (082)

443

K

ХУНАНБАЙН АБАЙ

(АБАЙ КУНАНБАЕВ)

ТҮҮВЭР ЗОХИОЛ

Их зохиолчийн мэндэлсний 150 жилийн ойд

Казах хэлнээс орчуулсан

Д. НЯМАА
Б. МОНГОЛХҮҮ
Х. ИСЛАМ
Х. ЖҮКЕЛ
Х. ХАНГАЙСАЙХАН

УЛААНБААТАР 1995

АЗИ ТИВИЙН АУГАА ИХ НАЙРАГЧ

Төв Азийн нүүдэлчдийн дундаас сүүлийн 800 жилийн дотор хоёр аугаа их хөвгүүн мэндэлсний түрүүчийнх нь Есүхэй баатрын хүү Тэмүжин, удаах нь Хунанбайн хүү Абай юм.

Түүх шастирт Чингис хаан хэмээн нэр алдраа дархалсан энэ хүн дерөөн дээрээ босч бөмбөрцөгийн талыг эзэмдэн дэлхийн гарамгай жанжин болохоо харуулжээ. Тэрбээр Чингис хаан Монгол нутгийн Хэнтий ханы Дэлүүн boldогт мэндэлснээс хойш даруй 650 жилийн дараа казахын өргөн уудам нутаг болох Чингис (урьдын Күндиккөш) уулын өвөрт бас нэгэн хөвгүүн мэндэлсэн нь Хунанбайн хүү Абай байв.

Их хааны нэрийг энэ хорвоод үүрд мөнхжүүлсэн Чингис уулын өвөр дэх Харуул толгодод нутагладаг Оскөмбай цэцэний хүү Хунанбайн чихнээ алтан гургалдайн дуу сонсогдсоны маргааш өдөр түүний тоонот гэрт Абай хүү мэндэлсэн нь санамсаргүй хэрэг биш боллотовтой.

Нүүдэлчин түмний аж байдал, зан заншил, төрөлх нутаг-уул ус, хээр тал, гол горхи тэр аяараа уянга дуулал байдаг учир Оскөнбай цэцэний ач Абай ая дуугүй яахин явах билээ. Түүний мэндэлснээс хойших 150 жилийн бараг 100 жилд нь Абай Казах түмний мөнх тэнгэрийн дор нэгэн гэрэлт од болон гялалзаж ирлээ. Энэ нь бас учиртай, Азийн аугаа их найрагч тэрбээр Гёте, Пушкин, Лермонтов нарыг орчуулж Ази-Европыг холбосон ард түмний хэл соёлын шинэ гүүрийг дархалсанаар тайлбарлагдана. Абайг дорно дахины аугаа их найрагчдаас ангид авч үзэх учиргүй.

Дорно дахины сэргэн мандалтын долоон гэрэлт одод—Абильхасим Фердауси, Низами Ганжеви, Хожа Хафиз, Омар Хаями, Авдraphман Жамый, Алишер Новай нарын гүн ухаан, хайр дурлалын «тэнгэрүүдийн» аугаа их сургуулиас Абайг ялгах аргагүй нь мэдээж. Дорно дахины эдгээр гэрэлт оддын нөлөөн дор шилдэг бүтээлээ туурвисан Европын уран угсийн мастерууд Шекспир, Гёте, Байрон, Монтецкий, Шиллер, Пушкин, Лермонтов нар дэлхийн утга зохиолын алтан хуудаснаа нэр нь мөнхөрсөн билээ.

Абай эдгээр сонгодгуудын тэргүүн эгнээнд явааг дэлхийн таван тивийн соёлт хүмүүс андахгүй. Тиймээс ч Хунанбайн хүү Абайн мэндэлсний 150 жилийн ойг Азиас Америк, Австралиас Европ хүртэл Дэлхийн соёл шинжлэх ухааны хамтын нийгэмлэг «ЮНЕСКО»-гийн санаачилгаар өргөн дэлгэр ёслон тэмдэглэж байна.

Түүхэн замнал, гарал уүсэл ойрхон Монгол, Казахын ард түмэн үеийн уед зэрэгцэн оршиж ирсэн мөртлөө түрэг түмний оюун ухааны охь манлай болсон 1000 жилийн түүхтэй Казахын Баласу-

ганы зохносон «Хутагт билэг», Монголын уран зохиол, соёлын нандин өв «Монголын нууц товчоог» дөнгөж саяхнаас эх хэлээрээ шимтэн ушиг болсон нь энэ зууны нэг ололт, уншигчдын аз завшаан юм. Бас нэгэн өлзий дэмбэрэлт үйлс болсон Абайн аугаа их найраг, казах түмний соёл, эрдэнийн сувдан сондорыг монгол эх хэлээрээ уяналтуулсан нь юутай баархалтай хэрэг билээ.

Монголын аугаа их хөвүүн Чингисийн тухай домог, тууль, найраглал казах түмэнд хичнээн ойр байгаатай адил Абайн уяангат найраг, домог болон дэлгэрсэн ая дуу нь монгол түмэнд аль хэдийнээс ташил билээ. Казах ард түмэн «Монголын нууц товчоо», «Алтан товч»-ийг төрөлх хэлээрээ амтархан цээжилж, Дашдоржийн Нашагдоржийн «Учиртай гурван толгой» казах үндэсний тайзан дээр уяналж, Б. Дамдинсүрэнгийн «Хэнтийн өндөр ууланд» симфони хөгжим, ардым дуу «Үлэмжийн чанар», «Цээнхэрлэн харагдах уулс» зэрэг сонгодог бүтээлүүд өөрийн үндэсний урлаг мэт зүрх сэтгэлд хоногшсан юм. Түүний нэгэн адил Абайн аугаа их бүтээлийг монголын уран угийн нэрт мастерууд, тухайлбал Бямбын Ринчен «Үүрний туяа» хэмээх түүхэн романдаа ишлэл авч гүн ухааны шүлгийг нь тавиад жилийн өмнөөс орчуулж байсан баримтыг бас дурдалтай.

Казах ард түмний соёл, шинжлэх ухааны түүхэнд Ибрай Алтан-сарини нээсэн гэгээрлийн зам, Шохан Уалиханы гүн сэтгэлгээ, Абай Хунаанбайи гал цогтой яруу цайраг, гүн ухааны эргэцүүлэл нийлж гурван том оргил болон сүндэрлэсэн билээ. Их сэтгэгч яруу найрагч, соён гэгээрүүлэгч Абай амьдарч байсан цаг үеийнхээ дуу хоолой болж үеийн уед гялалзаж байх жамтай төржээ. Тэрбээр үндэсний бодол сэтгэлгээний явцуу хүрээнээс халин гарсан сэтгэгчийн хувьд «Хүлэг морин дэлээрээ гайхуулж, хүн төрөлхтөн сэтгэлээрээ гайхуулна» гэсэн үнэнийг Абай чин зурхнийхээ дуудлага болгожээ. Аман зохиол, туульсын бүтээлээр хөглөгдөж ард түмний хэдэн мянган жилийн турш уламжлан хөгжүүлж үрсэн эх хэлийнхээ ариун өвлийт гүнзгий судалж, утга учрыг нарийн мэдэрсэн аугаа их найрагчийн дуу хоолой, дэлхийн соёлын түүхэнд Казахын ард түмнээс оруулсан томоохон хандив болсны жишээ олон.

Зөндөө олон зүйлийг оролдож байж бичлээ

Зөгнөж мөрөөдөж байсан ирээдүйнхээ төлөө ч бичлээ

Ухадитнууд нэрэлхэж ичээд байхаар нь

Ухаарч ойлгоод засрах болов уу гэж бичлээ

Гэсэн мөрүүдийг туурвисан их найрагч амьдарч байсан нийгмийнхээ дараалгуйлал, бурангуй үзлийг жигшиж, бусад ард түмний ухаант мэргэдийн явуулж ирсэн оюуны ариун тэмцлийг казахын уудам талд анх түрүүнд татаж авчирсан юм. Ард түмний оюуны мэлмий болсон найрагч, дуугүй явах эрхгүйгээ ухаарч:

Эрээгүй хашуирах нь чихэнд аялуун гэж үү!

Эрдэмгүй мансуурах нь өөрт чинь аятай гэж үү!

Дан будуулэг золигууд хичнээн хэлэвч зөв гэж үү!

Дэмий явж насыг элээх нь амьдралд чинь чимэгтэй гэж үү!

...Үнэн ухамсар гэж манайд байх биш дээ!

Үерхэл жаахан холдвол, гутгэлэг нь бэлэн байдаг

Авах авлагага, өгөх өргүй ч гэсэн

Аль нэг хүн чадлаа гайхуулж өргөдөл шиддэг

хэмээн тухайн цаг үеийнхээ байдлыг нээн шүүмжилж, нигүүлсэх сэтгэлгүй болсон баячууд, дарангуйлагчдын багийг хуулж байсан нь казах түмний зан чанарыг ариусгасны жишээ гэж хэлэлтэй.

Их найрагч уянгын төгс зураглалаар амьдарч байсан цаг үеэ дүрслээд зогсохгүй, уншигч таныг өнгөрсөн зуун руу хөтлөн аваачиж, тэр үеийн амьдрал, уй ашууг оюун ухаанд чинь хоногштол үнэн мөнөөр нь ойлгуулж өгнө. Хүнийг хайрлан хүндэтгэх, ирээдүйн сайн сайхны төлөө авьяас чадлаа бүрэн зориулах нь Абайн хүний мөс нандин чанар байсан юм.

Аугаа их найрагчийн шад, бодол, мөр, үг бүхэн жирийн байгаагүй. Ард түмэндээ амьдралын гоо сайхан, амьдрахуйн утга учрыг гүзгийг ойлгуулж, хүн төрөлхтний оюуны соёлтой танилцуулахыг тэрбээр эрхэм зорилгоо болгосон юм. Энэ нь түүний бичсэн гүн ухааны сургаалиудаас тод харагддаг. Абай дорно дахины одод болон дэлхийн гэрэлт өртөнцийг Пушкин, Гёте нарын хэмжээнд харж мэдэрч байсан нь гайхалтай билээ. Абай тэдний бүтээлийг нарийн төгс ойлгож мэдэрч, шүлгүүдийг нь өөрийн уран уянгаар х хэлээрээ чадамгай орчуулж, өرنэ дорнын сонгодог яруу найргийг ард түмэндээ хүргэж өгсөн иэгэн. Их зохиолч Мухтар Ауэзов «Абайн зам» хэмээн туульсын гурамсан зохиол бичиж дэлхийн 30 орчим хэлээнд орчуулагдсаны иэг нь Францын алдарт зохиолч Луй Арагоных байдал. Тэрбээр орчуулгынхаа оршилд: «Би уг зохиолыг орчуулж дуусаад ширээнээс босохдоо өөрийнхөө арт түмнийг казахын арл түмэн шиг тэнгэрлэг цог хийморьтой, уянгалаг найрагч-ард түмэн байгаагүйд харамсаж байна» гэсэн бол мөнөөх туульсыг бутээсэн их зохиолч Мухтар Ауэзов «Абай өөрийн үснийг хүртэлх нэрд гарсан дэлхийн сонгодогуутыг бүрэн судалж мэлэж байсан төлийгүй түүгээрээ арл түмэндээ оюун ухааны түүхэн замыг нээж өгсөн гарамгай хүн гэж тэмцэглэсэн байна.

Их найрагч, үр хойчлоо дутуу дулимаг юм үлдээсэнгүй Эдүгээ дэлхийн олон арван хэл дээр хэвлэгдсэн түүний хоёр бөгүй номноос хүний гэгээн сэтгэл, оюуны гал дөл, яруу төгс уянга тодын тол дуурстаг.

Абайн яруу найргийг «Оюун ухаан, гоо сайхны мэдрэмж, хүнийг хайрлах сэтгэлийн тэнгэрлэг хүчний нэгтгэсэн амьдрахуйн их толь» хэмээн тодорхойлж болно. Азийн аугаа их энэ шулэгч яруу найрагийт бус, харин яруу найраг нь өөрөө Абайг сонгосон мэт санагддаг.

Энэ нь:

Салхигүй шөнө сав саруулхан
Сарны тuya уснаа явгална
Үднийн шөнө айлын хаягаар
Үерлэсэн гол шуугин урсана
Шигүү ургасан мөддүн навчис
Шивэр авир үг хэлэлцэнэ.
Нойтон газрын хөрс сэргэж
Ногоон өнгөөр дэлхий баясна...

гэхчилэн түүний шулэглэснээс бэлээхэн харагдатаа.

Абай цогтой яруу найрагч төдийгүй гүн ухаан, оюуны охь манлай болсон казах түмний түүх шастир, зан үйлсийн товчоон буюу «дочин таван эргэцүүлэл»-ийг хүүрнэл зохиолын хэлбэрээр туурвин

бичжээ. Қазахын ард түмний зан чанарын хоцрогдол доголдлыг билгийн нүдэр шүүн тунгааж түүнээс ангижрах арга замыг сувэгчилсэн нь бас нэгэн гайхамшиг гэж хэлэлтэй.

Алтай хэлний гэр булд багтдаг турэн түмний түүх шастирын тоймыг гаргасан эдгээр сургаал буюу эргэцууллийг гүн ухаан, мэргэдийн бодол санааны цоморлиг гэж ойлгож болно. Ерөөсөө казах түмний оюуны чадавхийн багтаамжийг агуулсан эдгээр эргэцуулэл нь хүннүгээс гаралтай «модон ханатай эсгий туургатай» Төв азийн нүүдэлчийн түүх шастирыг бузгай сайн судалсны илэрхийлэл гэж үзэлтэй. Энэ нь түүхэн замнал ойрхон, зан заншил нь адил төстэй казах, монгол, киргиз түмний түүх судлаачдад чухал сурвалж болж байгаа бөгөөд цаашид ч болсоор байх болно.

Казах түмний уран угийн гэрэлт од уран зохиолын үүрд мөнхерсэн сонгодог зохиолын тулгын чулууг тавиж Абайн бүтээл эцэж цуашгүй хүлэг, элэгдэж хуучрагүй хөшөө адил хүн ардын хэрэгцээ болон өдөр тутам ашиглагдаар ирсэн юм. Тиймээс ч цаг хугацаа улирах тусам тэр улам тод гялалzan гэрэлтэж байна. Қазах түмэн байгаа цагт Абайн sod бүтээл аллах тэнгэрээс заясан гэгддэг Куран судраас ч илүү ихээр олон онгод хайрлах авьяастанд угийн хүч, найргийн илч цог болж үүрд мөнх орших жамттай.

Азийн аугаа их энэ найрагчийн лугших судас, цохилох зүрх нь эрин зууны үеийнх мэт цохимой. Эрин цаг аугаа их гайхамшигт хүнийг өөрөө төрүүлдэг жамтай. Мянга, мянган жил улирсан ч эрин цагтай хөл нийлүүлж дэлхийн гайхамшигийн гайхамшигт зүй ёсоор тооцогддог Абайн уг, Абайн яруу найраг, Абайн сургаал казах түмэнтэй хамт үеийн уед гялалзах нь эргэлзээгүй. Энэ аугаа их үйлээд Монгол улсын соёлын яамны соёл урлагийг хөгжүүлэх сан хандиваа оруулж түүний яруу найргийг монгол хэлээр орчуулахад зүтгэл санаачилга гаргасан Монгол улсын төрийн соёрхолт яруу найрагч Долгорын Нямаа, яруу найрагч Б. Монголхүү, Х. Жүкел, Х. Хнгайсайхан нар болон хэвлэн нийтлэхэд онцгой идэвх зүтгэлтэй оролцсон Соёлын яамны хэвлэлийн хэлтсийн дарга Т. Етекбай, зураач Ц. Байды, хэвлэлийн «Шувуун хаарал» компанийн инженер Ж. Оюунхүү нарт уншигчдын зүгээс талархалаа илэрхийлэх нь зүйтэй. Абай шиг sod дэлхийд ганцхан удаа мэндэлдэг. Тэгвэл түүний анхны болон сүүлчийн бүтээлийг яруу сайхан монгол хэлээр уянгалуулахад хувь нэмэрээ оруулсан энэ хүмүүсийн нэр алдар мөнхөд орших учиртай.

Их найрагчийн яруу найргийн өвөөс болон дөчин таван уянгын эргэцуулэл буюу сургаал угийн товчооныг дээр нэр дурлсан билдний хэдэн хүн чадан ядан монголчилсон нь ховор тохиох az завшаан хэмээн үзэж байна.

Хөх тэнгэрийн орон монгол казахын ард түмэн ихрийн адил үүрд оршиж цэцэглэн мандаж, Абайг дурсан санаж явбал билдний урьдаа тавьсан зорилго хүсэл мөрөөдөл маань ч биелэгдсэнд тооцохос өөр зорилгогүй.

Абайн уг, их найрагчийн алдар буурал түүхт монгол түмний дунд үүрд дурсагдахын өлзийтэй сайхан ерөөлийт лэвшүүлж одоо уншигч авгай нар түүний бүтээл туурвилийн сангаас орчуулсаныг шүүн тунгааж, болгоон соёрхохыг хичээнгүйлэн хүсье.

Түүхийн ухааны доктор Х. ИСЛАМ

НЭГ. ЯРУУ НАЙРГИЙН АЙМАГ

1855~1885

* * *

Идэр насандаа Эрдэмд эс анхаарчээ.
Ид шидийг нь мэдсээр байгаад үл анзаарчээ,
Эрийн цээнд хүрсэн хойно гар сунгаад ч,
Эрдэм сурх цаг хэдний өнгөрсөн байжээ.
Гар хоосон үлдсэнд минь хэн буруутай вэ?
Гайгүй эрт хичээсэн бол ингэх гэж үү?
Хүний баяр баяслын нэг нь хүүхэд гэдэг
Хүүхдийг номд сургахыг буруугүй гэдэг
Хүүгээ «эрдэм сур» гэж сургуульд өгсөн,
Хэргэм зэрэг олог гэж бодоогүй, би.
Өөрөө ч оргил өөдөө өгсөж мацав
Үг хэлээр хэнд ч дийлдэхгүй явлаа, би
Тэглээ гээд намайг ойлгосон хүмүүс үгүй
Тэгэхлээр нь би мөрөөрөө явахыг бурууд үзсэнгүй

* * *

Иузи-сарнай, нүд нь хархан
Ягаахан хацар нилдээ «ахмар»
Хоолой нь цаснаас «ам бихтар»
Хөмсөг нь бурханлиг, гар нь «шига»
Үзэсгэлэн төгөлдөр «Рахбар»
Үзсэн бүхэн чамд дурланам за.
Сулейман, Ямшил, Искандар
Цуглуулсан хөрөнгөө өглөө ч багадах,
Сарнайд сарнай л зохирном за,
Санасан бүхэн биеллээ ч гэсэн
Царайг нь харахаас хэтрэхгүй,
Санаж мөрөөдсөөр өтөлнөм за.

* * *

Тунликбайн авгайн нэр Шарип,
Тогтох амьдрах нөхөргүй нэгэн карип,
Дэргэдүүр өнгөрөх нохой болгон сарьдаг,
Дэрс бутнаас ялгаа тэр юун!

* * *

Бурхан тэнгэрт залбирагчдыг
Бишгүйдээ л би нэг үзсэн.
Уишлага тарни мэдэхгүй хүн
Угтаа Абраалаас өөр алгаа
Куран судар уншуултал
Үсэглэж ядан түгдрэв.
Үнэндээ ухах тархигүй хүн
Үйлээ үзэж юугаа хийнэ.
Газраар домнох шиг
Лай хураан тонголзож
Үдшийн уншлагын дараа
Үе үехэн бөхөлзөнө.
Хэтийн ариуслыг ухаарайхгүй
Хэлсэн тарни нь салхинд замхарна.
«Еннатайна калкоусар»
Эгшиглэж хэлээд ч зөвдөхгүй
Хожмыг бодож хэлсэн нь
Хошиг дуунаас хэтрэхгүй
Ингэж уншсан тарнийн ном
Яахин буян болох билээ?
Ургуулан бодож үзэхүй
Үураг тархигүй хоссон чих ээ!

* * *

Мэдээтэй яваарай Жахсlyк минь,
Мэргэн бөөгийн дайтай юм чамд бий шүү!
Өргэй хүн өөдлөх гэж байхгүй,
Өргөн дэлхийг хэсээд ч буян хурахгүй!

Аяа, сэтгэл минь юунд тэгтэл догдолно вэ,
 Амарлингүй байваас хорвоо хоосрох гэж үү дээ!
 Хол ойрыг бодоод дандаа догдоод байх чинь,
 Хонгор зүрхийг булаглуулам ямар учир тохиов доо
 Хүлцээд зүгээр байваас хорвоо дэлхий хоосорч,
 Хүний үр ханна олохгүй наасаа элээх гэж үү?!
 Тогтох ядан харцаа энд тэнд чулуудаад.
 Түнэр харанхуйг юунд чи хэснэ вэ?
 Үнэи мөнөөрөө бусдад халгүй явбаас
 Үхэл ирж чамайг зайлцуулах гэж үү?
 Аяа, сэтгэл минь тогт, тогт,
 Адгаж аюул ирдгийг сана!
 Хэтийг бодож, алсыг ухаарвал,
 Хүмүүнд нүгэл болно гэж үү?
 Өөрийгөө саатуулагч сэтгэлийн түшиг,
 Өр зүрхийг баясаагч амин холбоо;
 Алсын мөрөн шиг түргэн урсгалт
 Амин насны алтан заяа,
 Эрүүл, өвчтэй олныг ч ялгахгүй,
 Энэхэн бие минь дуусах уу.
 Аяа, сэтгэл минь аяд, аяд,
 Алив бүхэнд шаналж битгий зов oo!
 Орчлон хорвоог туулахад амаргүй,
 Онилж буй үхэл ч холгүй.
 Бүсгүйн халуун хөнжил олдлоо ч
 Буян болох нь бас үгүй.
 Үчраад салахын төдийд
 Ухаанд үлдэх нь бас үгүй.
 Хүүхнүүд намайг таална гэж
 Хамраа сөхөх хэрэггүй.
 Буян нүгэл хутгахыг
 Бурхан зөвтгөх гэж үү!
 Аяа зүрх минь тайвшир, тайвшир.
 Адгаж өөрийгөө бүү хоосло!
 Бүхнийг чи мэддэг хирнээ
 Буруулж одоохон үйлана даа.
 Асаж, дүрэлзэж, шатаж.
 Аяа, өөрийгөө бүү зовоо!
 Баавгайн мөрт ахыгаа,
 Бас авгай хүүхнүүдийг

Хэдийдээ чи цатгав даа?
Үнэг шогшимгүй их атирааг
Үзтэл харалгүй юунд давхинам.
Хэн нэгэн чамайг
Бахаа ханатал зодвол
Хүсэл сэтгэлд чинь нийцэх үү?
Өмссөн хувцасы чинь тонож
Олны өмнө нүүргэлбэл
Хүлцэнгүй байж чадах уу?
Аяа, зүрх минь амар, амар,
Санааширч битгий шанал!
Хүүхнээс холуур явбал
Хэн чамайг хараах вэ?

Аххны цасаар бүргэдчин анд мордоно,
 Асгат хадаар явбал үнэг олдоно.
 Хүлэг морь-ул хуурах үнэнч нөхөр,
 Хөнгөн хувцас анчин эрийн чимэг.
 Сондуул бутаар явж гярхай ажиглавал
 Саяхан гүйсэн үнэгний мөр таарна.
 Уулын энгэрт бүргэдчин, бэлд нь үргээгч
 Урам бадарч шинэхэн мөр хөөнө.
 Бөхөлж өмсгөсөн томгы нь авахад
 Бүргэд өндөрт хөөрч ав эрнэ.
 Доогуур нисвэл үнэг газар өөд бултах тул
 Догшин кыран өндрөөс түүнийг ажина.

 Зугатааж амь гарахгүйг мэдэх тул
 Залт үнэг сүүлээрээ шарвахыг болно.
 Амаа ангайн архирч, шүдээ сүртэй хавирч
 Амиа өгөхгүйн тулд хирэндээ бас тэмцэнэ.
 Зуурдын зугаа тайлан, сэтгэлийн бах хангаж
 Замын бартааг ажихгүй анчид давхина.
 Уур уцаар болон аргаа барсан үнэг
 Унаад өгөх дайсан биш, хээнцэр кыранд.
 Нэгэнт шийдсэн баатар маргаашийг хүлээхгүй,
 Найман савар-сэлмээ зэрэг хурцална.
 Даль өд нь сугран, салхи татуулан шуугиж

 Тэнгэрээс кыран үнэгэн дээр асгараход
 Гарамгай баатрууд барилцан хүч үзэхийн адил
 Гал бутруулан цавчилцан хоёулаа үзэлцэнэ.
 Хөх тэнгэр, эх газрын зэрлэг амьтас
 Хүний төлөө улаан цусанд будагдана.
 Цас-цагаан, бүргэд хар, үнэг-улаан,
 Царайлаг бүсгүй нүцгэн усанд орохын адил.
 Хархан үс, улаахан царайг нуун далдалж,
 Хааяа бас үсээ самнаж суухын адил,
 Зоригт эр, үзэсгэлэнт хүүхэн биесээ таалан,
 Золоор нарийн хөнжилд учирсан мэт,

 Цагаахан бие, улаахан хацар, чармай нүцгэн
 Цасан дээр нуруу бэлхүүс нь аяар хөдөлнө.
 Жаран хоёр аргатай үнэг барьсандaa
 Жавхаа нэмсэн анчин шувуутайгаа аминчирхана
 «Азаргаараа гурван ес» гэж инээмсэглэн,

Ахмад настны ганзганд анхны олзоо уяна.
Сэргсэр малгайгаа сажиж өмсөөд
Сэтгэл ханамжтай тамхиа нэг үнэрлэнэ.
Уулнаас гүзээлзгэнэ түүх адил олдвол
Улаан үнэгний ав сэтгэл хангах нь тэр,
Алив мую санаагаа таягдан хаяж,
Ангийн тухай л ярилцан явахад
Хэний ч нөлөөгүй өөрийн бисэр анх харсан
Сэтгэлийн гэрэлтэй, ухаан төгс нэгэнд
Хуурамч зүйл орчлонд энэ л аж.
Сэргж мэдрэхэд энэ шүлэг тодорхой бус уу?
Шулуухан уншаад зураглалыг үл ухвал
Шүлгийн утгыг хараахан үл тайлна.
Үг болгоныг тунгааж чадаж гэмээн
Ухаанд чинь аяндаа сүүдэр арилж, гэрэл гийнэ.
Үүнийг сонирхвол анчин залуус унштугай,
Үнэг авлахыг үзээгүй бусад хүн ойлгохгүй!

Ямархан охинд хүн татах увидас байна вэ?
 Ялдамууд нь тийм үедээ зүгээр явдаггүй ээ,
 Арван найм, арван ес хүрэнгүүтээ л,
 Алим нь уушиг болон агшнаа суларна.
 Зарим нь зан үйлээ нуун далдалж,
 Үг сольж үзээгүй мэт хоосон маяглана.
 Зарим нь цайлган сэтгэлтэн болох гэж
 Уулзсан хүн болгонд инээд цацна.
 гаасаа хүүхний явдал бидэнд тодорхой,
 Олны магтсан хархүүд охид талтай,
 Зарим залуус гавихаар үйл бүтээхгүй
 Хүлцэнгүй, биеийн амрыг бодно.
 Зарим нь ичих нүүрэндээ илэг нааж
 Хүршгүй их үйлст хоосон тэмүүлнэ.
 Зөв үйлийг хөөж, тус буяныг бодлоггүй
 Тийм залуус хөөрхий болоод хайран,
 Хэрэггүй зүйлд сэтгэл алдан явсаар
 Хэтдээ тэд хоосон хоцорч хий шанална.

Цалин цагаан мөнгө лүгээ өргөн магнайтай
 Царайд нь зохирсон алаг нүд нь гэгээ татна.
 Чимэгт хар хөмсөг нь зурсан юм шиг
 Шинийн нэгний хавирган сарыг санагдуулна.
 Магнайнаас нь эгц буусан хянгандуу хамар
 Машид гэрэлт царай, улаахан хацар хэл сорно.
 Уруул нээхүйд лавай шүд нь туяарч
 Уран гарын шигтгээ мэт сэтгэлд зохирно.
 Үг яриа нь лусын дагиных шиг уянгалаг,
 Үе үе эрхлэх дуу нь алтан гургалдайн адил,
 Цагаахан торго лугаа булбарай хүзүү нь
 Цагийг элээсэн нарны илчинд үл гундана.
 Тэгшхэн Мөр, чилгэр нуруу нь галбир нээж
 Тэнцүүхэн хоёр алим цээжинд нь үл хөдөлнө.
 Хүүхдийнх шиг зөвлөн булбарай цагаан гар,
 Үйл урлах сүмбэн хурууд нь нүд унагана.
 Угаасаа өөрт нь ерөөлөөр заясан
 Уран бэлхүүс нарийн мөчир лүгээ туяалзана.
 Хархан үс нь мяндсан ширхэгээр намирч
 Харц соронздон голт зурх булиглуулна.

Фзули, Шамси, Сайхали,
 Навой, Сагди, Фирдауси,
 Хожаа Хафиз-Та бүхэнд залбирнам,
 Хөөрхий над дууны хувь үлдээв үү!

* * *

Сурсан эрдэмгүй байж бардмыг бүү хичээ,
 Суусан суудалгүй байж ямбыг бүү бод.
 Сул дэмий наргиан цэнгээнд
 Сувайран хорхойсож дэмий бүү ташуур.
 Таван юмнаас дайжисхийж яв,
 Таван юманд давшисхийж яв,
 Хүний зэрэгтэй хүн байя гэвэл та.
 Хүсэл мөрөөдөл амьдрал урд чинь бий,
 Зайлсхийж юмаа эрж байгаа бол та.
 Засдаг уг, хов жив, сайрхал,
 Залхуу хойрго, үрлэгэн зан,
 Бодоожоор таван дайсан чинь тэр.
 Авьяас билэг, аж төрөл, гүн бодол
 Арвич сэтгэл, энэрэл хайр,
 Хараажаар таван эрхэм юм энэ.
 Сэвтэй мууг үзвэл та
 Сэтгэлээ хөргөж мухардана.
 Үлгэртэй юм харвал та
 Үргэлж санаандаа тээж явна.
 Эрдэм помтой бололгүй яах вэ,
 Эрт багаасаа хичээвэл та.
 Та өөрөө эрдэмтэн эс боллоо ч
 Таарадсан нэгнийг дууриахыг хичээ
 «Түүн шиг болох хaa байсан юм» гэж
 Түргэн ам гаргаж болохгүй, та.
 Асаагүй байж унтрах юм бол
 Аливаа эрдмийг хэн танд өгнө.
 Ариун эрдэмд сэтгэлээ өгвөл
 Амьдрал ч тэр, баялаг ч тэр.
 Учир зүй мэдэх хүний үгийг
 Ухварлаж ойлгоод шүтэж яв.
 Учирч тохиосон аливаа нэгэн юмны
 Учрыг олоогүй байж бүү итгэ.
 «Буурлын ч уг, буянтаны ч уг»,
 Бусад хэний ч хэлсэн уг бай
 Бултыг ухаанаараа л дийлнэ, та.

Буруу доройгийн үгэнд авталгүй
Үнэн үгээр явж өнгөр, та.
Куран судрын хэсэг биш юм чинь
Хөөрүү болж дээ гэхгүй биз ээ.
Хичнээн та сөрж зөрсөн ч гэсэн
Бишдийн нүдэнд харагдах гэж битгий ярь.
Бидний үгэнд орвол, та.
Айлтгаж үүнийг бичсэн хүний
Алдрыг нь биш үгийг нь сонс!
Амьтны энэ хорвоог
Алтан гургалдай шиг дуучид ч орхисон,
Алдар цуутай удирдагч, мэргэд ч орхисон
Учир утгаар нь үгийг ойлгосон бол, та.
Ухааны дэнсээр хэмжүүр болгож яв.
Харин тэгтэл буруу болох аваас
Хаях уу, хэмхлэх үү, таны дур.
Хэрэв зөв байх аваас
Хэрсүүхэн бодож чихэндээ хоногшуул.
Мунхаг нь олон, ухаантай нь цөөн гэдгийг
Мухарласан үг юм шиг битгий бод.
Ойрын хүний үг зөөлөн тусдаг болохоор
Оносон байдаг гэж битгий бод
Ёроолгүй тэнэг нэгний хэлсэн
Ес бусын үгийг битгий дага.
Танд хэлэх гэсэн аюултай юм минь энэ,
Өөрийнхөө төлөө суралцвал,
Өөдгүй болгоныг жигшивэл,
Өөрийгөө нээж таниулна, та.
Өрөөлийн төлөө суралцвал,
Өөр хүн мэдэхгүй, чи мэддэг бол
Өвлөж сурсан чинь бүгд дэмий.
Үг яриагаар нь хүнийг шил,
Үзэгдэх царайг нь хараад үгийг нь бүү дага.
Аль нь үнэн үг болохыг мэдэлгүй,
Аливаа юмнаас хоосон үлдүүзэй!
Үүнийг бичлээ, барлаг нэгэн
Эрдэмт мэргэн Дауани
Ийнхүү хэлжээ, түүний зөв.
Туурвилаас уншиж дахин эргэцүүл.
Түргэн сурч, түргэн бүү мартаарай
Залуу байхад сэтгэл цэцэг шиг байдаг аа

ЗУН

Өгөөмөр зуны тэргүүн сард
Өнгө өнгийн цэцэг ногоо
Өргөн талаар дүүрэн ганхана.
Мяралзан урсах голын хөвөөнд
Малчин айлууд нүүж бууна.
Үнгалдаж янцаах адуун сүрэг
Ургасан ногоон дунд нуруу нь гүвэлзэнэ.
Бөөн бөөнөөрөө адуу малын
Бөөр гэдэс нь цүндийж янцаглана.
Сүргээрээ адуу ус тийрч
Сүүл шарван ялаа үргээнэ.
Томынхoo дунд унага даага
Тойрч тонгочин үл амарна
Галуу нугас өөдөө сөөргөө
Ганганан дуулж нисч бууна.
Охид бүсгүйчүүл гэр барьж
Онгон булбарай бие нь цулцалзана.
Цагаахан бугуйгаа ил гаргаад
Цаанаа л нэгийг жиг жуг гэлцэнэ.
Сүрэг малынхаа дундуур ороод
Сэтгэл санаа тэнэгэр баячуул
Явдалт сайн хүлгийнхээ алхаагаар
Явж ирээд айлд бууна.
Хөхүүртэй айрагнаас таслан авч,
Хүмүүс дундаа сөн тавьж,
Хөхрөлдөн хэлэлцээр тухлан сууна.
Хөөрхий зарцыг хуурч тоглосон жаал
Хөлийн хурдаар эхийн хажууд шигдэж,
«Мах авч аль» гэж уйлагнан эрхэлнэ.
Толгой дээрээ сүүдрэвч босгуулсан,
Тохой доороо хивс дэвсүүлсэн,
Том баяны хоол буцалж
Тогоон дотор пор порхийнэ.
Учир мэддэг нь уг хэлбэл
Уралдааны морь шиг хадуурахуй
Бусад нь бүгдээрээ толгой дохииж,
«Тэгэлгүй яахав» гэж зөвшөөрнө.
Цагаан цамц хэдэрч таяг тулсан
Цал буурал өвгөн гадаа гарч:

«Малаа цааш нь гил» гэж
Малчдад чимээ өгөн хашгирна.
«Хөөрхий минь» гэж баян өрөвдөж,
«Хөхүүртэй айрагаасаа дуудаж өгнө» гэж
Хөл алдан зарц нар нь тал засна.
Дээлийнхээ хормойг шууж,
Дэлт хангалыг сургаж
Аль өглөөнөөс ноцолдсон
Адуучид бууж ирнэ.
Буу агсаж, шувуу агнах
Бусдаас онцгой залуу эр
Голын эрэг дагаж сэлгүүциэ.
Хөх тэнгэрт жигүүртэн шувууд
Хөөрөн нисэх агшин зуур
Хөөрхий галууг тэр унагана.
Өнгөрсөн өдрүүдээ бүгдийг нь мартсан,
Отөлж чадал тэнхээ нь харьсан,
Өнөөх нэг хөөрхий өвгөн
Гаднаа зогсож байхдаа
Гайхаж бахдан инээнэ.

* * *

Агуу их гүрэн, хайран казах түмэн минь ээ,
Ах захаа алдаж, сахал үсэндээ баригджээ.
Сайн муу хөёрыг ялгах ухаан нэгэн дутаж
Цус өөх завьжинд нь зэрэг холилдож дээ.
Нүүр, өгч магтвал гэрэлтэн туяарах атлаа
Хэдийд гадна төрх чинь чантуу шиг ингэж хувирас даа.
Өөрийгөө зөвтгөх мортлөө бусдын үгийг ухаараахгүй
Өвс хазаж, хэлээрээ дэмий л чалчих юм даа.
Өөрийн малаа минийх гэж зориглон хэлж чадалгүй,
Өдөр инээдээ үргээн, шөнө нойроо хулжаах юм.
Үзэн ядах нь ихсэж, шийдмэг зан мөхөсдөж
Үнэн худлыг ялгахгүй юунд тэгтэл гоморхено вэ?
Дур дураараа авирлан эв нэгдлээ алдаж
Дүүрэн хишигт улсаа юунд ингэж бутаргана вэ?
Эрх мэдлээ алдахаас сэтгэл зовохгүй мортлөө
Элдэвт тусгуй нохой зан тэгтлээ юунд гаргана вэ?
Талаар нэг тархсан адuu мал баялаг чинь
Тэнгэр бүрхдыг мартагнуулж, шунал нэмэх нь энэ үү
дээ?

Хүч сорьсон үзэн ядалт эв нэгдлийн сарниулж
Хүчээр нэгтгэсэн их улс бутран салах нь энэ үү дээ?
Тогтвортгуй дэмий уг, хоосон амлалт гэгч
Учиргүй инээднээс өөр юу та нарт өгөв дөө?
Утгат уг айлдах ухаант хүнтэй учирлаа ч гэсэн
Угийн шогч муу зангаа гаргахгүй тэвчих гэж үү дээ?

* * *

Омоглон бүргэдийн сойлго таарвал бүхнийг барих атал
Олон түмэн хэрээ бялзуухай цуглувалж биесээ отно.
Кыран бүргэд өндөр авч элин нисэхийг харвал
Хэрээ шувуугаа бас хашгируулж олзны тушаа болно.
Өөрөө ч барьж чадахгүй, кыранд ч бариулахгүй,
Өөдгүй хэрээ хон хон дуугарч бүхэнд садаа болно.
Ид бахаа хангаж, араатан барих зориггүй
Ийм амьтас хоосон салбагнаж ниссээр өдөр барна.
Чин үнэндээ юу хожсоноо бодох хүнгүй,
Шөнөжин сууж шувуугаа магтаж, маргалдана.
Хүмүүс хийгээд өөртөө ч ашиг тусгүй
Хайран ард түмэн ингэж л наасаа элээж явна.

Гэрэлт ертөнцөд олон хоног харамсалтай өнгөрч
 Гэгээн оюунд томох чимэг эрдэнэ үгүй үлдлээ,
 Ухаан төгс номтонд өөрийгөө тооцож хууртсаар
 Угтаа гэнэн магтаалыг өвөрлөн үлдлээ,
 Үлгэргүй олныг сургах гэж бусдаас сүүлдэж
 Үгээгүй тэнэгүүдийн дунд хүлэгдэж хоцорлоо.
 Засаршгүй муу зуршил, цаг нөгөөөх инээд,
 Золбин нохойн занд юунд би ойртов доо.
 Үнэн үгт, шударга зантанг «орос» хэмээн шордовч
 Үзэн ядагч залтын этгээдийг ялгаж эс чадна.
 Хэрэгтэй бүхнийг зүхэж, нөхрөө таньж ядсаар
 Хүнлэг сэтгэлээ алдаж, эцэстээ хоосон үлдэнэ.
 Итгэлгүй тэнэмэлүүд эв эеийг эвдэж
 Үнэнч нөхрөө хайрлах сэтгэлгүй боллоо.
 Үл ялигхан алдааг ч насы чинээ бодож
 Үүнд занаж явах хуншгүй чанар шүгэллээ.
 Эвэлсэн шагай лугаа зааггүй сэтгэлт
 Элэг зүрхний үерхэл мөнхийг туулах ёстой.
 Дотно нөхөд гэж бидний хууртаж явсан маань
 Дэмий хийрхлээс бүтсэн сэтгэлийн ачаа л байж дээ.
 Итгэл даах нөхөр, дотно нөхөд ч үгүй
 Энэ биеийн уйтгарыг шүлгээр би тайлнам.
 Ээнэгшсэн сэтгэлд зул болон бадамлаж
 Эцэс төгсгөлгүй ухааны нуур гэрэлтэнэ.
 Бурхнаас заяатай үерхэл бидэнд тэнхэл өгч
 Бодол хуваалцах аваас сэтгэлийн толбо арилгана.
 Тоггоон барьж үл болох түр зуурын үерхэл
 Тэнэгийн идэш болж насын эцэст зовооно.
 Үнэн мөнхийн үерхэлийг олох гэж зүтгэсээр
 Үгүйлэгч сэтгэл өдөр шөнөгүй уйтгарлана.
 Дарлагч дайсанд автажгүй нөхрийг эс оловч
 Дассан сэтгэлийн эеэс өөр үнэнч зүйл үл олдоно.

* * *

Баячууд адуулсан малынхаа буяныг үл эдэлж
Нэр төрийн золионд дэмийццааж явна.
Нэгийг өгч хариуд нь арвыг нэхэх шунал
Нэрээ тэнгэр тэднийг ийн заясан гэлтэй.
Ертист нутгаар очиж усы нь уусан бухэн
Эрээгүй нэгнээ муулж өргөдөл заавал өгнө.
Арьсандaa багтаж ядан хөөрөн сагсуурч
Улсыг захирч, усыг хүртэл эзэгнэнэ.
Ганзага дуургэн хол аялах гэтэл морьд нь эцэж
Гарзанд өртөж, эд баялагaa дэмийццаа.
Арга залийн алив муухайг сурах авч
Аллах тэнгэрийн үнэн мөрийг үл дагана.
Хүлцтэй нэгнээ айлган дарлахыг бодож
Хот руу байн байн элчээ илгээнэ.
Хүчтэй нь унагаж, хөрөнгөтэйгээ дийлэх гэж
Хамаг аргаа сувэгчилж зарганд гүйнэ.
Хэзээ ч яахав ач тусл нь үзнэ гэж
Хун болгон нэг нохой тэжээнэ.

* * *

Эзэн тэнгэртээ залбирнам,
Эндэлгүй зөв залагтун намайг,
Дайсан дайрч амдан байхад
Дотно нехөр олдохгүй зовном.
Аргын, Найман нийлэн шагширч
Алтаар сольшгүй угээр магтана.
Хорвоод хоосон Тобыктыхан
Хайран угий минь зэнд нь хаяна.
Мөнгөөр солимгүй шижир алтыг
Манггуу тэнэг нь даанч тоохгүй.
Элдүүр нь ханасан шаргал нэхийг
Эндуурч, бусдын даавуугаар солино.
Эзэн тэнгэр тушаал буулгаж
Эрдэм номын урьхинд хүлбэл
Тэнгэр бурхдын мөнхийн зарлигийг
Тэрсэлж гарах хүн олдоно гэж үү?

* * *

Хүн бүр зах руу одохыг харж суухад
Хүссэн зүйлээ тэндээс олж сэтгэл ханана.
Шүүр, будаа тэргүүтнийг нэг нь авбал
Шүр сувдаар гангалж нөгөө нь буцна.
Хүн болгонд адил зүйлийг зах өгөхгүй,
Хүсэл гэгч үнэндээ түмэн ондоо байх шүү.
Оюунт нэгэн ухаанаараа үгийн цэц мэдэрнэ,
Огт учры нь олохгүй өөр нэгэн тэнэглэнэ.
Өнөр олон бүгдээрээ адил байхгүй гэвч
Өнөө харин үг ойлгох хүн олох бэрх болжээ.
Бичсэн үг минь явч хөсөр хаягдахгүй,
Бие биендээ дамжуулж хүн зон хүртэнэ.

* * *

Үгээгүү хөөрхий Кекбай уйлна,
Уйлан байж дуулна.
Уйлахгүй яахан байх билээ,
Үнэндээ энэ цөвүүн цаг
Үргэлж зовлонд учруулна.
Нэг нь мал хулгайлна,
Нэгөө нь толгой цусдана.
Болох бүтэхгүй олон юмс
Бодолд нулымс асгаруулна.

* * *

Хөөрхий дөө. Жамантайн хүү Көжек гэдэг
Хүн болгонд хов зөөдгөө ердөө болихгүй,
Учралт нөхдийг бие биенд нь муулна,
Ухаангүй тэцэг өөрийн бурууг үл анзаарна.

* * *

Нас ахиж, гуниг дарж, мөрөөсөл ихсэж
Надаас хойш амьдрах үр хүүхэддээ зовном.
Хөлсөө гаргахгүй, үэсэн бүхэндээ нүдээ унагаж,
Хүн болгон ашиг хонжоо хайдагт нь шаналнам.
Байхгүй зүйлий чинь олж тусална гэж
Бас хожим ихийг өгнө гэж баячууд авна,
Би казахын өшөөг дайснаас нь авна гэж
Ноён тайжууд нударга үзүүлж авна.
Ядуу нэгэн хөдөлмөрөөрөө төлнө гэж авна,
Ямбатнууд сонгуульд тусална гэж авна
Өстөн дайсан айлган сурдуулж авна,
Өглөг өгөхгүй бол чамайг ад үзнэ гэж зовооно.
Найз нөхөд авна, өгөхгүй бол гомдоно,
Дайсны чинь талд орж, андгай тасална гэнэ..
Зууг өгч, хоёр зууг авдаг нь бас буй,
Залуу хөгшингүй бүгдийг нь шалгана гэж
Амьтан хүн цуглувулж, мал гарга, мах өгнө гэж
Мал гаргаж дайлвал чи миний төлөө бай гэж
Хэн илуүг өгвөл би түүнд андгай тангараг өгнө гэж
Хар хэрээ шиг олон түмэн шуугилдана.
Эв ээ алдан, бие биесээ мөшгөж
Эвдэрсэн болохоос олон түмэн засарсангүй.
Толгой сүүлээ алдан, түмэнтээ хуваагдсан олны

дунд

Тэнгэр бурхдын мөрөөр яваа хүн бий гэж үү?
Эцэг нь хүүгээ, ах нь дүүгээ цагдаж,
Эзэнгүй золбин нохойн зовлогыг эдэлнэ,
Хүн нэрээ худалдаж, эд малын төлөө явагчдын
Хэлсэн уг, гарсан авиа нь талаар өнгөрөг.
Ойр холын казахууд бугд тэнүүчилж,
Огюоос биенээ хайхрахгүй явна бус үү?
Эд баялагийн төлөө аз хийморио үхүүлж
Паруацигар эznээ амь болгоном бус үү!
Тангараг өгч, бурхдаас амь гүйгчдын
Төрөө цөлмөж хураасан баялаг, нэр төр нь сөнөг
Богино өдөр дөчин газар зоорь бэлдэж
Залт үгээр халхалсан хууль нь сөнөг,
Нэг нэрэндээ зуу хувирсан бузар нүүртийн
Өөрийн гэрт ихэрхсэн их зан нь устаг

Нас ахиж, гуниг нэмэгдэн, нойр сэргэж,
Нартын жаргал уур уцаараар солигдоно.
Бодлы минь хуваалцаж аман үг солих хүнгүй,
Болгоож хэн сэтгэлий минь сэргээж хань болох вэ?
Нас өтөлнө, үгүй зүйл буй болж, төрсөн нь үхнэ,
Өнгөрсөн бүхэн эргэж ирэхгүй тавиланг дагана.
Гишгэсэн мөр, үзсэн жаргал цөм ард үлдэж,
Гагцхүү тэнгэр бурхадаас бусад нь бүгд хувирна.
Эрийн үйл-үг сонсож, ухаанаар бүхнийг хийх атал,
Эрдэмгүй хүний үйл-зөвхөн үхэлд үл сөгдүүлиэ.
Зорьсондоо хүрэх холын үйл бүтээхгүй,
Залхуу хүн унхиагүйгээсээ бүхнийг хулиэнэ.
Увайгүй хүн ариун үйл бүтээх чадваргүй,
Хулгай хийж, худал хэлж өөрийгөө тамална.
Хэтдээ тэгээд муугаа үзэхгүй байх гэж үгүй,
Хэзээд нугэл нь илчлэгдэж, тар нь танигдана..

Эрдэмгүй бүү ташуур
 Эрээгүй бүү хашгир
 Билэггүй мую үйлд
 Битгий шунаг дурла.
 Таван зүйлийг эрхэмлэж
 Таван зүйлийг цээрлэ:
 Хүн болохыг хүсвээс
 Хүрэшгүй жаргал өмнө буй:
 Хүртэж түүнийг амсахыг бод.
 Хүнээс дутуугүй амьдарч үз.
 Хов жив, хөөрүү сэтгэл,
 Худал үг, зожиг зан,
 Хөдөлмөр хийхгүй залхуу,
 Хэт нь хүнд тус болохгүй
 Энэ таваас холуур байж
 Эгнэгт цээрлэж явах нь зүй.
 Хөдөлмөр, зүтгэл, гүн ухаан,
 Хайр ивээл, шунахай бус зан
 Энэ тавд ойр байж
 Эгнэгт сахиж явах нь зүй.
 Муу явдал, жигшүүрт үйлээс
 Сэтгэл оюунаа бүрэн ариулж
 Сайн мөр, сургаалт улгэрийг
 Цаг хайлалгүй сурах нь зүй.
 Энэ бүхнийг ухаарч чадваас
 Эрдэм номын үүд нээгдэнэ.
 Эрдмээр их гэж бардалгүй
 Эрхэм мэргэдээс сургаал ав!...

1887

* * *

Аллахын ивээлийг
Амин үйлд бодож
Алив өглөгийг нь
Ашидын буянд тооцном.
Тарни номын шидийг
Талаар бодолгүй
Абишийн өвчнийг
Аваасай гэж хүснэм.
Сарнайн шинжийг
Санаснаар хуртээсэн
Би яахан мартнам.
Гүйцээгээгүй захиагаа
Буян өглөгийг нь
Гунигаар дүүргэнэм.
Сүлд хийморь мөхөж
Сульдсан бие хөөрхий.
Бодлоо гүйцээж
Бичих гэж зовном.
Буянт үйл хүүдээ
Бүтээх гэж шаналнам,

Харь газар байвал
 Хамтран зүтгэх нөхөд чинь
 Санаа бодлоо хуваалцах
 Салахын аргагүй андууд чинь
 Ядарч зовох үед чинь
 Яаж чамд туслах вэ?
 Өөрийн сонирхсон зүйлээ
 Өрөөлтэй хуваалцахгүй гэж үү?
 Галзуурсан дайсан чинь таарч
 Гай зовлонгоо тоочвол
 Урмын үгээ түүнд хэлж
 Уучлахгүй гэж үү дээ?
 Хуучин андуудаа үзэж
 Худал үнэн амлаж
 «Бузар үйлийг зайлцуулахыг
 Бодол оюундаа хүснэ» гэж
 Тэнгэр бурханд тангараглан
 Тарни номыг бузарлана.
 Ирж буцах нь олширч
 Хэлэх үг нь зөөлөн ч
 Итгэлт нөхөд болно гэж
 Хэцүү санаа нь хувирахгүй
 Хуудуу занг нь муулсаар
 Хүнд бас ойртуулахгүй
 Хов, маргаан үүсгэж
 Хүн болгоныг жигшээсээр
 Хэтдээ харин сайн хүнийг
 Хэрүүлч болгож орхино.
 Багалзуурдаж алах дайсантай
 Ноход адил хамт зугаалцгаана.
 Гэрт сууж чалчих болохоор
 Гэгээн хүн шиг харагдана.
 Гадаа гарвал булзаж
 Биесийнхээ хушууг долооно.
 Дайсан хэрэв нэмэгдвэл
 Дэргэд хэн ч үлдэхгүй.
 Хор, бузраар амь зогоож
 Хань нөхөдөө худалдана.
 Ахан дүүдээ гомдох нь

Авгай, хүүхдээс долоон дор
Аюул зэтгэрээс эмээхгүй
Ариун үнэнийг бузарлана.
Буян хурааж, мал олохгүй
Бузар үйлээс бас буцахгүй
Амар хялбарыг хайж
Амь зогоохоо андахгүй.
Сайн явахад салахгүй,
Саар явахад олдохгүй,
Угийн мuu үйлтэн
Ургийн холбоотой байх шүү дээ.
Нар хиртэхэд өвөрт орж
Наран гарахад зугатаадаг
Атгаг санаатан олширсноос
Ахан дүүсийг салгах юм.
Сайнаар ханилсан нөхөд нь
Зөвхөн голомтондоо цэцэрхэж
Гадны хүний дэргэд
Үгээ олохгүй түгдэрнэ.
Золбоо хийморь муутай
Зориг мохоо, харимтгай
Чөлөөтэй газар бардам ч
Чөдрийн морь шиг хашин,
Зөв боловсон харьцаж
Зөөлөн аашлахыг мэдэхгүй
Ихэрхэж суух нь олонтоо,
Ихэмсэг дүр үзүүлж
Чалчаа тэнэгүүд өөдлөхгүй,
Сурсан зангаа орхихгүй,
Хэрэв ялагдахаа мэдвэл
Хөндлөнгийн нэгэнд
Хэргээ чихэхээс буцахгүй,
Өрөөлд харуулах үйлсгүй
Өстөнд үзүүлэх хүчгүй,
Өөрийн дураар явуулбал
Өнөд юунд ч цадахгүй,
Хэрүүлийн голдуу үгтэй,
Хэдэр нэгэн зантай,
Хэзээ ч зөвөө олохгүй,
Аливаа гэмээ ойлгохгүй,
Авдраа эвдэхээс буцахгүй
Аяа, тийм төрөлтөн

Ах дүүс яахан болох вэ?
Адайр зантайг жигшихийг
Ард олон ч мартжээ.
Нээрээ л энэ ахан дүүс
Нохой зангаараа үлдэх үү?
Өмсөж зүүж, идэхээс
Өөрийг бодох хүнгүй.
Асар тэнгэрийн үүл шиг
Алаг цоог нь ч олдохгүй нь.
Хэрэг зарга ихсэж
Хов жив нүүрлэлээ.
Эзэн нь малаа мэдэхгүй,
Эцэг нь хүүгээ захирахгүй,
Албатаа захирах ноёд нь
Айл хэсэж хоцорлоо
Харь элгийн оросуудад
Хошуу ноён тал засч
Харц ардаа шулж
Үе өнгөрөөгчид айл хэсч
Эеэ алдагчид үг отож
Маргаашаа бодохоо болилоо.
Мэдэл чадалтай залуус нь
Хүмүүн ёсыг ухааран
Нэрээ бодох нь бас үгүй,
Гадуурхаж түмэнтээ муулавч
Гадны хүнгүйгээр амьдрахгүй
Хүний олон нь Тобикт
Хүмүүн ёсоо алдлаа.
Буянтыг муулсаар
Буруу нүгэлдээ дарагдлаа.
Бие биенээ хуурсаар
Барахгүй өрөнд баригдлаа.
Казахын буяныг цацаж
Хамаг нуглийг хурааж
Төр ёсоо алдаж
Түмэнд шившигээ тарилаа.
Ийм л зантай бидэнд
Итгэх ч хүн олдохгүй,
Нэхэж өрөө цуглуулахаас
Наймаачид зугтдаг боллоо.
Явуулын хүн ямбатанд


Итгэж үнэмших нь үгүй.
Ард олон биесээ хүндлэхээ болилоо,
Андгай тангараг алдарч
Төрийн багана ганхлаа,
Улс орноо гэж бодох
Үнэнч шударга хүнгүй боллоо

* * *

Ичгүүргүй, тэвчээргүй, залхуу,
Үзэн ядагч, шуналтай,
Энэ л зангаасаа казахууд
Эвээ алдаж хагаралдана.
Өөр хоорондоо муудалцаж,
Өө сэв эрэн уралцаж,
Хүншгүй чанараа харуулна.
Хэнээс ичихээ ч бодохгүй,
Хэлсэн үгийг ч ухаарагхүй,
Хэрэгтэй үйл ч бүтээхгүй,
Нэг л харайж хүрнэ гэж,
Нэг л үсэрч гарна гэж,
Бэртэж дандаа хэвтэх юм.
Хулгайгаар мал олно гэж,
Хүч гаргаж тононо гэж,
Тэнгэр бурхадад ниргуулиэ.
Тэнэг зангаа гайхуулж
Тэрсэлж дандаа шөргөөлцөнэ.
Булхай нүглээсээ зайлна гэж
Бусдад буруугаа чихэж
Өрөнд баригдан хүлцэж
Өөдлөхгүйгээ мэдэнгүүт
Өөр нутагт нүүдэллэнэ.
Хөдөлмөрлөж мал олохгүй,
Хөлсөө гаргаж шамдахгүй,
Хоосон хонохоос зовохгүй,

Хорвоогийн тавиланг зүхэж
Хайран наасаа өнгөрүүлнэ.
Эрчүүд нь нэрээ хугалж
Эхнэрүүд нь гэртээ гуниглаж
Өөрийнхөө тогоонд зочин болж
Өлсөж суух нь хөөрхий.
Учры нь олоход бэрх
Утгагүй заншлы нь өрөвдмөөр
Золбоолог нэгэн болохоор
Зогсоогүй хот руу давхиж
Зарга, хов мэдүүлж
Зон олноос ичихгүй,
Ховоноос өөр мэхгүй,
Хөдөлмөрт ер нүүргүй,
Хоосон магтаалд талтай,
Худал үгэнд дуртай,
Нэг л өдөр наизалж
Нэг л үзэнд гоморхдог
Алдар нэрнээс илүүд
Арга заль боддог
Залиа гайхуулж явах гэж
Зан үйлээ ч мартдаг,
Адайр муухай нь хөдөлж
Архи уулгүй согтдог,
Төр амгалан бол уйдаж
Тэсч ядан гуниглаж
Гэртээ суувал сүлд нь бууж
Гадаа гарвал хийморь нь сэргэж
Худал үнэн шог хэлж
Хүн болгонд инээвхийлж
Өөрийн гэртээ тогтохгүй
Өрөөлийн хойморт намбалж
Үнэн уgtэй нэгнээ
Үзэн ядан шоглож
Буян туст хүнийг
Байж ядан ховлох
Мал буяны дайсан
Мугуйд тэнэгүүд олширлоо.
Бусдаас дутуугаа ойлгохгүй
Гөлөг атлаа хуцаж
Үг залиараа ихэрхэж
Элс шороо үмхүүлж

Тусыг усаар хариулах юм.
Хийж чадах үйл нь
Худал хуурмаг, заль мэх
Өр хатуу тийм хүн
Өрөөлд яахан тус болох?
Буян, ачийг бодож
Бусдад яахан нүүр өгөх?
Үнэн үг хэлэхгүй,
Үйл буяныг бодохгүй,
Худал зусарч магтаалаар
Хоосон нүүрээ таглах юм.
Үнэнийг би хэлэх гэж
Үгээ хэрхэвч нуусангүй,
Ард олон үүнийг бодоосой,
Аливаа мууг жигшээсэй!



HAMAP

Саарал үүлс тэнгэр бүрхэн зэгий дааж
Салхигүй чийг манан газарт бууна.
Цадсаных уу, жийрхсэнийх үү, бүү мэд
Цанхаалан адуу тонгочиж, унага даага уралдана

Зуных шиг өнгийн цэцэг, зүлэг ногоо үзэгдэхгүй,
Зул шиг залуус инээж багачууд үймэн тоглохгүй.
Настан буурал, бадарчин ачил царай алдаж
Навчнаасаа нүцгэрсэн модод өгөр даана.

Урь идүүлж гайд хийсэн арьсаа нэг нь хутгана,
Уранхай хувцас навсайж салбарна.
Эх нь өвдөг зогдроор утас ээрч
Эхнэр хүүхнүүд гэрийн цоорхойг нөхнө.

Галуу, тогорууд зэллэн буцах уес
Газрын холоос ачаа жингийн цуваа эргэнэ.
Айл гэрүүд цаанаа л нэг уйтгартай
Аялгуу дуу, инээд наргиан дутна.

Өвгөд эмгэд бээвгэр, хүүхдүүд бүрсгэр,
Өдөржин мал дагахад зэврүүн хүйтэн.
Хэмтэй яс, шөлний шавхруу олдоогүй ноход
Хээрийн оготоно ангуулчилж, гаднаа эс тогтоно.

Хуучин намаржааны хөлөөр чийр болж
Хуй салхи босч шороо тоос манарна.
Айл гэрүүд гал хөсгүй зэхий даах нь
Амьхандаа ис тортоггүй суухыг бодсон нүүдэлчний
дорийн

ӨВӨЛ

Ханхар бие, цагаан дээл, урт сахалтай тэр
Харалган, эргүү хэнийг ч гэсэн үл ялгана.
Хамаг бие нь цан хүүрэг, хүйтэн дүртэй
Газар чахруулан гишгэлсээр хүрч ирлээ.

Амьсгал нь тасхийм жавар, хайрах цас
Хөгшин худ-өвөл ирж сандралд оруулав аа.
Сэгсийх үүл шиг малгайгаа шовоилгоод
Үлээх жаварт минчийж сүр оров оо.

Бор үүл шиг хөмсөг нудийг нь бүрхээд
Буурал толгойгоо сэгсрэхэд цас орж зуд тарив аа.
Зүд шуурга шиг догшрон хилэгнэхэд
Зургаан ханат цагаан гэр дэндэлзэв ээ.

Нүд хужирлан гүйлдэх хүүхэд багачуудын
Нүүр гар хайрагдан хөлдөн завдав аа
Нэхийн дээл, ноосон хүрэм давхарласан малчин
Эгцэлж харж чадахгүй нүүр буруулна.

Цас малтхаас залхдаггүй адун сүрэг
Цариг хүчээ алдахад тун дөхөв өө.
Өвөлтэй цуг хэл амаа чоно долооллоо.
Өлөн боохойд малаа алдуузай, малчин минь.

Сэргүүн бэлчээрт малаа адуулан манаж
Сэргж нойроо эс мартваас амар заяа өгөхгүй нь ээ.
Боохойд өгсөнд орвол Кондыбай, Канайгийнхан идэг л
Дээ,
Болж өгдөггүй энэ өвөл-өвгөнийг гар хоосон буцаа.

* * *

Салхигүй шөнө сав саруулхан,
Сарны тuya уснаа явгална.
Үдшийн шөнө айлын хаяагаар
Үерлэсэн гол шуугин урсана.

Шигүү ургасан моддын навчис
Шивэр авир үг хэлэлцэнэ.
Нойтон газрын хөрс сэргэж,
Ногоон өнгөөр дэлхий баясана.

Нохойн дуунаар эзэн нь чимээлэхэд
Нойрмог уулс хоршин цуурайлна.
Хөлөөс зайдуу уулзах болзоондоо
Хөдөөгүйн замаар чи минь ирнэ.

Цаанаа л нэт дөлж бишүүрхээд,
Царайнд нь улайх цайх хоёр ээлжлэнэ.
Дэнсэлсэн сэтгэлээ тогтоож чадахгүй,
Дэмний хоосон үргэж сэргэлзэнэ.

Түгдэрч сандраад ярьж чадахгүй,
Түг түг хийж зүрх нь цохилоод
Хүзүү цээжинд минь хацраа нааж,
Хүүхэн чи минь зогссон биш үү?

* * *

Мушгиralдан байж
Мөрөө цуцааж,
Хамраа мурийлган
Тамхиа татаж,
Хоосон гангарч
Хирээ мэдэхгүй томорхож
Тэгтлээ дандаа сайрхдаг,
Тэр зан чинь над таалагдахгүй!

Үхэл зовлонд нэрвэгдвэл хэн ч гашуудна,
Үнэн шаналсан сэтгэл нь заавал шархална.
Алаг нүднийхээ нулимыг барьж ядан уйлавч,
Аялгуулан юунд дуулнам билээ, хөөрхий?

Хүргэн оруулж, бэр мордуулж, найр хийж,
Хүмүүст зугаа бэлэглэж охидтой танилцъя.
Намайг чагнавал сэтгэлд минь шүлэг дүншиж буй,
Найр наадам дуу шүлэггүй өрнөдөг билүү?

Хүүхэд мэндлэвэл угаалга, цайллага хийж
Харанхуйг үргээж, үүр цайтал дуулалдана.
Эртэдийн мэргэдээс бидэнд их өв үлджээ,
Эргэцүүлж бодоход шүлэг, уг болгонд учир бий.

Хорвоогийн хаалгыг хүмүүн гэгч ая дуугаараа нээж
Хөрст газрын хэвлэйд дуутайгаа цуг шингэнэ.
Амьдын хамаг жаргал дуутай цуг амилна,
Аяа, үүнийг эргэцүүлэхгүй яахан явах билээ?

Дуу дуулах нь байтугай ойлгох ч хүнгүй,
Дуулах авч утгын гүнд хүрэх ч чадалгүй,
Чамайг бодож дуугүй яахан байх билээ,
Чи юундаа тэгтэл гилюрч дүнсийнэм бэ?

Дуу гэгч-үгийн утга, найрал хийгээд
Үгний холбогч айзам эгшгийн бүрдэл,
Утга төгс үгийн амт зохицвол,
Угтаа маргаж суух хүн гарах уу?

Гэдэс цатгалан, цээжиндээ эрдэмгүй хүн,
Гэгээн номыг ухаантны адил ойлгохгүй,
Хүнд айлдах үгийн утга учрыг тунгааж
Хэлэх цагаа алдалгүй олох нь бас зүй.

Сайн шүлэг хэлж өрээлийг баясгалаа ч
Сайрхаж, бас хишиг бүү горил, чамаас юм унахгүй,
Үг ойлгох ухаантай хүний төлөө зүтгэ,
Аялгуу дуугаа худалдаж, өргөл авагчлыг цээрлэ!

Олны дотор уг мэдрэх хүн цөөхөн бол
Огтоос дуутгүй байх нь арай дээр,
Нэг нь үүнийг, нөгөө нь түүнийг бодож суухаас
Нээрээ энэ казахад уг сонсох хүн бий юу?

Шортанбай, Дулат, Бухар... энэ бүх найрагчид
Шүлгийн утгыг бодохгүй үг хэлэх нь илүү,
Аяа, үг тиних эрдэмт хүн тэдний шүлэг уншваас
Алдаж оносон үгс нь ялгаран байгаа бус уу?

Эгшигт үгээр жигүүр хийж, гүн урлагийг ухаарч,
Эрдэмгүй тэнэгүүдийн мэлмий, сэтгэлийг нээхсэн, би,
Учиргүй инээд, найр цэнгэлээр зугаандаггүй,
Ухаант залуус үүнийг үлгэрлэн сурахыг хүснэм, би!

* * *

Залуу наасны гал дөл чи хаана байна,
Залж, зүрхийг яагаад догдлуулахгүй байна?
Оюун эрдмийн тусыг ойлгож
Орчлонгийн сайхныг төсөөлэхгүй байна уу?

Мөс чанарыг бодохгүй бол
Мөнхүү хүний аргыг эс олно.
Сэтгэлийн тамирыг мэдрэхгүй бол
Сэмхэн тэрээр гарг эс орно

Ханийн сайхныг олоогүй бол
Хайрын сайхныг хэн мэднэ.
Зовлон гууниг төвөггэй байвал
Зориглож санаснаа шуудхан хий!

Анд нэхрийн журмыг баталж чадвал
Амиа үл хайрлан тэр чамайг дагана.
Залхууралгүй байж сүргээ эс хариулваас
Залж түүнийг хэн авчирах юм бэ?

Ариун шударгад хүрье гэвэл
Адуулж малаа харнуулж сур!
Амьдралын дөртэй болоогүй байж
Амаараа хашгирч биеэ бүү зовоо!

Олон юмнаас хоосон үлдлээ,
Одоо харин юу хийх билээ.
Амьдралд хөл гарaa олохын оронд
«Ам руу хийгээд аль» гэдэг болжээ.

Амин сэтгэл минь энэлж шаналж байна.
Амьдралын өдрүүд чамгуйгээр зовоож байна.
Хувь тавилангаар хүрч ирсэн зовлон
Хүч тамирыг минь барж байна.

Тэнгэрээс заясан-тавилан юм хойно
Тэрний дор төрөөд юуг эс үзэх вэ?
Уянгалан дуулаад бай, хоолой минь
Уянгалан дуулсан цагт ужиг энэ өвчинөөс
сална.

Учралт хань тангарагаасаа няцсан хойно,
Уүц нуруу минь бөгтийлөө.
Уйтгар гунигт автсан сэтгэл
Угаас яаж амар байх вэ?

Их саналаа шүү би, чамайг
Эргэж уулзалгүй уджээ, хоёул.
Хүний чинээн намайг санаж
Хүүхэн чи захидал бичсэнгүй.
Яс гэхнээ хэврэгшсэн хойно
Яаж зүрх минь ая тавтай байх вэ?

Ийм нэгэн уйтгар гуниг
Ирээдүйн ханьд минь хүрч чадвал,
Амрагийн минь амин сэтгэлд
Анагааж эдгээх эм болж,
Ухаан бодлыг ариутгаж,
Үнаган биенийг чинь түвшнтгэх бус уу?

Ухаантны амнаас гарсан уг
 Учиртай нэгэнтэй зам нийлэг.
 Хүний дотрыг нэвт харах
 Хүрэн зүрхний мэлмийтэй байг.

Зүрх нь толь бол сэтгэл нь сэргэг,
 Зөв үгийг ухаардаггүй бол тэр мунхаг.
 Билиг авьяас нь бэлэн байвал
 Бишдийн үгийг ухаараггүй яаж байх вэ.

Золигийн сагсуу хэн нэг нь
 Зүйтэй үгэнд орно гэж үү?
 Засрахаа больсон хэн нэгэн
 Зөв үгэнд орно гэж үү?

Хэлээч яриач гэж өвдөг сөхрөгчид
 Хэрсүү янзын царай гаргана.
 Унтаа залхуу нөгөө нэг нь
 Ухаараагүй мөртлөө хаширч эхлэнэ.

Ухаан бодол хүлээтэй бишээ,
 Балчир хүүхэд шиг сониуч шүү дээ.
 Бодох л юм нь зугаа цэнгэл,
 Ангалзаж алналах нь хэрэггүй зан.

Хөөрхөн хүүхэн, сайхан эр,
 Биш юм бол тэнгэр аваг.
 Болчимгүй хүмүүнд сургамжийн уг,
 Булчирхай мэт хаягдахын нэмэр,

Сайн хүнд сэтгэл хайлваас,
 Сайхь тэр зүрхиээс ухаарна.
 Ялааршгүй өвчинд эм гэж үзвэл.
 Яагаад ч алтыг гууль гэхгүй.

«Тэнгэр минь, тэнгэр минь» гэгчид
 Илжигтэй адил,
 Нэг бол арга заль, эсвэл хорон санаатай,
 Тэдэнд ямарч бодол байдаггүй хойно,
 Тэр нь торго ч бай, хоргой ч бай адилхан

Ар нуруугаа дагасан гурваар дарсан гэзэг,
 Аяс намбанд нийцсэн зүүсгэл чимэг.
 Зургар хөмсөг, булбарай хүзүү, минжин малгай,
 Зургийн юм шиг хөөрхөн царай зүснийг харсан уу?
 Толь мэт нүднээс гэрэл цацарч,
 Тогтох харах тоолонд зүрх халуу дуугиэ.
 Булбарай танхил бие, гэрэл бадарсан царай,
 Бусгүй хүний тийм сайхан төрхийг харсан уу, чи?
 Бусэлхий түяхан, нуруу цэх, хөл шулуун,
 Байх уу, ийм хүүхэн хорвоод ер нь.
 Болсон алим шиг амттай түүнийг,
 Бодож хүсэхээс аргагүй харсан хүмүүн,
 Хүүхэн түүний бугуйд нь гар хүрчихлээ гэжэд,
 Хүрэн зүрх булгиж судсаар цус түрнэ.
 Зөвхөн түүнд ойртон суух төдийд
 Зөөлөн амьсгаа нь ясны тосыг хайлувуна

ХАРХҮҮГИЙН ИЛГЭЭСЭН ҮГ

Хөмсөг зургаар хөөрхөн чи минь сайн уу?
Хөрөнгө мал, амь биеэ чамд зориулъя,
Чамайг санан санан суухад,
Цавчих нүдэнд минь нулимс хурах юм.
Ертөнцөд чамаас илүү нь төрэхгүй.
Ер нь төрлээ гэхэд илүү гараахгүй.
Харин чамаас өөр хэнд ч бай,
Хайр сэтгэлээ би өгч чадахгүй.
Ариун сэтгэл хувиршгүй биз ээ.
Ам тангарагаасаа буцашгүй биз ээ.
Уулзсан ч тэр, уулзаагүй ч тэр,
Уяхан сэтгэлээс чи минь хэзээ ч гараахгүй.
Өрөөл бусдад би харц чулуудахгүй.
Өөрийн минь санаанд ч тэд хүрэхгүй.
Хоёул багтахгүй орондоо чамайг тэвэрч,
Хоолой цээжийг чинь үнсэж үнгэхсэн.
Сунагар гэзэг чинь, мэрэн дээр
Сул задгай асгаран томолдоё юу.
Нүд аниастай мансуурсан сэтгэлээр,
Нэгэн агшинд боловч жаргал эдэлье юу.
Таны гоо үзэсгэлэн, миний хувь ерөөл,
Талархан хэлэх үг минь гарцаагүй үнэн.
Тан шиг ханийн сайн сайханд,
Таашаал эдэлж би үл хана юу.
Хоёр бие нэг нэгэндээ хүрэхэд,
Халуун амьсгал ойртон чиний үнсэхэд,
Хайрын сэтгэлд гал авалцах шиг олоод
Хамаг бие жирс жирс цочроно.
Бор зүрх минь сүжрэн ивэлж,
Бодлын үгээ зангидан шийдэж,
Эв найрыг тогтоож чадсан цагт
Энхрий чамайг хаанаас ч олох шонхор билээ,
би,
Ааш зан чинь өөлэхийн аргагүй,
Ажин харахад элбэг баян юм.
Цаг мөч улирах тоолонгоор,
Чи надад халуун дотно болох юм.
Гоёхон жигүүрт гургуул минь чи
Гоо зүс царайгаа надад харуулаач.
Улам улам наашаа ойртож,
Уран цагаан хүзүүгээ үнсүүлээч.

ХҮҮХНИЙ ХАРИУ ӨЧИЛ

Эвлүүлж байгаад магтах юм, та.
Эрвэл олохгүй үг танд байхгүй биз ээ.
Хөөрхий надад эрх мэдэл алга аа,
Хөтлөх залахаа өөрөө мэд ээ.

Бүсгүйчүүл бид хүн болгоныг хардаг юм.
Бүтэлгүй нэгнээс нь нүүр буруулдаг юм.
Эрхэм тан шиг нэгэнтэй учирваас,
Эгэл би толгой юунд сэгсрэх юм бэ?

Ухаан бодол, үг хэл чинь нийцэх юм,
Улаан галын дөлөнд тос шиг хайлах юм, би.
Халуун үг чинь сэтгэлийн гүнд нэвтрэхэд,
Хайлахгүй байж тос яахин чадах билээ.

Хайрыг минь та тосч авбал сэтгэл минь амар,
Хаяад хэрэв явчихвал хөөрхий би яана даа.
Замбуулин хорвоод тэгвэл над шиг хөөрхий,
Заяа дутсан амьтны үр байх юм гэж үү?

Зөн мөрөөдлийг минь талаар болговол,
Зөнгөөрөө орхигдооос аргагүй болно доо, би.
Өр зүрхнээсээ хайлаж чадахгүй бол чи,
Өөртөө намайг ойртуулж бүү дасгаарай!

Харуусал гэдэг өвчин эмгэгтэй тэнцэнэ.
Харласан сэтгэл эзгүйрсэн нутагтай дүйцнэ.
Чинийх л биш бол бусдын ор дэр
Чимээгүйд орших булш бунхантай адил.

Эх замбуулинг эзлэн хүчээ авсан.
Эрэлхэг шонхор гэвэл та билээ.
Боолын боол бидэн шиг бүсгүйчүүл,
Босгыг чинь сахисан барлагууд билээ.

Чин зүрхнээсээ намайг хүсч,
Чиний сэтгэл догдлоод байгаа бол
Начин шонхор гургуул барихын адил,
Намайг тэврээд ханатал чи жаргалаа эдэл,
Торго дурдан шиг эвхэгдэж болох,
Түяхан бургас шиг нахицаж мэдэх,
Хүүхэн намайг хамаг жингээрээ,
Хүслийг минь дээдлэн жаргаах ажаам уу...

Ухаан санаанд орсон угээрээ,
Учирлан байж үүнийг бичлээ, би.
Эрхбиш санаанд чинь таарвал залуус аа,
Энэхүү шүлгийг минь уншиж үзээрэй.

Үүний утгыг ухааран уншаад,
Үнэн эүрхэнд нь гал бадраг.
Үгийг минь ухаарах хүн таараад,
Үргэлж дуулаг энэ дууг.

Айзамт шүлэгтээ шимтэн баясаж,
Аялгуут дуундаа хайлан уярана.
Кекбай гэтэл хөвсөргөж явсаар,
Хөөрхий болсон нь даанч тоогүй өэ.

Үзэгдэх биенээс цаашгүй минь хоосорсон,
 Үүнийг би бусадтай уулзах болгондоо хэлдэг ю
 Өнөөдөр нөхөр байсан нь өглөө дайсан болно,
 Өөрөө би тэдэнд ямар гэм хийсэн юм?

Орон гэртээ бол хэн нэгэн нь,
 Оргилох ус шиг сур бараатай байдаг юм.
 Гадны хүний өмнө очихоороо,
 Хашин морь шиг ядмаг байх юм.

Урьд нь ийм байсан билүү,
 Учир нь юунд байна, баатар минь?
 Гурван өдөр нуруугаа амраавал,
 Гундашгүй хангал болж орхих юм.

Амиа аргацаах гэж сандарч тэвдвэл,
 Аль нэгний сэтгэлийг уяраах гэсэн шиг байх ю
 Яваандаа ая эвээ олбол чи
 Яагаад бусдад хөндий ханддаг юм.

Хулгай, худал хоёроор хүлэхэд,
 Хүлээсийг чи тас огтлох юм.
 Өгөх юмандаа чи гар татуу,
 Авах юмандаа чи алга тэнэгэр.

Зуун янзын зарга заальхайнаас,
 Зулбаж зайлсаад амжих юм.
 Эцсийн эцэст чам шиг нь,
 Ийм юмыг үзээгүй яваа гэж үү?

Эргэж татах үүд хаалтыг,
 Эрхэм та битгий саваарай.
 Өсч өндийсөн ч, өөдөлж дэвжсэн ч
 Өөр нэг өдөр дахин татах хэрэг гарна шүү.

Цаг хугацаа нөгцөөхийн тулд би шүлэг бичдэггүй,
 Цагийн зугаа болгож хоосон зүйл хэлхдэггүй,
 Сэтгэлийн гэрэл, алсыг харах нүдтэй хойч үедээ,
 Сэргж мэдрэх ухаарлын үгээ үлдээхийг хүснэм.
 Үнэн энэ үгий минь хөөрүү нэгэн мэдрэхгүй ч
 Ухаан эрүүл, сэргэлэн залуус минь аяндаа ойлгоно.

Учир утгын тунгааж ухварлаж үл чадваас
 Угтаа гаднах өнгөөр бодлын нууц тайлагдахгүй,
 Хүүхэд ахуйдаа сонсоогүй бол үг хичнээн чимэгтэй ч
 Хожимоо харин хачин эвгүй сонсогдож мэднэ.
 Өмиөх үеийнхээ сургаалыг ухаарч амжаагүй хүн,
 Өтөлсөн хойноо үгээр тоглож юугаа хийнэ.

Өнө эртэднийн зөнч мэргэдийн ёсыг сахиж
 Өнөө би гоёл чимэггүй үнэнийг хүснэ.
 Өтгөс хөгшдийг шоолж, үхэлд өөрийгөө түлхэх
 Өсөж буй залуусын ичгүүргүй занг үл тэвчинэ.
 Гоё чамин үгийг надаас бүү эрэгтүн,
 Гүн сэтгэлд нуугдан буй утгын нууцыг тайлагтун!

Баатрын удмаас хулчгар нэгэн төрөх нь бий,
 Бүсгүй хүн өнгөнд хууртдаг ёсон бий,
 Олонд тусгүй, ажилд талгүй, ойворгон сагсуу зан,
 Осолгүй амархан мэдэгдэж тар нь танигддаг шүү Џээ!
 Тэнэгүүд хичнээн шоолж инээсэн ч хамаагүй,
 Тэднийг гаргуунд нь хаяд шүлгий минь уншигтун!

Шүлэг найраг тэрлэдэг насан бага дүү нар минь,
 Шулуухан хэлье, надад хараал бүү тавигтун,
 Өрөөлд байтугай өөрт ч тус болохгүй,
 Хайран эрДэм талаар дэмий өнгөрөх вий дээ!
 Хэтдээ нэмэргүй хээнцэр зан, утгагүй инээд
 Хэдэн жил чиний сэтгэлийг баясгах билээ л?

* * *

Эрдэм номын ухаан гэгч хүйтэн мөсний адил,
Энэ биенийн илч гэгч халуун зүрхэнд л хурдаг юм.
Тэвчээрт зан, хамгийг бүтээх чадал гэгч,
Туйлбартай үнэнч зориг ухаарлаар бүтдэг юм.

Ухаан, золбоо зориг бүхэн тэгш бүрдэж
Үг чанраараа хүмүүн бусдаас ялгарал бус уу?
Зоргоороо явж биесээ үл түших аваас
Золбин зан сэтгэл хөнөөж хор болох бус уу?
Ухааны нүд, сэтгэлийн тамир, баясалгүй хүн
Утгыг үл тайлж, зүрхээ дэмий л зовоох бус уу.
Ээл гурван чанар үгүй эрдэм хураах гэвэл
Эрдэнэт хүн дэмий шаналж эцэстээ хоосон үлдэм уу!

* * *

Аяа, өд хатгаж, шившиг тарни уншлаа ч
Ажлын морьд аргамагаас түрүүлийн гэж үү?
Усан тэнэгүүд үгээр шорлон, сэтгэл шархлааж,
Уцаар төрүүлэлгүй зүгээр явна гэж үгүй юм.
Гөлгөн нохой олныхоо хүчээр чоно барьдаг билүү,
Гэтэж ирсэн аюулаас эзэн тэнгэр л авардаг шүү дээ.
Гэрийн үүдэнд хүлүүлж хичнээн удаа яллагдавч,
Гэм буруугаа ухаарч тэнэгүүд ичдэгсэн билүү?
Өөдөө матах дуртай оросууд олzonд шунасаар
Олон байтугай цөөнхийг ч гааруулж гүйцлээ.
Хэн нэгний гар харан, тал засах нь ихэссээр
Хэтдээ галзуу, тэнэгээр Семей хот ч дүүрлээ.

* * *

Хар авгай гэгч үнэндээ хар авгай юм даа,
Хазаж, чимхэж, тасдаж хоногийн хоолоо олох юм,
Халуун зуны турш ч ханийхаа бараа харахгүй,
Хөөрхий авгайд казахын жаяг номын хэрэг юун?

АЙМАН МӨРТИЙН ХЭЛХЭЭ

Холоос даллаж
Голоос ундарч
Голт зүрхийг шимшруулсан
Бүхнээс хурц
Бүгдээс хурдан
Бөхөнг гүйцэж эргүүлсан
Ай яруухан хэл минь чи
Ардын сэтгэлд юутай уяган бэ?

Үзүүртэй гээд
Учиттай зүү
Үгсийн хуарыг үл хатгаю.
Уран үгсийн
Сувдаи хэлхээг
Тэнэгүүд үнэлж үл чадю.
Үгс минь одоо дуугаа тат
Үгээгүй годлиуд үл сонсюу

Үгэнд ургүй
Ухаанд нүдгүй
Үйлж дуулахаас хэтрэхгүй
Түвшин зангүй
Түмэнд тусгүй
Тэнэгүүд үг ойлгох биш дээ
Бодож сэтгэхгүй мунхагын дунд
Болж өгвөл дуугүй бай!

Ууц нуруугаар хүйт оргино,
Уур шатаж дотор бачуудна.
Урагшгүй тэнэгүүдийг харахаас л
Урам нэмэх халуун үг
Ухаан тэлэх үнэн үг
Талын салхинд л замхарна,
Тэгэхэд харин бузар хэрэгт,
Тэд хичнээн үнэнч гээч.
Ховын үгэнд хүлэгдэх
Хотноос гарахгүй уягдах
Хөөрхий тэднийг яалтай вэ!
Зальхай зайдан үгт
Заяа тавилан муут

Зөнт эцгээ ч үл хайрлах
Зөв явж хоол олохгүй
Зүргүй олиныг яалтай билээ?

Хов зөөж хоол олох нь
Худал хэлж мал олох нь
Донгио хүний л ажил даа,
Сагсуурч согтох нь
Сайрхаж донтох нь
Савсаг амьдралын л ааш даа,
Цүнхээл ус мэт гүн сэтгэхүй
Хөөрхий тэдэнд тун хэрэггүй.

Хүний мөс голтой бай,
Хүн дүрс, буурьтай бай,
Хүч чадлаа үл хайрла,
Хов хэлэхийг тэвч
Худал яриаг түвд
Хүнд тустай буяныг бод,
Хөдөлмөр зүтгэлийг эрхэмлэвэл
Хэтийн буян аяндаа хурна.

Арилжаа наймаа хийж сур,
Арвай будаа тариалж сур,
Ажил хийж өөрийгөө тэжээ,
Эхнэр нь эрдээ энхрий бол
Эр нь ажилдаа эрэмгий бол
Элдэв хэрэг бүтэх нь тэр
Хасаг хасагтаа итгэхгүй бол
Хамаг амьдрал ёозгүй болюю

Бусдын гарыг бүү хар,
Буман сүргээ бүү бар,
Хүү минь хүний дотор л бүү ор,
Дээрэнгүй ёс устаг,
Дэнгүй харахуй арилаг,
Аливаа олиггүй бүхэн бүү өндийг!
Үйл буян чинь мандан гийж
Үнэн үгийн ачийг үзэг.

Хэт их баярхал
Хийх ажилгүй залхуурал
Хүн шинжийг хэтдээ барна,
Саар юманд дурлагч
Сайн нөхөртөө дайсагнагч

Сайнаа үзэхгүй насыг барна.

Гэмших нүүрээ түмэндээ уруулж
Гиншиж, ёолсоор ясаа тавина.

Голг бие сулудаж

Галт сэтгэл шатаж

Галдах мэт цориглон байнам,
Гай зовлон зүрх шархирааж

Гайхаш тасарч сэтгэл унтраа,

Самуун маргаан хаан л бол,

Саар муу бодол чамайг ноёлно.

Аяа, амьдын жаргал юутай богино вэ,
Алсын зорилго юутай урт вэ?

Аян замын голд алжааж би суув
шүү!

Элиин хальсан өдөр хоног

Эргээд ямар ирэх биш дээ!

Алиа, ихэрхэх залуу нас эргэж
олдох биш дээ,

Нөөцөлж гарсан наслүй юм чинь

Нөхөх арга алга даяа энд үлдэхээс!

Алдар хүнд нэр төр гэгч

Арван түмд нэг л юм шүү дээ.

Аяа, тэгэхэд үнэнч үг хэлчих нь
үгүй юм шүү дээ,

Залуу нас өнгөрч одлоо,

Зантгар толгой цайх боллоо,

Олны хөл үймээнээс ойлгосон нь
хомс шүү дээ,

Хорсол хилэнгийн манан дунд

Хоосон, дэмий наасаа элээж дээ.

Гуа сайхан амьдрал юугаа

Гутаав бололтой ашиггүй,

Гэгээн бодолд хорсол дүүрнэ,

Амиа өгч хайрласан ард түмэн минь

Амьд, үхсэнийг ялгахад хэцүү,

Далайсан газар далд орно,

Далласан газар ил гарна.

Аймхай улсаа айлгаж чи
Амьд байгаа чинь аль вэ?

Алдар нэрэнд сүнсээ зольж
Амьтан бүхэн амиа хайцаалж
Аж төрөхийг ажна уу чи,

Амин голтой гэлдэрнэ үү чи,
Завхай эхнэрт залилуулсан эрд
Заяа буяа хурах гэж үү?

Өнөө чамтай нөхөрлөгчид
Хэт нь хэнд ч хэрэггүйг мэд
Уруудаж зовох цагт чинь
Урваж одохыг бүү март

Харь газрын хар хулгайч
Хавьтахын аргаѓуй бөөн заль
Ажиж л бай чамайг нэг
Араар чинь тавьчихаад арилах бий.

Үүц нургуугаа тоосонд даруулж
Үйлт толгойгоо цусанд хутгаж

Харалган зусараа үл орхино уу чи,
Ухаан алдан гүйцгээж
Унан дусан мөргөх юм.

Учиргүй тэгээд баярлах юм,
Санаа шулуун ардын
Саруулхан төр нь хаачив аа?

Саваагүй нохой хуцлаа гэж
Шилбүүр барьсан хүүхдүүд
Цааш нааш гүйлдэхэд
«Хүүе байг, битгий!» гэж
Хүний үрийг ичээх гэж,

Хэлэхийг юман чинээ бодно уу, чи!
Их л сурхий хэрэг болж дээ,
Ичгэвтэр ч юм болж дээ.

Оролдлоготой нь зоригло,
Орчлонг таньж л зөвхөн чад.

Оролдлого байвал болох юм чинь
Эрдэмгүй харалган хүн гэгч,
Эрээгүй бүхэнд л ховдоглоно.

Эрдмээс урьтаж хоол бодно,
Тэр бүхэнд тэrsуу байлаа,
Тэгэвч заяа минь гашуун байж.

Эрдмийг би эрж сурсан
Эрсээр тэнэсээр эцэж цуссан
Ийш тийшгүй бишгүй л ширтсэн
Аанай тэр мунхагууд чинь
Ажил хөдөлмөрөөс айдаг болохоор
Амьдралаас би залхаж гүйцлээ.
Салаа замын бэлчирт
Цайрах малсын барааг ширтэнэм.
Элгэн улаан хадны оройгоос
Эргэн тойронд хашгирсан би.
Ул хөндий ч надад хариу өгсөн,
Уудам талд ч надад хариу өгсөн.
Хаанаас тэр дуу хангинасныг
Харах гэж эрсэн хайсан, би.
Элгэн улаан хад л эгц доор минь
байсан,
Хадны цуурай замхарч, харин
тэрээр дүнсийн байсан.
Морьтой хүн давхиж одсон,
Морьгүй хүн явгарч үлдсэн,
Хэндий хүү хэн болохыг
Хэн ч мэдэлгүй тэгээд л ходорсон
Хэнхдэг цээжинд нэгэн юм
Хэм хэмээр цохицлж байсан.
Хэг алсад бас нэгэн юм харагдсан,
Хэнд ч хэрэггүй миний үг байсан.
Хэнхдэг цээжинд
Нэн зовиуртай хатгана.
Хэл ам хатаж
Халуун галаар цоргиг.
Хрэв би тэр чигээрээ
Шатах байгаа юм бол
Хэрхэн би ү.и мэгших,
Хүчин хаанаас олно.
Өдөн дэр чулуужиж
Хад болж хувираад
Аятай унтах амрах
Аргагүй боллоо.
Хүмүүс хайхрах ч шинжгүй,
Хайрлаж өрөвдөх янзгүй,

Муу заль, хар хэл хоёр л
Муруй гишгэхийг минь отож байна.
Өнөр бүлтэй
Өглөгч айлд төржээ, би.
Өнчрөл үзэхийн учир алга.
Ах дүү олонд
Аядаж хэлэвч
Аяа, уг ойлгох хүн алга.
Бусдаас салангийн булш шиг
Бөгтгөр миний л үнэн энэ дээ!

* * *

Үнэнч нөхөд олдохгүй нь ээ.
Үүрдийн тангараг хaa байна,
Өнөөгийн жаргал маргааш эргэхгүй,
Өлөн худал юунд ноёрхоно вэ?!

Ач тусыг хоногтоо мартаж
Андуу гишгэвэл алдас болно.
Хал үзэхгүй гэлдрэх аваас
Халуун тусыг бодоод ч нэмэргүй.

Ашиг хонжоо, дэмий хийрхэл
Аминд чимэг болно гэж үү?
Хэнд ч хэлдэг ховын үгээ,
Чалчицгааж л байг, хамаагүй.

Ханилах ганц нөхэр ололгүй,
Хайран амьдрал хий өнгөрч,
Өрөөлийг нээд г сэтгэлийн цонх,
Өнөө гашуун гуниглалд цантав аа.

Анд нөхөд түмэнтээ хувирч,
Атааг дайсан занаж сүрдүүлнэ.
Чухам үүнд хэн буруугайг,
Шүүж чадалгүй амьдрал өнгөрнэ.

Хэтдээ үнэнч хүний шинж
Хэн ч харсан илхэн атал
Овжин залиар амь зогоогчийг
Олж юунд таниж ядна вэ?!

* * *

Хайр дурлал, янаглал хоёр ангид,
Хүсэл тачаалыг янаглал тайлдаг юм.
Чамаас илүүг хайлгүй чамдаа сэтгэл алдав,
Чин хайрандаа би шатаж, чи минь мэнд үлд дээ.
Сэтгэлшүй минь баяр гэгээ чи мөн бол,
Сэвгүй царайны чинь өнгөнд би баясъя,
Хүн бүхэнд таалагдах үзэсгэлэн гоо ховор,
Хэн хүний сэтгэл булаасан чи юутай ялдам?
Хайрын гал асвал бүх биеийг эзэгнэж
Хачин шаналгаат өвчин лүгээ адил зовооно.
Хамаг бие дагжин чичирч горь тасарваас,
Халуун янаглал түүнийг агшинд илааршүүлнэ.

1890

ХАВАР

Хавар болоход өвлийн хүйтэн эс тогтож,
Хамаг дэлхий хивс адил өнгө засна.
Амьтан адгуус, хүн төрөлхтөн тэмүүлбэл
Аав ээж шиг нарны нүд уясана.

Зуны өнгө нүүдлийн шувуудгай ирнэ.
Зунаар залуус жавхаажин үеийнхэнтэйгээ баясан
Цэнгэнэ.

Булш бунхнаасаа босч ирсэн мэт өвгөд эмгэд
Бусадтайгаа уулзаж уулга дуулга алдана.

Хөдөө, хотынхон хоорондоо ирж очилцож
Хөөр баяр болж тэврэлдэн золгоно.
Аж амьдралаа хөөсэн залууст зав гарч
Анд нөхөдтэйгээ учран сэтгэл сэргээнэ.

Ингэ буйлж, хонь хургалж хотондоо шуугина.
Эрвээхэй нисч, шувууд хөндийгөөр чуулна.
Цэцэг соёолон, модод гөлэглөж ганхана,
Цэлэлзэнхэн мяралзаад гол мөрөн урсана.

Нуурын эргээр хүнгалиу явгалж
Нутгийн хүүхдүүд өндөг эрэн гүйлдэнэ.
Хангал хурдан мориор давхиулан буухад
Хайлгана шувуу нисэж үл амжина.

Агнасан шувуутаа зээглүүлэн ганзагалж ирэхэд
Алиахан бүсгүй өмнөөс нь баяргай угтана.
Эмс охид зунаар гоёж гоодно
Эрээн цэцэгс газрын өнгийг чимэглэнэ.

Хээр талд болжмор жиргэвэл хөндийд гургалдай
Дуулна.

Хэц өндрөөс ууль, хөхөө шувууд хөг нэмнэ.
Тал талаас шинэ бараатай худалдаачин цувна.
Тариачид газраа хагалж үр суулгана.

Мал сургийн нэг нь хоёр толгой болж
Малчид шинэ төлөөр буянаа арвитгана.

Хатан дэлхийг уран тэнгэр чимэглэж
Хайр булаам орчлонд гэрлээ асгана.

Ачтан эх шиг дэлхий ивэлж шимээ хөхүүлэхэд
Асралт эцэг шиг тэнгэр дээрээс өнгийнө.

Дэлгэр зуныг илгээж хар газарт амь оруулсан
Дээд тэнгэрийн ивээлд сүсэглэн итгэнэ.

Хүчээ аван мал таргалж, идээ цагаа арвижин
Хүн амьтны сэтгэл өөдлөн сэргэнэ.

Бул чулуунаас бусад юм цөм уясаж
Хариг нэгнээс бусдынх нь сэтгэл зөөлрөнө.

Бурхан тэнгэрийн хишигийг хачирхан харагад
Хамаг бие нь талбирч, зүрх сэтгэл хайлна.
Эмгэд өвгөд ээх нарыг дагаж хүүхдүүд шуугилдан
Эрдэнэт сүрэг эрх дураар хөрвөж жаргал эдлэнэ.

Холын шувууд тэнгэрээр Дуулалдан прээд
Хун галууд нуурын уснаа гангтар гунгар хийлдэнэ.
Бий нарны эзгүйг од сар орлож
Битүү харанхуй шөнө гялалзалгүй ер яахав

Өглөө болж нар мандахад харин
Өнгө нь буураад шөнийнх шигээ яахан байхав.

Холын хүргэн—Нар, сүйт бүсгүй—Газар
Хоёр биенээ мөрөөдөх сэтгэл нь тийм хүчтэй.
Хүлээсэн нар мандаж ташуухан дэхсөөр
Хүргэн болж ирэхэд сар, од хэдийнээ бараа сураг
тасарна

Урьхан салхи нар, одонд мэдээ хүргэхэд
Улс амьтад баясаж найр цэнгэлд хөөрнө.
Үйтгарын манан хөнжлөө с гсэрч хаяад
Уужим дэлхий мишээж нүүр царай нь гэрэлтэнэ.

Өөр хоорондоо уттал уулзаагүй нар—амрагаа
Өвлийн турш газар дэлхий мэрөөднө.
Сэтгэл нь нарны илчинд бялхсанаас хойно
Сэргэж газар дэлхий тоть шувуу шиг өнгө орно.
Өөдөөс нь эгцэлж харж болдоггүй нарны нүд
Үнсэж, дулааран тогтоод амьд бүхнийг ивээнэ
Үдшийн шар гэгээнээр алтан шаргал майхандаа
Өдрийн аянаас буусан нар яваад орохыг үзлээ бил

Янз янзын юманд сэтгэл шамдуурч болно,
Яруу найргийг харин орхино гэж байх уу.
Эгшиг дуугаа онготдойхон хайлахад
Эмгэг өвчин арилж, дотор ариусдаг юм.

Хангинатал дуулаарай, хоолой минь,
Харласан сэтгэл минь сэргэг!
Өлбөн сувд шиг нулимсаа асгартал уйл,
Өвөр энгэрийг минь тэр дэвтээг!

Бүтэл муутай хэрмэл цагаач
Бүдүүлэг амьтан яаж ойлгох вэ?
Чин зүрхэндээ галтай нэг нь,
Чих тавьж намайг чагнаг!

Дуугий минь хэрэв хэн ч эс сонсвол,
Дуншиж зүрх минь шаналан зовниг!
Дуугарсан үгийг ёсоор болгоовол,
Сэтгэлийн минь шарх сэрг сэдрэг!

Өндрөө авч элин халиг, дуу минь,
Өрдсөн гал болж дүрэлзэн бадраг!
Уйлж, дуулж яваар төгсөхөд,
Удам хойчийнхонд үг үлдэг!

Тохирсон хөөрхий нэгэн учирвал,
Толгойгоо гилжийлгэн бодол бочог!
Хэлсэн үгийг минь ганьж чадвал,
Хэрэгсэх нэг нь түүнийг аваг!

Яаж гайхаад ч гаднаас нь сонсвол,
Ямар тус байх вэ, мянган мунхагг.
Тэгсэнд орвол учрыг тайлах,
Тэгш ухаант нэгэн байсан нь дээр.

Ерөөсөө та нар бодоорой,
Есөн шидийн амьтад байгааг!
Хэрэв эрдэм, ухаангүй бол
Хээрийн зэрлэг амьтинаас ялгаа юун!

Чин зүрхээрээ сонсож эс чадвал
Чихээрээ тэмтрээд юуны нэмэр!
Янз байдлыг чинь үзэн харан байж
Яаж би тэдэнд ханатлаа дуулах юм бэ?

* * *

Хааяа хөөрхий сэтгэл хөөрөлд автаж,
Хайр дурлалыг эрж тэмүүлнэ.
Үүхсан зовлонгийн ундааг гэж
Эмнэг зүрх цовхчино.

Үзсэн зовлон туулсан нас,
Фнэн зүрхний галыг эс унтраана.
Дурлал хайр—амьдралын чимэг нь үнэн,
Дууссанас хойш тэр ч чимээ үл гаргана
Амраг сэтгэлгүй бол амьдрал нэхөр минь,
Амьтны тоонд орсонтой адил юм.
Сайн сайхнаас бусад нь бүгд хоосон,
Гэргий, хүүхэд гэдэг нэхөр чинь юм.
Зүрх нь уян, мэдэж ухаарсан эгэл нэгэн,
Зөв нэхрийг олоогүй цагт амарч эс чадна.
Анд нэхрийг олж чадаагүй бол,
Алдар хүнд, эд баялаг бүгд хоосон.

* * *

Амьдын нас элээж гүйцлээ,
Авснаас өөр юу үлдлээ?
Сэргүй мэргэн үг холдож
Сэргүүн намар сэтгэлд ирлээ.
Үг сонсох миний ардыг
Угаас тэнгэр тэнэг заяажээ.
Өдий насыг элээж дуустал
Өөрийн хүнийг олсонгүй,
Өр зүрхний үнэн үгээ
Өреөлд ойлгуулах гээд чадсангүй.
Дандаа мулгуу тэнэгүүдэд уруулж
Давах давааныхаа оргилд хүрлээ.
Чөдөртэй морь мэт догонцоор
Чөлөөтэй явж үзсэнгүй.

Гунигаар дүүрсэн сэтигэлийнхээ
Гутарлыг нимгэлэх гээд барсангүй.
Баригдаж зовсон сэтгэл минь
Барьц алдарч нис дээ, нис!
Сэтгэл дүүрэн гуниг, зовлон
Сэрэхүйн чөлөөнд юунд үлдэв.
Чихээ дэжиртэл хүмүүс сонсдог,
Чимэгт үг минь нис дээ, нис!
Оюун бодлыг зовлон тэмтэрч
Охыюу сэтгэл гуниг нэрнэ
Үгээ барах гэж зүрх догдолно.
Үй түмэн тэнэгийн дунд
Үнэндээ би ганцаардаж явна.
Мөрөөрөө байж хоол олохгүй
Мугуйд тэнэгийн төлөө зовном.
Худал хэлэхээс өөр авьяасгүй
Хувхай нүүртэнг яалтай билээ?
Төрсөн нутгаасаа салж ядан
Тэнэгийг номхоруулж чадалгүй
Үйл тамтай олныхоо дунд
Үгээ гарздаж суунам би.
Бурхан тэнгэр минь угаас намайг
Бузар улсын дунд илгээжээ.
Гэртээ ганцаардан буг болж
Гэнгэнэн дуулсаар насыг элээв.
Хүн болсон нэр төрөө,
Хүншгүй зант олон түмнээ,
Хэнд итгэж үлдээнэм, би,
Хээвинэг яаж үхнэм, би!
Буй биеэ шаналган зовоовч,
Бүтэн жаргал эдлэхгүй нь.
Бүрэн улсын заяаг бодохул
Бурханы мөрөөр үхэж чадахгүй нь
Авгай эргүүлдэг хэн нэгнийг
Анаж суугаа картай эр шиг
Амарч тайвширах зав олдохгүй
Адгаж тэвдсээр насыг барав,
Адаг сүүлд нь хэн хохиров?

* * *

Залуугийн гал дөл бадарч,
 Зүрхэнд ассан мөч,
 Авьяасын хүлэг довтлоод,
 Аль хэцүү замаар орсон үе.
 Уйтгар гуниг бага, итгэл их,
 Ямар ч зовлонд эс ажирна.
 Өнөө маргаашгүй хүрэхсэн гэж
 Өр зүрхээрээ буяны зүг тэмүүлийн.

Урагшлах замдаа зоригтой орж,
 Ухаанаар арга эвийг нь олно.
 Хуурамч магтаалд тайвшралгүй чи,
 Дулаан царайгаар гялалзаж яваг.
 Зоригондоо эрдэж ташууралгүй,
 Цагийг нь олж дайталц.
 Ховч эмсүүд шиг хэл амаар хөөцөлдөлгүй,
 Хүч чадлаараа дайталцвал зохилтой.

Энэ биений гал дөл буурна,
 Эргэх цагийн аясаар үлдэж хоцрохгүй
 Цоохор замтай эргэх хорвоогийн
 Цоорхой газрыг олж сахь.
 Нүүр нь хүн, сүүл нь дүгваранз,
 Нүгэлт үе чацуутанд хэзээ ч бүү итгэ!
 Хуурмаг нь гаднаа, хар нь дотроо амьтан,
 Хаана ч тааралдаж мэднэ, хөөрхий нэгэнд.

Анддаа хандах ариун журамтай шиг
 Атаат нэгэнд ч адилхан шударга бай!
 Хэтэрхий яарвал харуусалд хүрдэг,
 Хэдийд ч санах тэвчээр тэр юм.
 Цайлган сэтгэлтэнтэй санаа нийлж,
 Сайхан сэтгэлээ дундаа хуваалц.
 Санаа мөхөс, ичгүүргүй овт үгийг
 Голт зүрхэндээ битгий ойртуул.
 Зусар зуйлганы энэ цаг үе,
 Залуу хүнд цэцэг шиг. харагдана.

Өнгө жавхаалаг сонирхолтой амьдрал,
Өр зүрхийт нь читгэлээр бялхаана.

Нэг юм сэтгэлд нь нийцвэл,
Нэхэн бодож түүнийг нягтлахгүй.
Хөөргөж олноор магтахад нь,
Хөөрцөг тэр дуртай байдаг юм.

Хэрэв итгэлцэхийн цаг ирвэл,
Хэн тааралдсанд итгэлээ өгнө.
Олон түмэн итгэмтгий хүнд,
Ов залийг бас нэмж залгуулна.

Нэр нүүрээ барсан зальтан чи,
Намайг мэхлэ л дээ, би эс тооё.
Нэгэнт ганхах иялзрай зэгсхэн
Намайг чи бүү хадаач, ургаж би төлжье.

Чамайг сайн гэж эс тооцвол,
Үгэнд чинь ер итгэх юм үү?
«Яая даа» гэж нүүрээ улайлгавал,
Өөрт чинь тэр гутамшиг биш үү?

Алаг нүдний хар нь,
Ахуй сэтгэлийн гуниг нь,
Амраг хайрын шарх нь,
Аньж, арилж угүй болохгүй.

Қазахын оньч мэргэн нь ч,
Хашир суусан ахмад нь ч,
Чадах уу даа «бий» гэж
Чам шиг хосгүй хөөрхөн хүүхэн.

Үйлъя, үйлъя, уянгалан дуулъя,
Усгал нүдний тосыг шавхая.
Хоорондоо ярих өдөр ирэхэд,
Хонгорттоо хэлэх үг минь бэлэн.

Өр зүрхнээсээ үгээ ундруулъя.
Өрлөг ёсноос эс түрүүлье.
Өөрөө ч мэднэ дээ,
Олон үгээр бүү урсгая.

Нэвт шувт харах юм.
Нэг их ширтээд байхгүй юм.
Үг дуугүй явах мөртлөө чи,
Үнэхээр их сонжих юм.

Хамаг олон мохож шантарна.
Хатуу байж чи чадна.
Шатах шахан би бухимдана.
Шаналгааг минь чи үл хайхарна.

Гэгээгүй гэр байдаггүй.
Гэгээрээгүй ноён байдаггүй.
Сэтгэлдээ галгүй хүнд,
Сэтгэх тархи байдаггүй.

Үнэн хайранд хүндэтгэл байхгүй.
Хүндэтгэл байлаа ч нууцлах юм байдаггүй.
Хүсэл сэтгэлээ би илчилье,
Болбол болог, эсвэл өөрөө л мэдэг.

Өргөн магнай, өтгөн гэзэг нь,
Өсгий цохимоор урт гэдэг нь,

Улаа бадрах царай зүсээ,
Учралг чи минь надад харуулаач.

Хар нүдэн, саран хөмсөг
Харсан хүн сэтгэл ханашгүй.
Балын улаан цэцэг юм, уруул чинь.
Бал тортогтгүй цагаан юм, шүд чинь.

Шулуун хамар, нарийн бэлхүүс,
Шуугин үлээвэл салхинаа түялзам.
Булбарай цагаан бие цогцос,
Бурхны бүтээсэн содон цэцэг.

Сэвгэр чи минь нааш ир,
Сэтгэлээ надад хандуул.
Хайрт чинийхээ царайг, бл
Харж нэг ханая.

Үйтгарлах чинь өвөл, баясах чинь зүн,
Учрахаар баяр хөөр болно.
Чи алтан гургалдай шиг дуулбал,
Чиний дуу намайг эзэмдэнэ.

Маш дотно царай гаргах хирнээ,
Маяглаж битгий дамшигla!
Мал хөрөнгө байтугай толгой юугаа,
Чиний төлөө золиход багадна.

Тансаг анхилам цэцгийн үнэртэй,
Царайны чинь сайхан нар шиг цацаарна.
Таарах болгонд сэтгэл уярч,
Яс минь хуртэл хайлмагтана

Хэлэх өөгүй царайгий чинь,
Хэнээс ч илүү алдрыг чинь,
Дуулах магтахын ёс журмаас
Дутуу байж эс чадна.

Сэтгэл зүрхний цэнгэл нь юм, чи.
Сэрэхуйн хүслүүт хангагч нь юм, чи.
Түмнээс илүү бүтээж заясан,
Тэнгэрийн үзэсгэлэнт хишиг нь юм.

Үзэсгэлэн гэдэг тэнгэрийн буян нь,
Үнэхээр таалсан хүндэтгэл нь,

Үзэмжийн сайханд дурлана гэдэг
Зэн билгийн араншин юм.

Ярьсан хэлсэн үг минь чамд найрсуу ч,
Янаг сэтгэлийн шаналгаа эдэлнэ, би.
Ганцхан удаа чамайг харвал,
Гал шатах зурхэндээ тус болохсон.

Харчуул биднээс дурлагчид олон,
Харин чамд хэн нь таалагдана бэ?
Оволзож догдлоод зүрх минь,
Олигтой ч юм хэлж чадсангүй.

Туялзсан алхаа гишгээгээрээ өдсөн,
Тохуурхалд чинь яаж тэснэ.
Яралзсан инээдээрээ чи,
Яасан их анхаарал татна.

Бүрэг ноомой эр биш болохоор,
Бүх хүн чамд тэмүүлдэг болохоор,
Ай тэнгэр, энэ сэтгэл минь
Амсхийх нэг өдөр ирэх болов уу?

* * *

Залуусын цөс цалгиж сэтгэл нийлэхгүй нь
Цөвүүн цагийн шинж даруй мөн.
Өөр хоорондоо хорон санаалж
Өвөр турийдээ чулуу чихнэ.
Нэр төрөө арилжаанд оруулж
Нэгэн наасаа дэний барна.
Зүтгэл гаргаж хөдөлмөр шүтэхгүй,
Зүгээр сууж, хоног өнгөрөөнө.
Бүтэлгүй юманд гаргуун сурч
Бүгээх үйлсэд тэмүүлэлгүй
Үхэр шиг гэдэс цадсандаа мансуурان
Үг өдөж таарсан бүхэнтэй шөргөөлдөнө.
Наргия үгэнд улам гаарч
Нүдээрээ инээж наасаа элээнэ.
Гэдэгнэж годогнох нь уцаар хүрэм,
Гэрт гахай торойлохтой адил зовлон.

ОНЬСОГО

I

Аллах тэнгэр найман баатар заясан нь,
Аль эртнээс өнөө хүртэл тулалдана.

Ээлж ээлжээр бие биенээ унагаах нь,
Эцэстээ хэн нь ялахад таахад бэрх:

Тайлал:

Намайг үүнийг таавал найрагч гэж хэлээрэй,
Нэрлэж хэлж эс чадваас юуны ухаан байхав.
Өдөр, шөнө, алдар хүнд, эв нэгдэл,
Өвөл, зун, сайн, муу үйлтэн найм бус уу!

II

Хүмүүн төрөлхтөн газар шороог эзэмшиж
Хэзээ ч барахгүй их баялгийг хэрэглэх болов.
Эрдэнэт зуун түмэн эрдэнэс дотроос
Эгнэгт ашигтайг нь нэрлээд аль?

Тайлал: Төмөр.

III

Залуусын чадлыг шалгах цаг энэ,
Сэтгэлийн гэгээтэй нь наашаа ир!
Хүмүүний хорвоод амьд явахад
Хүслийн дээдийг нэрлээд аль?

Тайлал: Сурч мэдэхийн хүслэн.

1892

* * *

Хий манан сааралтан бүрхэж,
Хилэн хантааз чийг даана.
Ханцуйгаар нүдээ шудран арчиж,
Хариугүй залуу эр уйлагнана.
Эмс шиг битгий уйл.
Эр зориг гарган худындаа оч!

Дуу аял,
Гэртээ хары!

Хадам авыг чинь хадам ээж чинь ятгаж,
Харсаар байтал диваажинд суулгаагүй юм.
Хан тэнгэр түүнийг цээрлүүлж
Харуусалд хөтлөн аваачсан юм.
Охин хүнд ямар ч итгэл байдаггүй,
Оч хаялсан гал маргааш нурам болно.

Нүүрээ угаа,
Бүсээ бүсэл!

Ээ халаг, зүрх минь цохилохoo зогс, одоо
 Элэг доог, инээдэм болж мэднэ шуу дээ.
 Харж байна уу, болж уз, одоо
 Хааяагүй итгэх юм алга шуу дээ.

Өнчин хурга эхээ угүйлж,
 Өвсөнд орно, горьдлого тасраад.
 Хөөрхий зүрх маань мөн адил,
 Хөндүүр эмзэг нь, юунаас болоод.

Зоргоор итгэх нөхөр ололгүй,
 Золбин зүрх минь хий тээнэгэлзвэнэ.
 Амьдралдаа нэг ч ханалгүй цохилдх нь,
 Ай хөөрхий юутай тэнүүчлэл билээ?

Хэрэггүй гэж чи надад хэлсэн биш уу,
 Хэсэг болж чи өөрөө салаагүй юу?
 Ээлж дараа ириэ гэж чи бодсонгүй юу,
 Эргээд, одоо би чамд хэрэг болоо юу?

Цахилан тачигнах аянгын гялбаа
 Цайран шаагих аадрын бороо
 Аэгүй олны толгой дээрээс
 Арилан холдох болоогүй юу?
 Ойн гүнд очих болгондоо,
 Олон өнгийн цэцэг түүж
 Оргилуун сэтгэлтэй ирдэгсэн би.
 Одоо тэгтэл цэцэг байтугай
 Орог өвс ч ургахаа болжээ, тэнд.

* * *

Өчигдрийн (одсон) Оспан,
Өмөг түшиг ондоо,
Гэртээ өглөгч, гадаа найртай,
Гар татахгүй,
Бусдад тустай,
Бүхнийг хүртээгч нэгэн байсан шүү.
«Хэрэг болвол ирээд,
Хэрэгтэй юмаа ав аа» гэж хэлэхээс
Хэзээ ч тэр буцдаггүй байлаа.
Бөөн бөөнээр ирцгээж,
Боодол, багцаар нь авцгаав.
Бод доо хэн тэгээд хоосон үлдэв.
Дайсанд зэвсэг,
Нөхөртөө элгэмсэг,
Нүнжигт хүи түүнээс илүү байсан
гэж үү?

Зориг харилгүй,
Зон олонд танигдав.
Хамаг олныг бодогч
Хариуд нь өөрөө шаналтагч
Хайран нэгэн цэцэг
Хөрснөөсөө тасрав.
Тустай, нүнжигтэй
Тийм сайхан эрийг
Толгойтой олон дахин үзэхгүй.
Өнчрөл орхиж
Оспан одлоо.
Одоо хэнд нь аз хурах вэ?
Хулгайд малаа,
Харцад мэдлээ,
Хэн нь алдаж, хэн нь үлдэх вэ?
Амьтан хүн амрыг алдаж,
Алс зорилго утгагүй болов,
Арга билгийг хэн сахих вэ?
Мэргэд цөөрч,
Мэхт олшров.
Ахуй, түмнийг хэн захирах вэ?

卷之三

За би итгээ дээ, итгээ.
Зааж хэлснийг чинь бүрэн дагая.
Цагаан алчуур толгойдоо зангиdsan
санваартан ч
«Санаа муутай байдаг» гэж хэлэхээ
больё

Ариун шударга сэтгэлтэй хүн,
Аяндаа олдоно гэж бас хүлцээ.
Хайлласан, мишээсэн хүн цорын ганц
байвч

Хайлан сүжрэн байж түүнтэй найрсая.

Шарх олсон сэтгэл эдгэрэх,
Тийм жаргал хорвоод байх учиртай.
Сайн хүн гэдэг хоосон уг
Амар олдохоор биш байлгүй

«Үзэж гуулсан амьдрал зүүд юм,
Үнэн ёсоор ирэхдээ л нэг ирнэ» гэж
Итгэж найдсан юм би, «надад итгэ,»
Ингэснээрээ гэтэл би юу хожив доо?

Өнгөрсөн амьдрал, үжирсэн сэтгэл хоёр
Өр зурхийг минь шархлаан тамаллаа.
Өдөргөө бодол эрж мөрий нь мэшгөхдөө
Өрөөлийн юм бүхнийг өөлж тэнэжээ.

Тэдний нэгийг нь ч ололгүй явсаар
Тэндээ сая ухаарч бодол болов.
Юман түрүүнд бүх бнэийг хордуулсан
Юм юм нь хуурамч энэрэлтгүй хорвоо.

Хар толгой дээр чинь элдэв ирэхэд
Хамгаас зайлж толгойго сэгсэрлээ, чи.
Ахиад хэлэх уг байна уу чамд?
Айхтар итгэмтгий юм бол чи, одоо итгэ!

* * *

Халуун, хүйтэн бүхэнд
Хүлцэж, дадсан сэтгэл,
Хүлээсгүй шуналтыг орхиж,
Хагацаж. ширгэх өдөр буй.

Аминч бодлын эндэлд
Алдсанаа тооцож
Ахуу сэтгэл цухалдах
Авралт тийм хором буй.

Хангинан баясахын оронд
Хамаг жаргалыг зүхэж
Хаяж, гээсэн бүхэнд
Харамсах суух ичгүүр бий.

Золт тохиол нимгэрч
Зөн дурдатгал зузаарч
Өрөөлд үг хэлэхээс залхаж
Өр тамирдах мөч буй.

Хэлэх угээ цацаж
Хэт зорилгоо барсан тул
Хүнд хэрэгтэйг ухаарч
Хүлцэж зөвших өдор буй.

1894

* * *

Сээрэл мэдрэмжээр хэн хэндээ
Сэтгэл хайрыг үлгүй ярина.
Зэрвэсхэн харц юм уу, инээмсэглэлээр
Зэрэгцэж хоёул ойлгоно.

Нарны эртэд энэ хэлийг
Нарийн ойлгох эрдэмтэй явжээ.
Зөнгөөр мэдрэх тэр үг нь
Зүрхэнд одоо буухаа болжээ.

* * *

Элдэв юмаар буу чамирх,
Эрдэм авьяастай бол бахарх!
Амьдралын нэгэн тоосго юм, чи
Аль онгорхой газрыг олж өрөгд!
Зуларч зугтаасан ч, нэхэж хөөсөн ч
Зориг ухаанаар л замаа олно.
Хэн шударга байж чадна,
Хүн болгоны сэтгэлд тэр нийцнэ.
Эхний хоёр нь сүүлчийнхгүйгээр,
Эвлэж бүтнэ гэж үгүй.
Өмнө чинь гал, ард чинь мөс
Өөр чи хаашаа гарах юм бэ?
Ашиг завшаан хөөн байж,
Алдрын төлөө буу санаашир!
Алдаагаа чи нуун байж,
Алдар хүртэхийг бүр цээрлэ!
Өөртөө юу байгаагаар бардаж,
Өрөөлөөс давахыг буу санаарж!
Атаа жетөөг нь хөдөлгөж,
Амьдралын зовлонд буу ээрэгд!
Болгоомж, ухаантай явж чадвал,
Бодол үйлс чинь талаар болохгүй.
Багш хүн халшрахгүй байж,
Багачуулд хамаг эрдмээ өгнө.

Бүх биеййг чинь ганц сэйтэл,
Бүлээсгэнэ ч, хөргөнө ч
Энэ орчлонг мартуулсан хүслэн
Элэгдэхийг чи ойлго.

Хамгийн түрүүнд
Хариагүй сэтгэл,
Амьдралын өнгийг
Ажиж нэг болгоо!

«Сайхан цаг үе минь» гэж
Сайрхаж хуучилна.
Удаалгүй «юусан билээ» гэж
Улайж ичинэ.

Тэнэг нэгэн хүүрнэл шиг
Санагдаж мэднэ ээ.
Түүнийгээ бусдад
Хэлэхээс түвэгшээнэ.

Хэлэхийг мэдвэл ул түвэгшээ,
Худхээсээ болж ялатдахгүй.
Мэдэх нэгэн хэлбэл түүнд
Мунхат тэнэг нь хоргодохгүй.

Өчигдрийн Оспан хүү
 Өрөөлийн өмнө нүгэлгүй,
 Бусадад гар таталгүй,
 Буян үйлдсэн удаа бий.
 Хүч агуу, ухаан ихтэй
 Хумуунд тусыг хүргэгч,
 Нөхөртөө түшигтэй,
 Дайсанд халтай,
 Нүглийг үл тэвчигч,
 Үнэний төлөө тэмцэж ,
 Үгээгүйг тэтгэгч,
 Хулгайч, хорон үгтнийг
 Хөрсөөр нь ховхлогч
 Нүүрний буянтай,
 Мал арвантай,
 Нүнжигт нэгэн байв шүү.
 Хулгайн хар мөргүй,
 Хүнд харин тустай,
 Амьтын үр байсан сан.
 Аюулын хар ангал,
 Алтагүй үхэл
 Авав шүү, түүнийг,
 Ай, хөөрхий!...

Хонин бор, хүнлэг ноомой Бакен,
 Хүнд тустай, үнэн сэтгэлтэй Бакен,
 Хулгай, зэлгий ихсэж, х... үрчийлгэж,
 Хамаг бүхний зовлонт болж дээ Бакен!
 Битибай, Лекер, Аталыхт,
 Жанхожа нарын зовлонг хэн үүрнэв?
 Байузак тэднээс дутахааргүй.
 Бүгдээрээ л хүн шиг байсан бус гэж үү?
 Даулыбай охид хүүхнүүдтэй үгээ ололцож
 Дасахуй дор зүс буруулж одно.
 Догдолсон хүслээ тэвчиж, эв зөвөө олохгүй,
 Дэвруүн сэтгэлт хоёр сэтгэл нийлэх гэж үү?
 Инээдээр эхэлсэн үгэ наргианаар өндөрлөж
 Ичгүүр томоогүй насаа элээх зовлон.
 Сэтгэлийн хатат хүмүүн юут бүтээж явнам,
 Сэргж нэг ч атугай ухаарч үз хүү минь!
 Шотхара инээж ирээд, инээдээр буцна.
 Шогт Досахт хүн болж харагдах гэнэ.
 Түмэн олноос надтай маргах хүн бий юу?
 Даулыбай Кыздар хоёрын занг мэдэх үү?
 Айтхожагийн заль мэхэнд хуурагдаж,
 Араас нь гөлөг адил дагаж гүйх үү,
 Ухаангуй нялхамсаг чиний зан,
 Үг сэтгэлийг минь бачимдуулах юм даа!

Хэл минь чамд өчье би,
Хэлэх үгийн утгыг тайл,
Ган үзгийг чанга атгах,
Гар минь чамайг яанам билээ.

Зүрхний үгийг хэлээд аль хэл минь
Зөрүү худлыг бүү дурс.
Өөриймсөг өтөл номтонгууд
Өөлж хэлэхгүйгээр тэвчих гэж үү?

Хайрын нүдээр үсэглэж
Халуун зүрхний цохилтыг чагна.
Уян сэтгэлээр захидал бичив,
Ухаант нүдээр түүнийг унш.

Уян сэтгэлийн тусгалыг
Уншиж үзээд ухаараг.
Үг хулгайлсан гэх юм.
Үгэнд хулгай байх гэж үү,

Хүн хэлээгүй үг бий гэж үү,
Хэн түүнийг батлах юм бэ?
Дэмий мэтгэхийн хэрэг юун,
Дассан угэнд би үнэнч.

Абиш ахыгаа бодохул
Ахуй сэтгэл уярах юм.
Хэтэрч байг даа Магаш минь,
Хэт илүү үг хэнд хэрэгтэй юм бэ?

Золт Аллахын ивээлээр
Тунгааж шүүх хүн олдох шүү,
Золгоjk нэг учирвал
Түмэн их түмнээс.

Хамаг бие сульдахуй дор
Хажуулж сая л унтнам.
Түшиж тулах хоёр багшид
Тууштай үнэнч зүтгэнэм.

Галтай зүрхний цохилтоор
Ганцхан тэнгэрт залбирнам.
Аливаа занг тэвчиж
Аллах тэнгэрт сөгднөм.

Энх тунх та нарын
Эрүүл биетэй золговол
Мөр шулуун явбал
Мөнхийн жаргалд бодном.

Газрын холд хулэгдэж
Ганцаараа шаналнам.
Үулзаад ярих түшиггүй
Үнэндээ би нэн гунигланам.

1895

* * *

Хүүхэд нас чинь өнгөрлөө, чи мэдсэн үү?
Хүрэв үү, тэгтэл, эрийн цээндээ?
Өнгөрлөө бас, залуу нас чинь, тогтоож чи
чадаагүй.

Өвгөн настайгаа учирлаа шүү дээ.

Даруугаасаа болж унтраав уу,
Даруулгагүйгээсээ болж уруудав уу?
Ай золиг чамайг хэн мэдэх вэ?
Аль эсвэл заяагүй чи,

Ботготой ингэ шиг зэлээ сахисаар
Болих ч юм бил үү, бүү мэд дээ.

Амьсгал хураатал хөөрхий минь дээ,
 Амандаа тарни хэллээ дээ.
 Санаж тоолсоор хөөрхий минь
 Сайн гаригт буцлаа даа.
 Газар дэлхий хөмрөх шиг
 Гашуудлын дуу хадлаа даа.
 Олон ахан дүүс бүгдээр
 Орь дуу тавилаа даа.
 Эзэндээ хүрсэн үрээ би
 Эргэж дурсаж уйллаа даа.
 Энхрий төрсөн үрээ би
 Эрж үгүйлээд уйллаа даа.
 Дуутай төрсөн хүү минь ээ
 Дунд зууныг үрсэн дээ.
 Дундрашгүй асгараах нулимын ээ
 Дуулим хорвоогийн үйлсэн дээ.
 Алт шиг төрсөн хүү минь ээ
 Ариун буяны үрсэн дээ.
 Асгараад ирдэг нулимын ээ
 Ахиад учрахгүй зөнсөн дээ.
 Хангарьдын баяцхан үр нь ээ
 Хадаа мөргөөд унаалаа даа.
 Жимс, мөчирт мод нь ээ
 Жигтэй түймэрт өртлөө дөө.
 Тулгандаа эзэнгүй үр минь ээ,
 Тунчиг эрт буцлаа даа.
 Дэлий нь засссан даага нь ээ
 Даанчиг эрт буцлаа даа.
 Боловсорч гүйцээгүй өвс нь ээ,
 Бодоогүй гуниг үлдээлээ дээ.
 Нартай, төгөлтэй хорвоо нь ээ
 Наран хүүгээ үдлээ дээ.
 Үлдээсэн ганц үргүй дээ,
 Үхэлд нь хүүгээ өглөө дөө.
 Үнсэх ач үгүйд нь ээ,
 Үгүйлээд барахгүй нь хүүгээ.
 Цэцээ билэгт үр минь ээ,
 Цэцэг шиг эрт хагдарлаа даа.
 Үнтаад л буцсан хүүгээ дээ
 Үйлаад уйлаад үзэхгүй нь ээ.

Ай даа, Аллах тэнгэр минь,
Аюул зовлонг юунд нөмөргөв.
Халуун залуу насандаа
Хагацлын гуниг юунд би амсав.
Дүүрэн гуниг сэтгэлд байхад
Дуулахгүй яахан суух билээ.
Дотно амрагаа санаж суухад
Үйлахгүй яахан тэсэх билээ.
Сайн амрагаас үүрд хагацаан
Сэтгэл зүрхийг юунд өмрүүлэв.
Абиш лүгээ хүүгээс минь салгаж
Ассан галыг минь үнс болгов.
Алаглан дэлгэрэх цэцэгсийн балыг
Амсаж чадалгүй гансарсаар үлдэв.

Хорин хоёрхон насандаа
Хайрт амрагаасаа хагацлаа даа
Хүйс тасарсан цагаасаа
Хүний жаргалыг үзсэнгүй дээ
Гуниг сэтгэл нөмрөөд ирэхэд
Гэгэлтэн сэтгэл ч хэврэг юм даа.

Харууслын дуу аялан суугаа
Хүүхэн заяа хөөрхий юм даа
Халуун журамт амрагаа
Харахын гунигт автнам.
Хайр булаасан занг нь хөө
Хүсээд хүсээд ч нэмэргүй ээ.
Хагацаах нэгэн заяагаар
Хясаад байдаг хорвоо юм.

Нисээд явсан шувуу шиг
Эргээд буудаггүй тавилан юм.
Гэрэл гэгээ минь унтарч байхад
Гэрэвшин уйлахгүй яалтай билээ.
Хүрээд л ирэхгүй амрагаа би
Хүсэх сэтгэлийг яалтай билээ.
Амраг хүүгээс минь хагацааж
Аяа, тэнгэр минь юунд шаналгана.
Хүний үрийн ухааныг хөөрхий
Хүлээд л өгч дээ тэнгэр минь.

Тогтоож барих ухаан өгсөн
Тайтгарч болдоггүй сэтгэл хөөрхий
Зүүдлээд л сэrsэн зүүд шиггээ
Залгуулж болдоггүй жаргал хөөрхий.
Тэнгэрлэг сэтгэл харанхуй нөмөрч
Тэнгэрийн наар гаражгүй нь хөөрхий.
Тавилан хатуу заяанд төөрч
Тамирдаж суугаа сэтгэл минь хөөрхий.

Ухаант хүү минь явчихаад байхад
Уйлж дуулахгүй яахан суунам.
Уудам орчлон давчуураад байхад
Үй ташуугүй яахан туулнам.
Зовхи дүүрэн нулимстай байхад
Золгүй энэ заяаг яанам.
Үнэнч хүү минь явчихаад байхад
Үхэж чадажгүй юунд суунам.
Гэгээн жаргалд хүрлээ гэж
Гэрэлт тэнгэрт юунд хууртав.

Үгүйрлийн эзэн тэнгэрийг гэж
Үйлийн үр би юунд бодов.
Үхлээс өөр хагацалгүй
Үнэн тэнгэрийг юунд шүтэв.
Гүйгээд гарчих заяагүй
Гүн хорвоод юунд ирэв.
Эрвээхэй жаргалаа хийсгэж
Эгц хавцалд уналаа даа.
Сэтгэлийн нараа үгүйлж
Цэцэг дэрлэж уйллаа даа.
Амьдын жаргалаа тэнгэр минь
Алганаас булааж авлаа даа.

Мөнхийн жаргалаа тэнгэр минь
Мөс болтлоо уйллаа даа.
Хосгүй төрсөн амрагаасаа
Хорвоогийн жамаар хагацаа даа.
Хоёргүй амрагаа үгүйлж
Хоосон чөлөөнд үлдлээ дээ.
Алтан тэнгэрийн мандалд нь
Наран гаражгүй зовоох юм.
Амрагын жаахан сэтгэлд нь
Нулимс тогтохгүй унах юм.

Харуусал даахгүй сэтгэл минь
Хонон өнжин уйлах юм.
Хонгор амраг Абиш минь
Хоногийн уртад харапдах юм.
Хайр хүссэн сэтгэл минь
Хагдран хагдран Өмрөх юм.
Хайртай амраг Абиш минь
Хаашаа нуугдаж одно вэ?
Хоногийн уртад амрагаа
Холоос санах сайхансан.
Хайрын жаргал эдлээд
Хагацал мартах сайхансан.
Тэнгэр нийлүүлсэн амрагаасаа
Төөрөлдөж ганцаар үлдлээ дээ.
Хорголон нулимстай хорвоод
Хоцорч ганцаар уйллаа даа.
Үгүйлээд байгаа амрагийн жаргалыг
Үнэндээ хоёр жил үзсэнгүй.
Зүрхний чимэгт амрагаа би
Зүүдэндээ үзэхээр үлдэж дээ.
Хуудутай энэ хорвоог би
Хуурч ирээгүй юмсан,
Хайрын гүннig эдлэх
Хатуу тавиланд төрж дээ.
Санахын жаргал эдлээд
Санаж суух сайхансан.
Салж өнчирсөн хөөрхий би
Сэтгэлээ юугаар тайлнам бэ?
Тэнгэрийн өгсөн заяаг
Тэрслээд тэрслээд дийлэхгүй нь
Тэмээн жингтэй хорвоод
Тэсэж сууж чадахгүй нь
Амрагаа гэсэн нулимсаа
Астаад асгаад барагчгүй нь.
Абишаа гэсэн сэтгэлээ
Аргадаад аргадаад болихгүй нь.

Үйлсан хүнийг аргадаж
 Учир айлдах ч ёс буй.
 Учирсан хоёр хагацаж
 Уйтгар нэмрөх ч жам буй.
 Улаахан цэцэг чинь хагдарч
 Цагаахан сэтгэл чинь харлав.
 Үй олныг заримдаа ингэж
 Үнэн тэнгэр шалгадаг шүү.
 Ор ганц намайг бус
 Олныг ингэж ганцаардуулдаг.
 Уйтгарт энэ жамыг бодож
 Үйлахаа тувд дээ бэр минь.

Заяа тавилант тэнгэрийг зүхэж
 Зовож шаналаад яанам билээ.
 Хаад ч суудлаа орхидог хорвоод
 Хайллан дуулаад яанам билээ.
 Цагийн жамыг дагаж хүлцээд
 Зуны цэцэг хагдардаг шүү.
 Хутагтыг ч залгидааг энэ хорвоо
 Хүнээс ухаан гүйхгүй шүү.
 Уйтай дуутай хорвоод нь ээ хөө
 Үйлж гутраад яанам билээ.
 Дуудаад дуудаад эргэхгүй хойно
 Дундарт шаналаад яанам билээ.
 Хайллан дууллаа гээд охин минь дээ
 Хувь тавилан эргэхгүй шүү дээ.
 Хүссэнээ болгодог тэнгэр минь дээ
 Хүний эрхэнд орохгүй шүү дээ.

Ай. энхрий Магиш минь дээ,
 Асгартал үйлаад яанам билээ.
 Алагхан дэлхий уудам хойно доо
 Хагацалгүй суух нь үгүй юм даа.
 Хайртай ганц хүү байтугай
 Хамгаар өнгөрдөг хорвоо юм.
 Хайрлсан ганц үр байтугай
 Хаад нь нурдаг хорвоо юм.
 Нисэж одсон шонхор нь ээ хөө
 Эргэж буудаггүй хорвоо юм.
 Цэнхэр тэнгэрийг үүл нь ээ хөө

Нөмрөөд ирдэг хорвоо юү.
Цээжнээс төрсөн урийг нь ээ хөө
Шилээд авдаг хорвоо юм.
Өргөстэй цэцэгтэй тавиланг нь ээ хөө
Өргөж даахгүй хорвоо юм.
Хайлж суугаа аав, ээжийгээ хөө
Хайрлаж нэг аргадаач.
Хайрыг хөлдөөсөн гүнигийг ээ хөө
Хамтарч нэгэн дундлаач.
Хайран ч эрдэнээ алдчихаад
Хамтдаа шаналан суунам бус уу
Ихэмсэг нэгэн сэтгэлээ би
Үүрч даахгүй нугарав шүү.
Түшиг нэгэн тулгуураа би
Тулж үзэлгүй хугалав шүү.
Үр хүүхдээсээ онцолж
Үзтэл чамайг хайрлав шүү.
Үндэст мөчрөө даалгүй
Үгүйрч нэгэн хугарав шүү.
Өрөөлийг хүн гэж бодолгүй
Өндөсхэн заяаг дагав шүү.
Өндөр заяат нэхэлгүй
Өдөр сэтгэлтэй явав шүү.
Үнэн гаслант хорвоог
Үүрч даахгүй уйлав шүү!

Олдохгүй одсон үрээ хөө
 Орилж дуудаад яанам бэ?
 Хагацал гэгч тавиланг ээ хөө,
 Харааж зүхээд яанам бэ?
 Өмөг түшиггээ алдаад ээ хөө
 Өтлөхийн жамд хүлэгдэв дээ.
 Төрөхийг заясан тэнгэр минь ээ хөө
 Төгсөхийг хамтад өгч дээ.
 Буцахын заяаг хүлцээд ээ хөө
 Буян үйлдвэл дээргүй юу?
 Ай, уудам ч хорвоо юм,
 Арслан, шонхорын дүртэй еэ!
 Аплатон, Сократ байтугай,
 Агуу хичит Галиг ч авч дээ!
 Өчүүхэн заяагаа хүлцэж
 Өдөлж, уруудаж явав шүү.
 Хүүгээ авсан хорвоог
 Хүслээр нэгэн хайрлав шүү.
 Муслим сүсэгт бидэндээ
 Мууг тэнгэр минь өгсөнгүй.
 Гайт үйлэнд үйлэнд учирч
 Гав гинжинд оров шүү,
 Будаа, тарна ургуулан
 Буян болсон боолчууд юм.
 Искандар, Төмөр, Чингис нь
 Мусилманы гавьяя юм.
 Бүх казахын үрс нь ээ хөө
 Бутралгүй өдгөө оршиж дээ хөө.
 Тархай Тобыктыг нэгтгэх хөө,
 Түвшин улсаа байгуулж дээ хөө,
 Хүрээ хийд босгож дээ хөө,
 Хүж дэнлүүгээ асааж дээ хөө,
 Түмэн сүргээ өсгөж дээ хөө,
 Тэнгэрт цацал өргөж дээ хөө,
 Төгсөх цаг нь ирж дээ хөө,
 Төгөлдөр цэцэгс хагдарч дээ хөө.
 Эцгийг минь авсан тавилан дээ хөө,
 Эцэж гутраад нэмэргүй дээ хөө.

Зөрүү уг хэлдэгтүй,
 Зорьсон замаасаа буцдагтүй,
 Өрөөлийн тусад
 Өөрийгөө зориулдаг,
 Буруу номтны дунд
 Бузрыг үйлддэгтүй,
 Ном эрдмийн тулд
 Нас биеэ хайрладаггүй.
 Төлөвшиж түшмэд болсон ч
 Түүндээ эрддэггүй,
 Эд юмсад
 Эр биеэ худалддаггүй,
 Үг, ухаанд цэцэн гэвч
 Үнэрхэж илүүг боддоггүй,
 Үнэн хэлсэн хүүхдийн ч
 Үгийг үнэлж чаддат,
 Хэтийн үйлсдээ тууштай,
 Хэзээ хариуг ологч,
 Саная ариутанд
 Сэтгэлээ уудлагч,
 Ахан дүүсээ тэтгэж
 Ачийг илүү бодогч,
 Зөв бус үйлийг
 Зөвхөн дотроо бодож,
 Амраг олон түмний
 Алдрыг я өргөдөгсөн.

Бодол ухаан нь тэгширсэн,
 Буй биеэрээ нэр төр байсан чи.
 Зорьсондоо заавал хурдэг
 Золбоот их зориг байсан чи.
 Залууст залуу, өтөлд өтгөс шиг байж
 Зантай оюунаа шавхаж барагүй
 Авьяасын гүн талбарт
 Асаж буй гал байсан чи.
 Амьдрал, цаг үе давчуу болоод
 Аргагүй чи багтсангүй дээ!

* * *

Авьяасын хүлэг эмээллэж
 Асга хаданд дүүлэв чи.
 Оюуны эрэлд цангаж
 Олон ч оргилд гарав чи.
 Алс хэтэд нүд бэлчээж
 Ашгий нь бас үл хүртэв.
 Нас нэйт үеийнхэндээ
 Номын түрүү эс өгөв.
 Хүүхэд гэж өөрийгөө
 Хууртаж хоосон үл суув.
 Ихэсийн хэргэм хүртлээ ч
 Ихэрхэж ер явсангүй,
 Төлөв олон түмэндээ
 Тууштай үнэнг хэлэхээс
 Ондоог бодлогүй нэгэнсэн.
 Бодлоо даанч гүйцэнгүй.
 Эрж олох тавилан
 Хүү надад заясан даа,
 Бодол мөрөөдлөөрөө би үхэхгүй,
 Би үхээгүй л байна шүү дээ!

Хорин долоон насандаа
Хонтор Абиш нүд анив,
Хэн ингэж хорвоогоос
Хэт залуудаа буцлаа даа?

Эд юмны шуналгүй
Эхнэр хүүдээ буянтайсан.
Хөөрүү сагсуу зангүй
Хувирашгүй үнэн сэтгэлтэйсэн.

Энэхэн нэгэн биеэ
Эрдэмд хайргүй зориулсан,
Орчлонгийн үнэнт таних гэж
Орой үдэшигүй зүтгэсэн.

Ухаан оюуны нүдгүй бол
Удаан насалж юугаа хийнэ?
Сэрэлгүй явж дууссан бол
Сэтгэлийн цонх яахан гийнэ!

Өвчний эмгэг аюулыг
Петербурагт анх мэджээ.
Олон түмнээс нууцалж
Өнөө хүртэл явжээ.

Угтаа бас тоглоом болгож
«Удаан наслахгүй» гэж хэлдэг байж.
Бусдад дараа болохоос эмээж
Битүүхэн тэр шаналдаг байж.

Ахархан насаа уртасгах гэж
Эрдмийн оргилд хайргүй зүтгэж.
Богинохон насаа уртасгах гэж
Бүхнийг үзэхийг хүсэл болгож.

Туркистан, Кавказ, Кырым,
Тайгат Сибирь, Ресей,
Тэр бүгдийг үзэх гэж
Тоотой насаа элээж.

Төгөлдөр суулт од шиг
Төрөөд л буцлаа даа хүү минь,
Үзсэн бүхэн дурсаж
Үгүйлэх юм даа чамайг минь.

Хатан зориг; харишгүй ухаант
Хайран хүүгээсээ хагацлаа даа.
Үхлээс айхгүй тэмцдэг,
Үнэнч хүүгээсээ саллаа даа.

Аав, ээжийнхээ төлөөгүй
Өрийг чинь би яанам даа.
Амжиж бичээд завдаагүй
Андгай тангарагийг чинь яанам даа.

Зуу насалсан өвгөдөөс
Чиний үзсэн илүү юм.
Зовлон үүрсэн төрлүүдээс
Чиний үхэл хүнд юм.

Цагийн төсгөл би байж,
Эхлэл нь чи болов шүү.
Цагаа цагаа дагаад л.
Эцэг, хүү хагацаж шүү!

Гэгээн мөрөөдөл минь чи байж,
Гэсгээлт гунигаа яанам бэ?
Ташуурдаад байх шиг дуслах
Тогтвортгүй нулимсаа яанам бэ?

* * *

Хорвоогоос хальсан эр Абиш
Хүнээс онцгой нэгэнсэн.
Халуун сэтгэлт, хатан биетэй,
Хамгаас содон төрсөнсөн.
Авьяас билэг нь төгөлдөр
Эрдмийн нүйтэй хөвүүнсэн
Алив ядууг үзэхлээр
Амиа ч өгдөг хүүхэдсэн.
Өрөөлд тушаа болдоггүй
Үйлс нь тэпш хөвүүнсэн.
Өрөнд барьцаа болдоггүй
Өглэг буянтай хүүсэн.
Буртаггүй цагаан сэтгэлээ
Бузарлалгүй явсаар буцлаа даа.
Үхлээс харихгүй зоригоо
Үүрч яваад буцлаа даа.
Тавиланг гэтлэх арга алга
Тогтож суух нь дээр юм.
Учрахын заяаг аргадаж
Үйлахгүй суух нь буян юм.

* * *

Хажы хэргэмт эцэгтэй,
Хаадын зоог хишигтэй,
Уран цэцэн билэгтэй,
Ухаанд үлдэх үйлтэй,
Үнэн мөрийн төлөө,
Үнтах нойроо маргсан,
Өглөг буяны төлөө,
Өнөр тэмцэж зүтгэсэн,
Ямбатны эсрэг тэмцсэн,
Ядуугийн зовлонг хугасалсан,
Бүхний төлөө тэмцсээн,
Буянд наасаа зольсон,

Үнэнч хөвгүүн гэлцсэн,
Үлэмж олон хүндэлсэн,
Муруй мөрийг тэгшилсэн,
Мугуйд тэнэгүүдийг зүхсэн,
Казах түмний үнэнч хүү,
Хамаг буяны үүдэл хүү,
Хайр энэрэлийн нүдэн хүү,
Хагацал зовлонгийн наран хүү.
Орчлонг тулж төрсөн хүү,
Орь ганцаар ирсэн хүү,
Дээрэн хишигтэй төрсөн хүү,
Дүүрэн нэртэй буцсан хүү,
Цагаасаа эрт төрсөн хүү,
Цагаасаа турүүн буцсан хүү,
Мэргэдийн заяанд төрсөн хүү,
Мэргэн гэгдэж буцсан хүү,
Төрөх нэгэн тавилан буй,
Төгсөх нэгэн учир буй,
Төрөгсөд учрах тавилан буй,
Төгслөөр салах үйл буй.

* * *

Байгаль юмс мөхдөг ч, хүн үхэхгүй,
Буцаж харин ирэхгүй. инээж наадахгүй.
«Бие» болоод «ююн бодлын» салах утгыг,
Битүүмжилж «үхэл» хэмээн хэн нэрлэв.
Олонхи хүн эд баялаганд биеэ эзэмдүүлж
Осолгүй хөл алдаж тэмтчин унана.
Охь дээдийн сургаал үлдээгч ухаантан
Орчлонгоос бүр халин одсон гэх үү?
Амьдралд хүн бүхэн хоргоддог ч гэлээ,
Ашид мөнх, агшин цагийн ялгааг үл тайлна.
Буруу зэвийн заагийг тэгс эргэцүүлэх аваас,
Буян нүглийг аяңдаа салгаж ухаарна.
Амьддаа бат нөхөрлөж явсан хүмүүс
Буян хутагтын газар очоод адил байхгүй.
Буцахыг үл огоорч, хойт наснаас эмээгчид,
Бурханы ариун номыг хэзээ ч гүйцэд тайлахгүй!

1896

* * *

Борхон үүл сарнин,
Бороо хааяа орно.
Хамаг бие энэлэн
Халуун нуулымс асгарна.

Орсон бороонд сэргэж,
Орчлон дэлхий хүчээ авна.
Үйлсанаас толгой өвдөж,
Үхаан санаа уймарна.

1

* * *

Хайрлах нөхөрлөхийн цагт
Хэн ч байсан тэн болохгүй.
Хажууд бэлэн бай гэхэд
Зуурдын амраг ч хань болохгүй.

Алаг зүрх минь мэднэ,
Амьдралд хүн хатуу сэтгэлтэй.
Янаг сэтгэл үүрдийнх биш бол
Ямарч үнэ цэнэ түүнд байхгүй.

Төрүүлсэн эх эцэг үгүй,
 Төрүүлэхээр үр хүүхэд үгүй.
 Садан төрөл, үе чацуутан,
 Сайн сайхан бүнд үгүй
 Дундуурыг дүүргэх арга байхгүй.
 Дүргиж явах чадал байхгүй.
 Сайхан нойр. хоолны амт харьж,
 Сахал үсэнд хар юм үлдсэнгүй.
 Зөрүү бурууг залууст тохдогтой нь
 Зөрж цухалдаад тус нэмэргүй.
 Зөгөөрөө хүний хот сахисан
 Зөнөг өвгөнд ухаан байхгүй.

Хүлэг морин дэлээрээ гайхуулна.
 Хүн төрөлхтөн сэтгэлээрээ гайхуулна.
 Бусдын дайтай аж төрсөн хүнд
 Буян сайхан, хүүхэд баясгалан.

Бахдаж магтмаар хүүхэд заяадаг юм
 Баяр баходал авчрах уу, чи Рахымшал?
 Залхааж ядраах үр хэрэв заясан бол
 Заяа тэнгэр нь буцааж аваг, түүнийг

Хааны зарц хөөрхөн бусгүй байсан юм гэнэ.

Хамаг байдгаа түүнд золихоос хаан ер буцдаггүй гээ
Алт эрдэнэ, хоргой торго хөдөрсөн хааны

Ар өвөрт нь шивэгчин хүүхнүүд сүүтгэнэдэг гэнэ.

«Бух уртэй, будилаанчийн мундартай» гэгчээр

Булт олны дунд хаан жаргаж явах хооронд

«Өвгөн таалах ногдос юм бол өт хорхойд өгье» гээд
Өндөр хаднаас хүүхэн усны эргүүлэг рүү үсэрчээ.

Хэргэм зэрэг, эд хөрөнгө эмнэг зүрхийг яж тогтоох
Хэн ч байсан үе насны хань ижилдээ тэмүүлэх юм чи
Зөн мөрөөдөл, амьдралын нараан тонгойсон хойно,
Зөнөг толгой түүгээр хэн дутна гэж дээ.

Хөгшин залуу хоёр уг хэлээ олохгүй,
Хөг дан нийллээ ч амраг сэтгэлийг солихгүй.

Хүний нас хорин таваар зөрдөг юм бол,
Хөрөнгийн ихийт өгөөд ч ханьтай байж чадахгүй.

Дур зоргоороо эр залуу эхнэрт дуртай гэнэ,
Дурлалгүй бол залуу бүсгүй зовлонд шаналдаг гэнэ.
Амраг хайр ёсоороо тэнд байдаггүй хойно,
Аргамж чөдрөөр тогтоосон малтай ялгаа юун.

Мөнгө хямгадахгүй хөгшин баян санаандаа хүрнэ.
Мөрөөрөө байвал хөрөнгө гэдэг хэрэг болохгүй. золи
юм чи

Хүний охиныг малаар солиод авлаа ч гэсэн,
Хүсэлтэй залуугаа гэсэн түүнийг яж тогтооно.

«Амраг минь юу болж байна» гэж чадахгүй хөгшин
баяны

Араар нь тавьж нөгөө нэгэнтэй нөхцөн хүүхэн хэцүү
Ороолон эхнэр нь ид шид гаргахад хууртах юм хөөрхөн
Олби зэтгэрийн шавь түүнийг яах вэ, аргагүй.

Эрхэм баян чи угэнд орж сэрэмжтэй бай,
Эхнэрийн ятгалганд автвал сүйрэх ч юун магад.
Идээ будааны элбэг сайхнаар даварна гэвэл,
Их бодож өөрийгөө баягаад дуусах биш үү.

Залийн санаагүй их хатантай эв алдвал,
Залуу багынх нь сэтгэл хөрч дур гутна.
Өрөөсөн нь нялхаараа, өөр нэг нь хагдарсан байхад,
Өвөл зун хоёр өвөртөө яаж багтах юм бэ.

Сүүлээ шарвах шиг зэвүүцлийг нь хөдөлгөж,
Сувээ зоог нь илэн талаад ч нэмэр болохгүй.
Оргилтуун сэтгэл, жилийн газар шиг зйтай байхад,
Ойртуулах гээд зөнөг толгой хүч хүрэхтүй.

* * *

Цагийн цохильт гэдэг зугаа цэнгэл биш ээ,
Цаашилж байгаа амьдралы минь хэмжил юм.
Хором бүхэн амь настай минь тэнцэж
Хоног хугацаа өнгөрвөл дахин хэзээ ч эргэдэггүй юм.

Халуун судсанд минь цагийн цохильт лугшин
Хамаг амьдралыг маань нууцаар хумсалж байгаа юм.
Байгаль ертөнцөд юм бүхэн өөрчлөгдөн хувирч
Байгаа нь мөхөж, байхгүй нь төлжиж орчлонг
нөхдөг юм.

Цаг хугацаа өнгөрч амьдралын хэмжээг заасаар байхад
Цайлган зангаар тайвширч, сэтгэлээ битгий хуураарай!
Орчин тойрноо таньж, ажиглаж сайн ухааралгүйгээр
Олиггүй мую заль хэрэглэх, дэмийн битгий зугацаарай!

Өдруүд уралдан сар болж, сарууд жил болсоор
Өнгөрөн довтлох он жилүүд биднийт нэгэнт өтлүүлжээ.
Тэсгэлгүй хүлээх ертөнцийн цаг хугацаа хуурамч
Тэнгэрлэг үр ач минь залуу насаа хайрлаарай!

1897

* * *

Хайрт минь, би чинийхээ
Амар мэндийг эрье.
Хар уйтгарт дарагдан суугааг минь
Харин чи мэддэг үү, үгүй юу?
Өдрийн бодол шөнийн зүүд болж,
Өр зүрхэндээ сургийг чинь хүлээнэм.
Хэрэв чи хүнийх болсон бод
Хэрхэн би амар тайван явах билээ.
Чин зурх минь тайтгар эдлэх,
Цэнгэл жаргал минь чи шүү дээ.
Чамгүй бол баяр баясталан сарниж,
Цэцэглэх амьдрал дуусна шүү дээ.

* * *

Чийртэй хоосон бахираан,
Чихэнд эвтгүй нь ганц энэ юм гэж үү?
Чадах юмгүй сагсуурах нь
Чамд ер сайхан гэж үү?

Тэнэгүүд хичнээн хэллээ ч
Тэрнээс авах юм байдаггүй.
Дэмий өнгөрүүлсэн амьдралаас
Дэмтэй юм улддэггүй.

Урьхан хавар дэлбээлсэн өнчин яргуй,
 Амьдралын урт богиныг яахин мэдэх билээ.
 Улиантарт атаархан эн зэрэгцэхийг хүсэж,
 Аагим зуныг үзэн галт наранд мансуурна.
 Хяруут намар ирэхэд үндэс нь царцаж,
 Хялганын өндөрт ч хүрээгүй байхад нь зун өнгөрнө
 Хэнзхэн насны араншиг олонтоа би үзлээ
 Хэзээ ч хүрэхгүй юманд гар сунтахын хэрэг юун?
 «Дөнгөнө дөө» гэсээр явтал зориг харьж
 Дөл унтарч, залуу зүсийг атраа дарна.

Олны хөөргөсөн магтаалд битгий итгэ,
 Ов хадгалж дотроо тэд элдвээр зовоодог юм.
 Өөртөө итгэ. Өөрийг чинь авч гараж
 Өөдрөг үйлс, ухаан хоёртоо л итгэ.

Гэнэн зангаар өөрийтгөө битгий зов оо.
 Гэнэ алдаж магтаал хөөгөөд битгий явчих.
 Сайхь олонтой нийлэн өөрөө өөрийгөө мэхэлж
 Самбаганаж зэрэглээ элдэх чинь чамд түстай юу?
 Зовлон гай учирвал сөрж тэмц, бүү сөгдөөрэй.
 Зол жаргал ирвэл битгий амтарх, хувиратгайг
 бүү дагаарай.
 Зүрхэндээ чаньлан бодож, эцсийг нь сайтар тунгаа
 Зүйтэй эрдэнийг тэндээс олох юм шүү, бүү
 хаяарай.

Сайхан дуу, эгшиг аялгуу
 Чихнээ найрсан биеийг эзэмдэнэ.
 Санаа сэтгэлд олныг бодуулах
 Аялгуу дутг над шиг бишнэр.

Өөрөө өөрийгөө мартахын цагт
 Өрлөг дэлхий санаанаас гарна.
 Хүрэн зурх минь намайг дулаацуулж,
 Миний сэтгэл дууг ойлгоно.

Аялгуу дуу сонсоно гэдэг
 Аягамал цөлд ус олохтой адил
 Хэн нэгэн намайг үймүүлсэн ч
 Хэрхэвч би дуунаасаа салахгүй.

Тулгарч явсан зовлон, жаргал.
 Түгүлсан замаа би санаж байна.
 Байхгүй бүхнийг бий болгож,
 Бартаат амьдралын дээл нөмөргөнө.

Сэлгэсэн цагийн сураг чимээг,
 Сэргээж чих минь дуулгах шиг болно.
 Өнгөрсөн амьдралаа дахиин амилуулж
 Өр зурх минь бодлоор дүүрнэ.

Улирсан өдрийн хор хорслыг
 Уусаар би гүн бодолд автана.
 Булт олны хуурмаг шуугианыг
 Буруу зөрүүгүй үнэн гэж бодно.

Байнга хүнийт мэхэлдэг юманд,
 Бас л дахиад итгэж эхэлнэ.
 Ухаанаа гартал аиж зугтажгүй ээ,
 Уугаатгүй хор байна гэж үү, надад?

* * *

Өдрийн араас өдөр ирнэ,
Нэг ч өдөр үл амсхийнэ.
Бодлын араас бодол төрнө,
Салхин хүлгээр ч эс гүйцнэ.

* * *

Энэрэлгүй хорвоо цөлмөж байна, аргалах аргатай юу?
Эр чадал, өнгө зүс чинь урьдын адил хэвээрээ юу?
Ирээдүйдээ итгэл, ардаа харуусал үлдээдэг хуурамч
амьдрал чи,
Ирмүүн хүсэл сэтгэлийг нь нураагаагүй тийм хүн
байх уу?

Амт шимтээ алдахгүй бурам тэж байна уу?
Адгавал хэн ч байраа олохгүй шүү, түр зуур ч гэсэн
Алаг эрээн амьдралын юунд нь шохоорхон
Андуудыг эвдэж, ойрын саданг холдуулдаг шүү, тэр
Ариун зүрхнийх биш бол үгээ бүү хэл,
Аманцар болгож сургачихсан байна шүү, хэл чинь
Хэл ясгүй, уруул задгай болохоор
Хэзээд үнэнийг халхалж хөшиг болно.

Хөндүүр зүрх аяар цохилно
 Хөшиж ядарсан цээжиндээ булгичиж эс чадна,
 Эргэж хөрвөсөн шөнүүдэд амарч ядан байхад н
 Эмнэг халуун цус түрж гарна, түүнийг

Эргүү харанхуй бодлыг уйтгар мэрнэ.
 Эрхлэх, нөхөрлөх хоёрыг ёсноос гадуур үзнэ
 Ухаан ичгүүрээ барж үймэгчидтэй
 Учрах тоолонд хамаг бие зарсхийнэ.

Улирах өдрүүдийг угүйлэн санах зуураа
 Урсаж явaa энэ цагийг өөлж бас хараана.
 Хааяа аз жаргал, амар амталанг хүснэ.
 Хааяа зовлон гунигийг ч бас эрж хайна.

Үйлахаар туниглахын дуугаа хааяа дурсана
 Уруу байсан өдөр хамаг мууг бодно.
 Алдар нэрээ «барах вий» шоолвол тэж бодоод
 Амьтны нүднээс нулимсаа би нууна.

Өнчин зүрх аяар аяархан цохилно,
 Өвчнөө дотроо нууна, мэдэгдэж ядаад,
 Хааяа эмнэг цус бас л дахиад түрнэ.
 Хааяа агшин зуур амсхийнэ, чимээ алдаад

Алс хэтийг зорих чин зориггүй бол,
 Амарлингий бодлыг юугаар сэрээх билээ?
 Ариун ухаанд гэрэл дутаж тэмээн,
 Адгуус амьтдаас хүн яхин ялгарах билээ?

Урам зориг дутах юм бол,
 Ухаарч, эргэцүүлж үл чаднам.
 Замхарч бүдгэрсэн өтөл брдол,
 Заавал өөрийн зүгийг даганам.

Бие цогцсын хүслийг эс хангаваас
 Амар жаргал эдлэх нь үгүй.
 Амталж эдлэх юманд
 Алсдаа хүн цадах нь үгүй.

Ухаан мэдрэмжгүй гэлээ ч
 Адгуус хүртэл махран бодьтой бус уу?
 Үнэнийт тунгаах ухаан дутваас
 Үзэх амьдрал түүнээс ялгаа юун?

Бусдаар алдар нэрээ дуудуулсан хойноо
 Буцаж яхин тэнэг болном?
 Ард түмэн минь мунхаг аваас
 Алсдаа яаж засарнам!

Сульдсан цээжинд намуухан булгилж
Шаналсан зүрх аяар цохилен.

Заримдаа халуун щусанд хахан цацаж
Зүүрмэглэх шөнөөр үл амарна.

Дүлий сэтгэлийт гуниг эзэмдэж
Дотно нөхдийн үг өвчин лүгээ мэдрэгдэнэ
Хамтдаа амьдрах бухнээс горь тасарч
Хамат муу юм шүглэсэнд нь жийрхэнэ

Өнгөрсөн өдруудийг сэрээх атал дахин цангаж
Өнийн үеийг үзэн ядан хараана.

Заримдаа амарлингүй тайванж жаргал бас хүсэж
Зоргоор бус зовлон тунигийт хамтад эдэлнэ.

Хааяа гаслахуй асгартал, уйлмаар болж
Хоног өдөр бухэн өвчин адил бодогдоно.
Үе үехэн түүнийгээ бусдаас нууцалж
Үхээнц үг, хов живнээс уйдаж залхана.

Өвчилсөн зурх аяар зөөлөн цохиlj
Өвчинөө нуух гэж дэмий шанална.

Заримдаа халуун щусаар хахан цацаж
Заримдаа чимээ даран амьсгална.

* * *

Сэтгэл омголон эрх дураар явсан,
Сэргэлэн залуу насаа санаж байна уу?
Учирсан болгоныг нөхөр шиг бодож,
Ухаангүй, гунигтүй мансуурч явжээ, чи.

Хайр, баяр, мал буянаа
Хань нөхдийн дундын юм шиг боддогсон.
Итгэл ойр, сэтгэл цайлтан явахаас
Илүү сайхан юм тэжк юу байна аа.

Хайр баяслаар дүүрэн он жилүүд
Хаашаа арилж одов oo, тэмгэр минь.
Хойно хойноосоо ухарсаар
Холдоод явчихжээ, хөөрхий.

Гүйж мөргө, харааж ерөө,
Гунитлаж сана, угүйлэн дурс,
Мөс чанар, анд нөхөд холдоход
Мөрдөж нэхээд эс түйшнэ.

Нүдэнд минь нулимын аль, уйлъя
Нүнжит тэвчээр аль, хатуужъя
Шаналан эдгээх эм дом аль,
Шарх олсон зүрхээ нөхөж нэг узье.

* * *

Нэгэнтээ гөлөг тэжээж нохой болготол
Хөлийн минь булчинг тэр сэт татав аа.
Нэгэн амьтанд буу барихыг зааж өгтөл
Цэц сураад над руу тэр гох дарав аа.

* * *

Алаг хорвоогийн зовлонгоос болоод
Аттахан зүрх минь далан нөхөөстэй
Юм юмнаас цөхөрсөн сэтгэл
Юу боллоо гэж зүгээр үлдэнэ

Амьтан хүнд тал өгснөөр энэ зурх
Амьддаа ялагдаж зовлон үзнэ
Нэг нь хорлонтой, нөгөө нь заргатай
Түшнэ гэх тулгуур үгүй.

Буурай нас ч дөхөж ирлээ,
Буцаах арга бидэнд байхгүй.
Зовлон үзээгүй нь догшин байдаг,
Зон олонд түүнээс нэмэр байхгүй.

Энэлэл дүүрэн амин зурхийг
Эргүүлж, надад нэг өгөөрэй
Насны гунигт цөхрөөгүй сэтгэлийн
Нандин чанарыг тунгааж бас үзээрэй.

* * *

Янаг дурлал гэж бүү дэмийр,
Ажлаа барахын нэмэр.
Явсан зам руугаа эргэж хар,
Амьдрал гэдэг зүүд зэрэглээ
Үхтэл үнэнч нөхөр гэж байх уу,
Үнэнийг хэлэхэд баяр, гунит цөм хоосон.

* * *

Хүн гэгч баас тээсэн баасны хүүдий
Хэрэв үхвэл бааснаас илүү өмхий ханхална.
Надтай яахан зэрэгцэнэ гэж ихэрхэх юм,
Номгүй тэнэтийн уг л тийм шүү дээ!

Өчитдөрхөн хүүхэд явснаа өнөө их насалж,
Өнө мөнхийн юм гэж үгүйт ялгаж эхэллээ.
Хүмүүнийт хайрлаж, бурхны сургаал сонс.
Хорвоод түүнээс илүү жартал гэж үгүй ээ!

* * *

Гунигтүй ихэмсэг нэгэн сэтгэлээр
Гэгээн тэнгэрт тэмүүлэн өслөө.
Хөрст газрыг бүрхсэн нялх ногоо адил
Хавар хаврын агаарт урган төлжлөө.

Нартад өдгөө олон хоног, олон жил өнгөрч
Намар оройн ургацыг хадах үе ойртжээ.
Хүйтэн бүлээн хоёрын аль алиныг үзэж
Хайр бялхсан сэтгэлийн илч номхорчээ.

Хүнд бодол үүрч шаналсан сэтгэл минь
Харуусал гунигийн тэмдэг нүүрэнд үлдээжээ.
Түрүүгээ даахгүй гулзайх тариан шилбэ адил
Түмэн бодлоо даахгүй иэг л өдөр бөхийнө дөө.

Үхнэ гэж бодоод хэзээ ч хүмүүн одохгүй.
Үхэлгүй мөнхийг сэтгэсээр нас, үйлээ барна
Үнэнийг эрж гүйсээр насаа элээх ўрс минь
Үхэл үрж урхилдагийг мөнхөд санаж яваа.

Хүн төрөлхтөн өнөө ялгаатай ч маргааш бүгд шороо,
Хорвоогийн амьдрал хуурч оргомоор холдож одно.
Үнэндээ маргааш чи хаана очихыг мэдэхгүйгээс хойш,
Үхэхийн төлөө төрснөө эгнэгт бүү март аа!

Гэрэлт тэнгэрт дурлаж өссөн чи,
 Гүнитгүй ихэмсэг сэтгэл өвөрлөн
 Хавартаа нэг дэлгэрч хөрст газрыг чимэглэсэн
 Хангайн өвс хээрийн цэцгэстэй адил ургасан чи

Уйтай дуутай цаг хугацаа олонтаа эргэлдэж
 Ургасныг хадах намрын улирал ойртжээ.
 Хүйтэн халууныг биеэр туулсан болоод ч
 Хөөрхий гэнэн сэтгэлд хат чадал суужээ.

Хүнд бодолдоо дарагдан зовж үзсэн хүн чи
 Хөрслөг царайд чинь aanай бас атираа суужээ.
 Тариан түрүү боловсорч салхин аясаар гудайх шиг
 Тархинд эргэлдэх түмэн бодол чамайг мөн бөхийлгөжээ

Үхнэ гэж үхдэггүй хүмүүн тавилан хийгээд
 Үүйртлээ түүнийг бодох нь сэтгэлд там байх юм.
 Хэр сүүдрээ тусган хагацал ирж нөмөрвэл
 Хорвоогийн үнэнийг хэрхэхээ бодож суух нь зүй аж.

Хэт ирээдүйдээ хүн бүхэн шороо болон хувирдагч
 Хорвоогийн амьдралт тэднийг даанч гэнэгүй хуурах юм
 Өнөө амьд судтаагаа анзаараглгүй явсаар
 Өнжөөд буцах тавиланд нэг наасаа өгөх юм.

1900

* * *

Нарыг цаг хугашаа тулхэж
Тэнгэрийн хөх хязгаарыг давуулна
Хар сүүдэр толгойгоо өргөж
Харах нүднээс алсыг нууна,

Сайн муу хоёрыг тэтэхэд
Санаа сэтгэл минь аяндаа шүүнэ.
Туулсан үеийн амраг сэтгэлтнийт
Тунгааж сая зөв ойлгоно.

Тэнгэрийн «шүтээн» гэж залбираад
Тэрний ид шидийг гайхна.
Өрлөг түүний ивээл нь их гэлээ ч
Өөрт минь хүртэх нь юу ч үтгүй.

Тэр намайг яаж хайрлах вэ.
Тэнэг би түүнтэй суугаагүй юм чинь.
Тэгэхдээ би ганцхан чамайг л
Тэнгэрийн ивээлзээс илүүг гэдэг байсан шүү

Хар сүүдэр уртасаж
Холын бараа бүдгэрнэ.
Шингэх наран улайрч
Тэнгэрийн хаяанд цогшино.

Бүрэг сэтгэл минь тайларч
Бүгээн үдэштэй ярилцана.
Нуд анин бодлогоширч
Нартын гунитыг хуваалцана.

Бүдгэрч арилсан насны мөр
Бүүр түүрхэн бодогдоно.
Алдаж оносон алив үйл
Алганд тодхон харагдана.

Барьж болдоггүй тавилан
Бараан үдэштэй найрсана.
Гашуун амьдрал зурхэнд
Гуиниг нэрж шаналгана.

Төөрч одсон гөлөг шиг
Тэнгэр ширтэн гаславч
Эргэшгүй нэгэн насны
Эцэст нь эеийг дагана.

Тарна цацсан хөрсөнд
Шарилж уртаж зовоох юм.
Хорхойд хортгүй насaa элээх нь
Хорвоогийн нэг жаргал бус уу!

卷之三

Утга төгс хэллийг чинь,
Уран цэцэн угийг чинь
Ухаантан л зөв ойлгоно.

Өрөөл бусдын үгийг
Өрөөн чи ухаарч
Буруу зөвийг нь ялгана.

«Хайлах сэтгэлтэй,
Хайрлах зүрхтэй нөхрийг
Харсангуй» гэж горьдлого ул тасарна.

Үг яриа, үзэл бодлоор
Үнэнч сайн нөхөр
Эрхмээс эрхэм.

卷之三

Навч нь онгосон хуучин горьдлогоор
Найдвар болгож цагийг баржээ, би,
Сэлгэж өнгөрсөн шалдар булдар өдруүд
Сэтгэлийг гижигдэн амар заяа эс үзүүлнэ.

Болж өнгөрсөн сайхан цаг амьдрал биш, зүүд юм.
Бодолд өөрийгөө цатга, сайн сайхныг

мөрөөдлөөсөө эр!

Халуун зүрх, царай зүс, эр чадал байна уу гэж
Хамаг биеэ чи бүртгэж нэг үз!

Эргэж хөрвөсөн олон гэдэг зэрэглээ мөн,
Эв тунжин, унэнийг дааж ул чадна.

Одны амаар явбал сайнаа үзэж чадахгүй,

Ондын агаар ялан салнаа үзүүлэхэд туслахад

Оргилүүп зүрхийн эз дуудлагадаар зорилж ишигэвчилж
эрхэм минь!

* * *

Насан залуудаа бүү баярла,
Наргиан, мансууралд битгий омтгойр!
Нөхөрлөл, дайсагнал хоёрын алиныг ч
Нүд чинь яаж онож харах юм бэ?
Үе тэнгийнхний «сонин юм» гэснийг
«Үг» гэж битгий шүүрч ав.
Ариун цатаанаар олсон зоосыг
Агуулаад л яв, хэтэвчиндээ
Гарт юу байгаагаа хямгадаж хариул,
«Мал хөрөнгө хямд» гэж битгий эрд!
Төрх намбатай явж аж төрлөө бод,
Түйвэргэж яваад бүү энд!
Хамаагүй амьтанд сэтгэлтээ бүү хандуул,
Хар хорын гай учрахгүй, сэрэмжтэйд.
Тавь гарсан бид хүртэл
Таньж, хүнийг чадсан гэж үү?
Улайм цайм ховдог шуналтан
Уралдаан зодоон, үймээн түйвээн...
Хэрэлдэж зодолдохыг нь харахгүй байна уу,
Хэл амаа долоолон идэж цөлмөгчид минь!

* * *

Ичиж зовох гэгч сэтгэлийн юм шүү,
Итгэлгүй шуналд амьдралаа бүү алд,
Үнэнч хань, үерхэх нөхөргүй ч
Үүрдийн гунигт автаж битгий зов
Үйдааж, цөхрөөж; урам сэргээж, гуниг шатааж,
Угтаа энэ амьдрал хүмүүн заяагаар тоглох юм.
Нэр нүүрээ бодохын оронд хүн чанараа эвдэж,
Нэхэлгүй нэгэн насандаа хоног өдөр элээх юм.
Төрөл төрөгсөд, наиз нөхөд биесээ хуурсаар
Тоолж барамгүй дайсан үнэндээ олширлоо.
Хайлдаж гэвч хоосон, хайлдтувал зүхэх,
Хачин энэ амьдралд юунд би уягдана вэ?
Нас ахисан ч хүн зэн чэвээрээ,
Нартад үзсэн зүйл бүхэнд тэмүүлнэм.
Аав нь хүүгээ загнах нь зохих авч,
Ааваа хүү нь захирвал аятай харагдах уу?

* * *

Уран тоть шувуу шиг эрвээхэй
Уулын амаар зун дэлгэрнэ.
Амьд цэцэг хагдарч унахад
Алат эрвээхэй хатаж цөөрнө.

Хүн төрөлхтөнд юу хэрэгтэй,
Хайрлах, сэрэх, аж төрөхийг бодно.
Хэрэг зоригтоо шамдан гүйлдэнэ.
Хэрсүү бодож үгээ хэлэлцэнэ.

Цаг үед хэн хүнгүй чирэгдэнэ.
Цаг үе хэнд ч үл захирагдана.
Цаг үетэй мую хүн нөхцөнө.
Цаг үе түүнийг элдэнэ.

* * *

Зүрх гэгч-далай, жаргал гэгч-эрдэнийн чулуу
Зол жаргал барагдвал амьдрахын хэрэг юу?
Зүрх нэгэнт халуун илчээ алдваас,
Зөнт хүмүүний хамаг хүсэл унтарна.

Үерхэл, нөхөрлөл, атаа, хорсол... бүхэн зүрхний үйл,
Ухаан бодол, ичих сэтгэл түүнийг манана.
Нэр бүтэн, ухаан төгс, хүнлэг байваас,
Нартын хоногууд аяндаа жаргалд булхана.

Нас ахих тутам биеийн илч харьж,
Илч харьсан сэтгэл олигтой үйл бүтээхгүй,
Ажил үйл бүтээхээс сургаал хэлэх нь ихсэж,
Алхаа гишгээ нь ахихгүй цагийн эрхэнд сөхөрнө.

Аллах ч үнэн, мэргэдийн хэлсэн сургаал ч үнэн
 Алтан усэгт үнэн үг хуудуу болох гэж ер үгүй,
 Анирт ертөнцөд аллахаас олон ном илгээсний,
 Андуу, мадаггүй дөрөв нь мөн чанарыг илтгэдэг,
 «Аман тү»-г уншаагүй хүн гэж бий юу?
 «Уактубихи» таринд итгэдэггүй хэн байнам,
 Аллах хэзээ ч хувирахгүй атал хүн мөнх бус,
 Амьдрах, үхэхийн зарлигийт ямар ч мэргэд дагана.
 Цаг үе, үйл бүтээл, зан төрх заавал хувирна.
 Цаг цагийг дагаж ертөнцөд зөнч мэргэд мэндэлнэ.
 Тарни номыг тайлах жаяг сургаал өөрчлөгдөвч
 Татриф аллах хэзээ ч хүн шиг хувирахгүй,
 Тэнэг мунхагууд хувиравч аллахын сэтгэл хувирахи
 «Ахли китап» энэ үгийг худал гэж маргахгүй,
 Хүмүүн харин шуналт хийгээд хувна хичээдгээс болж
 Хуудуу үг хэлж, хоосон юманд хууртана.
 Хайр ивээллээр хүн таныг төрүүлснийг бодож,
 Хариу сэтгэл гаргаж аллахыг үнэн шүтэгтүн,
 Өөрийн төрсөн хүн лүгээ хүн төрөлхтөнг хайрлаж
 Өглөгч их үнэний ариун мөрийг дагагтун.
 Эл гурван хайраар тарни ном мандан гийж,
 Эгээрэл, ухаарал бүрдэх нь отоос хувирахгүй тахих
 Тунгалаг тэгээн сэтгэлээр үгсийн утгыг таниж,
 Тэр бүхнийхээ хариуд үнэн мөрд зүтгэгтүн,
 Шашин шүтлэг, тагат ном ариун сэтгэлд оршиж,
 Зөв буянтай сэтгэл тэгч тастих өдрийг олдог юм.
 Эл бүхнээ харшлах гурван зүйл үнэний номд айлдах
 Эрээгүй зан, шунахай сэтгэл, мунхаг бодол гэсэн буй
 Руза, намаз, зекет, хаж-маргашгүй уйл,
 Зөвтэй сэтгэл гаргаж орхилгүй бүгдийг бүтээ,
 Эхний гурван ёсыг дагахгүй, эл дөрвийг бодвоос
 Эцэстээ тийм сэтгэлээс сайн үр гараахгүй ээ.
 Толгой, хүзүү мөр, бүхнээс өндөрт заяжээ.
 Тунгааж сайтар бодохул мөч бүхэн учиртай,
 Үйлс бүтээл ямагт эхлэлд хамааралтайг санахуй,
 Үнэн шүтээн гэгч хайраас эхэлдэг нь утгатай.
 Номтой мэргэд «гибадат»-аас үг эхлэн айлдаж,
 «Хуснизан» шүтээнийг үнэн сэтгэлээр биширдэг.

Эгээрэл, ариусалын утгыг гүйцэд ухаарч үл чадваас
Этгээд маяг үзүүлсэнээс оюун төгс болж сэтгэлийн
буртаг арилахгүй.

Аллах ариун, пайгамбар үнэн сэтгэж чадсан хүнд
Му мин болох гэвэл сэтгэл өгч үнэн итгэ.
Куран үнэн, аллахын үг үг юм шүү,
Та уйлиин хүрэхэд хүмүүний ухаан мөхөсдөнө.
Ариун сэтгэлийг дагах нь үнэн номын ёс
Аллах, пайгандарын заасан ариун мөрийг даганам,
Ашиг хонжоо, муунхаг бодол, эрээгүй зан-чөтгөрийн үйл,
Алив шуналыг түвдвэл тус болох бус уу?
Му мин болох гэвэл шүтээн бишрэлийг сахиж,
Хүмүүн боолд аллах тэнгэр ивээл хайрладгыг бүү март.
Үнэн итгэж, чин сэтгэлээс буян үйлдэхийг бодож,
Мунафих нэгэн зангаас ямагт сээрэмжил,
Аллах тэнгэр дотоод бодлыг мэдэрч байдал юм шүү!
Андуу буруу сэтгэлээр өрөөлд битгий муу сана.
Хувирашгүй үнэнд тэрсэлж му мин болох гэж үгүй,
Хүн болж төрснөөс хойш энэ л ёсыг дага!

1903

* * *

Өөрөө би чамд мэндийн захидал бичлээ,
Өгнө тэсэн хулэг чинь хаа байна вэ?
Хүний нүүр харвал яаж бултах юм бэ,
Хүйсбай чи хуурамч гэгдэх хэнд хэрэгтэй юм бэ?

ОН ТАВИГДААГҮЙ ШУЛГҮҮД

* * *

Хан тэнгэрт нар сарны гэрэл ээлжлэвч
Харанхуй сэтгэл минь юунд ч эс гялбана.
Надаас илүү амрат чамд олдох авч
Нарны дор чам шиг ханьтай би үл учирна,
Журамт гэргий хувиран хэлсэн үтнээсээ буссан ч
Золгүй би хэвээр санан санан бэтгэрнэ.
Доромж басамжлалд нь цөхөрсөн ч
Дотнын түүндээ буруу санаж эс чадна.

* * *

Та нар намайг дууриах гэж
Таахалзаж алхахын нэмэргүй.
Хоёр нудээ эргэлдүүлж,
Хоосон харах юм, тэнгэр өөд.
Сурсан эрдмээс бусад нь
Цугаараа гай, даврагчдад.
Тийм хүн удахгүй
Тэрслэн тосогчидтой учирна

* * *

Гэмтэй зэмтэйгээ ухааран,
Гэгээн бодолд сэтгэл автлаа.
Тал талаас нь өөрийгөө харж,
Та хэн бэ гэдгээ ажлаа.
Харин тэгтэл өөртөө таарсангүй,
Хаана багтана даа, би чинь одоо.
Ханилж явaa мuu юмнаасаа
Хагацаж яаж сална даа.

Алдаа оноогоо тооцоход
Астын чулуунаас бата биш юм.
Зүрх юугаа шинжихэд

Зүүний сувэгч төдий ч ариунгүй юм.
Аваад хаячих гэхлээр
Агууд байгаа шавар биш.
Юм бүхэн наадаас боллоо,

Юутай ч бурханд нүгэл байхгүй.

Ухаангүй явсны зовлонгоор
Учир бүхнийг олох гэж шохоорхов.

Цэвэр ариун зүрхний

Цэх журмыг алдав.

Сургамж мэдлэг хоёроос

Суларч, горьдлого тасрав.

Сувдаг, заль хоёрыг

Сувд адил хэлхэв.

Атгаалжин мангас шиг ховдоглон

Айж ичихээ больжээ.

Хуурах мэхлэх хоёрыг

Харцага шонхор шиг сурчээ.

«Та л мэднэ шүү» гэсэндээ

Таатай нь аргагүй онгирчээ.

Сайрхахгүй юманд сайрхаад,

Сэргэлэнд өөрийгөө тооцжээ.

ХҮҮХЭД НАС

Санашгүй явдалтай учирчээ.
Саруулаа нулимсаа дүүргэжээ.
Харахаа ч, сонсохoo ч гүйцээжээ.
Хамгийг таниад ухаарчээ.
Хайрлаж ч, хайрлуулж ч явжээ.
Хамгаас яараад харамсчээ.
Эрхлүүлж өсгөсөн ээжийн
Эсгэсэн оёсныг өмсчээ.
Үймэж ч, уйлж ч явжээ.
Үтийн цэц хаялцжээ.
Түүнээс цаашаа болохоор,
Түмнийг тоохоо болжээ.
Танхил авирлах үлджээ.
Танхай явахад дурлажээ.
Тоглоом шуугианд хөл алдаж,
Чөмгөө дундартал туржээ.
Өтлөхгүй юм шиг бодож,
Өөдгүй амьтныг дагажээ.
Хэнэтгүй ингэж явтал
Хэдийнээ хөгшин нас уулзжээ.

ХАРЦАГА БОЛЖМОР ХОЁР

Үүрээр нэгэн харцага
Уулыг ташин нисэв ээ.
Ховдот тэр үүрнээсээ
Хоол эрж тийн гарчээ.
Жижиг бутнаас нэг болжмор
Жиргэн чарлаад ухасхийжээ.
Доор юм нугас галуунаас гэлгүй
Догшин харцага түүнийг шүүрчээ.
Сандарсан болжморыг тийнхүү
Савхийх завдалгүй барьжээ.
Өдөсхэн ч байсан идэхээр
Үүрэндээ аваачиж буужээ.
АЗгүй болжмор тэгэхэд
Люулт харцаганд өчсөн нь:
— Амь алдах минь юу ч биш,
Асгаруулсан хөлс тань л талаар боллоо доо
Гавьж таныг цатгахгүй шүү дээ,
Галуу нугас биш болохоор би.
Өл залтхад тань ямар хоол гэх вэ.
Өрийн чинь зоригт бол харин алдар юм.
Цагаан ястай хаантан танд
Цагтаан аваагүй магтаал ховор.
Харц ядуусын хоолыг идсэн ч
Хаантанд яж зоог болох вэ.
Таны зүрхэнд тустай байгаа бол
Тасдан идиэ биз наимайт, та!
Хэнз бие, зүс царай минь энэ,
Хэрэг болох цэцэгхэн амь мянъ энэ.
Хоол эрсэнээсээ болж эзэнтэн та
Хуруу хумсаа дэмийхэн бузарлажээ...
Болжморын үг үнэн юм.
Бодоожоор тэр идсэн ч цадахгүй юм.
Эр зоригоор тэгж барьсан гэж
Эрхэм алдрыг авахгүй юм.
Нэн ихээр хүч дийлж,
Нэг айлгавал болихгүй юм.
Харцага тэгээд барьц алдаж,
Хариугүй суллажээ, бялзуухайт.
Үнэн үгийт онож хэлбэл
Үхлээс ч аварч чаддаг байна.

* * *

Тэнэг хүн номтныг үл дийлнэ,
Төөрөг заяаг хүмүүн үл дийлнэ,
Сав шимийн ертөнцийг амьтан үл дийлнэ,
Цагийн хатуу аясыг яргуй үл дийлнэ.

* * *

Тария тарьсан хүн нэг хожно,
Төгс эрдэмт хүн нэг хожно,
Түшмэд суудлаа даахгүй нэг унана,
Тарих үргүй зүтгэл эцэстээ нэг хоосорно

ИСКАНДЕР

(Найраглал)

Филипп хааны хүү Искандер гэгч байжээ,
Алдар нэрэнд нэн дуртай нэгэн ажээ,
Эргэх орчлонд тэгтэл Искандерийг мэдэх билүү?
Энгийн үйлсийг тэр залгамжиж чадсан уу?

Идэр хорин нэгэн насандаа тэр
Эцэг Филиппийн ширээ залгамжиж хаан суужээ.
Төрсөн газар ус нь түүнд бага санаагдаж,
Хөршийн нутаг руу тэр санаархах болжээ.

Ов мэхээр цэрэг зэвсэг тэр цуглуулж
Ойр хавийн гүрэн улс руу довтолжээ.
Хамаг олныг түйвээн цус урсгаж,
Хаадыг нь яргалж, орон хотыг нь эзэлжээ.

Гэмгүй номхон түмнийг ч хөнөөж,
Гол мөрний усиг цусаар булингартуулжээ.
Өөдгүй энэ цуст хэргийнх нь хар мөр
Өргөн орчлонд арилахааргуй тод үлджээ.

Дийлдэшгүй бүхнийг тэр өвдөг сөхрүүлж,
Дэлхийд өөрийн нутаг усаа өргөтгөсөн ч
Дэндүү их шунал нь улам бүр бадарч,
Дэлгэр орчлонг бүхэлд нь эзлэхээр санаархжээ.

Түүний хомхой сэргэл үнэхээр ханасангүй,
Төдөлгүй бүхий л орчлон ч бага санагджээ.
Бялдуучид харин түүнийг хөөргөн магтаж,
«Бүх хаадын их хаан Искандер» гэж өргөмжилжээ.

Нэлэнхүй орчлонг тэр бүхэлд нь захирч,
Нэр алдар нь лазар сайгүй түгэн дуурсжээ.
Үй түмэн цэрэг элсүүлж, зэвсэг агсаж,
Улс гүрнийг аянта мэт ниргэж явжээ.

Эрэлхэг түүний өмнө үнэндээ хэн ч гарсангүй
Эзлэгдсэн ард түмэн өвдөг сөхрөн боолчлогджээ.
Эзэмшлийн газар нутаг нь аанай бага санатдаж,
Эгээ л бас сэтгэл нь ханасантгүй ажээ.

Явсаар тэр нэгэнтээ хүнгүй цөлд төөрөлдөж,
Ядарч цуцахын зовлонг биеэр амсжээ.
Балга ч усгүй цацгаж, халуунд шатаж,
Байж суух газаргүй болж туйлджээ.

Ус хүссэн хүмүүс үзтэл тэнхэл доройтож,
Хувь заяагүй тэдэнд үхэхээс өөр замгүй болжээ.
Ундаар гачигдсан хаан ч бас тэвчээр алдарч,
Хамаг олноо өөрөө хүйс тэмтрэхээр завдджээ.

Үнаж явсан морь нь тэгтэл эцэн сөхөрч
Барьж явсан жолоогоо ч Искандер алджээ.
Нөхөр нь болсон хүлгийнхээ толгой илэн босоход
Нэгэн гэрэл цацуулсан зүйл нүдэнд нь харагджээ
Гэрэл цацарсан тэр газар луу хүрч очиход
Шүд хата ташсан устай горхи мэлмэрэн байжээ
Искандер ухаан жолоогүй сөхрөн унаж
Ид шидийн рашаан уснаас ханатлаа уужээ.

Хатсан загасны мах голын усанд хийж,
Шороо тоосы нь угаатаад аль гэж хаан тушаажээ.
Харсаар байтал загасны мах өнгө орж,
Хачин сайхан үнэр амттай болжээ.

Искандер албатаа дуудаан: «Энэ юун ус вэ,
Ийм ус би хэзээ ч үзээгүй юм байна

Ханатлаа та нар ууцлаа, нүүр гараа угаацгаа,
Харин энэ усны эх ундаргыг заавал олно шүү!

Яриангуй энд нэг баян бурд байна,
Ямарч байсан түүнийг олж эзэмших болно.
Хамат баялагий нь хүртэж шутаг руугаа буцна
Хатан зоригоор алдар нэрээ мандуулна» гэжээ.

Цангасан хүн, морь уснаас ханатлаа ууж,
Цааш нь замдаа нийлж олон өхөног явжээ.
Хэнгэрэг дэлдэн, хуяг дуулгаа гялалзуулан
Тэнгэр тултал бүрээн дуу хадаан байжээ.

Явж явж өндөр¹ сүрлэг ууланд хүрэхэд
Ян сарьдгийн хавцал фуу горхи шурган оджээ.
Тэгтэл гэнэт нүсэр том алтан хаалга шижиртэн.
Тэнгэрийн үүлэнд шүргэн алдан харагджээ.

Алтан хаалгыг Искандер хүчтэй нүдэхэд,
Алс тэртээ дуу нь цуурailan холджээ.
Чийрэг гар нь өөрийн эрхгүй сульдаж,
Чилтэр шулуун хаалган ханаанд боогджээ.

Ямар ч саад тотгор гэгчийг мэддэггүй Искандер
Ямагт тулаанд ялалт байгуулдаг их хаан
Өөрийгөө бүхнээс хүчтэйд тооцдог эр зоригтон
Өнөө харин арга нь барагдаж мухарджээ.

Барьсан илдээ өндөр өргөн байж,
Байдаг чадлаараа хаалгыг дахин нүдджээ.
Хана болсон хаалганы алтан бие нь доргитол
— Хаалгаа нээ!? гэж бүхнийг цочтол хашгирчээ.
Хаалганы цаана тэгтэл хөлийн чимээ гарч
Харваас манаач бололтой нэг хүн иржээ.
— Хан хурмастад нэвтрэх үүд энэ юм шүү,
Харин түүнийг онгойлгох эрх надад байхгүй гэжээ.

— Би ялтуулсан их хаан Искандер гэгч байна,
Бүхий л орчлонг байлдан дагуулсан билээ.
Хаалгаа даруй онгойлго, хариу надад өг.
Хаана ч, хэзээ ч ийм саадтай учирч байгаагүй!

— Хүчтэй чадалтай гэж бүү сайрх,
Хүч чадал чинь энд хязгаарлагдах болно,
Чи дэндуу шунаг, атаархуу, орчлон чамд бага,
Чи дахин цааш явна гэж бүү горьд!

— Наашаа би шууд, шулуухан явж ирээгүй,
Надад үнэцааш явах газар үзэх юмгүй бол,
Үнэхээр энэ орчлонгийн хязгаар, төгсгөл юм бол,
Үүнийг тумэндээ гэрчлэх нэг юм өг! гэжээ.

Хaalганы цаанаас тэгтэл нэг боодлой юм,
Харин болгож шидэж, үүнийг та авах ёстой,
Доторхи зүйлийг нь сайтар болгоож үзвэл,
Даруй та бүхний учрыг олох ёстой гэжээ

Боодлой юмыг Искандер баярлан авч
Болгоомжтой гэгч олны нүдэн дээр задалжээ.
Алчуур дотроос тэгтэл хөсрий яс гарахад
Алмайран гайхаж, уур омог нь улам шатжээ.

Өгсөн бэлгийн учрыг олж ядеан ч

— Өөрий минь ердөө энэ үү гэж зандрэн,

Өгөр ясиг холоо тэгч нь шидчихээд

— Өрлөг их жанжныг битгий доромжил гэжээ

Мэргэдийн их мэргэн Аристотель тэгтэл
Мөнөөх шидсэн ясиг болгоон авч,

— Энэ жирийн яс биш шүү, та харнаа гэж
Эрхэм хаантанд ёктойхон гэгч хэлжээ.

Ухаантны их ухаантан Аристотелийг тэр үед
Анхаарч сонсохгүй хүн байсан билүү?

— Жигнүүрийн тавганд алт, яс хоёрыг хийе.
Аль нь хүнд болохыг одоо үзэцгээс гэжээ.

Хаантан, ухаантны үгийг сонсон дуугүй болжээ.

Харваас жигнүүрийн хоёр таваг тэнциүүхэн байжээ.
Нэг тавганд нь олзолсон бух алт эрдэнэс тавьжээ.
Нөгөөд нь хөсрий яс хийхэд алт өд шиг өргөгджээ

Үүнийг харсан Искандер хаан мэл гайхаж,
Үүрч зүүсэн зэвсэг, хуяг дуулгаа алтан дээр

нэмжээ

Хөсрий яс тэгтэл улам доош жин дарж,
Хөх төмөр, алт эрдэнэсээс илүү хүндэрчээ.

Аристотель мэргэнд их хаантан хандаж:

— Алт эрдэнэс би үзтэл бага цуглувулжээ
Хөсрий ясны жинд хүрэхгүй байна бус уу
Хэрхэйг та болгоож, уг хэлнэ үү гэжээ.

Аристотель тэгтэл газраас атга шороо авч,
Хөсрий ястай тавганд цацаж орхижээ.

Харсаар ястай таваг өргөгдөж,
Хамаг алт, эрдэнэс аргагүй л жин даржээ.

Үүнийг харсан Искандер бүр алтайран гайхаж,
Үг хэлгүй юм шиг хэсэг дуугүй байснаа:
— Энэ гайхамшигт нууц үндад нэг л ойлгомжгүй,
Эрхэм мэргэн та учры нь тайлж өгнө үү гэжээ
— Энэ бол хүний нудний ухархайн яс шүү,
Эрдэнэс алтанд шунасан нуд ханана гэж үү,
Өлөн нуд олзны ихэд ханахгүй бол,
Уксэн хойною элсээр дүүрч сая ханана.

Өлөн нүдтэнд орчлон хэзээ ч багадна,
Өөрөө бүхнийг захирсан ч сэтгэл цадахгүй,
Харин тэд үхэж нуд аньсан цагт нь,
Хамаг эрдэнэс атга элснээс ч үнэгүй

Эзэнтэн минь болгоож хайрла, аман үт нэмье
Эрдэнийн алтан босгы минь та цавах эрхгүй,
Туйлын ихээр харамсан халаглалаа ч гэсэн
Өөрийн тань хүрэх хязгаар энд дууслаа гэжээ.

Их ухаантны үгийг дуугүй сонссон хаан,
«Ингэхэд үйлдсэн хэрэг минь бузар аж,
тэнгэр гэсгээх» гээд

Ирсэн замдаа эргэн орж наманчлан оджээ,
Их цэрэг нь ч хойноос нь жолоогоо эргүүлжээ.

Бяцхан тууж үлгэр минь үүгээр дууслаа
Багахан ч гэсэн сургаал та авах болтугай
Алдар хүндэд шунаж сэтгэлээ бүү сэвтээ
Атгаг шунахай сэтгэлийг юугаар ч цатгахгүй

Амьдрал гэдэг богинохи, нэг мэдэхэд өнгөрнө
Аз жаргалая зүдэрч бүтээгээгүй бол бүү сайрх,
Санаа сэтгэлээр ядуурч, нэр төрөө гутаавал
Сайн үйлс өндер гавьяа чинь үнэгүй

Хэн чэгэн чамайг тэнгэр тултал магтсан ч
Хэнхдэгээ дэлдэн, хамраа сөхөх хэрэггүй
Чамайг явсан хойно, араас чинь инээлдэж,
Чааваас даа, тэнэгээс салж амарлаа гэцгээнэ.

Тэнэгүүд чамайг мандуулж өргөмжиллөө ч,
Өөрийнхөө хүч чадлыг өөрөө мэдэж яв,
Тэнүүн орчлонд сайн үйлс бүтээсэн бол,
Өргөн олонд худтэхдээ л нэг хүртэнэ.

Хоёр. СУРГААЛ ҮГСИЙН АЙМАГ

НЭГ ДЭХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Өдий насалтлаа сайн юм их үзсэн үү, эсвэл муу юм их үзсэн үү, юутай ч атугай насыхаа ихэнхийг өнгөрөөж, нэлээд амьдрал туллаа. Уцаарлан ундууцаж, маргаж мэтгэсээр хэцүү бүхнийг даван туллаа. Насны ихэнхийг элээсэн авч өдгөө хүртэл хийж ирсэн маань эцэс төгсгөл, зангилаа учиггүй хосон зүйл болохыг саял ухаарлаа. Алжааж сульдсанaa мэдэрч, амьдралынхаа улдсан очуухэн хэсгийг юунд зориулж, ямар тустай үйл бүтээхийг эргэцүүлэн тунгаанам. Нэг бол хүн бурт нэн тустай ариун үйл бүтээхийг хүсэх авч, тийм үйл чухамдаа юу болохыг бас үл олоном.

Ард олиыг захирах уу? Үгүй, ард олонд хариуллага, маллагаа хэрэггүй. Толгойдоо булуу хураахыг хүссэн хүн, эсвэл залуу халуун насын илч аагинд дотоод сэтгэл нь буцлан буй хүн л тийм юм хийнэ үү гэхээс биш отол маань мэтийн тэнхэл хүрэхгүй, тийм бэрх үйлээс бурхан тэнгэр холдуулж хайрлаг!

Мал маллах уу? Үгүй, тийм ажил хийж бас эс чадах аж. Хүүхдүүд маань өөрсдийн хэр лэмжээгээр л малтай болог. Ийн өглөхийн цагт жаргалыг нь гүйцээж амтлахгүй хэрнээ, хулгайч залт этгээдүүдийн хоол хүнсийг бэлдэхийн төлөөнөө улдсан цөөхөн амьдралаа үрэхийн хэрэг юун.

Эрдэм номын мөр хөөх үү? Үгүй, эрдэм номыг амьдралын зорилго болголоо ч гэсэн хэнээсээ сурах билээ, сэтгэлд хүрэх эрдэмт хүн бийсэн бил үү? Сурч мэдсэн зүйлээ хэнд зааж, мэдэхгүйгээ хэнээсээ асууж лавлач билээ? Эзгүй хээр огтлох махгүй атлаа тонгорогоо дэлгэн атгаж хосон суухын хэрэг юусан билээ. Зовлон гунигаа хөнгөлж, санаа бодлыг минь хуваалцах хүнгүй аваас эрдэм ном ч гэсэн зовлон болж түүндээ амархан ётлөх нь гуниг биш гэж үү?

Гон биеэрээ бурханы мөр хөөх үү? Үгүй, тэр ч ба бүтэхгүй, түүнд бүхнээс амирлангуй чөлөөт тайваа байдал хэрэгтэй. Бодол сэтгэлд атугай үзэж өнгөрүүл сэн амьдралд маань хоромын төдий ч гэсэн санаа та вирах тайван байдал алга. Нийм газар, тийм улсын дун юуны номч, даяанч байх билээ.

Үр хүүхдээ ачлах уу? Тэднийгээ ачилж бас эс чад нам. Харж хандаж, ачлан өсгөж, хүн болгохсон, гэв яаж ачилж, юунд сургахгаа өөрөө ч үл мэднээм. Юуни тусад сургаж, ямар улстай нөхөрлүүлж, ямархан аав зантай болгох билээ. Үр хүүхдүүдээ хүртэл ирээдүйн нь амьдралыг тайван ухаалаг, юмны утга учрыг эрдээ номын нүдээр тайлахыг зааж сургасангүй. Хаашаа явж юунд хүрч, юу бүтээвэл тустай болохыг ухааран тайлж амжсангүй. Тийм болохоор эл бүхнийг амьдралын аавтустай зүйл болгож эс чадав.

Эцэст нь бодохул: Энэхүү толгойд харвасан бух бодлоо цаасанд буулгасугай! Цагаан цаас, хар бэхий сэтгэлийнхээ зугаа болгож, хэн нэгэн үүнээс хэрэгтэ үг олбоос тэмдэглэж, үгүй бол цээжлэн авч үйл болгог. Бас уншиж үзээд огт угтагуй зүйл хэмээн үзвээ өөрийн санаа өөртөө зэвийг чандлан сахиж, тааллаараг л болог, юутай атугай сэтгэлийнхээ гэгээ тасартал бий янтайгаас гар салгахгүйг өөртөө чанд тангараглав. Үүнээс өөр хийх буянтай үйл эл биенд минь үгүй бөлгөө

ХОЁРДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хүүхэд ахуйдаа манай казахуулын нэгэн яриа олонтоо сонссонсон. Казахууд чантуу хүн харчихаад шулга тажикууд, хaa хол газрын мухраас байшигийн дээвэрт дэвсэнэ гэж хулс ачих мөртлөө, бут сондуулаас айж сандрах нь юу вэ дээ гэж шоолдогсон. Татаруудын харвал бас л шоолж, «тэмээнээс айдаг татар, морь унавал ядарч, явган явбал амардаг ногой гэж нэрлэснээс нохой гэвэл таарна. Юунд ч эв дүйгүй, цэрэг ногой оргодол ногой, «башаашник» ногой. Оросуудыг харахаа раа «айл гэрийг харвал адайрч тонодог оросууд» гэх. Бас санаанд орсныгоо хийдэг.. юу гэж хэллээ ч үнэмшидэг, «алсын юмыг сонсох урт чихтийг олоод аль гэж гүйдаг» гэж шоолдог асан. Тэгэхэд би, өө тэнгэр бурхан минь, манайхаас бусад бух ард түмэн бүгдээрээ л мулгуу хоосон, тэнгэрээс ивээл хүртсэн, ганцхан ухаан

тай нь миний ард түмэн юм байна даа гэж бодлогсон. Өдгөө бодохул, чантуунууд тарьж ургуулаагүй тариа ногоо гэж үгүй, ногойчуудад яваагүй газар, дархчуулд нь хийгээгүй зүйл гэж алга. Бие биенээ үзэн ядаж өвөр хоорондоо маргалдах нь үгүй. Оросыг түшээгүй байхад казахын үхдэлүүдэд өмсгөх цагаан өмсгөл, амьдад нь өмсгөх хувцасыг нь тэд л дөхүүлж өгдөг байсан. Эцэг нь хүүгээсээ харамладаг хэдэн малыг нь тэд л сурэг сүргээр нь авч тухж байв. Оростой нэгдсэнээс хойш оросын эрдмийг биднээс илүү тэд л сурч эзэмшилээ. Баян, хоосон ялгалгүй бүх чанарыг тэд л бүрэн шингээж авч цэджээ. Ногой татарууд ч гэсэн цэргийн, ядуурлын, үхэл хагацлын бүх зовлонг бүрэн давах чадал сууж, эрдэмт мэргэн номын багш, хүрээ дацанггуудаа хамгаалж, шашин үйлийг дэлгэрүүлжээ. Хөдөлмөрийн амт шимт, мал маллах арга ухааныг сайн эзэмшиж, баяр цэнгэл, гоо сайхныг ч гэлээ төгөлдөр гүйцэд мэдэх болсон аж. Харин тэдний мал хариулж маллахаас хэтрэхээ больсон бидний ухаан идэхийн шуналд автсан хон хэрээний шувнал хүсэлтэй санаа нэгэн буй. Бидний өнгөтэй өөдтэй гэж урдаа барьдаг баяныг хүртэл «гишэгсэн газраа хөлөөрөө бузарладаг өмхий казах гэрээс зайл» гэж хөөнө. Энэ бүх чанар нь тэднийг хоосон нэр алдарт хуурталгүй аливааг тууштай, үнэнхүү бат эрхэмлэдгийг нь харуулах аж. Бид оросуудыг яахан муу хэлэх билээ. Учир нь бид тэдний ядуу зарц, шивэгчнийх нь дайтай амьдралтай байна биш үү! Ингэхлээр бидний мөнөөх хоосон сагсуурал, хий хэнээрхэл, шоолж инээсэн инээд бүхэн маань угтаа юу болох нь тодорхой байж бус үү?

ГУРАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Казахууд бие биенээ яагаад үзэн ядаж хонзогнох хийгээд өрөөл бусдаас сайнаа харамлах, олон үгтэй, залхуу, үнэнч нь цөөхөн байдгийн учир юу вэ? Хүмүүн төрөлхтөнд ухаан билгээрээ алдаршсан номч мэргэдийн айлдсан нь: «Аливаад залхуу хүн аймтгай, золбоогүй байдаг. Золбоогүй хүн ухаан хомс, тэнэг, тэнэг хүн ичих нүүргүй байдаг. Ичих нүүргүй залхуугаас их идлээ ч цаддаггүй ховдог, сонссоноо тогтоох чадалгүй мунхаг, амь голтой ч гэсэн хэнд ч хань боломгүй амьтад төрдөг. Энэ бүхэн дөрвөн хөлт мал дагахаас өөр юм хийх чадваргүй гэсэн үг юм. Тарна тарих, наймаа хийх, ур-

лаг, эрдэм зэрэг чухал зүйлсийн мөрийг хөөгчид ий болохгүй билээ. Мал дагасан маань өөртөө болоод үхүүхэддээ хэдэн малгай болгохоос цаашгүй. Эцэст хэдэн малтай болчихвол хариулгын хүн зарцалж, өөрөө идээний сайныг зооглож, царайлаг охид хүүхнийг эзэн нэж, хурдан морь уяж, амарч хэвтэхээс цаашихыг ба бодохгүй. Өвөлжөө нь багадвал үг хэлээ билүүдээ өргөдөл шидэлж, бусдын өвөлжөөг булаан авч, буу газаргүй балсон нэгнийгээ нутгаас нь зайлцуулахаас буцахгүй. Казалын амьдрахуйн зорилго нь энэ. Ийн хүмүүс бие биендээ тус дэм болж сайн юм хийнэ гээд үү?

Ядуучууд олширвол мал дагах зарц олширно гэж баячуулын мал цөөрвөл өвөлжөөний билчээр ихсэн гэж, би хөршөө ядуу байгаасай гэж, хөрш маань наамайг хоосорч үхээсэй гэж, анхандаа дотроо хадгалсан байсан муу бодол маань аажимдаа гадагшилж, маргаан булаацалсаар эцэстээ өөр хоорондоо дайтахад хүргэнэ. Ийм өш хонзонгоор буцалж буй хүмүүсийн зарим нь үг хэлээ цэнэж, эв аяыг нь олж хэдэн мал цуглуулахаас ач тустайг бодож тайж ноёдын суудлыг булаацалдаа эрх дархын төлөө тэмцэлдэнэ. Үүнээс болж томоото нэгнийх нь хүүхэд харь газар очиж, хөдөлмөр эрхэлж мал адуулах, тариа тарих, наймааны ажил хийх хэрэг гүй болно. Өөрийн туслын тулд эвсэл байгуулагчдын нэгэнд нь өнөөдөр, нөгөөд нь маргааш туслах гэж явсаа нэг насыг барна. Хулгайчид ч цөөрсөнгүй. Ард түмээн амгалан байваас амархан илчлэгдэх тул их үймээний дунд л тэд санаснаа гүйцээж дөнгөнө. Ард түмэн хэсэг хэсгээр талцан муудалцахад өнөөдөр нэгийг нь маргааш нөгөөг нь магтаж сайрхсаар итгэл олж хулгайгаа ч төдий чинээ хийж амжина.

Олны доторхи ганц нэг үнэнч шударга хүмүүсийн нэр дээр худал мэдүүлэг өгч хэрэг өдөөсөөр хэрэгтэй болгож амжина. Тэгж гайгүй нэгийгээ сонгуульд оруулахгүйн тулд муу бүхнийг өдөөж маргахад ард түмний жолоо аль нэг залтъ этгээдийн гарти орно.

Муж захирагчид өөрийн заль «хүнлэг» аргаар энэ суудалд хүрснээс хойш томоотой нэгнийгээ үл хүндэлнэ аль болох өөрөөсөө заль мэхээрээ илүү хүмүүст таасна, тэдний ов мэхээс айна. Арайхийж олсон суудлаа алдахгүйг хичээнэ.

Қазахын дунд «үйл нь бус, хүн нь мэднэ» гэсэн зүйр үг бий боллоо. Үүний угга нь: «үйлийнхээ зөв буруугаас бус хүнийхээ ов мэхийн чадвараар амжилтанд хүрнэ» гэсэн үг болой. Сонгогдгчид эхний жилдээ «Чамайг бид сонгосон биш үү! Чи бидний тусын тулд юу ч хийхгүй байна» гэсэн олны айлган сурдуулэх үг сонсож өнгөрөөнө. Удаахи жилээ өрсөлдөгчид хоорондоо мөргөлдсөөр өнгөрөөнө. Гурав дахь жил сонгуулийн хугацаа ойртоож, бүхний үг сонсож, бүхнийг өөрчлөхөөр амлаж, дахин сонгогдох боломжийг бодсоор өнгөрөөнө. Тэгж хий хоосон цаг нөгцөөн юу ч хийхгүй одно. Қазахын түмэн будилаан дунд хутгалдан жилээс жилд до ройтоож буйг үзэхүл миний сэтгэлд дараах бодох хургах юм: «Ард түмний захирагчаар сонгогдох хүн бүрэн боловсролтой хүн байх ёстай. Хэрэв тийм хүн олдохгүй бол, цэргийн талын боловсролтой, олныг захиран тушаах мэдэлтэн байх ёстай. Үүний давууг чухаг болгох нь, сэхээтний боловсролтой хүн, нэгд үр хүүхэддээ ч эрдэм ном сургана, хоёрт боловсролоороо сонгогдсон хүн ард түмэндээ өртэй бус, удирдагчдад өртэй байхсан билээ. Ийн аваас алив өргөдөл мэдүүллэгийг шүүхдээ түүхт үнэнийг илүү харж, худал хуурмаг мэдүүллэг өгөгчид цөрч, магад бүр үгүй болох нь ч лавтай. Бас алив му жид ахлагч бүхэн нэг ноён сонгох нь ард олонд илүү чирэгдэл учруулах нь тодорхой боллоо. Эл удирдлага гэдэг нь манай казахад жирийн сонгуультны хийж чадах ажил бас биш. Үүнд урьдын «Хасым хааны гэгээн мөр», «Есим хааны хуучин мөр», Ариун Тауке хааны «Күл тебе дэхь өдөр бүрийн хуралдай» болон «Долоон заргыг нь» мэдэх чухал.

Хуучны цааз бичгийн үг өгүүлбэр өнөө цагийн аясад үл нийцвээс үеэ өнгөрөөсөн хэсгий нь засч залруулан цаг үедээ тохируулан хэрэглэж чадах чадвар бүхий боловсролтой хүн хэрэгтэй бөгөөд тийм мэдлэгтэн цөөхөн хийгээд хараахан бас үгүй аж.

Қазахын эртний ёсыг сайн мэддэг мэргэдийн өгүүлэх нь: «Ноён хоёр болбоос зарга дөрөв болдог» гэх бөлгөө. Үүний утгыг ухваас, суудал ямба нэмэгдвэл ноёдууд хоорондоо суудал булаацалдаж, зарга олширно хэмээх утгыг айлдсан буюу. Тэгж зарга олшруулсанас хошуу тамга бүрээс гүйцэд боловсролтой гурван хүн жил харгалзахгүйгээр сонгогдвол, хэрэв огцрох

нөхцөлд буруу ажиллагаа нь олонд тодорхой болсохийгээд бусад нөхцөлд буруу ажиллагаа нь олонд тодорхой хоосон мэдуулгээр сонгуул явуулахыг зогсоонь зүйтэй.

Харин зарга мэдуулэгчийн дагуул нөёдгүйгээр хоёр талаас нэг нэг хүнийг шүүгчээр сонгон, бас нэг хүний дундын этгээдээр томилон авч, мэдуулсэн заргыг шударгаар шүүж, хэрэв заргыг тасалж чадахгүй болсон нөхцөлд л мөнөөх гурван нөёны нэгийг нь оролцуулан шүүлгэвэл сая тэр нь түвшгээ багатай, бас үнэнд илүү дөхөм шийдэл болох ажгуу.

ДӨРӨВДӨХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Ажигч гярхай алив хүнд дараах зүйл тодорхой Инээд гэгч согтуурлын нэг төрөл бөлгөө. Согтуу хүнээс нүглийн шинж илүүц илрэн, үг хэлэх уед нь сонсож суугаа хүн илүү ядарч, толгой өвддөг. Ийн ахул инээдэнд шунасан хүн нэг бол ажил үйлээ нөгөө бол ухаанаа алдан худал үг хэрэглэх нь олширч ичгүүр сонжуураа мартдаг. Тийм хүн энэ насандaa бус ч гэсэн хойт насандaa тамд очихоос зайлхгүй.

Өөртөө гуниг зовлон хураахаас ацгид явагч хүн амьдын болоод хойт насныхаа төлөө илүү нямбай байдаг Аливаад нямбай ханддаг хүний насан эцэс дэх буян нь илүүц бөлгөө. Хэрэв бид бүгдээрээ л тийм байх аваас үргэлж мөнхийн гуниг зовлонгоор бие сэтгэлээ зовоохгүй байж болох санж. Нөгөөтэйгүүр хүн болсон хойноо үргэлжид инээдгүй байж чадах гэж үгүй. Тиймээс хүнийг үргэлж инээдгүйгээр амьдар гэж тушаавал бас инээдтэй хэрэг болно. Гуниг зовлонгүй юманд гуниж сурх ба гунигаа тайлж чадах сэтгэлийн хатыг олох нь чухаг юм. Аливаа утга бүхий зөв үйл нь сэтгэлийн гунигийг аяндаа тайлдаг унир хоосон инээдээр бус тэрхүү үнэн зөв үйлээрээ гунигаа тайлдаг байх нь бүхнээс эрхэм чухаг чанар мөн.

Гарах үүд хаалгагүй битүү гуниганд төөрч мөрөөн ололгүй будилж гэмээнэ тэр нь ухаант хүмүүний ёс биш хийгээд бас алив муу хүний буруу үйлийг үнэн санаанаас шоолж инээх бус, уурлан уцаарлаж инээх нь чухаг юм. Учир нь ууртай инээд жинхэнэ гуниг байх авай. Тийм инээдэнд хүн сэтгэл алдахгүй, хүмүүн чин сэтгэлээр гэрэл тэгээ татуулан үнэн инээж гэмээнэ тэр нь

сайн сайхан бүхний сайныг олж харсаны шинж хийгээд тэр нь сэтгэлд тэнхэл өгч, алжаалыг тайлдаг. Алив ухаарагал нь сэтгэлийг согтууралд оруулахгүй барьж хэмжээ хязгаарыг нь чандалж байдаг. Тэнгэр бурхадаас зяаят үнэн сэтгэлийн эрхээр бус зориуд зохиомлоор гадна төрх байдал, нүүр амаа мөн зориуд засаж гарах авиаг нь хүртэл тааруулан ямар нэгэн шинжийг илэрхийлэхийн төлөө байдаг дууриамал инээдийг би зөвтгөхгүй.

Хүний үр өрөөлд инээд бэлэгдэн төрөөд гуниг үлдээж одох жам буй. Энэ хооронд амьдын жаргал хаа буйг анзаарагүй, бие биендээ сайрхаж, үнэт амьдралыг бодолгүй, хуурамч үйлээр нас буянаа элээж, эцэс төгсгөлд нь ганц өдрийн үнэнг амьдралын хамаг баялаганаараа худалдаж авах гэвч чадал дутдаг нь нөхөгдөшгүй харамсал юм. Заль мэх гаргаж, бусдын нүүр харангут ая тал засаж, өрөөлийн буяныг хумслаж амьдрах нь ямар ч авьяасгүй нохой зантай хүний л шинж болой. Тэгэж муугаа үзүүлснээс тэнгэр бурханд залбирч, дараа нь өөрийн чадал зоригондоо итгэж, үнэнчээр хөдөлмөрлөвөөс газар шорооноос хүртэл буян хурааж, эцэст нь явч чи хоосон хоцрохгүй буй заа.

ТАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Бодол саамшиж, сэтгэлд шингэсэн гуниг ивлэн гарахын үес үе мөчийг чилээж, нүднээс нулимс, амнаас үг болон асгардаг байна. Казахууд «Өө тэнгэр минь нялх хүүхдийн адил гуниггүй сэтгэл хайрла!» хэмээн хүсэн залбирахыг би нүдээр үзлээ. Тэр нь нялх хүүхдээс илүү өөрийгөө ухаантайд тооцож, бүхнээ сэтгэл зовох дүр үзүүлэх, гунигт хүн болох гэсний илрэл. Казахуудын гуниг гэж юуг нэрлэж байсныг зүйр үгнээс нь мэдэж болно. «Эрээгүй хүнд эцэг нь хүртэл өөр харагддаг». «Мал буян нь хүний элэг зүрхний адил». «Малтай хүний царай гэрэлтэй, малгүй хүний нүүр сэвхтэй». «Эрэйн буян замаас, чонын идэш хээрээс олддог». «Эр хүн уйдах үед «Бусдын малаар олз хийдэг нь», «Өглөгч сэтгэлд буруу үгүй», «Баянд талгүй хүн, бурханд ч итгэлгүй», «Өлсөх үедээ өрөөлийн үхэлд оч», «Харамч хүн загасгүй нууртай адил» гэх зэрэг зүйр үгийг тоолж гүйцэхийн арга үгүй.

Эл зүйр үгнээс бид юу ойлгоно вэ. Бүхэнд тодорх
казахууд амарлингүй учир эрдэм ном, үнэний төлөө с
гэл л зовохоос илүү санаж сарвайх өнөөх хэдэн малы
хаа төлөө үнэн зовж шаналах нь их. Харин ч яаж малт
боловхын учир утгыг гүйцэд ухаарагчий ч, малтай хүн
арга барилыг олж түүнийг залилан мэхлэж түүнээ
гүйцэлдүүлбэл нударга үзүүлж, булааж авахыг ичгүү
бодлогчий нь харамсалтай. Яагаад ч юм хулгай, за
гуйлга мэтийн хазгай аргаар малтай болохын арга ч
гыг олсон байдаг нь даанч инээдтэй.

Эл бүхэнд нялх хүүхдийн ухаанаас ялгагдах
Нялх хүүхэд улаан галтай тулганаас айдаг байт
хулгайч луйварчид тамын галаас ч айдаггүй байт
Үүгээрээ нялх хүүхдээс ялгарч байгаа гэлтэй. Бас ц
луулсан хөрөнгөө утга учиргүй тарааж, үрэхийг болд
гүй. Үнэнч шударга хүнээс зугтан, хол байхыг бодох а

Ёстой тэнгэр ниргэг! Ийм зан авир бидэнд хаана халдав гэж гайхширахаас аргагүй.

ЗУРГААДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Казахын нэгэн зүйр үгэнд: «Эвтэй ээтэй явбал гүйгаар шаазгай барина» гэдэг. Эв нэгдэл ямархан хиолоор буй болж, ямар ард түмэнд яж тогтдоги бас л ойлгосонгүй. Казах хүний сэтгэлгээнд унах ун дундынх, идэх хоол дундынх, өмсөх хувцас, хөрөн буян дундынх байгаасай гэж бодох мэт. Тийм ба аваас баян хүнийг балаг тойрох уу, ядуу хүний зовлы хоёр юугаараа ялгагдах болж байна. Ах дүү нар маташтай бэлтэй байхад мал хөрөнгө цуглувулж зовлон раахын хэрэг гэж юусан билээ? Үүнийг эв нэгдэл нь хөрлөл гэх үү? Үгүй, эв нэгдэл оюун санааг зангидах хөрөнгө буяныг зангидахгүй. Огтоос танихгүй хөндлөгийн хүнд мал өгч, буян үйлдэж гэмээж нь түүний ач эв найртай амьдарч болно шүү дээ.

Эв нэгдэл мал хөрөнгөнд зарагдах аваас андгайрамдал алдсаны шинж. Ах дүү олон түмэн эв наадэлд өгөө аваа бодохгүй байх нь зөв. Эс тэгэж гэм нь аллах тэнгэрийн авралыг эвдэж, хүний мөсөө алдабие биендээ үүрүүлэх зовлон нь ихдэнэ гээч. Нэгэн бүхий төрхөө, негөө бол гомдол гоморхлоо урьтал болож, угүй бөл ямар нэгэн байдлаар төвөг удааж за

алдсаар юм буулгаж авахыг илүүд бодно. Үүнийг яаин эв нэгдэл гэж хэлэх билээ.

«Буян үйл амьдын заяэтай» гэнэ, амьдын заяа жарал гэж юу билээ? Тэр нь амин цээжнээс гаралтай бус эж үү? Үгүй, тийм амь нохойд хүртэл бий. Амьдыг луүд боддог хүн үхлийг ад үзэж, хойт насанд нүглийг арьдаг, Амиа бөөцийлөн, дайснаас зугтаж, зориггүй-ээ илчлэн, хөдөлмөр хийж, хөлс ургахаас эмээж хүн сэрг эвдэж буян үйлдэн дайсан болдог. Амьдын мөн с гэж үүнийг хэлэхгүй амьдын жаргал гэж сэтгэл үрх, оюун санааны ариун байхыг хэлэлтэй. Хүн амьдээдий ч сэтгэл нь үхсэн байх ахул уг ойлгох ухаан хомсож, ариун цагаан хөлсөөр мал олох чадал дутна бий.

Гажуу хойрго залхуу, хэнхэг

Бэлэн хоол, бэлэн идэшт

— Гаднаа гэрэлтэй, дотроо харанхуй

Гэгээн оюунгүй хөлдүү тэнэг

айж гэмээ нь өөрийгөө амьдад бүү тооц, тэгэж явсаас тэнгэр бурхадаас илгээсэн ариун үхлийг хүртэх үхамаагүй илүү.

ДОЛООДОХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Нялх үрс эхээс хоёр юмыг өвөрлөж төрдөг. Нэг нь дэх уух, унтаж амрах. Энэ нь биений хүслэн, үүнгүй-ээр бие аминд гэр болж чадахгүй, өсөж торнихгүй, үч чадал хуралдахгүй. Удаах нь аливааг мэдэхийн үслэн. Үзэж харсан бүхнээ тэмүүлэн, өнгөлөг бүхэнд үнаж, амандaa хийж амтлаж үзэхийг дурлан, соңирож, дуутай бүхний авиааг чагнан, яльгүй торнихуйд охой хуцах, мал майлахыг хүртэл хачирхан, уйлж буй эгнийг сонирхон дэргэд нь очиж, «тэр юу вэ?», «энэ юу вэ?» хэмээн, «тэр яагаад тэгдэг юм бэ?», «энэ яагаад ингэдэг юм бэ?» гэж чихнээ шивнэж, нүднээ туссан бүхнээ асууж лавлан амар заяа үзэхгүй. Энэ бүхэн иений хүслэн, сурч мэдэхийн эхлэл» гэлтэй.

Ертөнцийн үзэж харагдах хийгээд нүднээ үл өртөг-өх бүхнийг ухааран ухаарагчийгээр хүнлэг ёс төгс өгөлдөр бүрэлдэхгүй. Аливааг мэдэж ухаарах ухаан шутахын хэрээр амь бие, хүмүүнлэг шинжийг алдан, драатан төрхөд илүү ойртдог жамтай.

Угаас тэнгэр бурхад хүмүүний амийг бусад амьтадын аминаас илүүд, бүхнийг ухааруулан мэдрүүлэхийн

төлөөнөө бүтээжээ Ухаан нь төгс бүрэлдэж, бие нь гүцэд торниж амжаагүй хүүхэд ахуйн сониучхан зан, ногдохолоо умартан ертөнцийн юмс үзэгдэлд тэмүүлэх түмүүлэл, аливааг сурч мэдэхийг хүсэх хүслэнгээ, осёвийн төрнисон хойно орхилгүй хадгалж, мэдэхгүйгээ лавлахаа ухаант хүнийг таньж, эрдэмтэн мэргэдийн алтан суугаалыг дагадаггүй маань даанч харамсалтай.

Тэрбээр мэдлэгийн хүрээгээ тэлэн, хүслэн болцуулсан юмаа арвижуулан чадаж гэмээ нь энэ бие тэнхээ нэмэхсэн. Биенээс амь илүү үнэтэй, биеийг амиа захируулаас зөв байхсан. Үгүй, бид тэгэж чадсангүй алагтуу адил шуугилдан, хэрээ адил бархиралдан, хорооны хаягдлаас холдсонгүй. Амь биднийг өнгөлжүүлж удирдан байж. Эрийн цээнд хүрч, хүч чадал суунаас хойш түүнд удирдуулахаа болив. Амийг бие удирдуулан, юунд ч үнэн сэтгэлээс хандахаа зогсоон нудээр үзэж, чихээр сонсохоо болж, сэтгэл оюуны зогсоогийн зарлигийг дагаж хүлцэхээ умартжээ. Нүднүүд туссан зүйлээ гаднаас нь хараад нүдээ баясан үнэтэй утгыг нь сэтгэлийн тэнхээгээр тайлалгүй, түүнийг мэдэхийн хэрэг гэж юусан билээ л гэж орхигдуулж явахын саар эцэс суулдээ адгуус төрх нь энэ баялагаасаа ичхээ ч болов бололтой. Хэн нэгэн хүн үнэнийг зөвлөвөр «Өөрийн эрдэм өөртөө», «Хүний гараар тос ууснаас өөрийн гараар ус ууяа» гэж зожигрчээ. Дээр хөх тэнгэрийн байхад хүн хүнээсээ илүү гарах гэж юу байх билээ хэмээн хий цэцэрхэж, хэрэгтэйг ухаарч, хэлсэнийг суралыг бодохгүй явсаар хайран цагийг нөхцөөжээ.

Ухаанд гэгээ, сэтгэлд итгэлийг алдаруулан аливах тохиолдлын хувьд хүнээсээ илүү гарахад хүнээсээ хоосон нудээр үзсэн бидэн дөрвөн хөлт амьтдаас юугаадаа ялгарах болж байна. Харин ч хүүхэд насандaa илүү өөрдөг байж. Өдгөө бид араатан амьтдаас ч үхээж доорд болчихжээ. Амьтад юмыг мэдрэхгүй, мэдэхийн төлөө булаацаалдахгүй. Бид юуг ч мэдэхгүй атлаа бүхийг мэднэ гэж бие биедээ тэнэг мунхагаа гайхуулгаа маргалдахуйд үхсэн сэхсэнээ ч анзааралгүй, гүрээндээ хээ судсыг юунд л хайр найргүй зангируулам гээч!

НАЙМДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Эл ухааныг минь хэн нь сурч, сургаалийг маасан хэн сонсоно вэ! Бүгдээрээ хэргэм зэрэгтэй нэг нь нийн нөгөө нь тайж. Тэдэнд ухаан гүйцэж, мэдлэгээ арвайж,

жуулах утийн хүсэл өрөөсөө үгүй учир аллахын ивээлээр ямбатны суудалд заларчихжээ. Тэд өөрснийгөө бусдад зөвлөгч, чиглүүлэн заагч мэдлэг чадалтай хэмээн олны итгэл хүлээж ссынгогдоц амжжээ. Өөрснөө аль хэдийнээ боловсорч гүйцээд одоо ард түмнийг гэгээрүүлэх нь л дутуу үлдэв гэнэ. Тэгэхлээр тэд мань мэтийнхний угийг яахин чих тавин сонсох билээ л, чих тавих хүсэлтэй авч тийм чөлөө зав олно гэж үү? Өөрийн гэсэн ажилтай гэгдэж байхад төр улсын тэргүүн гэмтэн болох уу? Үгүй бол нутгийн зүггүйчүүдийг давраах эсвэл нутаг хошуугаа тараачих бий, эсвэл өр авлагая цуглувулж чадалгүй явсаар өрөнд баригдчих бий л хэмээн ээдрээтэй бүхний эвийг олох гэж зовлонгоосоо илүү зовлон хуралдуулан суугаа тэдэнд ямар зав чөлөө байх билээ дээ. Баячууд ч гэсэн ялгаагүй ганц өдөр ч атугай буян хураахаа бодож, ертөнцийн тал хувийг нуруундаа үүрч явна. Тэд байхгүй зүйлдээ мал хайрлахгүй өгч зарж наймаалж авна. Бодол нь тэнгэрт бэлчиж, хараа нь талаар тархаж сайн, муу, буян, нүгэл аль алиныг малаас илүүд бодож чадахаэ ч байна. Мал буян нь арвижих аваас тэнгэр бурхалыг хүртэл хахуульдан хоморголж болно гэж бодно. Тэдний шүтэн бишрэх сэтгэл, нутаг ус, эх орон, эрдэм мэдлэг, нэр төр бүхнийг нь зөвлөн мал орлодог гэж төсөөлнө. Үг сонсож ойлгох чадал гэж үгүй, ойлгох гэвч зав чөлөө, олдохгүй явна. Тэрээр малаа услах, бэлчээж харнулах, наймаа хийх зэргийг л бодож, бас хулгай, дээрэм, чононохой мэтээс малаа хамгаалуулах хүн олох гэсээр хоногийг барна. Тэр бүхийг гүйцээн хийж хөлөө амраатал хаана ч билээ дээ.

Хулгайн мөрийг хөөсөн залт тэтгээдүүдийн хувьд мэдээжийн хэрэг, тэд ямар ч хүний угийг сонсохгүй-

Эгэл борчуул нь болохлоор хөөрхийс хоногийн хоопло ч олж чадахгүй зүлэрч явна. Тийм хүн эрдэм нохмоор юугаа хийх билээ л. Тэгээл ч ядуу хүнд эрдэм номын хэрэггүй мэт: «Биднийгээ яах гэв дээ, ном сурхайц чадал бэлтэй баячуудад заахгүй дээ л» гэнэ. Тэрбээр бусдад гэм хал үгүй өмнө хэлсэн гурвыг эрхэмлэдэг хүнд бодож, гуних зүйл гэж срдөө үгүй бөлгөө.

ЕСДЭХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Би казах хүн. Казах түмнээ хайрладаг уу, эсвэл үзэн яддаг уу? Хэрэв хайрладаг гэмээж нь хийж, бүтээж буй зүйлийг нь хүлцэнгүй дагах ёстойсон. Баячуудаас нь хүн ардад тустайг магтаж, сайшаахаар иэгээхэн зүйлийг ч атугай олж харах учиртайсан.

Тэрбээр тус болж сайныг нь хөхүүлэн дэм тус болгох, ач тусын үрийг боловсруулах гэж хичээвч хөөрхий надад чадал дутжээ.

Хэрэв ад үздэг гэмээж нь ямарч үед өөрийгөө холдуулан барьж, үг сольж учир тайлалцахаас цээрлэж, «яагаа бол» гэж санаа зовохын оронд, эзэнгүй хээрд гон бие тонилох учиртайсан. Энэ ард түмэн гэдэгт алдаагаа засч залруулан зөв замд оруулиа гэж баталгаа байхгүй тул итгэхэд хэцүү.

Тийм горь ч үгүй. Энэ бүхэп ямар учиртай юм бол? Тэр бүхнээс горь тасалж амьдрах учиргүйсэн.

Би гүйшэд төгөлдөр ухаантай мэргэн хүн бас бишээ. Энэ нь ард түмнийг бодсон сэтгэл, тэдний алив муу зан үйлд нь санаа зовсоноос ч юм уу, эсвэл огтын өөр зүйлээс хамаатайд юм болов уу хэн мэднэ? Учир нь үл мэдэх энэ алаг хорвоо гэж! Гаднаа амь голтой гэлдрэвч бие сэтгэл минь аль хэдүйн бөхжээ. Уурлах авч, байж ядан уцаарлах аргагүй. Инээх авч үнэн сэтгэлээс баясаж чадахгүй ярих үг минь өөрийн үг биш, инээд минь өөрийн инээд биш тэр бүхэн өрөөл бусдынх мэт болчихжээ. Чадал ухаан төгс үед казахыг тэвчин үлдээж, ондоо газар явах нь байтугай тэднийг хайрлан сайшааж, тусыг горилдог байж. Хэзээ хойно нь итгэл хүсэл унтарч бөхөхийн үеэс элэг эмтэрч зурх шимширч суух юм даа.

Тэр бүхнийг бодож ухварлахуйяа өөрийгөө дотоод нөөц нь бөхсөн, амьгүй нэгэн цээжин бие болохоо мэд-рэв. Заримдаа уй гашууд умбаж ийн бодном:

— Энэ ч гэсэн сайны талтай байх, хожим үхэхийн үест «хайран галтай, цогтой жаргалтай амьдрал минь!» гэж сэтгэл харамсах, гуниглах, зүйлгүй үлдэж буйг бус. ирж буй цагийг хий дэмий тэмтэрч хүсэх ажгуу.

АРАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Зарим хүмүүс Аллах бурханаас санаж сарваиж үр хүүхэд гүйна гэнэ. Хүсэн залбирахуйн үтга учир нь

үхэхүйд минь амьдралыг минь залгуулж, хойтохыг минь уншиг гэж л бодсоных биз. Нартад үүнээс өөр бодох зүйл байхгүй гэж үү? Хүүхэд маань амьдралыг минь залгуулах болтугай гэхийн учрыг ямраар тайлах билээ дээ. Ертэнцөөс хагацахуйн үеэс үлдэж буй эд хөрөнгө, эд хогшлоо эзэнгүйдэх бий дээ хэмээх шунахуйн хүсэл барагдашгүй зовиур шаналал төрүүлдэг ч юм билүү дээ? Эсвэл бусдад дэм болохоор горь төрүүлэх сайн юм угүй хэрнээ өөрийн бодол өөртөө үнэн байдгийн мөрөөр амь зогоох төдий амьдралдаа харам болдог ч юм уу? Хүнд сайн үр заявавал жаргал, муу үр заявавал зовлон нэмдэг. Увидас шидэт үнэнийг уртаж таах чадал ухаан дутдаг байтал айсүй ирээдүйгээсээ юуг мэдэрч аллах бурханаас үр гүйв даа! Энэ насанд хүмүүн таны амссан зовлон, хийсэн нүгэл, нохой зан хоёрын аль нь ихийг юугаар тайлбарлаж яачин хэмжих билээ. Тийн атлаа дахин нэг зовлонт үр төрүүлж, түүнийг ч бас араатан ноход мэт болгож, зовлонгийн мөрөөр эдлэх шарх сорви нэмэхийн төлөө тэгтэлээ юунд тэмүүлнэ вэ?

Хойт уншлагыг минь хэлж, буян үйлийг минь арвижуулаасай гэж боддог бол, таны үйлдсэн нүгэл хөнгөн, буян тус их байх аваас ялгаагүй үлдэж буй бүх хүмүүн таны тусад ном айлдана бус уу? Нүгэл ихтэй байх аваас хүүхдийн чинь уншлага буян болох нь юу бол? Хойт насыг бодож хүүхэл гүйх нь хүүгээ нялхаараа алж буй хэрэг. Хэрэв өсөж торниж зөв хүн болбосой гэвээс, зөв мөрийг хөөж, хайр энэрэлээр насаа өнгөрүүлэх, сайн үйлээрээ эцэг эхдээ буян хайрлах хүүхэд казахаас төрдөг болов уу? Тийм хүүхдийг чам шиг эцэг чиний ард гүмэн шиг улс түмэн тэжээж өсгөдөг гэж үү?

Отлөхөд минь асарч хамгаалаг гэж бодвол мөн адил гэнэн гоомой хоосон үг. Нэгд, чи өөрөө биеийн чинь тэнхээ тамир алдарч хүч харих хүртлээ өндөр насалж өтлонө гэж үү?

Хоёрт-Хүүхэд чинь ач гусгай, өрөөлнийг энэрэн хайрлах сэтгэлтэй, чамайг асрахуйц хүн болж өснө гэж үү?

Гуравт-Малтай, бэл чадалтай хүнийг асарч хамгаалахгүй хэн байх билээ? Мал хөрөнгөгүй бол ямар асрагт тэтгэлт байх билээ л. Хүүхэд хожим мал цуглуулах, эсвэл цуглуулсан малаа үрэгдүүлэх нь бас л өөр өөр утгатай буюу.

Хүсэхүйн төлөг бууж аллах тэнгэрээс үр хүүхэд

хайрлаж гэж бодъё, тэр өгсөн хүүхдийг нь чи зөв хүмүүжүүлэн хүн болгож чадах уу? Үгүй, чи чадахгүй, өмнөх нүгэл зовлонгоо үүрсэн дээрээ, хүүхдийнхээ нүгэл зовлонг бас хуваалцах болно гээч. Юуны өмнө «Үүнийг өгнө, түүнийг өгнө» гэж өөрийн төрсөн үрээ хуурна. Эхэндээ хүүхдээ хуурснаа сайрхаж, сэтгэлээ тэтгэнэ. Хожим нь хамаг буруугаа юугаар далдлах вэ?

Эхэлж өөрөө зааж өгч хараалын үг хэлүүлчихээд, «ааш муутай, битгий уурлуул» гэж харамлан хайрлаад, хамаг мууд өөгшүүлж хожим ном сурах болохлоор ноомой төлөв лам эрж, үсэг тайлдаг болчихвол болно хэмээж, бас «тэдний хүү тийм зантай, эдний хүүхэд ийм зантай тэр бүхэнтэй битгий нийл» гэж амьд хүнд итгэх итгэлийг нь алдагдуулж зожиг гажууд хүн болгож өсгөнө. Чиний өгөх сургамж энэ гэж үү? Тийм хүүхдээс ямар тусч, хүн ардын төлөө бие сэтгэлээ зориулсан хүн гарах вэ.

Бас болоогүй, мал хөрөнгөтэй болохыг хүснэ. Үүнийг ч гэлээ бурханаас гүйх уу? Мэдээж тэгнэ. Тэнгэр бурхад өглөө гэмээ нь өгснийг нь бас авахгүй. Тэнгэр бурхад чамд хөдөлмөр хийж, мал олох хүч чадлыг өглөө. Тэр хүч чадлыг муюүл хийх, буруу замд ашиглах гэж үү? Бас хүч чадлаа аливаад зөв хуваарилан ашиглах ухаан сэтгэл заясан. Залхуурч хойргололгүй хөдөлмөр хийж, горь тасарч урам хугалалгүй эрэл хийвэл, баяжихгүй хэн байх билээ? Чи түүнийг бас хэрэгсэхгүй. Чиний бодол нэгийг сүрдүүлэн авах, нөгөөг гүйж гувшиж авах, гуравдахийг хуурч авах. Чи энэ мэтээр л амьдарч гол зогоохыг бодно.

Энэ нь аллах бурханд хүсэн залбирч буй хэрэг бүс, хүн нэрээ, хүмүүнлэг чадал, ухаанаа зарж, алдар хүндийг олох гэсэн атаа шунаг сэтгэлийн шинж. Ингэж мал олж, баяжиж олсон мал хөрөнгөө өгч байж эрдэм ном сурах хэрэгтэй бус уу. Өөрт эс олдож гэмээ нь үр хүүхдээ ч атугай номтой болгохыг хичээгтүн.

Эрдэм номгуйгээр хойт нас ч, ертөнцийн амьдрал ч үгүй. Эрдэм номгуйгээр уишсан уишлага, хийж буй мөргөл залбирал юунд ч дэм буян болохгүй. Өдий наслах хүртлээ буруу замаар будаатээж мал хөрөнгө олдог ч түүнийгээ сайн үйл, эрдэм номд зарцуулж ариун шудрага үйлсэд зориулж буй казахыг олж харсангүй. Бүгдээрээ л нүгэл үйлдэн олсон зүйлээ нүглийн замаар

цуувуулчихна. Сэтгэлийн ариусгал, харанхуй гунихрал, цээжин далдад бөхжих дааж давамгай нүгэл гурваас бусад зүйл биенд нь чимэг болж үлдэх нь үгүй.

Юмтай бэлтэй чинээлэг үедээ баянаараа гайхуулж, хоосорч үгүйрэхэд «урьд нь надад ч гэсэн хөрөнгө мал байсан» хэмээн хий сагсуураад яах вэ. Ядуурахын үеэс бас л гүйланчлалын замд орно.

АРВАН НЭГ ДЭХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Өдгөө манай казахуудад хоол зоог болгож буй хоёр зүйл буй. Энэ нь нэгдүгээрт:

Малын хулгайч нь хулгайгаараа мал хоол олно гэж бодно. Малын эзэн баяжсан дээрээ баяжина гэж бодно. Ноёнтон, ямбатнууд танд би авч өгнө гэж зарагчийг идэж, өршөөж цагаатгана гэж хулгайчийг идэх юм. Эгэл жирийн ард түмэн хулгайчийг илрүүлэх гэж нэр төрөө барж ашиглагдахаас айж балмагдан дэмий нөёдны зууш болчихсон байх юм.

Хоёрт залт этгээдүүд хэний ч бодоогүйг бодож, олоогүй аргыг олж тайж болно, Эсвэл баяжиж өшөөгөө авч чадалтайд тооцогдоно гэж бэлтэй чадалтайд долгинох дон туссан мэт. Хэл бусадтай эвдрэлцвэл би түүнд тусална гэж аазгайг нь хөдөлгөн онгироож жаал зугаа юм салгаж авахын түүс болж хий дэмий цаг хугацаагаа үрнэ.

Эрх ямбатнууд «зүйтэй, зүйтэй» Энэ нь жинхэнэ ухаант хүний арга байна, таныг дэмжиж тэтгэнэ гэж буруутанг магтан онгируулж, олз ашиг олохыг бодохоос өөр юмгүй мэт. Энгийн ардууд; «миний талд төчнөөн айл амьтан байгаа. Бид айл хотлоороо таныг дагана» гэж ам өчиг өгч, унтаж амрахаа мартан, аль олонхи болсны талд эд мал, авгай хүүхдээ хүртэл барьцаалан зарахаас сийхгүй. Эл хулгай зэлгий, адайр заль устах аваас ард олонд ухаарал төрөх бөлгөө. Хүн болгон энэ хүмүүнлэг бус үйлийн төлөө зовниж зөвийг бодох авч, санаа хоёрдон, зөв үйлд зориг шуудран орохгүй, буруу бүхнийг хэн засаж, хэн залруулах бол хэмээн явсаар хоног өдрийг элээнэ. Бодлоо хураахуй:

Хулгайчийг засаж болох мэт. Харин энгийн олныг хуурч, эвдрэгсэдийг өөгшүүлэгч баячуудыг хэн засаж хүмүүжүүлнэ вэ?

Юутай хяслантай хорвоо гээч.

АРВАН ХОЁРДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хэн ч атугай буян үйлийг бодож сайныг шүтэх буюу, эсвэл буруу үйлийг дагаж мууг шүтэх аваас түүнийг итгэл бишрэлээс нь салгах зориг дутааж, сайныг бодож яваа санаанд муу чанар үгүй бөлгөө хэмээн итгэж үг дуугарахаас халширнаам билээ.

Харин тийм бодолтой хүмүүс төгөлдөр сургааль бишрэлийн утгыг төгс тайлж чадахгүй ч гэлээ хийж бүтээхийн нэгэн хүслэнийг өвөрлөсөн байвал нэн тустайсан. Гэхдээ түүнд (хийж бүтээх, сурч эзэмших) зайлшгүй шаардагдах хоёр нөхцөл буйг мэдвэл зохильтой.

Нэн түрүүнд тарни номонд итгэх итгэл хийгээд түүнд хүлцэж сэтгэлийн хат суух чадал буюу.

Хоёрдугаарт: сурч эзэмшихийн тулд, энэ л болно хэмээн өөрийн зүтгэлээ хойш чангааж хойрогошолгүй ямагт суралын төлөөнөө тэмүүлэх тэмүүлэлтэй байх явдал чухал. Хэн ч атугай төгс сурч боловсроогүй атлаа суралыг чигээсээ няцвал түүнийг бурхан ниргэж, мөргөл уншлага нь хэзээ ч үнэн уншлага байж чадахгүй.

Сэтгэлийн хатыг олсон хээн ч атугай тарни ном хичнээн утгаас бүрдэж, хичнээн хувилбараар өөрчлөгдөж болохыг нь төгс дүүрэн мэдэхгүй байж, молла¹ хувцас ёмсөж, зөвхөн нэр алдрын төлөө уншлага уншиж, таршины үйлдэж буй нь: бэр гүйх ёсыг үйлдээд олон мал төлж чадаагүй атлаа сайн бэлгийг өгсөнтэй утга ижил мэт.

Эznээ олоогүй үг, зориулагдаагүй тарни ном гэж байдаггүй, өөрийгөө байнга анхааран цагдаж, үнэн ариун номын ёсыг ямагт үнэнчээр сахиж үл чадваас хойрго, залхуу, идэвхгүй тийм хүнийг номтой тарнитай буянтай хүн хэмээн итгэхэд нэн бэрх.

АРВАН ГУРАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Шүтэхүйн номлол гэгч нь Аллах бурхан, номин хөх тэнгэр, хэмжээлшгүй ариун эв нэгдэл нүгэлгүй чанар эцэс төгсгөлгүй эрдэм бүхэнд зориулж зөнч мэргэн номын эздээс бидэнд оноосон их хувь хишиг хийгээд бурхан тэнгэрээс илгээсэн зарлигийг нь даган хүлцэж, итгэх итгэлийг хэлэх ажгуу.

Үчир нийн аваас энэхүү шүгэхүйн номлолыг гүйцэлдүүлэн хулцэж, итгэж бишрэхийн тулд хоёр үндсэн зарчмыг бүрэлдүүлвээс зохино.

Нэн түрүүнд аливааг шүтэн дээдэлж, тарни үйлдэж гэмээж нь түүний мөн чанарыг ухварлан итгэж, төгс тайлах ухааныг бүрдүүлэн хулцэвээс үүнийг зөв тарни гэвэл зохилтой.

Хоёрдугаарт: Номоос сурах зүйл маш их. Үнэн номыг молла нараас сонсох, үнэн мөнөөр нь уншлага үйлдэж, тэрхүү уншлага үйлдэж буй зүйлдээ итгэх итгэл үнэмшилийг бүрдүүлэх явдал нэн чухал. Хэн нэгэн этгээд ална хэмээн айлган сурдүүлж байсан ч түмэн хүн түмэн янзын авир үзүүлсэн ч, түүнд сэтгэл зовинон тарамдахгүй байх, бат бөх чадалыг олох ёстой. Үүнийг зан үйл тарни номын хэмнэл хэмээн нэрлэмой. Чингэвэл тарни номыг хундлэн, итгэл бишрэлтэй байхын тулд аймшиггүй зориг, үл хувирах сэтгэл, сөгдөшгүй тэнхээ чадал, нүглийг тэвчих тэнхээ хүч хэрэгтэй ажгуу.

Сүсэг бишрэлтэй авч, эрдэм ном нь мөхөс, нэгэн бол бусдын үгэнд итгэж, нэгэн бол хүчирхийллээс эмээж, ашиг завшааны төлөөнөө харыг цагаан, цагааныг хар хэмээн нүгэл үйлдэж, худал хурмаг бүхнийг шүтэн дуугаа буруу номлогчдыг юу хэмээн ухнам билээ. Тэнгэр бурхан минь, ивээн тэтгэж, өршөөл үзүүлэх болтугай! Ухаант хүмүүн аливааг зөв ухаарч төгс мэдэх, тунгаан эргэцүүлэх ариун чанартай байваас өмнө өгүүлсэн хоёр чанараас өөр хүчин төгөлдөр тарни ном гэж ердөө үгүй.

Шүтэхүйн номын эсрэг хэн ч атугай алхан орох ёсон үгүй хийгээд «буруу үйлийг минь бурхан тэнгэр өршөөн соёрхох буйзаа» хэмээн өөрийн хийсэн нүглээс холдон зайлах, амар амгаланг эрхэм болгох гэвээс бурхан тэнгэрийн үнэн, зөнч мэргэн ёст ариун мөрд хэзээ ч үл нийцмой. Сэлэм харшилдахуй тангараг тасрана гэгчээр бурхан тэнгэрийн өршөөхгүй нүгэл гэж үгүй хэмээн сэтгэж хоосон зүйрлэлийг бишрэн үнэмшигчид зайлсан уствал таарна.

АРВАН ДӨРӨВДӨХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хүний зүрхнээс илүү эрхэм чухаг эрхтэн байдаг гэж үү? Казахууд баатар хүнийг зүрхтэй хүн гэж нэрийддэг авч зүрхтэй холбоотой өөр бусад чанаруудыг тө-

дийлөн гүйцэд улаардаггүй аж. Хүмүүнд тус тус үйл, энэ-рэнгүй сэтгэл, аливаа хүмүүний үрсийг ад үзэлгүй ах дүү лугаа адил сэтгэж, тэдний сайн үйлийг өөрийн жаргал лугаа адил мэдрэх чадавхи бүхэн зүрхтэй холбоотой хийгээд адгаж тэвдэх айж самуурах хүртэл лүгших зүрхний ажиллагаа мөн бөлгөө. Үг хэл хүнийг эдгээдэг, үг хүнийг өвдөөдөг учир зүрхний цохилтыг хүлцэж гэмээж хүн бурууг үйлдэхгүй. Харин зөв мөрийн бус арга залийн урхинд автагдахуйд зүрхний зарлиг зөрчигдөнө.

Казахуудын «зүрхтэй» гэж хэлэх нь магтаалд үл нийцнэ. Ихэсийн зөв бурууг мэдрэх, дуулгаварт зан, хэлсэндээ байж, муу үйлээс өөрийгөө ямагт чөлөөлж (магад зайлцуулж) чадах чадавхи, жин дагасан жингэр адил аливааг даган дуурьсахгүй байх сэтгэлийн хат, буруу мөрд орогчдын жолоог залж, зөв замд оруулах, үнэн шударгуут ухаарах, шударга бусыг мэдрэх авч түүнийг давах хэцүү даваа бүрийг тэсэн тэсвэрлэж үнэнийг олох, оюут хүний ухаанд нийцэхгүй зүйлийг хялбархан авч хүлцэхгүй байх ариусахуйн бүх чанарыг зүрхтэй, зоригтой гэж хэлэх болохоос казахуудын зүрхтэй гэх ойлголт нь үнэн зүрхтэй бус, араатан чонын адил зүрхтэн болчихвол юу болох вэ.

Казахууд ч гэсэн хүн төрөлхтний нэг эс, хүний үр шүү дээ, ихэнх нь ухаанаа зарахгүй бэлэнчлэхээс бус бусдын зөв үгийг хүлээж авах ухаарал чадавхи дутсанаас болж буруу замаар явчихдаг нь харамсалтай. Мэдэхгүй, ухаarahгүйгээсээ болж буруу гүйлдлээ гэгчдийн үгэнд итгэхэд бэрхтэй. Учир инү:

Тэд эрдэм номтой, зөвийг ухаарах чадалтай авч, засч залруулах чадавхи казахуудад ихээхэн дутагддаг юм уу даа. «Сайн эр», «чадалтай зоригтой эр» гэж ард олны сайрхан магтаж буй бүхэн нь хүнийг муу үйлд нь даамжуулахын төлөө л бие биесээ «зүйтэй, зоригтой» гэж уухайлан агсаруулж, эцэст аливааг бодож тунгаах сэхэл олгохгүй байгаа хэрэг. Түүнээс аллах тэнгэр ариун бурхадын зорилгыг хүлцэж, мөс билгийн тэнхэл авч чадах чадалгүй сэтгэл ухаарлын жолоог алдуурласан хүн, хүн нэрийг яахин авч явж чадах билээ!

АРВАН ТАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Ухаант хүн, ухаангүй хүн хоёрын хооронд үл нийцэх ялгааг би ийн бодном.

Нэн түрүүнд ертөнцөд бий болж төрснөөс хойш хүмүүн нэгээхэн зүйлийг ч нээж харахгүйгээр амьдрах гэж үгүй. Тэрхүү эрсэн зүйлээ олж харсан мөч-хамгийн аз жаргалтай үе болон сэтгэлд мөнх хадагдаж, ухаант хүн ирээдүйтэй зөв юмыг дурлан шохорхож, хэлэхүйд чих, ухварлахуйд оюун санаа цэлмэхүйц гэгээлэг, сэтгэл ханашгүй нандин сайханд нь дурладаг байна. Тэрбээр өнгөрүүлсэн амьдралын «хайран» гэж харамсах мөч гэж үгүй болох аж.

Ухаангүй хүн аль ч учрыг олохгүй, юу ч байг хамаагүй, ирээдүй ч үгүй, хямд хялбар зүйлийг дурлан шохорхож, амьдралынхаа хамгийн жаргалтай үеийг утга учиргүй «нохойн замаар» өнгөрүүлчихээд, эцэст нь харамсаад ч ач тусыг олдоггүй байна. Насны залууд энэ нь болохгүй ч нөгөө нь болчихмоор, нөгөө нь бүтэхгүйд өөр нэг нь бүтчихмээр, бүр угүйд цоо шинэ зүйл буй болчихмоор санагдан, залуу нас, мөнхийн юмшиг, шөрмөс суларч тэнхээ тамир харихгүй юм шиг сэтгэгдэж явсаар нэгээхэн жаргалын үзүүрт золбоо хийморь цуцаж, нөгөөг эрэх хүч тамир харьдаг байна.

Гуравт: Аливаад шохорхогүй байх. Энэ нь хүний биед дур хүслийг буй болгодог байна. Алив дур хүсэл өөрт ер бус өвчин болон хувирч, ямарваа дуршиж хүссэн зүйлдээ хүрэхүйд, эсвэл хүрч ядан явах үедээ ер бус ихэрхэлийг төрүүлдэг байна.

Алив ихэрхэл алдаанд илүү өртөгдөж, ухааны нүдийг сохлон, эргэн тойрны ажиглагчдын мэлмийг нээж, «тэрнийг, түүнийг» гэж нэр зүүлгэн биеийг шалгагч шалгуур болдог аж. Ухаант хүмүүс тийм үед ухаан алдууллахгүй, сэтгэлийг хатамжилж, олонд өртөлгүй явж, хүссэн зүйлээ эрж хайдаг нь жам. Ухаангүй хүн эмээл хазаараа орхин, тоорцгоо унагааж, хормой нь морины хондлой нөмөрч, хоёр нүд нь тэнгэр шильтэн, ухаан солиотой тэнэг хүн лугаа адил давхисаар л байх аж, би түүнийг үзлээ, та минь юутай хөөрхий.

Хэрэв ухаант хүмүүсийн эгнээнд байхыг хүсвэл, өдөрт ганц удаа ч атугай үгүйдээ долоо хоногтоо, бүр угүйд сард нэг удаа өөртөө тооцоо хийдэг бай! Өмнөх

тооцоогоо хийснээс хойшхи хугацаанд юуг бүтээж, юуг эс бүтээв энэ өдөр хоногийг ямарханаар өнгөрүүлэв, эрдэм номд туст, хойд насанд буянт, хожим өөрөө харамсахгүй зүйлийг бүтээж чадаж уу? Эсвэл юуг бүтээж, ямарханаар хоног элээснээ өөрөө ч үл мэднэ үү?...

АРВАН ЗУРГААДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Казахууд мөргөл залбирлаа тэнгэр бурханд зохилтой, бурхан тэнгэрт буян болж байгаасай гэж санаа зовохгүй. Гагцхүү олны хийснийг хийж, босвол босож, суувал сууж байвал болов гэж үзнэ гээч. Наймаачид өр зээлээ нэхэхүйд, тэдний өөдөөс «хамж чимж цуглуванс маань энэ л байна, үүнээс илүүг газраас ухалтай биш яая гэхэв» гэдэг шигээ аллах тэнгэрийг ч гэсэн нэгэн адил хуурч болдог мэтээр боддог. Тийн байлгахыг хүсдэг. Үг хэлээ зүгшрүүлж, сэтгэлээ ариусгаж бодож бясалгаж зовохгүй. «Үүнээс илүүг мэдэхгүй, одоо өтөлсөн хойно юуг сурх билээ л» гэж өөрийгөө чамлана.

«Мөргөл үйлдвэл болов, хэл хугарал уншлага цээжилж, яах билээ л» гэнэ. Тэдний хэл соёл бусдаас дутуу заяагдсан гэж үү?

АРВАН ДОЛООДОХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Золбоо, ухаан, зориг турав эрдэм булаацалдан, маргаан таслуулахын үүднээс шинжлэх ухааны цэцэд очжээ.

Золбоо: Орчлонт ертөнцийн ямар ч зүйл надгүйгээр бүтэж, бүрэлдэхгүй хийгээд нэн түрүүнд таны түмэн увидсыг ухварлан ойлгохын тулд хүнд бэрхийг гэтлэн давахаас залхууран хойрогшолгүй сэтгэл зориг чангатган санасандаа хүрэх нь миний үйл. Ариун бурхадад зохилтой эрдэм, хурал, ном олох, хүмүүн орчлонд зохилтой буян эд өлгийг олох бүхэн нь хөлс хөдөлмөргүйгээр буй болохгүй. Бие оюуны зохисгүй зүйлд дасгахгүйгээр сэтгэлийг ариулагч, нүгэл хилэнц, аливаа ад зэтгэр бүхнээс зайлцуулагч нь үнэнээс төөрч буруу мөрийг дагагчдыг зөв мөрд чиглүүлэгч нь би л байдаг бус уу? Тийн атал ухаан, зориг хоёр надтай юунд маргана вэ? хэмээжээ.

Ухаан: Ертөнцөд хийгээд хойд насанд юу ашигтай бас юу аюул зовлон болохыг би л мэднэ. Таны үг бүрийг ухварлан ойлгодог нь би. Надгүйгээр миний орол-

Цоогүйгээр өөрт хэрэгтэйг олох, хорт муу бүхнээс зайллах гэж үгүй. Золбоо, зориг надтай юунд маргана.

Түүний дараа зүрх хэлэх нь: Би хүмүүн биеийн хаан нь, амин цус nadaас гаралтай, намайг дамжин, амьдрагч эд эс амин чадлыг олдог. Надгүй амьд амьдрал гэж үгүй. Дулаан гэрт, зөөлөн буйдан дээр амар амгалан гэдэс цатгалан хэвтэж буй хүн, эсвэл оргүй ядуу, даарч зовж буй нүцгэн нэгний амьдрал яаж байгаа бол гэж сэтгэл шаналган, нойр хулжаадаг нь би. Ахас дээдсийг хүндэлж, дүү нялхаст тусыг хүргэгч нь би. Гэвч хүмүүс намайг энэрч цэвэр ариун байлгаж чадахгүй явааар эцэс хожим нь зовлонд учруулдаг. Би ариун байх аваас амьтны үрийг алаглахгүй, туст сайн бүхэнд уярч, муу үйлийг цэвэрлэн бас зовж шаналан, үнэн ичгүүр, утгат зэрэг мөс билгийн ухаарлууд надаар дамжих болно. Золбоо, ухаан хоёр надтай юунд маргана гэжээ.

Шинжлэх ухааны цэц эл гурвын үгийг сонсоод:

Золбоод: — Чиний өчиж буй бүхэн зөв өө! Чамд ярьсан зүйлээс чинь гадна олон эрдэм байгаа. Чамайг үгүйд тэдний байхгүй нь үнэн хүчиндээ зохицсон хатуу чанар мартаж үл болох ач тусын хажуугаар чиний учруулдаг зовлон бас буй. Чи заримдаа нэгэн бол сайныг хэт их, нэгэн бол мууг дэндуулж барьдаг. Өөрөөр хэлбэл сайн хүнд дэндүү шунаж, эсвэл муу хүнийг дэндүү дордуулдаг. Энэ л чиний муу чанар чамд үл зохицох зүйл юм гэж.

Ухаанд хандаж: — Чиний хэлэх бас үнэн. Чамгүйгээр ямар ч үйл бүтдэггүй. Бүхнийг бүтээгч тэнгэр бурхадыг хүртэл чи таниулж, хоёр ертөнцөд болох бүхий л хэргийг чи л мэддэг билээ. Бас арга заль, авхаалж, самбаа чамаас гаралтай. Сайн, муу үйлийн шүтээн нь чи! Хоёулангийнх нь хүслийг хүлцэх нь чиний муу чанар!

Та гурав нэгэн биенд нэгдэх аваас туст сайн явдал болно. Харин нийлүүлэх нь миний үүрэг. Хэрэв тэгэж гэмээ нь зүрхээр удирдуулах нь зүй! Ухаан чи уужим зантай ч тэр бүрий чиний мөрийг зүрх дагахгүй, зөвийг тайлахад чинь хүлээн зөвшөөрөөд зогсохгүй чамаас илүү баярлах бөлгөө. Бас муу үйлийг зааж өглөө ч ухаarahгүй ухаарах нь байтугай уурлан уцаарлаж чигээ буруулна.

— Золбоо хүч чадал арга билэг төгс ч гэсэн чиний үгэнд бас орохгүй. Зөв үйлэнд хүч чадал зарцуулахын үл зөвшөөрнө. Буруу үйлт мөрлүү үл алхуулна. Та гурав нийлж, зүрхээр удирдуул! Эрдэм номонд тэгэж хэлдэг.

Та гурав миний хэлснээр иэгэн биенд оршивоос тэр хүн улныхаа тоосноос адис авам буянт хүн болно. Хэрэв та гурав үл иэгдвээс, би зүрхийг дагана. Зүрх ариун байх аваас бурхадын таашаалд нийцэх бөгөөд тэнгэр бурхад хүмүүн төрхийг үргэлж ажиж байдаг гэж номонд өгүүлсэн байдаг хэмээжээ.

АРВАН НАЙМДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хүн уранхай цоорхойгүй бүтэн хувцас өмсөж, биеэ цэвэр авч явах нь зөв үйл. Өөрийн бэл чанчаанаас хэтрүүлэн илүү хувцаслаж, хувцас нь хүрэлцэхгүй ч түүнд сэтгэл хангалаун явах нь ганган хээнцэр хүний шинж.

Ганган хээнцэр хүнд хоёр төрлийн ялгаа байдаг. Нэг нь бие галбир, үс сахал, алхаа гишгээгээ зориуд засаж, гар хуруугаа хүртэл гамнахын төлөө хамаг наасаа зориулна. Нэгөө нь морины сайныг унаж, хувцасны сайныг эдэлж зүүхийн төлөө түүгээрээ үеийн нөхдийн өрцийг урж, өмнөх үеийнхэнд тал засаж, удаах үеийнхэнд «эд нар шиг сайн морь унаж, сайхан хувцаслаж явахсан» гэх хоосон мөрөөдөл төрүүлж явахыг л боддог.

Үнэндээ тэр бүхэн ухаан үгүйн шинж. Ийм учир мугуйд зан хүмүүнд бодогдохгүй байх нь чухаг. Хэрэв нэг удаа ч атугай бодож гэмээ нь тэр хүн өөрийгөө татаж авах гэж үгүй.

Ийн учир хээнцэр гэдэг үгийг хэдэр адайр гэх уганд дүйшүүлнэм. Хүмүүн төрөлхтөн мөнхөд бие нээсээ ухаан билэг, эрдэм ном, ичгуур сонжуур, хүн мөсөөрөө ялгагдана. Давж түрүүлэх аваас түүгээр л түрүүлнэ. Үүнээс өөрөөр боддог бүхэн ухаан мөчид, ухаарал дутуугийн шинж байх бөлгөө.

АРВАН ЕСДЭХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хүн эцэг, эхээс ухаан өвөрлөж төрөхгүй. Ертөнцийн явдлыг сонсож, үзэж, барьж, амсаж сайн мууг таньж мэдэхийн ялдамд эрдэм ухаан нь өсөх ажаам. Ухаантнуудын хэлсэн зүйлийг алдалгүй хүлээн авч, түүнийг

амьдрахуйн мэр болгохыг хичээн зүтгэсэн хүн л ухаантанд тооцогддог. Алив нэг ухаарал дангаараа үйл болох нь бас үгүй. Бичиг номт ухаатнуудгас сонсож мэдсэн сайн зүйлээ тогтоох цээжтэй байж чадах ахул, түүнийгээ үйл болгож, ёс буруу зүйлийг таягдан хаях сэтгэлийн хаттай байх аваас тийм хүнийг хүн гэж нэрийлж болно. Чихэнд чимэгт үг сонсохул буруу тийш нь хадуурч, хөндий хоосон цээж зааж, босон, суун сонсох, үгүй бол сонссон зүйлээсээ мэдэхгүйгээ асууж лавлах хүсэлгүй бол сонссон сонсоогүй нь ялгаа юусан билээ! Үгийн цэнэ, утга учрыг ойлгохгүй нэгэнд үг хэлж, цаг үрсэнээс эзнээ таних чадалтай гахай малласан нь илүү байх гэж нэгэн номын манлай айлджаа. Ийн би үгээ жартгасу!

ХОРЬ ДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хувь тавилангийн зарлигийг та бүхэн мэднэ, өөрчлөгдөхгүй. Хүнд нэгэн зүйл уйдахуй гэж буй. Тэр ч бас хувь тавилангаар заяагдсан зүйл, түүнийг хэн ч гараар бутээгээгүй. Түүнд урхилагдсан хүний үр салж мултрах гэж үгүй. Зориглон тэсэж, биенээс сэгсэрч хаялаа ч гэсэн хэдийд ч юм ирээд наалдчихсан байх бөгөөд эцэс хожим нь бас өөрийн ялалтаар дуусдаг. Ухаан гүйцээж, төгс нэгэн бодхул эл хүмүүний үрсэд цуцаж залхуурдаггүй зүйл байдаг болов уу?

Хоол унд, багын тоглоом, инээд наргиа, хээнцэр зугаа, баяр цэнгэл, авгай хүүхэн.. ер орчлонгийн ямар ч зүйлээс сэтгэл уйддаг.

Түүний учир бүхний ялыг эдэлж, мөнх бусыг ухаарч, амьдын жаргалаас сэтгэл хөөр, гуниг нэмэгдэнэ. Хорвоогийн зүйлс нэгэн хэвэнд байдаггүйн адил хүний амьдрал, зориг чадал нэгэн хэвийн байж чадахгүй. Тэнгэр бурхад нэгэнт бүхнийг нэгэн хэвд заяагаагүй болохлоор хүсэл зориг ч гэсэн нэг хэмд тогтож үл чадах аж.

Гэвч уйдахуй чанар нь нүд тайлж, аливааг үзэж мэдэхийг хүсэгч ухаант хүнээс гаралтай байдаг. Хорвоогийн элдэв жаргал эцэс төгсгөлтэйг мэдэрч, амьдрахуйн үнэн утгыг таньж мэдэхийн үест бүхнээс уйдахуйн хүсэл хүмүүнд буй болдог. Ийм болохлоор аливаа гунигийг анзарагч сэтгэл үгүй ухаан мөчид хүн бүхнээс жаргалтай мэт бодогдоно.

ХОРИН НЭГ ДЭХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Их бага ямарч байлаа хүний үр магтаалаас хол баян хэцүү зүйл. Өдгөө би магтаалын хоёр өөр шинжилгээ ухаарлаа. Нэг нь үнэн бөгөөд их магтаал, нөгөө сэтгэлийн хий хөөрөл юм. Амьдрахуйн жинхэнэ үтийн үнэ цэнийг мэдэрч, хийж буй зүйлийнхээ үнэн мөнин тунгааж чадах хүн л их маггаалд дүйцэх аж. Тийм хүн тэнэг мугуй, аливааг эргэцүүлэх чадалгүй, хэрүү ховч, үнэн үг хэлэх нь цөөхөн, нэр төрийн утгыг эгээрэгч зэрэг хүнд үл нийцэх алив муу чанацуудаа цээрлэж чадах ба түүнийг насын зовлон гэдгийг бүрхийн ухаарч өөрийгөө тэр бүхнээс холдуулж чаддаг байндаг. Энэ нь ухаант хүмүүсийн чанар юм. Тийм хүмүүс өөрийгөө бусад магтуулахын төлөө бус муюу нэрээ гаргахгүй төлөө л шаналдаг.

Нөгөө нэг нь-бүтээж болоогүй зүйлд хий хоосон сэтгэл дэвэргэж, бусдын «магтаалыг» сонсохыг түрүү боддог. Баатар зоригт, ов мэхт, баян чинээлэг ер юу гаар ч атугай «хэлүүлэх» гэж бодсоор явж өрөөлийн «хэлээгүйг» анзаарах сэхээгүйд хүрч, нэг л мэдэх үнэндээ тийм болчихсон мэт сэтгэж сэтгэлээ хуурч ялангуяа даг хүмүүс юм. Ийм хүмүүс бас гурван янз байх аж. Нэг нь харийн хүмүүст магтуулах зүйлийг эрдэг. Тэдээ ухаангүй, гэвч хүн. Удаах нь өөрийн хүмүүст магтуулах зүйлийг эрдэг. Түүний тэнэг чанар нь гүйцэд гэсэн хүнлэг чанар нь гүйцэд бус. Гурав дахь нь зөвхөн өөрийн гэрт юмуу эсвэл айл саахалтынхандадаа хэлэхгүй бол өөр бусад хүмүүс сайрхаж магталаар газар зүйлийг эрдэг. Энэ нь тэнэгийн тэнэг, мунхагийн муухаг хийгээд хүн биш хүн юм.

Харь түмэнд магтуулахыг бодогчид ард түмэндээ сайнаар хэлүүлэхийг боддог. Ард түмэндээ магтуулахыг хүсэгчид ах дүүдээ магтуулахыг бодно. Ах дүүсээ магтаал хүсэгчид зөвхөн өөрийнхөө төлөө л бодож өөрөө өөрийгөө магтуулж явсаар бүхэнд хүрнэ гэж хуурдаг.

ХОРИН ХОЁРДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Одоо үед манай казахын дотор хэнийх нь талд орж хэнийг хүндлэхээ үл мэднэм.

Баяныг хүндлэх гэхлээр тийм баян байхгүй. Баян

хүн өөрийн эрх мэдэлтэй, өөрийнхөө малыг хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэж байдаг. Гэтэл өөрийнхөө малд эзэн болох баян алга. Зарим баячууд бусадтай хүч булаацаалдахын тулд зуун зуун хүнийг зусардан хөрөнгө буянаа үрж, хар сэтгэлтэнд хахууль өгч, түүнийгээ гүйлганд өглөө гэж бодно. Ухаарах ухаан дутсанаас мунхаглаж байгаа нь тэр! Түүнээс гүйлгах бус, гүйж гувшиж өгч буй хэрэг. Ач тус ч бус, эрэлхэг эрхэм чанар ч бус, нутаг нэгтэй ард олонтойгоо тэрсэлдсэн ухвар мөчид бодолтойгоос ухаан мөчид нэгэнд өврөө дэлгэж, буянаа хоослохоос хэтрэх зүйл бишээ. Зарим баячууд, ихэс дээдсийн өвөр хоорондын маргааныг далим болгон олширсон залт этгээдүүдээс хулгаж, тэдэнд тал засахын төлөө арга баран, тар тасарч, хэн нэгний идэш хоол болж явна.

Ихэс ноёдыг хүндлэх гэтэл, олонд өмөг түшиг болохуйц сайн язгуурт ноён алга бөгөөтөл хар сэтгэлд малаа өгөгч нь нохойноос олон. Нэг нь амин хонжоог олохыг оролдож олбог суудлыг санаархвал нөгөө нэг нь хошгоногондоо давст эсгий чихүүлсэн мэт учраа алдан, хэн таарадсан болгонд алцайлж хөхүүлж явна.

Хошуу тайж, шүүгчийг хүндлэх гэтэл, аллах бурханаас илгээсэн үнэнч тайж, шүүгч бас л байхгүй. Олонд тал засаж, нэр төрөө худалдаж олсон тайж шүүгчдээс ямар ач ивээл байх билээ дээ!

Хүч чадалтанг хүндлэх гэтэл, муу үйлэнд хүн болгон хүчтэн болохоос зөвийг бодож сайн сайхан юманд хүчээ-үзүүлэх жинхэнэ хүчтэн бас байхгүй аж.

Ухаант хүнийг олж хүндлэх гэтэл, хүнийг муу муухайгаас ангижруулан сэтгэл ариусган тэгшитгэх зөв элэгт ухаантан байхгүй. Мунхаг мугуйд, буруу үйлэнд хүн болгон ухаан сүвлэх аж.

Өнчин өрөөсөн, үхээнц өтгөсийг хүндлэх гэтэл, хэвтээ тэмээг мордож чадахгүй ч, мөр зөв ноомой явах нь бас үгүй. Хэрэв яльгүй л чадал суувал яагаад ч гэсэн санаснаа гүйцээнэ.

Өнөөдөндөө итгэл найдлыг тортогох залт этгээд, ов мэхтэнгүүд л үлдлээ. Тэд сайн үйлийн нүдийг таглаж, хатааж ширгэтэл санаснаа хийх гэж санаа амрахгүй.

Эцэст хэнийг хайрлаж, хэнийг бодов доо? Өтлөж,

ялзарч буй тайж ноёдыг ч яахав өнөөдөндөө бодохоо больс. Юун түрүүн хүлцэнгүй ноомойгоосоо болж «Буяныг бодогч, хэрүүл бодохгүй» гээчээр өглөг ивээл өгдөг хирнээн ач буяныг нь амсахгүй, хөрөнгө малаа эзэн болж гүйдэлт хулгайч этгээдүүдээс хамгаалж чадалгүй залт нэгний идэш болгож яваа үнэн даруу баячуудыг өрөвдөж хайлаж тэдний буяныг бодохгүй бол ѿор бусад хүнд тусг үйлийг олж нэрлэхэд хэцүү.

ХОРИН ГУРАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Бидний казахад чөдөр тушаа болж байгаа нэгэн зүйлийн тайтгарал, нэгэн зүйлийн баяр баҳархал байдаг.

Баяр баҳархал нь-нутаг уснаасаа нэгэн муу хүнийг олж өөрийнх нь хийж үзээгүй үйлдэл түүнд байх аваас учиргүй баясаж, баяр баҳархал болгодог.

Хэлэх үг нь: «Тэнгэр өршөөг! тэр гуай зайлцуул өөрийгөө хүн гэж боддог байх даа, түүний хажууд бид сэтгэл цэвэр хүмүүс юм даа!» гэнэ. Аллах бурхан түүнд тийм хүнээс илүү л байвал болно гэж зарлиг буулгасан гэж үү? Хүн мууг бус сайныг дагаж саруул сайхан явах ёс хайчив? Зуун морь уралдаж түрүүлсэн нь барианд ирснээ хэлж болох, харин сүүлдэж ирсэн нь төчнөөн морины урьд ирлээ удаад нь төчнөөн морь байсан гэж хэлэх нь юуны уг болох? Би тав, арван морины урьд ирлээ гэвэл тэр нь юуны баяр байх?!

Тайтгарал нь: «За ганц бид л гэж үү, энэ олон түмэн бүгд л адил шүү дээ» гэж хэлээд, түүнд сэтгэлээ тайтгаруулдаг.

Тэнгэр аллах бурхан тэдэнд мөн адил «олны аяиг дагаж сүүл барихгүй явбал болно» гэж зарлиг буулгасан гэж үү? Хүн нэг бүрт зарлиг хүрэлцэхгүй гэж хэлсэн гэж үү?

Эрдэм ном бүхэнд хамааралтай юу эсвэл нэг хүнд хамааралтай юу? Суут ухаан олноос төрөх үү, эсвэл нэг хүнээс төрөх үү? Хүний олонд зовлон тохиохгүй гэж үү? Нэг ам бүл зэрэг өвчлөх гэж үү, эсвэл тал нь өвдөж, тал нь эрүүл байх нь илүү юу? Газар мэдэхгүй төөрсөн олонд газарчлах нэг хүний хэрэг үгүй гэж үү? Аянчин олны уналга зэрэг эцэх нь илүү юу, эсвэл тал нь илүү юу? Олон тэнэгийг нэг тэнэг нь тайтгаруулж чадах үү? Өмхий амтай эрийн «бид удмаараа өмхий

амтай» гэж хэлэх нь эхнэрт нь таалагдана гэж үү? Тэгж хэлсэнээрээ эхнэрээ тайтгаруулж чадах үү? Тэгвэл, олныг дагаж өмхий амтай явах нь сайны нэр үү?

ХОРИН ДӨРӨВДӨХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Өдгөө дэлхий ертөнцөд хоёр тэр бум илүү хүн, дөрвөн сая¹ казах амьдардаг гэдэг. Бидний казахуудаас нөхөрлөл, дайсагнал, баҳархал, зориг, чадал, эрдэм сурх, буян хураах, өрөөлийг таних... зэрэг бүхий л үйл, зан чанар нь өөр бусад ямарч ард түмэнтэй адилгүй.

Бид биесээ дэмжиж дээш гаргахаасаа илүү мөр бүтэн хүнд чөдөр тушаа болж, бэлэн юм авахыг урьтал болгодог. Дэлхий ертөнцийн зах хөвөө хязгааргүй, таван тивийг гурвантаа тойрч узсэн ч хүн ард бий. Өөр бусад ард түмэн ийн ахул бид ингэж дэлхий ертөнцийн хүмүүний адаг сүүлийг барьж, хоосон гар хумхиж суугаад байх үү? Үгүй, хүн ёсыг дээдлэн аливаа эрдэм хийгээд буяны мөрд үнэнчээр зутгэж, зөв мөрөөр мал хөрөнгө, буян үйлийг алс чанадаас цуглуулж олох эрдэм бүхий хүн төрөх болов уу гэх горь төрөх авч, ай даа хол биз дээ гэсэн итгэл үгүй болол хамтад зовоох нь зуун хүний сайн үйлд хоёр зуун хүн шүдээ тас зууж, хорон шүлсээ залгиж явдагынх буюу!

ХОРИН ТАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хүүхдэд сүсэг бишрэл, эрдэм ухаан сургах нь сайн гэвч сүсэг үйлдэх төдий, араб үсэг тайллах төдий сургавал болно гэж үзнэ. Манайд энэ бодлого маш их алдаатай бөгөөд юуны урьд мал хөрөнгө цуглуваж байж л удаад нь араб эсвэл латин үсгээр ном сургах хэрэгтэйг ташаарч ойлгодог.

Гэдэс өлсгөлөн хүний бодолд нь ухаан, биед нь ичгүүр, эрдэм номонд шамдах хүсэл тэмүүлэл яахин байх билээ. Цадтал хооллохын тулд хичээх тарчиг ядуурал нь ах дүүгийн эв түнжин хагарах.. муудалцаал, зан төрхийн эвдрэл, хуурч зусардах, хүч хэрэглэн хулгай хийх бүхэнд түлхэж оруулахаас цаашгүй байдаг. Малтай хүний гэдэс цатгалан. Түүний дараа мэдлэг

боловод түүнчлэн урлаг соёл хэрэгтэйг улаарч өөрөө сурх эсвэл үр хүүхдэд сургах гэсэн хүсэл буй болно. Оросын эрдэм ухааныг сурх хэрэгтэй. Аугаа гайхамшигт оюуны соёл мал буян, урлаг, шинжлэх ухаан бүгд Оросод буй нь үнэн. Гэхдээ тэдний саар бүхнээс зугатан хөндийрч сайн бүхэнд ойр байхын тулд хэл, соёл, урлаг, эрдэм номыг төгс мэдэх хэрэгтэй.

Тиймээс ч тэд орчлонгийн хэлийг түрүүлэн эзэмшиж ийн байдалд хүрчээ. Тэдний хэлийг сурвал оюуны нүд тайлгадана. Ямар нэг үндэстний хэлийг сурч эзэмшсэн хүн тэдний дунд адил тэгш эрхийт олж нүд үзүүрлэгдэхээс ангижирдаг. Эрдэмтэй хүний сэтгэлийг олохын тулд харалган мунхаг хүн ах дүү, амраг саднаа зарахаас ч буцдаггүй юм. Зөвхөн хошуучийн инээд хэрэгтэй гэж сэтгэж бөгсөө шалдалж яваагаа ч ухаардаггүй. Оросын шинжлэх ухаан соёл нь-ертөнцийн тулхүүр, түүнийг сурч эзэмшсэн хүнд ертөнц ч хялбар бус уу. Үнэн байдалдаа өнөө үед үр хүүхдүүдээ орос түмний боловсрол мэдлэг сургаж буй хүмүүсийн ихэнх нь тэднийг Казахыг ойлгох сүр хүчинийг нэмэх зэвсэг болгохи төлөө л сургаж байгаа бололтой. Энэ нь буруу юм. Хүний баян чинээлэг сайн-сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлэх, эрдэмтэй хүнийг саар мунхаг бусад хүмүүс даган дууриаж түмэн олон ардыг төрийн нэгэн хуульд захицуулж байхын тулд оросын олны хүлээн зөвшөөрсөн хууль үйлчилдэг. Үүн лүгээ адил казах хүн казахдаа эзэн байж, эв нэгдэлтэй улс болж, бусдын сурч буйг сурч мэдэхийн тулд бидэнд нэр их зутгэл эрдэм боловсрол хэрэгтэй. Одоо ч гэсэн орос оронд сурч боловсорсон хүүхдүүдээс илүү сайн нь үгүй байна. Учир нь: аав-ээж, ах-дүү, амраг төрөл нь хүүхдийг эвдэж, буруу замд оруулж байхаас эрдэм сурх юуны мүү вэ? Тэглээ ч гэсэн мэдлэг эзэмшсэн аливаа хүүхэд нутгийн хилийн дээsnээс холдоогүй бусдаасаа онцгой сайн казах зан чанараас гаждаггүй байна. Ямраар атугай тэдэнд үг хэлж ойлгуулж болно, тэд цөмөөрөө баян эздийн хүүхэд биш харин ихэнх нь хүчээр албадуулж орос сургуульд явсан ядуучуудын хүүхдүүд шүү дээ. Тэд аргагүйн эрхэнд баяны хүүхдийн төлөөсөнд суралцсан гэнэн амьтад. Мөн зарим казахууд ах дүү лүгээ муудахад «Чиний зовлонд тамлуулж байхаар хүүхдээ орос цэрэгт явуулж, үс сахлаа ургуулан явсан минь дээр!» гэдэг.

Ийм муюу-муухай үгийг тэнгэр бурханаас айж, амьтан хүнээс ичиж зоволгүй хэлж байгаа казахуудын хүүхэд эрдэм сураад ч ямар хүн болох вэ?

Тэглээ гээд бусад казахын хүүхдээс илүү сурсан эрдэм нь хаана байна. Сургуульд орсон нэртэй, буцаж ирсэн нэртэй, хэргэм зэрэг хүртсэн нэртэй болохыг үнэн сэтгэлээс шимтэж эрдэм сурсан хүүхэд бараг үгүй. Эцэг нь ч гэсэн өөрийн хөрөнгөөр хүүгээ эрдэм сургахаас бусдын хөрөнгөөр сургахыг илүүд бодно. Шуудхан хэлэхэд хүүгээ өрх тусгаарлан битгий өмч салгаж өг, бүх хөрөнгөө бараад ч гэсэн орос түмний номын эрдмийг сурга. Миний хэлсэн энэ мөрд-мал хайрлаж болохгүй.

Аллах бурханаас эмээж, хүмүүнээс ичихийг бодож, хүүхдээ хүн дүрст хүн болгох гэвэл-сургуульд оруул, мал бүү хайрла! Эс тэгвээс нэгэнт казахын нохой мөрд орж, буруу хүмүүжсэн хүүхэд энэст нь чамд сайн-сайхан жаргалыг эдлүүлж, түмэн олон, айл саахалтаа хүндлэн буяны мөрөөр явна гэж үү?

ХОРИН ЗУРГААДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Маңай казахын уясан морь нь, барилдуулсан бөх нь түрүүлж, нисгэсэн шувуу нь олз шүүрэх ахул, эсвэл тавиул нохой нь бусдаас өрсөж түрүүнд ан баривал ухаанаа алдтал баярлана. Түүнээс бусад зүйлд тэгтлээ баярлахыг нь би лавтай хэлж мэдэхгүй юм. Магад үгүй байж болох л доо.

Энэ бүхэн казах ахан дүүсний дунд байх авч, бодохул нэгэн адгуус амьтны ур чадавхи хийгээд өрөөл нэгний ялалтанд тэгтэл баярлахын хэрэг юусан гэж инээд хүрмээр. Тэгтэл түрүүлж магтуулагч нь өөрөө бус, үгүйдээ л үр хүүхэд нь бус. Энэ бүхэн нь-казахад казахаас өөр дайсан үгүй, өчүүхэн зүйлийг их зүйл бүтээсний бахдал болгогч, өвөр бусдын хорыг асаах гэсэн хий бодлын үр хөврөл бөлгөө. Өрөөл бусдын хорыг асаах нь-шашин номд харш, бүтээх үйлд хорт, хүмүүн ухаанд буруу утг, бас хэн нэгний хорыг маажиж, эрээгүй сагсуурах нь хүмүүнд юун туст болох! Тэгээд ч уцаарлагч нь тэгтэл юунд газар шагайж хөсөр хаягдсан лугаа хорсдог юм бол?

Хурдан морь нэгэн үе энэ нутагт, нэгэн үе өөр нутагт шандас сорьж түрүүлэх тавилантай. Аинчин шувуу,

гүйдэлт нохой ч гэсэн түүн лүгээ тавилангаар адил амьтан. Хүч чадал төгс эр ч гэсэн үргэлж мөнхийн нэг нутагт төрж өсөж үүрд оршихгүй. Тодорхой үед тохиосон газраа төрж, өсөж амьдраад л хорвоогоос халих тавилантай. Тэгээд ч энэ бүхнийг хүн өөрийн гараар бүтээж чадах зүйл бас биш. Нэгэн удаа түрүүлж, нэгэн удаа дийлсэн бүхэн үргэлж мөнхөд түрүүлээд байж үл чадна. Тэр бүхнийг мэдэх авч аз жаргал үүрдийн юм шиг газарт орох мэт ичиж, буруу зүйлийг үйлдсэн мэт зовж, хор санаахын хэрэгт юу бол доо?

Одоо энэ бүхнийг эрэгшүүлэн тунгааж бодоё. Мулгуйд хүн баярлахгүй юманд баярладаг. Баярлахуйяа юуг хэлж, юуг орхигдуулсанaa анзаарах ухаан алдаж, эрээгүй шинжээ харуулдаг. Бас ичихгүй зүйлд ичих, ичих зүйлд эрээ-цээрийг алддаг. Энэ бүхэн эрдэм номоор нимгэн ухаан санаа хомсын шинж. Эдгээрийг анхааруулан хэлэх үеэс «зөв зөв» хэмээн толгой дохиж зөвчих атлаа удалгүй эргэж мартана. Тиймд тэдэнд итгэж бас үл болно. Тийм хүн бусдын угэнд орж муут үйлдэхгүй байх гэж үгүй. Алтуус лугаа адил араатан шинжээсээ ангижирч, өөрийгөө татах жолоогүй явсаар, гарч чадахгүй гүн ангалд орж дуусна. Хэн ч тийм амьтдыг засч, залруулж эс чадна. Ямар ч муу зуршил байлаа гэсэн казах хүн нэгэнт сурсан зуршилаа айх, эсвэл үхэж дуусах хоёрт л салж орхидог ажээ. Өөрийн ухааныг тунгааж, буруу зөвийг засах хүнийг олоход хэцүү. Магад олж үзэх ч үгүй биз ээ.

ХОРИН ДОЛООДОХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

(Гүн ухаантан Сократ, Аристотель хоёрын мэтгэлцэл)

Нэгэнтээ аугаа их эрдэмтэн Сокраг цэцэн, Аристотель хэмээх ухаант шавьдаа хандаж ийнхүү асуужээ. Тэрбээр энэ хүн урьд хоосон бясалгалин сүсэг бишрэлтэй хүнийг үнэн голоосоо элэглэн шоологчдын нэгэн юмсанжээ.

— Эрхэм Аристотель ээ, хүн авьяас билэг, сүсэг бишрэлийн алинаар эрхэм баян байх ёстой вэ? гэжээ.

— Тийм тохиолдол хүн төрөлхтний түүхэнд ээдрээстэй асуудлын нэгэн байгаа биз гэж Аристотель хариулжээ.

— Тэгвэл түүний аль нэгийг нь нэрлэхгүй юу? гэжээ.

— Аугаа их Гомер гүн ухааныхаа оюуны чадавхийн төлөө, Софокл гуниглал, шаналгаа хосолсон хосгүй сайхан зохиолуудын төлөө, Зэвс аугаа их уран зураачийн увидасынхаа төлөө шүтэгдэн бишрэгдсэн биз. Мөн эдэнтэй мөр зэрэгцэх сод ухаантан зөндөө байсан байлгүй гэжээ.

— Тэгвэл ямар хүнийг аугаа их гэх вэ? Тухайлбал, амьгүй, ухаангүй, ярих хэлгүй дүр зураг бүтээгчдийг үү, аль эсвэл амьд хүн, ухааны эзэн хүнийг буй болгогчийг бишрэн шүтэх үү?

— Сүүлчийнх нь арай оновчтой болов уу. Гэхдээ тэдгээр амьд эснийг бурхан тэнгэр буй болгосон юм чинь Харин хүн хэмээх аугаа их амьтан юуны тулд ухаантай, ухаангүй гэж хоёр тийшээ холбирдог нь юутай харамсалтай гээч,

— Орчлон хорвоод ашиг тустай, ач холбогдол ихтэй юмс үзэгдэл ч бий, отг мэдэгдэх аргагүй зүйл ч зөндөө. Аль нь илүү тустай байдал бол?

— Тиймээ, хүн ардад юу хэрэгтэй байсан тэр нь чухлаас чухал юм.

— Тэгтэл хүнийг бий болгосон хүн төрлөхтөний анхны өвөг Хауана, Хаута хоёр хүнийг анх юутай гайхамшигтай бүтээсэн гэж санана. Энэ хорвоогийн сайн, муут ялгах салгах гэж хосёр пүд заяажээ. Хөмсөг, сормуус дээрээс нь харуулдаг, дороос нь хамгаална гэж бодвол бүгдээрээ өөрийн үүрэг, зорилготой юм. Чихгүй хүн дүлий, уянгат сайхан ая дууг амтархан сонсох аргагүй. Хэлгүй бол оюуны соёл яахан байх вэ? Тагнай, хамар, эрүү, шуд цөмөөрөө нэгийг нөгөө нь төлөөлөх аргагүй өвөрмөц зорилготой эрхтэн. Хүн хэмээх амьд амьтны хайрлах сэтгэл ялгах салгах таашаал, сонирхол байхтүй бол араатан амьтинаас юугаараа ялгарах вэ? Энэ бүхэн хүний эрх ашигийг тал бүрээсээ харгалзан үзэж иж бүрэн маш ухаалгаар, уранаар бүтээсний гэрч биз ээ. Бид үүнд бурлан тэнгэрт бахархаж баршгүй өртэй дээ. Аристотель ингэж хүний нэг ч эрхтнийг дутуугүй нэг нь ч илүүгүй бий болгонд гайхсан ажээ.

— Нээрэн сайныг дагавал сарны гэрэл гэгчээр өөдрөг сэтгэлтэй өсөж хөгжвөл, мууг дагавал лай ланчиг үүрлэх нь мэдээж. Ингэхээр сайн, муу заавал хосолж байдал жамгтай юм. Харин хүн үргэлж өөрийнхөө сэтгэл санааг ариусгаж явах нь зүйл зохицтой биз ээ.

Гүн бодолд автагдсан Сократ уг асуудлыг лавч-руулан гүнзгийрүүлж цааш нь хэлсэн нь: — Эрхэм хүндэт Аристотель ээ. Та яахаараа иарт хорвоод хүнээс өөр ухаантан үгүй гэж бодов оо гэж хариу асуужээ.

— Хүний бие цогцос бол өөрийн өсөж төрсөн нутгийн элсний эс ширхэгтэй адил юм. Хүний биед агуулсан ус, цус газар эхийн өчүүхэн дусал мэт. За, тэгвэл энэ бүхнийг яаж сэтгэж ойлгож авах вэ. Хүний амьд биеэс эрхэм чухаг зүйл энэ хорвоод байдаг гэж үү?

Нээрэн аллаг дэлхийд бий болсон алив амьд эс өөрийн жам хуулттай, зорилго, чиглэлтэй. Өсөж төлжих, хөгжих, цэцэглэх, зогсох хуулттай. Амь гэж байхад сүнс гэж байх ёстой гэж шашны номлолд сургадаг. Үүнд учир утга байж болох л юм. Түүний нууцыг тайлах нь шинжлэх ухааны хэрэг биз ээ. Хүний оюун ухааны чадавхи гайхамшиг биш гэж үү?

— Эрхэм хүндэт багштан, таны түрүүнээс хойш айлдсан нь түмэн зөв. Энэ бүхнийг бурхан тэнгэр буй болгосны ид шидийг хэн яахан үгүйсгэх вэ. Харин тийм атал аугаа их үйлсийг бүтээгч, амьгүй эсийг амьтай болгогч, ухаангүй амьтныг ухаалаг болгогч аугаа их ид шидтэн Аллах бурхан чинь гагцхүү маань мэтийн өчүүхэн амьтны сүсэг бишрэлээр яахаараа дутаж орхисон бол доо?

— Аристотель, та арай дэгсдүүлж байна Хүн чиний төлөө бурхан тэнгэр ургэлж буян үйлдэж бузар юмыг холдуулж байна. Түүнийхээ төлөө чи насан туршид Аллах тэнгэрт өртэй гэдгээ мартуузай.

— Аллах бурхан өршөөж хайлраг! Өчүүхэн мунхаг би миний төлөө цаг үргэлж аллах бурхан анхаарал халамж тавьдагийг би яахан мэдэх вэ гэж тэрбээр их эрдэмтэн маг маг инээжээ.

— За, тэгвэл өөрийгөө бас сайн ажиж харагтун, мөн адил адгуус амьтныг өөртэйгээ зэрэгцүүлж бол. Хүн бол өнгөрсөнөө, одоо ирээдүйгээ сайн ойлгож чаддаг аж. Амьган бол гагцхүү онөөдрийг хагас дутуу мэдэрнэ. Ирээдүйг урьдчилан харах гэж ер үгүй. Жигүүртэнд далавч, адгууст дөрвөн хөл, хүнд босоо байж эргэн тойрноо сайн ажиглаг гэж хоёр хөл заяажээ. Хүн өөрийн хүчинд, оюун ухаандаа итгэхгүй ирээдүйгээ тооцөөлөхгүй бол юу болохсон билээ. Ирээдүйд итгэх, хойч

үедээ найдвар хүлээлгэх өөдрөг үзэл гэж бий. Адгуус амьтан гагцхүү идэж уух, унтаж амрахаас өөр юм боддоггүй. Хэрэв адгуус амьтанд хүний ухаан заявал өчүүхэн, дожоо мутай хоёрхон хөлтэй хүн хэмээх амьтанд юу болохсон билээ. Ёстой үхэл, мөхлөөс өөр замгүй. Хүнийг хүн шиг болгосон нь оюун ухаан, хийж бүтээх хүслэн эрмэлзэл биз ээ. Хүний бүтээсэн аугаа их гайхамшиг гэж бий. Аварга том амьтны бүтээсэн өчүүхэн үйлс үгүй. Их л сайндаа том нь багыгаа олонх нь цөөнхөө устгаж үгүй хийх жамтай. Хүн гэдэг аугаа их гайхамшигийг бүтээсэн Аллах бурхан мөн аваас түүнд залбиран сүсэглэх нь түүний төлөгдөж баршгүй өр төлбөр нь энэ буй заа.

ХОРИН НАЙМДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Өө, мусульманчууд аа! Нэгэн хүн баян байх, нөгөө нь ядуу байх. пэг нь өвчлөх, нөгөө нь эрүүл байх, нэг нь ухаантай, нөгөө нь тэнэг, бас тэгээд нэг нь сайныг дуурнах нөгөө нь мууд тэмүүлэх эл бүхэн юун учир вэ? хэмээн асуувал, манайхан энэ бүхэн аллах тэнгэрийн зарлигаар болж байгаа юм гэж хариулна. За, тийм байж гэмээ нь аллах тэнгэр буруу үйл, буруу санаа байдаггүй хэмээн итгэж бас тарни үйлдэнэ. Бас аллах тэнгэр үйл нь хазгай, үгээгүй нэгэнд буян заяах аж. Ижил-гүй ганц аллахыг шүтэн биширч, үйл бүтээж, ашигтайг эрсэн хүний үйлсийг хазайлгаж, авгай хүүхдээ тэжээх тэнхэлгүй болгож, ядууруулдаг юм байна. Хэнд ч халгүй исомой нэгнийг өвчинөөр шаналуулж, зовоодот юм байна. Тэгэх авч хaa хамаагүй нэгэн хулгайч, хар элэгтний махбодийг эрүүл заяадаг байна. Нэгэн аав ээжийн хоёр хуудийн нэгийг нь ухаантай, нөгөөг нь тэнэг болгодог байна. Түмэн олонд бурууг бүү үйлд зөв мөрийг дагагтун гэж зарлиг буулгадаг байна. Зөвийг үйлдэгчлийг диваажинд залж, бурууг үйлдэгчдийг тамд унагана гэж хэлэх авч олон шавь нарынхаа нэгийг мую үйлд зарж, нөгөөг нь сайн үйлд хөтөлдөг гэнэ. Энэ бүхэн аллах тэнгэрийн бүхнээс ариун амгалант, үнэн мөнийн буянт шударгуу ёст тохирох гэж үү? Түмэн олон шавь, төгс олон буян мал бүхэн өөрийнх нь хувь хишиг шуу дээ! Энэ бүх үйлийг нь юу хэмээн ухах вэ? Өөрийн буяныг өөрөө л захириа. Түүнийг буруутган хэлж болох-

ҮЙХЭМЭЭВЭЭС ТЭР НЬ АЛЛАХ ТЭНГЭРИЙН БУРУУ ҮЙЛ, НҮГЭЛ НЬ БАС БАЙДАГ АВЧ БИД ХЭЛЖ ЗҮРХЛЭХГҮЙ ГЭСЭНТЭЙ УТГА НЭТЭН БУЙ. ТИЙН АХУЛ ХҮМҮҮН ДАН ГАНЦ ӨӨРИЙН ЗҮТГЭЛЭЭР ЮУГ ОЛОХ БИЛЭЭ Л. БУХНИЙГ БУТЭЭН ЗОХИЦУУЛАГЧ НЬ АЛЛАХ ӨӨРӨӨ Л АЖ. ХҮН ХҮНДЭЭ ГОМДОХЫН УЧИР Ч АЛГА. ХЭН САЙНЫГ, ХЭН БУРУУГ ҮЙЛДЭЖ ЯВЛАА Ч АЛЛАХ ТЭНГЭРИЙН ЗАРЛИГИЙГ ГҮЙЦЭЛДҮҮЛЖ БАЙНА ХЭМЭЭН УХВАРЛНАМ.

Аливаа ухаант хүнд шүтэхгүй зарлиг, шүтэн бишрэх сүсэг хүлцэл зарлиг байх аж. Бас аливаа үнэн үйл ухаанаас эмээхгүй учир байх аж. Чингэхүй бид ухаарлыг дураар нь тавилгүйгээр аллах тэнгэрийн ухаан төгс хүнд шүтэхүй зарлиг буулгана гэдэг маань юусан билээ? «Хүмүүн намайг ухаалгаар танина» гэх номлол нь хаана үлдэх билээ л! Шашинд маань хүнээс нууц хоосон зүйл байхгүй бол, ухааныг захирч болох гэвч хүмүүн бие хүлцэх байсан гэж үү! Ухаан зарлигийг эс хүлцвээс, шашин бас юунд тогтох билээ л! Нэн түрүүн шүтэхүйг ухаарагчтүйгээр ном хүлцэл үйлдэх нь чухал гэж бодож нь юу л бол! Үгүй ээ! Чи сайн мууг бүтээгч, өвчин эмгэгийг илгээгч нь эд баялаг, эмгэг ядуурлыг заяагч нь аллах тэнгэр бус хүмүүн бидний үгээгүй зан үйлсээс болж буйг түйцэд ухаарваас сая л үнэнд нийцэх амой.

ХОРИН ЕСДЭХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Казахын зүйр цэцэн үг ихэнхдээ амьдрал үйлд ойртох авч, эс ойртох байтугай сүсэг бишрэл хүмүүнлэг чанарт дүйхгүй үг ч олонтаа тохиолдох аж.

Нэн түрүүнд «Ядуу хүнд ичгүүр хэрэггүй» гэжээ. Ичгүүр сонжуураа алдсан хүн, амьд явахын хэрэг юун. Хэрэв ядуу үедээ зарц хийсэн ч гэсэн буян хуралдуул гэж захисан бол тэр нь харин ёст үйл бөлгөө. Гар хумхин сууж, харцаа үнэлж бүгдийг харалгүйгээр хөдөлмөрлөн байж мал буян цуглувалснаас энэ нь ичгүүр сонжууртай хүн ёсонд ийицэх бөлгөө.

«Эвт хүн мөс хайлцуулдаг». «Гүйж чадсан хүн авч чаддаг» хэмээх тэнгэр ниргэмээр ч адайр үг байдаг. Гүйх аргыг нь олж, эвийт нь тааруулна гэж зовлонт амьдрал гэтэлснээс газраас гүйх юмуу эсвэл асгаруулсан дусал хөлснөөс гүйвал арай дээр бусуу.

«Гавъялагаараа эс алдаршвал, газар дэлхийг галдан-

шатаа» гэжээ. Ой мод газар дэлхийд түймэр тавьж галдан шатааж алдаршихын хэрэг юун? «Зуун өдөр бурантагтай ат болж явснаас ганц өдөр ч буур байсан нь дээр» гэж хэлжээ.

Аллах тэнгэрийн зарлигийг хүлцэхтүйгээ турж, эцэж даяанчын мөрөөр ганц өдөр буур болж зовлон хуваахын ач тус гэж юусан билээ? «Алт үзэхтүй Лха тэнгэр мөр хазайдаг» гэдэг. Лха тэнгэр ниргэмээр. Лха тэнгэрт алтны тус юу байх билээ л, харин өөрийн мунхаг тэнэгээ харуулах бус уу.

«Аав ээжээс мал илүү, алтан голомтоос амь илүү» гэжээ. Аав ээжээсээ илүү эд буянд дурлагчийн илүүд байх амь гэж юу л бол доо! Аав ээжийгээ малаас дорд үзнэ гэдэг нь тэнэг мунхагын шинж бус уу! Эцэг эх хүн зовлонг үзэн эд мал цуглууллаа ч гэсэн үлдэн буй үр хүүхдээ гэж боддог. Тэрбээр эцэг эхээ зарна гэдэг нь аллах тэнгэрт хүртэл дайсагнаж байгаа хэрэг амой. Ийн мунхаглан хэлэгдсэн цэцэрхсэн үг сургаалаас холуур явах нь зүй.

ГУЧДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хүмүүнд тус болохоос, тээр болох нь илүү «хоосон магтаал» гэж нэтэн зүйл зан авир буй. Тэр нь юун хэрэг болж, юу бүтээдэг болоо? Тэрбээр тийм хүмүүнд холын бодол, ичгүүр, зориг тэвчээр, хүсэл зорилго аль аль нь үгүй бөлгөө. Хүзүүгээ гэлжийлгэн: «Өө тэнгэр гэж, хэн хэнээсээ илүү гарах билээ дээ, хэн хэнийг гэж явах билээ л, хэний хоолыг хэн бэлдэх билээ, би түүнээс гүйлга гүйж, саалийн ямаа, чөдрийн морь нэхсэн гэж үү» хэмээн бултагнаж үгүй бол ганц амь юунд бөөцийлэх вэ, их л бол буудуулж, дутлаа гэхэд нутаг заагдаа л биз. хаана ч гэсэн нэгэн үхэл байхаас хойш гэж тэнэгээ гайхуулах хүн олон байх юм.

Та бүхэн мэдэх, хэлсэн үг нь өвч биед нь зохицох казахыг олж харсан гэж үү? Үхэл давах казахыг үзсэн ч үгүй. Хий хашигирч хоолой заахаас цааш хэтрэх ч үгүй. Хэрэв дээрх үг үйлэнд нь зохицох хүн тааралдуул ухаанаараа бус ч гэсэн, төрөлх авиаараа хүн бишрэхүйц байгаа шинж авай. Хэрэв хэрүүл шуугиан сонсохуй, орох нух ололгүй тэврэх авч олныг үгээр сүрдүүлэн «хүн аймаар амьтан» гэж хэлүүлэхийн төлөө л

хоосон сүр бадруу тагчдыг юу гэх билээ л. Тэнгэр нийрэг гэм! Биед тэнхээ хайрлаж, улаан нэмэх, жинхэнэ зориг бухий өглөгч тусг эрчүүдийн гөрх авирыг тэднээс яагаад ч олж үзэхгүй л юм. Ичгүүргүй хүнд, чалчаа завьж заяадат гэгчээр, эрээгүй хоосон чалчигчдын ач тусг гэж юу билээ.

ГҮЧИН НЭГ ДЭХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Сонссон зүйлээ мартахгүй байх дөрвөн төрлийн арга буй: Нэн түрүүнд: сэтгэл амгалант бөх байх, хоёрдугаарт: сонсож мэдсэн, үгүй бол үзсэн харсан зүйлээсээ ухаарал авах, үнэн сэтгэлээс тэмүүлэн, дурлаж чин сэтгэлээсээ сурах, гуравдугаарт: үзсэн зүйлээ түмэнтээ эргэцүүлэн бодох, зөвийг тунгааж ухварлах чадалтай байх, дөрөвдүгээрт: сэтгэлд түвшин бус зүйлээс холуур байх. Хэрэв санаандгүй тулгарлаа гэхэд түүнд сэтгэл алдахгүй байх. Цаг үргэлж сэтгэлээ ариусгаж нүглийг тэвчиж, буяныг бузарлахгүйг хичээх.

Сэтгэлд амгалант бус зүйлүүд: гуниг үгүй, саланга байдал, шоглоомт инээд, нэг зүйлд хэтэрхий гуниглах; аливаад хэт шунах шунал. Энэ дөрөв бол аугаа их ухаан эрдмийг сөнөөгч хор мөн.

ГҮЧИН ХОЁРДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Эрдэм ном сурахын хүслэнт хүмүүнд нэн түрүүнд анхаарууштай зүйл сэтгэл зурхний тэмүүлэл байх ёстой. Үүнд бас хэд хэдэн зорилт байдаг. Тэдгээрийг зайлшигүй мэдэх шаардлагатай. Хэрэв эс мэдэж гэмээ нь хамаг зорилго нь талаар болох бөлгөө.

Нэн түрүүнд эрдэм номыг ертөнцийн нэгэн сонирхолтой зүйлийг л нээж мэдэх төдий болохгүй байх. Түүний тулд эрдэм номд зохицох бухий зөв мөрт тэмүүлэл, зөвхөн сурч боловсрох замыг чухаг болговоос. аливаа мэдэхгүй зүйлээ олж мэдэх агшин бүрийд сэтгэлийн баясал эдэлж амирлангуйг олох бөлгөө.

Тэрхүү амгалант мэдлэгээ чанд хадгалж, мэдэхгүйдээ улам тэмүүлэх тэмүүлэл нь эрдэм номд туушт хайрлах хайрыг бүрдүүлэх авай. Тэгэх ахул сая эрдэм номын жинхэнэ үүдийг нээж, сонссон хийгээд үзэж харсан зүйлээ зөв ухаарч, жинхэнэ дур зургаар нь сэтгэл оюунаа хадгалах чанар буй болно.

Хэрэв сэтгэл шүтээнт нь өөр бусад зүйлд тэмүүлэй байх буюу ашиглах төдий ном эрдэм сурах аваас тэр нь өргөмөл эхийн хайртай ялгаагүй болно. Хүмүүн сэтгэл зүрхээрээ үнэн дурлаваас эрдэм ном ч гэсэн ивээл хайрланга, оюунд хялбар хоногшино. Дутуу сэтгэл дутуу ухаарал буй болгоно.

Хоёрдугаарт: эрдэм ном сурахад үнэнч шударгуу бодлоор хандах нь зүй. Бусдаас илүүд болохын төлөө ном сурах нь хазгай зүйл. Гэвч, бага зэргийн илүүд бодол буруу ч бишээ, харин хэт илүүд бодол нь хүнийг залах байтугай буруу мөрт хөтөлдөг. Учир ину: Аливааг илүү боддог хүн зөвхөн илүү харагдахын тулд бус, ялахын тулд тийн бодол өвөрлөдөг. Хүнээс илүүд гарах бодол атаархал төрүүлэх авч хүн чанарыг таниулдаггүй, харин хүний мөн чанарыг алдагдуулдаг. Зорилго нь номын бус хүмүүний оюуныг төөрөгдүүлж, буруу зүйлд хөтлөхийн төлөө л чиглэдэг. Ийм зөв бус мөрөөдөл хар буруу бодолтой хүмүүнд л байдаг. Зөв мөрт яваа зуун хүний мөрийг хазайлгагчид гарлага болог! Илуүг бодох нь номын нэг мөр авч түүнд үл цадагч, харам байдал зохицохгүй. Хэрэв тийм бодол өвөрлөж гэмээж нь хэт өөриймсөг бодол, онгироо байдал, узэн ядагч сэтгэл бисийг нь эзэгнэвэл тийм хүн хүмүүнд хор хүргэгч худал уг, хов жив, хэрүүл зодооноос ч хол байж чадахгүй.

Гуравдугаарт: Аливаа үнэнд тэмүүлж, хүн чанарт хүрч чадах аваас зөвхөн түүнийг эрхэмлэн ямагт салахгүй байх нь зүй. Хэрэв чиний мэдлэг ухаарал өөрийгөө эс ялах аваас өрөөлд яахин хэрэг болох билээ л? Өөрийн бие хүндлээгүй хүнээс өрөөл бусад нь яахин туслыг хүлээх?

Дөрөвдүгээрт: Эрдэм номыг баяжуулах хоёр зэмсэг хүмүүний дотод сэтгэлд агуулагдан буй нь нэг нь бодох, бодлоо хуваалцах, хоёр дахь нь өөрийгөө хадгалах чанар юм. Энэ хоёр чанарыг ямагт бодож хамгаалах нь зүй. Эдгээр нь хөгжихгүйгээр эрдэм дэлгэрэхгүй.

Тавдугаарт: Эл үгнүүдийн арван ест яригдсан ухааны гажуудалд холбоотой дөрвөн зүйл буй. Түүнээс хол байх нь зүйтэй. Түүнд гүнниглангүй саланта байдал гэж буй, ямагт түүнээс сэрэмжтэй байх нь ач тустай хийгээд нэн түрүүн бурханы, хоёрт ард түмний гуравт эд

буяны, дөрөвт номын, гавд ухаан мэдлэг бүхний дайсан тэр мөн бөлгөө.

Зургадугаарт: Эрдэм ном, ухаарлыг хадгалсан зан чанар гэгч буй. Үзэн ядагч, хөнгөмсөг байдал, хэн нэгний утгагүй үгэнд, нэг л тохиох жаргалд хууртаж гэмээж нь зан чанар алдарна. Тэгж гэмээ нь эрдэм ном сураад ч тусыг олохгүй. Хийх сав үгүй бол түүнийг хаана хадгалах билээ л. Хийе гэнээ хийх, бүтээх гэнээ бүтээх зорьсондоо хүрэх чанартай үгэнд ухаантай, сэтгэлийн хаттай байх хэрэгтэй. Энэ бүхэн ухаарал, хүн чанарын төлөө л юм шүү!

ГУЧИН ГУРАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хол, ойроос уран хүнийг олж, хамт үйл бүтээж, сурхыг бодлоггүй, гарг буй өчүүхэн ураа юманд бодож, сэтгэл ханан мөнөө л казахын урагшгүй занг өвөрлөн хэвтэхээс хэтрэхгүй хүмүүс бий. Хоёрдугаарт: Хүн нэгэнт сурсан зүйлээ залхуурлалгүй хийгээд байж эцсийг нь үздэг, атал казахууд ганц нэгэн бодын шир харанггуут л малд хахсан хүний дүр үзүүлэн «надад мал олдохгүй гэж үү?» гэх шиг хоосон ихэрхэл, үлгэргүй хойрго, залхуу, саланга зангаар биеэ зовооно.

Гуравдугаарт: «Чи бүхнийг чадна, гарын уртай хүн юунд алзах» гэх юмуу эсвэл «ахайтан минь юу байхав, энэхэнийг хийгээд л өгөөч» гэсэнд өөрийгөө хүн гүйх эрдэнэ мэт бодож, аргат үгэнд хууртан, алтан цагаа хоосон өнгөрөөнө.

Дөрөвдүгээрт: Найзархаг байдаг мөнөөх залт этгээд найз болъё хэмээн үл ялигхан зүйл өгсөн болood л «сүүлд болно биз найз минь» гэж мөрийг нь алгадсанд мөн л сэтгэл хууртан, бас шугаас холдож юм үзээгүй харалганаы гайд автан дэмий хууртан өрөөлийн хүссэнийг бүтээх гэж хайран цаг, хамаг хөрөнгөө үрж өрөнд баригдан, өр төлөхийн тулд бусдаас дахин гүйлга гүйж «хойморт морил» гэсэн ганц угний төлөө насаа элээж, хорвоог барна. Энэхэнийг хийх, төдийхийг бүтээх гэж явсаар олз ашиг олширч, буян хишиг хуралгүй өр нь ихдэж, барьцаанд хүлэгдсээр хүн чанарыг алдан, эрээгүй нэгэн хоног элээнэ. Ийм залхуу зан юунд хэрэг болно вэ. Казахын хайран хөвгүүд бусдыг хуурч чаддаг мөртлөө бусдад хууртдаг нь юных болдоо хөөрхийс.

ГУЧИН ДӨРӨВДӨХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Үхэл гэж зовлон байдгийг, тэрээр бас нас үл харгалзан тохиолдогыг хүн болгөн мэднэ. Казахууд үүнд бас итгэх авч сэтгэлд чандлан гүйцэд ухаарч үнэнээр мэдэрч үл чадах аж. Тэгэх авч бүхнийг бүтээгч бурхан байдаг, тамын зоволго зөв мөрийн диваажин гэж байдаг, тэрээр сайныг диваажинд жаргааж, мууг тамд зовоодог гэж мэдэх авч хараахан гүйцэд ухаж бас үл чадна. Тэр аллах тэнгэрт итгэж мөргөх авч үнэн мөнөөс хазгай, хоосон бишрэх авч, сэтгэл угт бататгаж авах эрдэмгүй байдаг. Диваажин там хоёрт үнэн итгэсэн хүн зовлон бодож гүнжкын хэрэг юун? Түүнд зохицох сайн үйлсийг эрж олоод болох шүү! Хэрэв энэ хоёрт дутуу итгэх аваас тийм хүнийг юугаар итгүүлж болох? Түүнийг яхин засаж болох? Тэднийг тарни номт мусульман гэж яхан хэлж болох?

Хэн ч атугай хоёр төрөлдөө зовлон амсахгүй байхыг хүсвээс харалган занг орхиж, нүд тайлах нь чухал, ямар ч хүний сэтгэлд хоёр жаргал, хоёр хүсэл зэрэг орших гэж үгүй. хоёр гуниг, хоёр аймшиг бас зэрэг тохиохгүй. Энэ бүхнийг хамтад тохиох зүйл гэж хэлж болохгүй. Тэгвэл хэн хүний амьдын гуниг, амьдын жаргал хойт насын гуниг жаргалаас илүүд байх аваас мусульман биш. Бодож үзэхэд: Манай казахууд мусульман мөн аж. Хэрэв хоёр зүйл байх аваас, нэг нь хойт насанд, нөгөө нь энэ төрөлд хэрэгтэй, нэгийг нь авч нөгөөг нь эс хүртвэл хойт насанд, хэрэгтэй зүйлийг эс авч, дараа хожим ээлж болоход хүртэх л биз гэж, хэрэв эс хүртэх аваас өглөгч тэнгэр аяндаа өгөх л биз, энэ удаад ээлж тохиосон зүйлийг авахгүй байж болохгүй байх гэж, амьдад хэрэгтэйг авбал, тэгээд ч амиа өгвөл, хойт насын буяныг амьдын зүйлд солиогүй гэж үзэж болох нь ээ?

Хүн-хүндээ найз нөхөд байдаг. Юун учир гэвэл, ертөнцөд амьд явах уед хүний өсөх нас, идэх хоол, өлсөж өлбөрөх, гуниг, зовлон, үхэл, хамаг бие сэтгэл, төрсөн газар, очих газар (хойт нас) бүхэн адил хийгээд авсанд орох, өгөрч үгүй болох, диваажинд очих бүхэн нь ижил бас хоёр төрөл дэх зовлон, гайд нэрвэгдэх нэгэн хоёр төрлийн жаргал, буяныг амсах нь хүртэл адил байдаг. Тав хонох нас бий юу үгүй юу? Хүмүүн бие-

Сиенцээ зочин аж, бас та өөрөө ч энэ амьдралд зочир аж. Тийм ахуй нэгний мэдэх зүйлд нөгөөг нь өрсөн дүүлж, нэгний мал буянд нөгөөг булаацаалдуулж маргаж мэттэж байхын ашиг юун?

Аллах тэнгэрээс гүйх зүйлийг хүнээс гүйж, чадлын хирээр хөдөлж, хөдөлсөний хэрээр хоол ол гэж хэлэхийн оронд тэр гуайн юмыг аваад л аль гэх нь хэлэх уг гэж үү? Аллах тэнгэрийн хүч чадалд нэгний төлөө нөгөөг зовоох нь нийштэй гэж үү? Хоёр угийн толгой холбох эрдэмгүй мөртлөө өөрийн үгийг зөв болгох гэж «Өө тэнгэр минь» гэж булаалцалдаж маргах нь юун сэтгэлийн уг болох? Түүнд ямар хүн чанар байх?

ГУЧИН ТАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Аллах тэнгэр хойт насын хаалганд хажы¹, молла, тэвш, гэлэн, даяанч, өглөгч, санваартан бүхнийг хамтад зэрэгцүүлэн байж өчиг авдаг гэнэм. Амьдад нэр хүнд олохын тулд, зөвхөн хажы нэр зүүхийн тулд хажы бологчдыг, өглөгч буян үйлдэгчдийг, бурхан мөрт насаа алдагчийг тусгайлан зогсоодог гэнэм. Хойт насын төлөө зөвхөн аллах тэнгэрээс ивээл ачиж хүртэхийн төлөө, нөө амьдрагчдыг бас ялгаж зогсоодог гэнэм.

Амьдын нэр хүндийн төлөөнөө амьдрагчаас: «Та нар амьддаа хажы гуай, молла гуай, номт гуай гэж хэлүүлэхийн төлөө л эрдэм хөөсөн хүмүүс тийм хуурамч зүйл энд байхгүй. Та нарын тэр жаргалт мөч өнгөрсөн, хийсэн үйл цуглуулсан эрдэм тань бүгд хамтад үгүй болсон. Одоо энд та нар нэр хүнд олохын төлөө хийсэн бүх нүгэлдээ өчиг өгсүгэй. Мал өглөө, нас өглөө юун тулд тэр мал буянаа, насаа хойт насыг халхавч хийж амьдыг илүүд бодогч шунал сэтгэлийн өнгийг даялдаж, слон тумнийг хуурч мэхлэхийн төлөө цацаж урэгдүүлэв?» гэж асуудаг байна.

Үнэн сэтгэлээс номын мөр хөөж, ёс чанарыг илүүд бодогчдоос «Та нар зөвхөн миний төлөө үнэнч байж, мал буян, нас амьдралаа зориулсан билээ. Би та нарт баярлана. Та нарт төхиох байр орон буй, оротгун! бас түүнээс гадна та нарын үйлдсэн буянд нэмэр болсон. Өөрөө үл хийсэн ч сайн үйлд сэтгэл нь ойр байсан тийм

бүянт хүн байх аваас тэдэнд та нар хариу тусыг бүтээ!»
1 ЭЖ ХЭЛДЭГ БАЙНАМ.

ГУЧИН ЗУРГААДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Аллах бурханы элч төлөөлөгч Пангамбар Мухаммед² гэгээнтний сургаалд: «Мань ла хаяихун уа⁺уа итанун ла+хү³» гэж буюу Хэн ичгүүргүй бол тэр хүнд итгэл бишрэл үгүй гэсэн ажээ. Бидний казахуудад «Ичих нүүртэд итгэл буй» гэсэн зүйр үг байдаг. Ийн бодохул ичгүүр гэдэг нь итгэл бишрэлийн холбоо бүхий утга нь юм. Тийн ахул ичгүүр гэж юуг хэлдэгийг мэдэх нь чухал аж.

Нэн түрүүнд: Харалган мунхагийн ичгүүр гэж байдаг. Энэ нь бага насын хүүхэд бусдын өмнө үг хэлэхээс ичих буюу нэр алдартай сайн хүн тодорхой утга учиргүй нүүр тулахаас ичих зэрэг бөлгөө.

Шашны жаяг номын, хумууний нэр төрийн асуудалд харш биш хэдий ч ухааны харалганаас болж ичихгүй зүйлд ичиж эмээх нь мунхаг муу хүний шинж болой.

Үнэн ичгүүр гэж-жаяг ном, хүн ёс, ичих элгэнд мэдээж харш зүйлүүдийг хэлдэг. Ийм ичгүүр нь хоёр нь өөр байдаг.

Нэг нь: Өрөөл бусад хүний ичгэвтэр үйл үйлдэж буйг үзэхүйд бусдын төлөөнөө ичих явдал. «Ээ зайлцуул даа энэ амьтан юу болох нь энэ вэ, хэтдээ яах бол доо» гэх шиг энэрэлийн нэгэн бодол сэтгэл зүрхийг эрхтүй эзэмддэг.

Нөгөө нь: жаяг ном, хүн ёс ичих эмээхүйд харш үйлдэл нь шуналт сэтгэлээс үүдэн гарах явдал юм. Ийм үйлдэл хийж буйг чинь өөр бусад хүн үзэж хараагүй ч гэсэн ухаан бодол чинь чамайг цээрлэхийн үест аяндаа ичих сэтгэл төрж хүн өөрөө-өөрийгөө цагаатгах явдал байдаг. Тэгсэн хүн бусдын нүүр харахаас зовож, нуутдах газар олохгүй тэвддэг. Ийм байдалд орсон хумуус бухнийг умартан, хоол унд идэж чадахаа ч больдог. Бичиг зохиолд тэмдэглэснээр ийм үед өөрөө-өөрийгөө хорлодог хүн ч байдаг байна.

Ичгүүр гэж-хумууний хүнлэг чанар буюу нохой мэт занг цээрлэн цаазлахын нэр юм.

Ийм үед ямарч хүн сэтгэл чадавхиа алдана, хэлэх угээ олж яддаг. Нус нулимсаа ч анзааран арчих сэхээгээ алддаг. Хүний өөдөөс эгцлэн харах нь байтугай хоёр нүд нь юм үзэхээ болино.

Ичиж байгаа хүнийг гомдоож буй хүн училж хэлт-рүүлэх нь байтугай унасан дээр нь тамлах гэвээс тэр өөрөө ч гэсэн адилхан ичгуургүй л байж таарна.

Өнөө миний нүүр учирч буй зарим хүмүүс ичих атугай улайх ч угүй байдаг. Ичгэвтэр үйлдэл хийж буйг сануулж хэлэхүл: «Би ч ичнэ биз, бусдын явдал чамд ямар хамаатай юм бэ?» гэнэ. Угүй бол «тэр гуай ухчих нь яасан, энэ гуай ухчих нь яасан, тэднийг бодоход миний ичих ч гайгүй хэвтэнэ» гэж ичих атугай хээв нэт өөрийгөө цагаатгаж суухаас буцахгүй.

Ийм хүмүүсийг чинь ичсэн гэх үү аль эсвэл ичээгүй гэх үү? Эс ичиж гэмээ нь сургаал номд айлдсан үгэнд харш, үйлдэл бүхий тэднийг бас итгэл бишрэлтэй хүн гэх үү?

ГУЧИН ДОЛООДОХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

1. Хүмүүний хүн чанар-үйлийн төгсгөлөөр бус яаж эхлэж буйгаар нь танигддаг.
2. Сэтгэлд буй чимэгт бодол гадагшлахын уеэс чинмэг алдардаг.
3. Харалган мунхагт хүнд суут сургаал хэлэхүйд уйлах ч байдаг, уярч дуулах нь ч байдаг.
4. Хүмүүнд эрдмийг харгалзан байж тусыг бүтээ. Тэнэг хүнд тусыг хийвэл, усаар хариу барьдаг.
5. Эдэгт тус түүхэд-өрөөлд дайсан. Өрөөлд тус түүхэд бүхэнд буян.
6. Эр хүн ихийг гүйж, багад баярладаг.
7. Өөрийнхөө л тус хөдөлмөр хийвэл
Өвс хазсан амьтны адил,
Хүн болгоны тус хөдөлмөр хийвэл
Хүчит тэнгэрийн ивээл адил.
8. Агуу их Сократад хор өгсөн, Иоанна Аркийг галд шатаасан, Есусийг цовдолсон, Мухаммед гэгээнтнийг тэмээний араг ясанд хэн булав? —Тэр-олон түмэн, тэгвэл олонд ухаан угүй. Эвийг олж замд нь оруул.
9. Хүний алаг үрийг эрин цаг нь хүмүүжүүлдэг. Хэрэв хэн нэгэн хүмүүжилгүй хүн байх аваас үенйнхэн цөмөөрөө буруутаи.

10. Хэрвээ би хууль барьдагсан бол, хүнийг хүмүүжүүлж болохгүй гэж номлогчийн хэлийг огтлох байсан.
11. Орчлонд ганцаардсан хүн-үхсэн хүнтэй адил. Хамаг гай зовлон түүнд нүүрлэдэг. Орчлонд буй хамаг муу бүхэн болоод хамаг сайн сайхан бүхэн түмэн олонд буй. Сайнаг хэн дагана? Мууг хэн хүлщэнэ?
12. Зовлонг хэн эс туулах. Горьдлого тасрах нь золбоогүйн тэмдэг. Орчлонд мөнх зүйл гэж үгүйн адил муу-муухай зүйл ч гэсэн мөнх оршихгүй. Цас ихтэй өвлийн дараа ногоо ихтэй хавар, бороо хур элбэг зун ирдэгсэн биш билүү?
13. Уурласан хүний үг нь цөөн бол хорсол занал буйн шинж. Үг хараал нь дуусашгүй бол сагсуу буюу зориггүйн шинж.
14. Аз баяр нь-онгиричихын үүдэл хийгээд түүнийг мянган хүнээс зөвхөн нэг нь даадаг.
15. Бүтэлгүй үйлс бүтээе гэвэл яаж эхлэхээ бод.
16. Өндөр хэрэм-оргил хад
- Яаралгүй мөлхсөн могой ч гарна
Дүүлэн нисэж жигүүртэн ч гарна
Хаагдсан түмэн хүрээгүйг магтана
Харалган тэнэг үнэн гэж итгэнэ
17. Орчлон-оломгүй далай
- Цаг үе-салхии шуурга
Эриний давалгаа-өмнөх үе
Эцэс давалгаа-хойч үе
Ээлж-ээлжээр ирж буй нь
Эгээ л урьдынхаар харагдаж буй.
18. Төөргөөр болдог хаадаас
- Тунгааж боддог хүн илүү
Үзсэнээ үнэлдэг өвгөдөөс
Үзэнээ хэлдэг нялхас илүү
19. Завхай шунаг-хүний дайсан
- Залхуу зан-даянчийн дайсан
20. (Нөхрийн сайн нь зовлонд танигдана)
- Муу нэхэр-сүүдэр адил
Нартайд зугтаж үл болно
Үүлтэйд эрж үл олъёюу
21. Тус үгүйд мэндийг сахиж
- Туст хүнд үгээ хэл
Зовсон хүнд нэгэнд тусыг бодож
Зовлон мэддэггүйд битгий ойрт

22. Зориг үгүй уцаар-хоосон

Туушт үгүй хайр-хоосон

Шавь үгүй эрдэмт-хоосон

23. Аз жаргалыг хүн бүхэн адил хүсэж, чадлаг нь
цөөн

Аяа, бас олсон нэгийгээ үзэж эс чадна

ГҮЧИН НАЙМДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Үнэн зүрхний минь түшиг, үр хүүхдүүд минь ээ! Та њарт хүн зан чанарын тухай цөөхөн хэдэн үт хэлхэж, дурсамж үлдээсү. Ёст үнэн сэтгэлээр хүндлэн уншиж, ухааран ойлгож авагтун. Тэгж гэмээ нь сэтгэл ариусан дотоод хайр тань бадамлан асах авай. Жинхэнэ хайр хүмүүний хүн чанар оюун ухан. эрдэм ном зэргээс үүдэн гардаг юм шүү. Төрөхүй утга нь-нэн түрүүнд сайн чанар, эрүүл бие, гэгч төрөлхийн чанарууд хийгээд тэдгээр нь сайн эцэг, сайн эх, сайн нөхөд, сайн багшаас заатай буюу, төгөлдөр авьяас, тогтоох мэдрэмж хүмүүний хайр сэтгэлээс гаралтай байдаг.

Эрдэм номд хайр элэгтэй болох нь ч эл гурван чанаараас шалтгаалдаг. Эрдэм номыг хүүхэд эхээс өвөрлөж төрдөггүй нь хийгээд өөрийн зөнгөөр эрж олох гэж бас үгүй. Нэн түрүүнд хүүхдийн зоригийг бадрааж, хуурч аргадах буюу учрыг таньж дур хүсэлтэй болох хүртэл нь шаардаж, зааварлаж байх нь зүй. Хүүхэд хэзээцээ эрдэм номд элэг сэтгэлтэй болох аваас чухам тэр мөчөөс эхлэн жинхэнэ хүн болох бөлгөө. Аллах тэнгэрийн мөн чанарыг таньж мэдэх, өөрийгөө таньж мэдэх, ертөнцийг таньж мэдэх, хүн чанарыг сахин дээдлэх хийгээд аваа, гээхийн ухаан төлөвшүүлж байх нь эрдэм номноос эхтэй буюу жинхэнэ хүсэлт сэтгэлд уяатай байх авай.

Эдгээрт эсрэг байх аваас тэр нь төгс номт болоод төгс ухаант болж үл чадрюу!

Учир ину: Ихэнх тохиолдолд эцэг эх нь хүүгээ бага нялих үед нь гайт буруу мөрлүү түлхэж. буруу хүмүүжицлд оруулж авчихаад өнгөрсөн хойно нь алдаагаа гэ-нээт ухаарч моллад өгсөн болж, хүүхдүүд нь өөрийн хүслээр ном эрдэм сурч буйгаар ташаарч ойлгодог бөгөөд түүнээс үдсэн сайн үр лбайдаггүй юм.

Нэгэнт буруу хүмүүжилтэй болсон хэцүү хүүхдүүд нь эрдэм ном, багш мэргтэд, ариун шутээнд хүртэл хал-

тайгаар барагүй дутуу хүн, дутуу молла, дутуу мусульман болж гардаг. Тэднийг жинхэнэ хүн болгох нь хүн алахаас хэцүү байдаг. Учир нь: Үнэйч сэтгэл нь муу үйлийн мөнхийн дайсан нь юм. Дайсныг дуудахад ямар ч хүн зүгээр яваад очдоггүй нь адилаар сэтгэл нь өөр юманд хамаатай болсон хүүхдийг түүнээс буцааж татна гэвэл үлгэр болох авай.

Хүмүүний оюун бодол, эрдэм ном нь ямагт үнэн шударга ёст хөтлөгдөж байдаг аваас хүн тэр бүхний хариуд үнэнг олохын төлөө зүтгэдэг.

Тэр нь-Аллахын эрдэм бүс бүхнийг мэдэгч номын мөрд зүтгэх зүтгэл хийгээд мөн чанар нь-хүмүүнд ном эрдмийн (шинжлэх ухааны) үүдийг нээх авай. Шинжлэх ухаан нь-Аллахын нэгэн шинж чанар, үнэн буюу түүнд хүрэх гэсэн үнэн, сэтгэлийн хайр тэрчлэн хүмүүний хүнлэг төгс чанар байдаг. Үгүй бээр мал олох, магтаал хүртэх, хэртээм хүртэх, зэрэгт шунах буюу түүнлүгээ нэгэн төст шинж төрхтэй байх аваас тийм орчинд эрдэм тогтож, буян хурахгүй. Мал, магтаал хэргэм зэрэг нь хүнийг хүсээгүйд олдож гэмээ нь хүн чанарыг төдийлөн сүйд хийхгүй харин ч чимэг болох бөгөөд хүн өөрөө тэр бүгдийг сөглөн биширч, хүсэн шунаж эрэх аваас олсон ч эс олсон ч ялгаа угуй мөн чанараа алдаж сүйрдэг. Хэрэв үнэнч шутэж, түүний утгыг тайлах чин сэтгэлтэй юм бол юун түрүүнд өөтөицийн явдлаас ухаанаа бүрэн чөлөөлж үнэн үгийг минь дагаж хүлцэхтүн.

Исламын лалын шашины мөрийг дагаж байгаа юм бол түүний өмнө үнэнч байхтүн.

Үнэн шутээн гэдэг нь-зөвхөн итгэн бишрэхийн нэр бүс. Аллах тэнгэрийн бүрэн төрх хийгээд Куран судар ариун уг болохыг, Мухаммед паигамбар түүний үнэнч элч тэлгийт бүрэн итгэх явдал юм. Тэгвэл хүмүүн та аллах тэнгэрт аллах тэнгэрийн өмнөөс шутээн үйлдэх үү? эсвэл өөрийн төлөөнөө шутээн үйлдэх үү? Таны шутэж биширлээ тэж Аллах тэнгэр өөрчлөгдэж хувирях уу?.. Таныг шутэж бишрэхгүй ч гэсэн Аллах тэнгэр өөрчлөгдөн хувирахгүй.

Ийн бодохул: Хүмүүн өөрийн ач тусын тулд аллах

тэнгэрт залбирдаг байна. Түүн лүгээ хүмүүний итгэл бишрэл зөвхөн бишрэх төдий л байх аваас хэзээ ч ач тусыг өгөхгүйн адил ямар нэгэн хэлбэрээр зөвхөн өөрийн тусыг бодож гэмээ нь мөн л тус буян хурахгүй ажаам. Харин Аллах тэнгэрээс ивээл буян горилж, үнэн тусыг хүртэхийг чин сэтгэлээс хүсэх ахул буян хурж та аугаа их ач тусыг хүртэнэ ээ. Чингэхийн тулз тэр аугаа их ач тусыг яахин олж болдог үнэн замыг нээх хэрэгтэй.

Та Арабын үгээр сөнөсөн хэлээр тарни үйлдлээ. Эл тарни нь Аллах нарын аугаа их нэр алдар буюу арван буянт, арван хар нүгэлт чанарыг илэрхийлдэг. Энэ чанар гэж чухам юуг хэлдэг мөн ямар утгатай хийгээд түүнд хамааралтай бүхнийг төгс тайлах хэрэгтэй юм.

Өөрийгөө Аллах тэнгэрийн боол гэдгийг мэдэрч, тэгсэнээр өөрийгөө Мусульман гэдгээ ухаарч, түүнд бүрэн итгэж, сэтгэл өгч буйгаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Чингэхийн тулд өөрийн хамаг бие, зүрх сэтгэлээ Аллахад бүрэн зориулахыг зорилго болго. Аллахад үнэн нийцэж зөв дууриаж чадаж байна уу гэх бодол төрөх аваас түүндээ сэтгэл зовиурласны хэрэг үгүй. Учир нь дагаж дууриах гэдэг нь давтахын нэр биш, үнэн чанартаяа уг юмныхаа ариун мөрт зогсож буй явдал юм. Түүний тулд аллахын нэрүүд: Хаят¹, Гыlyм², Худрет³, Басар⁴, Самиг⁵, Ирада⁶, Калам⁷, Такин⁸ эдгээр наймаас илүүд байхгүй ч гэсэн аллах тэнгэр аливаа хүнд адил тэгш чанаруудыг заясан болохыг ухаарч, бид өөрийн арван хар нүгэлд өчүүхэн нэрээ Аллах тэнгэрийн арван буянт агуу нэрнээс холдуулж гэмээ нь тэгсэнээрээ Мусульман болж чадахгүй хийгээд харин найман буяны эх үүдэл болох үнэмлэхүй үнэн, тэнгэрийн зарлигт өөрийгөө яаж захируулж болох учрыг зөв таних нь чухал юм.

Аллах тэнгэрийн мөн чанар билний хүсэл, зорилгод захирагдахгүй хийгээд харин бид бүхний мөн чанар аллахад бүрэн захирагддагыг ухаарч, хязгааргүй мөн чанаруудын утга санааг зөв таньж бүрэн тайлах нь чухал юм. Үүнгүйгээр Аллах тэнгэрийг ч үз таньмой-

Үчир нь бид Аллах тэнгэрийг зөвлөн өөрийнхөө нээж буй хязгаарт л ухаардаг. Түүнээс чанагшид сэтгэх ухаан бидэнд үл хүрэлцэнэ. Аллахын мөн чанар атугай айлсан сургаал төдийхөнд нь ямар ч номт сартваахын ухаан үл хүрэлцэх учир энэ буюу. Аллах тэнгэр хязгааргүй хийгээд бидний ухаан хязгаартай. Тодорхой зайн дахь хязгаартай ухаан хязгааргүй үлэмжийг сэтгэх гэж үгүй. Мөн бид Аллах тэнгэрийг цорын «ганц» буюу «байна» гэж сэтгэдэг ба «цорын ганц» гэж хэлж буй маань ч гэсэн ухаан бодлынхоо тодорхой нэгэн хязгаарыг илтгэж буй хэрэг юм. Үнэндээ «цорын ганц» гэдэг ойлголт нь Аллах тэнгэрийн мөн чанарт үл нийцнэ. Сав өртөнцийн болзошгүй аливаа зүйлүүдийн байж болох чанарууд нь мөн утгаараа цогт бурдэлээс ангид үл оршино. Тэрбээр «цорын ганц» гэдэг үг маань өртөнцийн хүрээнд, өртөнц Аллах тэнгэрийн хүрээнд багбат буй хийгээд тэнгэр бурхадын хөдлөшгүй найман үнэнийг номонд тусгасан байдаг нь (Куран сударт байдаг) ерэн есөн ивээлт сан нэрүүд лүгээ¹ адил ба эл бүхэн нэгдэж байж бутэн нэг цогц утгыг илэрхийлж байгаа явдал юм. Энэ бүхэн нь зөвхөн Аллах тэнгэрийн өөрт зохицох, зөвхөн өөрөө удирдан, бүтээж, цогцолж байх агуу чанарт тодорхойлолт нь болой.

Одоо аугаа их найман хөдлөшгүй үнэнээс дөрвийг нь тайлах гэж үзье:

Найман үнэний хоёр нь шинжлэх ухааны буюу ном ба үнэмлэхүй хүч чадал болой. Үлдсэн зургаа нь эдгээрийг тайлсан тайлбар ба эл зургаагийн нэг нь амьд амьтдын тухай номлол байдаг. Бид нэгэнт Аллах тэнгэрийг «цорын ганц» «байна» гэсэн утгуудыг тайлж байгаа болохоор номын үнэмлэхүй хүч чадлыг ч тодорхойлоход хүрнэ. Тэгвэл эл бүхэн цогц утга нь бүхий л ном, үнэмлэхүй хүч чадал хоёрт хамаарч болох уу? гэсэн асуулт төрнө. Номын хүч чадал гэж угаасаа байж болох зүйл юм; Амьд байх чанар нь ч тодорхой ба хүсэхүй чанарт цогц нэг юм. Ном байх аваас хүсэхүй чанар ч хамтад байх хийгээд тэрээр өөр бусад ямарч юманд шалтгаалахгүй. Хүсэхүй чанар нь номын нэг чанар буюу үгсийн санд оршдог. Тэгснээрээ үг буюу үг эхлэх гэсэн утгыг тайлна. Хүмүүний үгс нь эгшиг авиа,

үсэг гэсэн хоёр өөр зүйлээс бүтэх хийгээд Аллахын үгс нь-эгшиг авиа, үсэггүй байдал.

Харин Аллахын яг л хэлж байгаа мэт сэтгэгдэх хүч чадал нь-зөнч болоод сонсогч чанар нь байж буйг илтгэх ажгуу. Аллах тэнэгрийн сонсож, харах нь-бидний адил нүд, чих хоёрын шалтгаантайгаар бус сонсож, харах лүгээ мэдрэгдэх номын хүч чадал буюу бүхнийг бүтээгч гэсэн аугаа нэрэнд нь зохицох авай.

Хэрэв бүхнийг буй болгогч нэр нь тусгай чанар байх аваас Аллах тэнгэрийн мөн чанар өөртэйгөө зохицсон худам ба нэн түрүүнд мөргөн залбирах, ямагт буй болгож бүтээж цогцлохоос ангижрахуй хийгээд нэг чанар нь нөгөө чанараасаа их, бага байж хэрхэвч чадахгүй аж. Бас номын болоод хүч чадлын чанар лугаа чөлөөт байх чанарыг алдаж, ямагт буй болгохын эрхэнд байх аваас ямар нэгэн байдлаар хүсэж хүлцэхгүй байдал илэрхийлэгдэх ёстой.

Аллахын бүхнийг бүтээгч шинж нь-үнэмлэхүй мөн чанарт нь оршмой.

Номын болон хүч чадлын мөн чанар нь-найман үнэн чанар эвдрээгүй орших бүхийд тогтох чадьюу. Номын ид чадалд ямар нэгэн хязгааргүйгээс халширч, хүрч чадан харуусах, мөн хүч чадлын хүрээнд туйлдах зэрэг хоосон чанарууд байхгүй болой.

Бүтээгчийг бүтээлээр нь таньюу. Энэхэн сав шимийн ергөнц дахь сэтгэлд бууж, нүдэнд харагдах бүхий л юмыг ямархан ид шид зохицуулан зохицож, ямархан хүчин чадал бүтээж буй болгосныг хүний үр тааж үл барамуу!

Түүнлүгээ сэтгэж гэмээ нь: Аллах тэнгэрийн мөн чанар ч гэсэн ухаан гүйцэмгүй аугаа барьлоу.

Гэвч өмнө хэлсэн; ном, хүч чадал-бидний оюун ухаанд хоёр өөр зүйл лүгээ сэтгэгдэж байгаа хэдий ч угтаа нэг л зүйл нэг л номт хүч чадал юм. Эс тэгвээс мөн чанарууд өөр хоорондоо нэг нь-хөтлөгч нөгөө нь-хөтлөгдөгч болно шүү дээ. Энэ нь аллах тэнгэрийг таниж мэдэх ухаанд үл зохицно. Найман чанарыг буй болгож тэдгээр чанарууд мөн хийгээд мөн бус болж өөрөөр хэлбэл хүн болоод хүн төрөлхтний ангид орших хязгаар угүйн адил нэг ухаанд түмэн ухаан цогцлон багтаж байгаа явдал юм.

Хэрэв найман чанарыг найман өөр зүйл хэмээн ухаж,

тэдгээр нь огт өөр зүйлүүдээс нэгдэж байна гэж сэтгэх ахул Аллах тэнгэр ч гэсэн түүнлүгээ адил болох авай. Ийн сэтгэх нь буруу хийгээд үнэмлэхүй мөн чанар, ном зэрэг нь ухааны ангид орших мэт болох билээ.

Аллах тэнгэрт буй үнэмлэхүй мөн чанар-ном хийгээд үлэмж хайр болой. Үлэмж хайр нь найман мөн чанарт бичигдээгүй ч гэсэн Аллах тэнгэрийн Рахман (Ивээн тэтгэгч), Рахим (Энэрэлт-, Гафур (Өрөшөөгч), Үалуд (хайрлагч), Хафиз (Хамгаалагч), Саттар (Бурууг хэлтрүүлэгч), Разах (Хишиг хүртээгч), Нафих (Ач тус бүтээгч). Уакил (Элч), Латиф (Сайн санаат) гэсэн нэрүүд лүгээ үндэслэгдсэн нэгэн цогц чанарыг илэрхийлж бүрэн чадна. Үүнийг нотлохын тулд-өмнө хэлсэн үгнүүдэд эдгээр нэрүүдийг холбож нээн үзвэл болох, гэвч оюун ухаанаар батлахын тулд-Аллах тэнгэр энэхэн сав шимийн ертөнцийг хүний ухаанаас хязгааргүй хийгээд бодис бухнийг бие-биенээсээ ашиг олохын тулд зохицуулан бүтээснийг сэтгэж бodoх нь зүй. Амьгүй бухнээс ашиг ологч амьд бухнийг, амьд амьтдаас ашиг ологч хүний урийг бүтээж буй болгожээ.

Амьд амьтныг тэжээгч амьгүй юмыг өвдөхгүй болгож, амьд амьтныг ухааны эзэн хүмүүн тэжээдэг болгож, мөн амьтны хойд төрөлдөө тамд унахгүй болгож, эд бухнээс ашиг хүртэгч ухааны эздийг бүтээжээ.

Хүний урийг хийсэн нүглээ уурдэг болгож төрүүлсэнд үлэмж учир, үлэмж хайр байгаа буюу.

Хүний орнийг хорхой, шувуу... зэрэг бусад амьтны адилаар бус төгс бие заяаж хоёр хөл дээрээ гишгүүлж, толгойг өндөрт байрлуулж, бусад амьтны адил хоолоо амаараа авахгүй болгож, алсыг ахархаар нүд өгч, хоёр гарыг тэрүүнд үйлчилдэг болгож, гарыг аманд өгөхөд юу идэж, юухан ууж буйг мэдэрч байг гэж үнэр авч таашаал хүртэхүйц амны дээр нь хамрыг заяаж, түний дээр цэвэр ариуныг сахих нүдийг өгч, нүдийг бохирдолт болон аюулаас хамгаалж байх зовхи бүтээж, нүдээ нээж, аньж бухийд элэгдэлээс хамгаалах сормуус суулгаж, магнайн хөлс нүдэнд унахгүйн тулд хөмсөг өгч, мөн царайд нь чимэг нэмж нэг нь бүтээж чадахгүй ажлыг нэгдэж хийлгэхийн түлд, нэг нь нөгөөдөө бодлоо илэрхийлэхийн тулд уг хэлтэй болгож төрүүлсэн нь хайр биш гэж үү? Хэн чамайг хайлрана түнийг хариу хайлрах нь таны сэтгэлийн өр болой.

Ухааны нүдээр харагтун: Нар тэнгисийг бүлээсгэж үүлийг бүтээнэ, үүл бороо оруулж газар дээрх түмэн зүйлийн тариа будааг үржүүлж, жимс ногоог боловсруулж, нүдиээ чимэгт сэтгэлд баясгалант цэцэг навчсыг дэлгэрүүлж, чихрийн хулс лугаа амтлаг бүхий ургамалуудыг ургуулж, амьтдыг халхлуулж, булаг шандыг ундргуулж, булаг шандууд мөрөн голуудыг урсгаж, амьтан, шувуу, малд ундаа, загас жарайхайд өлгий болдог байна.

Газар хөвөн, олс жимс, ашигт малтмалаа, цэцгүүд дэлбээгээ, шувууд өд, мах, өндгөө, адгуус амьтад мах, сүү, ноос, хүч, арьсаа, голууд загасаа, загас түрсээ, зөгий бал бурмаа, хорхой мяндсан ... зэрэг бүхий л юмаа хүний үрийн ашиг тус тозориулж байгаа нь хэн ч гэсэн «зөвхөн минийх» гэж өмчлөмөөргүй нийт хүн төрөлтний дуусашгүй хишиг болой.

Сая түмэн ухаанаар буй болсон машин, үйлдвэрүүд нь хүн төрөлхтний бахархал, ашиг тусын тулд бүтээж гэмээ нь энэхэн тус түйлүүд нь хүний хайр ивээл, өрөөлийг гэсэн нь өглөгт сэтгэлийн үр нь бөлгөө. Хэн чамайг хайрлана түүнд хайраар харин барих нь хүн таны үүрэг мөн өө!

Хүн төрөлхтний хэт шунах шуналын үүдийг хааж, ан амьтдыг бүрэн сөнөөхөөс сэргийлэн, малыг хүний харамнах сэтгэлээр хамгаалуулж, бусад амьтдын нэгийг нь шаламгай даль жигүүртэнд итгүүлж, нөгөөг нь хурдан шалмаг хөлд нь түшүүлж өөр нэгнийг нь өндөр халилд нөгөөг нь үржин төлжихд хүсэлт болгож, нялх ахуйд нь маргаашийн хайр ивээлд шүтэн барилдуулж буй бүхий нь хүний үрийг үржин төлжиж, эрх чөлөө олохын төлөөнөө л бус тэднийг мөнхөд тасрахгүй удамт, мөнхөд идэх хоолтой байлгах гэсэн үнэн сэтгэлийн үр хөврөл бөлгөө. Эл бүхэн сургаалт зүйд үлэмж сайн сайхны үлэмж энэрэл, үлэмж хайр оршином бус уу. Хүн бээр эл бүхнийг үл огоорч, үнэн шүтээнээс ангид оршихуй үест хүмүүнлэг чанар алдарт сүсэг бишрэлт болохын төлөө л зүтгэсэн зүтгэл бүхэн нь талаар больюу.

Энэ нь наран лугаа мөнхийн үнэн бөлгөө. Аллах тэнгэрийн эл ариун ёсыг хүмүүн бүр мэдэж, эмдэрч байх авч бас өрөөлийн сэтгэлд буй шүтээнийг илүүд үзэхгүй мөртлөө өөрийн сэтгэлд гэгээ тусгахыг төдийлөн

дагаж үл хүлцдэг аж. Буруу гаслант мөр лугаа алхам эргэж буй хүн мусульман биш, эсвэл төгс мусульман биш. Аллах тэнгэрийн түмэн боолдоо зориулсан ариун мөрийг тэр бүрий таньж мэдэхийг юунд үл хүснэгт бэ?

«Тафаккар уналаа иллахи» — «Аллах тэнгэрээс заяат бүхэнд сэтгэл хандуул» гэсэн сургаал буюу «Инна Аллаху йух—уб—бул махситин» — «Хэрэв чи Аллахыг хайлравал тэрч гэсэн чамайг хайлрана» — гэсэн тарнийг хэн ч атугай үнэн сэтгэл, номын нүдээр тайлан хэлэхийг үзсэнгүй. «Атамурун ан—наса билбирри уя ахсану инна Аллаху йух—уб —бул муҳсинин» — «Хүн төрөлхтөнд сайн үйлийг бүтээж, сайныг борогтуу гэж зарлиг хэлэгтүн! учир нь Аллах тэнгэр сайн мөрд уриалагчдыг илүүд үздэг» буюу «Уа аллазина аману уя амилу с-салихати л-алайка с-хаб-ул жан-нат и-хум фихи халидун» — «Тийм хүмүүс Аллахад буян үйлдэнэ, сайн үйлийг бүтээнэ, тийм хүмүүс ямагт диваажинд хүрдэг» гэсэн таринууд мөн чанартай үлэмж сайн-сайхныг билэгдэл болгохыг илэрхийлж байх бөлгөө. «Гэвч Аллахад шүтээн үйлдэж буяныг боддог, Тэгсэнээрээ хүн болсон өрөө төлдөг, учир нь Аллах тэнгэр залтэй этгээдүүдийг үл хайлрадаг» гэсэн тарнийг үзэхүл үнэн шүтээн нь арга зальд харш болой. Тэгвэл хэнд ичгүүр үгүй бол түүнд итгэл үгүй гэсэн ойлголтыг зөнч мэргэн — Мухаммедин «Мань ла хаян лаху уя ла иманун Лаху» гэсэн тарни нь нотлох аж.

Үнэн шүтээн-үнэнч сэтгэл гэж хоосон шүтэлийг хэлдэггүй бөгөөд Үнэн шүтээн нь үнэнч сэтгэлээс үүдэг байна?

Буян үйлээрээ сайнаг үйлдэж түүнийгээ харнуд өрөөлөөс үнэн сэтгэлийн хариу авч буй хүнийг нэгээхэн ч харсангүй. Үүнийг нотлохын ч хэрэг үгүй. Үнэнч сэтгэл гэгч хамаг сайн сайхны эх үүдэл бөлгөө. Хүнлэг чанар, ичгүүрт сэтгэл-үнэнээс төрьёу.

Үнэнч сэтгэлт хүн нэн түрүүнд: Би энэ хүнийг яавал сэтгэлийг нь зовоохгүй байж ач буян болох билээ л-гэдгийг бодно. Энэ нь хамаг сайн сайхны эх үүдэл болой.

Тийн ахул нийн сэтгэл гаргаж, түүн лүгээ ариун сайхныг боддог мүн бүтээгч их тэнгэрийг бодохгүй яахин байх билээ. Буяныг дагаад буян төрдөг. Үүнийг сэтгэл оюунаа чандлан сахиж алдалгүй дагах нь зүй, Хэрэв алдаж гэмээ нь итгэл бишрэл, хүнлэг чанар бүхэн хамтад арилдаг хийгээд нэгэн даянчийн «Зуун ланг өгч нэг ланг авсан» үлгэртэй адил нэгэн болох бөлгөө. Ийн ухварлахуй Аллах тэнгэр-номт, энэрэлг, үнэнч бөгөөд үлэмжийн мөнх хүчин чадалтай болой. Үүн лүгээ та ч гэсэн ном, энэрэл үнэн гэсэн нандин чанаруудыг эрхэмлэх аваас төгс Мусульман төгс хүн болж чадмой.

Аливаа сайн хүнд эл гурван чанар тодорхой хэмжээнд байдаг нь үнэн хийгээд хүнлэг ёс, ухаан, чанар эл гурван үүдэлтэй байдаг нь жинхэнэ юм. Хүнлэг ёс, буян үйл болол нь номын нэгэн нэр бөгөөд энэ нь Аллах тэнгэрээс хүмүүнд өгсөн хамгийн дээд шагнал юм. Харин үүнийг ёст мөр болгон цэцэглүүлэх нь хүн бурийн хүчин чадал, сэтгэлийн хаттай холбоотой бөгөөд авхаалж зориг, үнэнч шинж чанараас шалтгаантай ажаам. Эл гурван чанарын анхны эзэд нь-зөнч мэргэд, удаах нь хутагт хувилгаадууд дараах нь-гүн ухаантнууд төгсгөлийн эзэд нь -үнэн мусульманчууд болой. Эл гурван чанар нь-аллах тэнгэрийн мөрд үнэнч байж, өөрийгөө тэнгэрийн боол гэдгээ бүрэн ухаарч тэгсэнээрээ гурван мөн чанарыг сэтгэл зүрхээрээ хайлалахыг зөнч мэргэдүүд сургасан аж. Хутагт хувилгаадад тэдний сургаалыг уншиж хайлаж дурласан хүмүүс юм. Гэвч тэд насан эцсийн ашгаа л боджээ. Хайлалахын эрхэнд тийм өндөрлөгт хүрч, орчлонг хийгээд түүн дээр оршин тогтнож буй хамаг жаргалыг мартаж чаджээ.

Гүн ухаантнууд энэ насандаа үзэх ашигт талыг өгүүлжээ. Үлгэрлэх ухаанаар харахуйц хоёул хоорондоо тийм ч зөрөөгүй аж. Аль альных нь хэлж байгаа арга барил нь өөр ч гэсэн Аллах тэнгэрийн үлэмж мөнх хүч чадалд итгэхийг хоёул-хоёулаа л айлдажээ. Хүлээн зөвшөөрнө гэдэг нь хүлцэж дууриахын үүдэл бөлгөө. Ухаан, ном хоёрын аль аль нь залт арга, зонхиомол төрх хүн-хүнээ хуурч мэхлэх зэргийг үл үзнэ. Аль аль нь үнэн сэтгэлт, хайр ивээлт болохыг сургагдаг. Энэ чанараараа хоёулаа буянт болой. Гэвч ми-

ний бодоход ёл хоёр ойлголтын эзэн хбёулаа л зөвхөн өөрийн биенг золиослогчид шиг санагддаг. Хэрэв хүмүүн бүгдийн мөн чанар нь хутагт хувилгаад болохын төлөөнөө чиглэх юм бол, хэрэв бүхий л хүн төрөлтөн идэж уухаа мартан шашны мөрийг дагах юм бол орчлонт амьдрал сөнөхөд хүрнэ. Тэглээ гэмээж нь малыг хэн нь маллаж, дайсныг хэн нь тогтоож барина? Хувцсыг хэн нь нэхэж, тарна будааг хэн ургуулна, газрын гүн дэхь ашигт малтмалыг хэнь эрж олно? Бузар зүйл, нүгэлт үйл зэргийг ярихыг түвшлээ гэхэд Аллах тэнгэрийн хүч чадал, ариун ивээллээр хүмүүн ухааны нь олж сайн сайхныг нь үзэхийн тулд буй болгосон тэр их зүйлийг үл ойшоож, эзэнгүй хөсөр хаях нь хүмүүн ухаанд багтах гэж үү? Эд буяны эзэд өршөөл үгүй бол шуналт зан нь ихсэж нүглийн тулам болох бус уу? Нөгөөтэйгүүр энэ замд хүн бүр дагаж гэмээ нь хүн төрөлхтөн ертөнцөөс үгүй болчих ч аюул бий.

Хэрэв энэ нь тодорхой хэмжээний бүлэг хүмүүст хамаарлтай юм бол хагас үнэн зүйл гэж байх хэрэгтэй. Үнэн юм бол бүхий л хүний хувьд үнэн байх хэрэгтэй. Алагсаж салгасан үнэн, алагсаж салгасан шударга ёс гэж байж болох уу? Тийм гэмээж нь хүмүүст нас буян гэж байхын хэрэг юн.

Нас буян-өөрөө үнэн юм. Хаана нас буян үгүй бол тэр газарт үнэн үгүй болно. Гэвч хутагт хувилгаадад цөмөөрөө ертөнцөөс залхсан хүмүүс бишээ. Жишээ нь: Гашеренийг Мухаммед гэгээнтэн амьд сэргүүн үед нь диваажинд хүрсэн гэж тодорхойлж байсан. Госман, Габдурахман бин Гуаф Уа Сагид бин Эбуахас гурвуулаа том хэмжээний чинээлэг баячууд байсан. Ертөнцөөс залхана гэдэг нь-ертөнцийн элдэв зүйлд хууртаж, хийж бүтээх зүйлээ дутуу орхихоос эмээж өөртөө үл итгэсэн явдал бөгөөд эдийн шуналт байдлаас түмний сэтгэлийг холдуулах, би наасаа зольж байхад бусад хүн шуналт сэтгэлээ золиосой гэсэн сонирхол, хүсэл зорилго, бодлын гориос гарсан зүйл болой. Тийн гэмээж нь тэр ч гэсэн бусдад гэсэн илүү хайраас үдсэн арга юм. Гэвч энэ зам-маш нарийн маш эмзэг зам юм. Энэ замын төгсгөлд зөвхөн өөртөэ үнэнч, тун хатуу дэглэмтэй хүн л хүрнэ. Одоо үед ховор тохиох эл чанарын мөн утгыг олохын тулд агуу номын агуу зориг, агуу хайр хийгээд хүн төрөлхтнөөс ертөнцийг таньж мэдэх

аугаа их хүч, ухаан шаардлагатай. Энэ бүхнийг цуглуулж нэгтгэх хамгаас хэцүү хийгээд магад саваагүй явдал ч болж мэднэ.

Оюун ухаанд нь хийгээд бие сэтгэлд нь ер бусын их хүч чадал заяах нь хүмүүн үрийг эвддэг зүйл. Аливаа тэнэгүүдийн бид даяанчийн замд орлоо гэж явдаг нь бид эвдэрлээ гэж хэлсэнтэй утга адил юм. Гүн ухаантан, ном гэдэг нь угтаа нэг л зүйл. Харин танъж мэдэхгүй нь хоёр өөр юм. Ертөнцөд гадаад ойлголтын ном гэж бий. Тэд тодорхой зүйлийг чиг болгодог. Үүнд гаргуун ухаантнуудыг эрдэмт гэж нэрийддэг.

Аллах тэнгэр ямар ч зүйлийг шалтгаангүйгээр буй болгоогүй байна. Үүнийг «Аллах тэнгэрээс зяят бүхэнд сэтгэл хандуул» гэсэн тарнийн үгс нотолдог. Аллах тэнгэрийн мөн чанарт хүний ухаан үл хүрэлцвэл түүнд хайртай гэж хэлэхийн ч утга алдарна. Хайр буюу хайрлах гэсэн хоёр үгийн хооронд ч гэсэн нэлээн их зайдаг. Аллах тэнгэр хүн боолыг үлэмж хайраар төрүүлсэнийг бодож хайрыг нь хайраар хариулна гэвэл сая л үнэнд нийцэх ажгуу. Тийн ахул ухаант тэнгэрийг хүн боол нь өөрийн ухааны хязгаар буюу хэмжээ хүрээнд л танъж мэдэхийг хүссэн хүсэлт хүмүүнийг ухаантан гэж нэрэлмой.

Ийм хүмүүс аугаа их юмын алив нэгэн утгыг танъж мэдэж тэгсэнээрээ бусад хүмүүст ач буяныг хүртээхийн тулд инээд наадам, өмсөх зүүх зүйл, ертөнцийн бүхий л явдлыг хойш нь тавьж юмын мөн чанарыг танъж мэдэхийнхээ хэрээр сэтгэлийн баясал амарлангуйг олдог.

Үнэн мөрийг дагагч ухаантнууд үгүй бол ертөнц сөнөх байсан. Хүмүүний аливаа үйлийн чиг баримжаа, алтан гадас нь-эл сайн мэргэд, сайн ухаантнууд байдаг, аливаа юмс тэдний хийж бүтээсэн сэтгэлийн хүрээнд явагддаг. Эдгээрийн ихэнх нь энэ орчлонгийн амьдралаас үдэж сэтгэдэг хийгээд тэдгээрийн бүтээсэн зүйл бүхэн нь орчлон хойт төрөлийн үр адил хойт насанд ургац болох зүйл байдаг. Аливаа эрдэмтэн-ухаантан бус, аливаа ухаантан эрдэмтэн байдаг. Эрдэмтэд ихэнхдээ өрөөлийн шутэн бишрэхийг харж дууриаж буян үйлддэг. Ухаантнуудын иомонд хүрч гэмээ нь шутэх нь жинхэнэ шутээн болдог.

Ухаантнууд гэдэг нь Мусульманууд ч бай эсвэл бу-

сад будда христос зэрэг шашных бай ялгаагүй зүтгэвэл хүрнэ гэсэн мөрийг чиг болгож, ергэнцийг хүн төрөлхтөний оюуны чанад сэтгэж, чадсан ч гэсэн тэр бүхнийг шашин номын таньж мэдсэн хэмжээнд хурч сэтгэж үл чадсан хүмүүс юм.

Эдний ихэнх нь тарни номын долоон жаягын зөвхөн нэг болох Аллахыг таньж мэдэхэд Харый (Да лам) болсон ч гэсэн улдсэн зургаад нь ямар нэгэн шалтгаанаар хурч чадаагүй байдаг. Гэвч тэд цөмөөрөө бидний багш болохгүй ч гэсэн Аллахын үнэнч элч Мухаммед гэгээтний: «Хүний сайн чанар өрөөлд тус буян болсноор илэрдэг» гэж хэлсэнийг бодоход хүргэдэг.

Эл ухаантнууд амрах зав, нойр, хоол, сонирхолтой бүхнийг түвдэн хүний хэрэгтэйг эрж олохын тулд жишээ нь: цахилгааныг олж, тэнгэрийн аянгыг залж, ертөнцийн нэг захаас нөгөө захад нь агшин зуурт мэдээ дамжуулж, гал усны ид шидийг нээж мянган хүн хийж бараггүй ажлыг нэг л хүн хийж чадах ухааныг иээсэн нь ялангуяа хүний үрийн ухааны царыг нэмэгдүүлж, үнэн зориг чадалын ид хавыг үзүүлэх зэргийг нээж сургасан нь угтаа хүмүүний сайн сайхан тусын тулд болохоор бид тэдэнд хүлцэлт, өртэй болох нь ч аргагүй юм.

Одоогийн молла нар ухаантнуудын эсрэг байдаг. Тэр нь мэдлэггүй буюу буруу ухаанаар буруу юманд сэтгэл алдасных юм. Тэдний шавь нар нь ч гэсэн араб персийн хуучирсан сөнөж усгагдсан хэдэн үг сурсанаа ихэд сайрхаж, өөртөө ихэмсэг байдлыг бий болгохын тулд олон түмэнд тус болохоосоо илүү ус болдог нь олонтаа. Магтаал, сайшаалаар түмнийг төөрөлдүүлж гүйцдэг. Эдний ихэнх нь зүгээр нэгэн андуу сэтгэл буюу тэрсүү уgt байдаг бөгөөд бас алдаагаа ухаарах чадалгүй байж бусдад ухаан айлддагийг яана гээч!

Үнэн үгэнд нүх ухаж, урхи тавих нь юун өөриймсөг хийгээд өөриймсөг хоосон зан ямарч хүнийг эвддэг аюулт зуршил болой.

Зөвийн утга нь-үнэн. Үнэний утга нь-Аллах юм. Үүний эсрэг дайтсанаас үнэнийг олж тавих нь зүй. Буруу санаатан шашинаа хүртэл орхих аюул байдаг. Бас Мухаммед пайгамбарыг галав юулэхэд жилд хүрэлцэхүйц нэг өдөр байдаг гэхэд үнэнч лха тэнгэрүүд» «тэр жилд хүрэлцэхүйц өдөр хэдэн удаа мөргөл үйл-

Дэх бол?» гэж хариу асуухад тэрээр «түүний учрыг тэр үсийн эрдэмтэд хэлэх биз ээ?» гэж хариулсанас бо доход цаг үе онгөрлөө ч гэсэн номын сургааль өөрчлөг дөхгүйг хэлсэнийх бөлгөө. Одоо үсийн сургууль номууд зөвхөн энэхэн цаг үед л захирагдаг учир цаг үед ч ач тус өгч чадахгүй. Тиймээс Туркэд — «цэргийн сургууль», «төрөл бүрийн ном заадаг сургууль» нээгдэж ирж бүй шинэ цаг үед зохицуулсан ном эрдмийг зааж байна. Эндэхийн хүмүүс ямарч ач тусгүй цагийг нөхцөөж, эрдэм ном сурахыг ухаанаас таягдан, аливаа илүүд хэрэггүй юманд шунаж явсаар амьд ертөнцөд ашиг үгүй болж, хүнийг отож, хүнийг хууран мэхлэх замд ордог. Ийм бүдүүлэг номтнуудын өрөөлд зааж хэлэх зүйл нь ч адгуус шинжтэй байдаг.

Ертөнцийн сайн сайхан нь хүний сэтгэл оюунд ер бусын гайхамшигт гэрэл гэгээг тусгадаг. Хэт ядуурал нь хүнийг адгуус шинжинд оруулдаг ч тал байдаг. Ертөнцийн учрыг таньж мэдэхгүй өнгөрөх нь-хамгийн аймшигтай тэнэглэл байдаг. Энэ нь Куран сударт бүрэн тайлагдсан ба «Ертөнцөд хэн ч болов өөртөө тусыг бод мал хөрөнгө цуглуулах аваас тэр нь бусдын гарыг харж, хишиг горилох сэтгэлийн үүдийг хаасан сайн санааны эхлэл болов. Харин хэт өөриймсөг сэтгэлээр хэрнээсээ хэт юманд шунах нь нугэл болов гэж ариун судар Куранд бичжээ.

Бид эрдэм номыг мал хөрөнгө олохын тулд сурахгүй. Урлаг соёл, мал буян хийгээд соёл урлагийн удисыг сурах нь-буяны үйл байдаг. Гэвч энэхүү урлахуй ухаан үнэнээс хазайхгүй номын ёсонд зохицсон байх нь чухал. Хүнд зохих хэмжээний өөриймсөг зан байх нь чухал, гэхдээ хэрээс хэтэрч болохгүй. Ийн Молла нарыг номлохоо түр азная.

Одоогийн элдэв төрлийн эрдэмтэй гэгдэх шүүрхий номч багш молла нараас ямагт сээрэмжлэгтүн. Тэд эвдэрч дуттуу боловсрогчид учир зовлонгоос өөр хүнд юм гэж тэдэнд байдаггүй юм. Бас жаяг номыг ч сайн мэдэхгүй, ихэнх нь харанхуй мунхаг хүмүүс. Хэр хэмжээгээ мэдэхгүй өөрийгөө орхиж бусдыг даяанчны мөрд оруулах гэж сургадаг. Энэ нь тэдний хийх ажил огтоос биш. Тэдний буян мөрд хүргэнэ гэдэг нь бутэхгүй зүйл. Тэд хүмүүнийг эвдэн сүйтгэгчид эрдэм номонд ч ёст мөрөнд ч аюултай этгээдүүд. Тэдний түшиг нь-тэнээ

мунхагууд, үг нь худал, иотолгоо нь гарас салгадаг гүй эрхи, урхи нь хүмүүний цайлган сэтгэл юм.
Тэдэнд түүнээс өөр ямар ч эрдэм үгүй.

Үр ач нар минь! Та бүхэн одоо л ухаарч эхэллээ. Аллах тэнгэрийн мэр гэдэг нь хэмжээ хязгаар, эцэс төгсгөлгүй үлэмж агуу зүйл байдаг. Түүнээс эцэс төгсгөлийг хэн ч үл үзинэ. Гэвч тэр ариун мөрийг хэн илүү үнэнчээр өөрийн зорилту болгоно тэр хүн ариун мусульман, төгс хүн гэж нэрлэгдмой.

Орчлон дахь эцсийн зорилго чинь өөрийн ашиг туслын төлөө чиглэх аваас чиний бие хэмжээ хязгаартай болох хийгээд тэр нь Аллахын мэр байж хэрхэвч үл чадна. Орчлонгоос цуглаж ганцхан надад асгарч овоортог гэж бодох нь эд буяны шуналгүй үнэнч ариун хүний чанар бишээ!

Тодруулбал: Ямар ч хэлбэрээр гэсэн мал хөрөнгө, ухаан бодол, эд агуурс,.. ер нь юу ч байсан хамаагүй байгаа зүйлээ тус болохын үүднээс өрөөлд зориулж гэмээ нь сая л тэр нь жинхэнэ Аллах тэнгэрийн мэр болой. Тэр нь хэмжээлшгүй мэр болох хийгээд хүн хэмжээлшгүй мөрт алхаж гэмээ нь хэмжээлшгүй тэнгэр лүгээ ойртож, жинхэнэ хүний мөн төрхийг олдог байна. Гэтэл ихэнх хүмүүсийн амьдрахуйн зорилго нь хоол олох, хувцас өмсөх төдийхэнд зориулагдсан байдаг нь харамсамаар. Энэ нь зөвхөн өрөөл бусдад магтан шагшуулах «аяа гэж дуу алдуулах» гэсэн мунхаг сэтгэлээс үүдэи гардаг нь түү ч өрөвдмөөр харагддаг.

Өрөөлд сайн хэлэгдэх эсвэл цуглуулсан эд агуурсаараа гайхуулан «бишрүүлэхийн» ач тус гэж үгүй билээл?

Жинхэнэ гэрэлт сайн чанар нь хүний гадаад төрхөд бус дотоод сэтгэлд оршин байдгийг мартаж болохгүй юм. Гадаад үзэмж гэдэг нь толинд туссан сүүдэр лугаа буюу хүн түүний г нэг л харахаас олон дахин харах боломж үгүй юм.

Харин дотоод сэтгэлд үлэмж тэгс үзэмж бүрэлдэж гэмээ нь тэр нь мөнхийн гэгээ лүгээ адил харагдаж, хүнийг шүтэн бишрэх сэтгэлээ ариусгах буяны дээд гэж хэлэлтэй.

Аллах тэнгэр сртөнцийг хосгүй гоо сайхнаар бүтээн бурдүүлж хүмүүнд түүний сайн сайхныг бахархан мэ-

Дэрч байхын туд ухаан заясан аж. Бас үргэлж мөнх өсөж буй болж байхаар болгож төрүүлжээ. Ийнхүү үргэлж өсөн төлжиж буй хүмүүний нэн тэргүүний зорилго нь ч -үнэнч наиз нөхөд олох явдал. Найз нөхдөө олшруулан, үнэнч нөхөрлөлийн эх үүдэл нь чадах бүхий эрөөлийн тусын тулд зориулах сайн санаа сайхан үйлсний үр төл болой. Хэнд сэтгэл илүү бол түүнд нөхөд олон байх хийгээд ямар нэгэн илүүц маяг гаргаж өрөөлд сайн харагдах гэсэн мулгуй зан, магтаал сонсохын төлөөнөө л амьдрах гэсэн муу-муухай зуршуудаас ангид оршиж чадах ажээ. Өөрийгөө илүүд харуулах гэсэн зан авир нь хэдэн янз байдаг.

Нэгдүгээрт; Аливаа муу-муухайг ялган салгаж, хүний мөн чанарыг алдагдуулдаг буруу үйлээс сургамж авч, түүнээс цаг алдалгүй өөрийгөө татаж авч чадах чадавхи нь хүнд гэрэл гэгээ болдог байна.

Хоёрдугаарт; Өөрөө өөрийгөө магтан сайшааж бусдаас илүүд болгох тэдэг нь хүний мөн чанарын гэрэл гэгээг унтраадаг байна.

Гуравдугаарт; Мууг үйлдэх, өрөөлд хорлол хийх, басаж доромжлох зэрэг нь дайсан цуглуулахын эх үүдэл юм.

Өөрийгөө илүүд үзэх аливаа хэлбэр нь-онгироо байдал, ухаан мунхаг хөөрүү сагсуу зангаас төрдөг.

Хөөрүү зан нь-бусдаас илүүд гарах гэсэн өөриймсөг сэтгэлнийг буй болгож, өөриймсөг сэтгэл нь үзэн ядалт, атаархалыг бүрдүүлдэг. Эл гурван зангаас өөрийгөө хамгаалж чадсан хүн сэтгэлийн амарлингүйтгэлдэг. Сэтгэлийн амарлингүй байдал нь-хийж бүтээхийн хуслийг төрүүлдэг.

Хүн төрөлхтөнд чөдөр тушаа болдог гурван муу зуршил байдаг. Энэ нь нэгдүгээрт:-мунхаг байдал, хоёрдугаарт:-залхуу зан, гуравдугаарт:-зальт мэх юм.

Мунхаг байдал нь-эрдэм мэдлэггүйн гай бөгөөд ертөнцийн ямарч сайн сайхан юмыг эрдэм ном үгүйгээр олж мэдэх гэж үгүй.

Мэдлэггүй хүн адгуус шинжээс үл ангижирюу!

Залхуу зан нь-сав шимиийн ертөнц дэхь хамаг урлагт гоо сайхны дайсан мөн болой. Ухааны мунхаглал, ичгүүргүй байдал, ядуурлын эх булаг бүхэн нь залхууралаас үдьюу.

Заль мэх нь-хүний үрийн дайсан нь болой. Хүнд

дайсан болох нь хүн төрлөөс салахын нэг хэлбэр байдаг. Тэгснээрээ хүмүүн та адгуус төрхөд орж байгаа хэрэг юм.

Эдгээрээс салахын арга нь хайр энэрэл. Хүн төрөлхтөн хийгээд ертөнцийг үзэх сайн үзэл, хийж буй үйлийнхээ эцэс төгсгөлийг харж чадах ухаан, эрдэм мэдлэг зэрэг нь болой.

Энэ нь номын үүдийг нээсэн Аллах тэнгэрийг хайрлах хайр буюу түүний хязгааргүй үлэмж хүчин чадлаар буй болсон дэлхий ертөнцийг хайрлан түүний түмэн увидасыг таньж мэдэх гэсэн чин хүсэл, тэнгэрийн ариун мөрийг үнэн сэтгэлээр дагаж хулцэх гэсэн өгөөжит сайн сайхан санаа зорилгын хөврөл юм.

Аллах тэнгэрийн буй болгосон бүхийл юмсын ач буяныг мэдрэх, тэгснээрээ өврийн биеэ тэр ариун бүхэнд чиглүүлэн бусад тусгүйлүүдийг бүтээх гэвэл тэр нь сайны үр хөврөл юм.

Үүнгүйгээр үйл нь үйл болохгүй, шүтээн нь шүтээн болдоггүй байна.

Аллах тэнгэр ямарч зүйлийг учир шалтгаангүйгээр буй болгоогүй байна. Ямар ч учир шалтгаангүйгээр хүмүүнд зарлиг, сургаал айлдаагүй байна. Бүхий л юмс угтатай хийгээд учир шалтгаанташ юм. Хүнд атугай номын ертөнц, хайр энэрэлт бүхэнд өртэй гэдгээ ухаарах нь хүмүүний өөрөөс шалтгаалах хэдий ч эл шалтгааны эх үүдэл болох ухаан, хайр хоёрыг аллах тэнгэр хайрлажээ. Сэтгэл нь ёст номын үүдэл бөгөөд үүнийг хэмжээлшигүй зөнт гэгээнтэн сургаальдаа: «Үйл бүтээхийн тулд сэтгэл чухаг» хэмээн айлдажээ.

Та шүтлэг үйлдэхийн тулд угаал үйлдэж, маатаг барьж, мөргөл хийлээ гэж үзэхэд эд бүхэнд сэтгэл өгөхгүйгээр үйлдэж гэмээ нь үнэн сүсэг бишрэл болохгүй гэдгийг мэдэх нь чухал.

Таны дотоод эрхтэн цэвэр байх нь угтаа тамиг сэтгэлийг барьж байх ёс хийгээд энэ нь таныг сэргэл оюуны нэгэн тусгал болж, та дотоод оюунлаараа буслад гэгээ болдог байна. Тиймээс ч ухаант мэргэдууд «Шуттээн хоёр бус нэг байдаг ба тэр нь сэтгэлийн амарлингүй хэсэгт оршиж, төгс утга гэгээрч, амарлингүй бус сэтгэлд бүдгэрэн сөнөж улмаар устаж үгүй болох аюул ч буй» тэж үзэсэн нь байдаг.

Надад нэгэн бодол бий: Ихэнх хүмүүс шашин үй-

лийг зөвхөн гаднах хэлбэрээр л дагаж үйлдэж байх шиг байгаа юм. Бас тэгснээрээ Мусульманы тоонд орж байна гэж хууртдаг юм шиг. Энэ нь зөвхөн ёст үйлэнд сахиул манааны үүргийг гүйцэтгэж байгаа явдал юм.

Сахиул хийж байгаа хүн манаж буй юмныхаа бүрэн бүтнийг хайхралгуйгээр, зөвхөн унтахгүйг бодох ахул ямар манаа болох вэ?

Зүй нь сахиулын үүрэг нь манаж буй юмаа бүрэн, бүтэн байлгах явдал шүү дээ!

Үнэнийг үл ухаарагчид сонсогтуун!

Номын ёсны эх булаг нь-үншлага хийгээд үншлага өмнө угаал¹ үйлдэл хийх ба тэгсэний дараа мөргөл үншлага үйлдэг. Угаалгын өмнө хүйс эрхтийн ариутган цэвэрлэдэг. Үүнийг сайн тогтоож авагтуун. Төгсгөлд нь хоёр гутлынхаа хоншиорт ус хүргэж угаалаа дуусгадаг. Эдгээрийн ихэнх нь зөвхөн ёс төдийхөн зүйлүүд шүү дээ. Та ёс болгож эрхтийн угаадаг санж. Таны эрхтийн цэвэрлэх нь өрөөлд ямар хамаатай юм бэ? Зүй нь та «Миний дотоод сэтгэл төгс ариун хийгээд, түүнийг, түүнийг гацаад орчны хүмүүн хараахай харж чадахгүй байгаа тулд би гацаад эрхтэнүүдээ угаан цэвэрлэж түүгээр дамжуулан дотоод сэтгэлийнхээ ариун эсэхийг харгуулж байна» хэмжээн байгаа бол зөв юм. Гэвч ихэнх тохиолдолд дотоод сэтгэлээ мартаад, гацаад эрхтэндээ анхаарал хандуулдаг шүү дээ! Уг үншлагын нэрийг-салуат буюу «Тарни» гэдэг.

Хөл хүзүүндээ ус хүргэж шавшлага чийж биед иллэг хийх нь утаал бус угаачихсан гэдгээ итгэх явдал байдаг.

Үншлагын үед хоёр чихээ таглах нь-Аллах тэнгэрийг өндөрт байгааг итгэж, гарсаа ялыгүй өргөх аялаж буй нь-нүгэлт амьдралаас авч авраач гэсэн гүйлгээ юм-санжээ.

Түүний дараа босож зогсож Аллахад залбирч гарсаа зориулэн барьж буй нь-эзнийчээ өмнө зогсох боол хийгээд, ард олон хаадын өмнө зогсохоос илүү Аллахын өмнө сөгдөх нь хүндэтгэлтэй болоод өөрийгөө өчүүхэн гэдгийг илэрхийлж байгаа явдал юм.

Наран жаргах зүг рүү харж зогсох нь аллах тэнгэрт ямарч байр орон зохицхгүй гэвч, Мухаммед гэгээнтний шарилаа байрлуулахыг гэрээслэсэн зүгруү нүүрээ харуулж, тэндэх тарни уншлагаас адис авах гэсэн санаагаа илэрхийлж байгаа хэрэг юм.

Түүний дараа «Кира-ат» буюу «Фатиха» хэмээх тарлийг уншина. Энд ганц уг урт удаан хэлэгддэг.

ФАТИХ тарnid маш учиртай түн утга шингээсэн байдал.

Аллах буюу тэргүүнээр мөргөх нь-Мөн аллах тэнгэрийн өмнө өөрөө өчүүхэнээ илэрхийлж буй хэрэг юм.

Цагаан нөмрөгтөө толгойгоо хүргэн иэн түрүүн газраас төрсөнөө, удаа нь буцаад газарт шингэхээ зөвшөөрч буй явдал аж.

Толгой өргөх нь дахин мэндэлж Аллахын өмнө хийсэн нүгэл буянаа өчих гэсэн үйлдлүүд гэж үздэг.

Уг мөргөлийн төгсгөлийн тарнийн дараа. Аллах тэнгэрт тахай-ат (мэнд хүргэж) түүний дараа ерөл, соёрхол хайрлаж түүний дараа хэмжээлшигүй зөнт дуусашгүй буянт Мухаммед гэгээнтэнд хандуулж тарни уншиж, Аллах тэнгэрээс хүсэх зүйлээ хэлнэ. Төгстөлд нь нийт мусульманчуудын сайн сайхныг хүсэн хүлээж буйгаа илэрхийлж уншлага өндөрлөнө.

Тиймээ, бид энэ үгнээс өчүүхэн ч атугай сургаал болох зүйлийг олж мэдэж гэмээ нь тэнтэрийн тэтгэлэг хүсэх юм байна.

ГУЧИН ЕСДЭХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Өвөг дээдэс маань эрдэм мэдлэг, амьдрах чадавхи, ариун цэвэр, боловсон байдлаараа өнөөгийн билний төвшингээс доогуур байсан нь үнэн боловч тэлэнд бидэнд байхгүй хоёр сайн чанар байжээ.

Өнөө үед өвөг дээдсийнхээ хоцрогдсон үзүүднийг таягдан хаяж байгаа нь энэ гэж нөгөө орхиж болшгүй нандин чанаруудыг нь бас хамтад гээгдүүлжээ.

Энэ үеийнхэн өөр зан төрх луу ханаран хэт хурлтай өндөр авч яваагийнхаа адилар өвөг дээдсийнхээ тэрхүү хоёр чанарыг орхилгүй хадгалж чадсан бол бид ч гэсэн бусад ард түмэн адил байж, тэдэнтэй мөр зэрэгцэн явж чадах байсан аж. Тэр хоёр нандин чанар үгүйгээс болж сурсан бүх зүйл маань хүн ёсны эсрэг чиглэж, хийж буй үйл маань заримдаа чөтгөрийн үйл

лугаа хувираад байна. Ард түмний төрхийг алдаад байгаа маань ч үүнтэй холбоотой.

Тэр хоёр чанар нь юу байв гэвэл, нэн түрүүнд, тэр улсыг толгойлогч, овог отгыг толгойлогч ахсахал нар тэж байв. Нүүдэл-суудал, заргашигуулэг зэрэгт тэд л эрх мэдлийг барьдаг байж. Бусад хар бор ард түмэн өөр өөрийн ажил үйлээ бүтээгээд л явдаг байна. Толгойлогч нар юу хийж, яаж зарлиг тушаал буулгаж байсан ч гэсэн ард түмэн тэднийг муу хэтж, буруутгаж тэрслэхгүй байлаа.

«Хонины шагайг барьж үзээд сэтгэлд нийцэнийг нь сах болго», «Бие биенээ эс хүлцвэл нутаг хангайд үл багтыюу», бие биедээ эzetэй бол ассан түймэрт ч үл автыюу» гэж мал гаргаж ёслол үйлдээд хоёр жолоо нэг цулбуураа таңьд атгуулваа. Атгуулсан гар авах гэж үгүй, атгасан гар алдах тэж үгүй ард төвшин бол, тэр төвшин!» эзийг сахин хэмээн андгай өгч, сайнныг нь мартаж, саарыг нь засаж, залруулж явдаг байжээ.

Түмэн олноор хүндлэн дээдлэж буй болохоор олны итгэлийг хүлээсэн толгойлогч нар ч гэсэн тэр бүрт итгэл алдаж, урваж шаргадаггүй байж. Бүгд өөрийн ахан дүүс, бүгд өөрийн мал буян болохоор үнэн сэтгэлээр тэдний төлөө л зүтгэдэг байж.

Хоёр дахь нь:-Нэр төрөө ихэд хүндэгтэдэг байж. Нэр ус хэлж, дээдсийн онгоныг дуудах үед ах дүү хоорондын хэрүүл гоморхлыг мартаж, амиа хайрлахгүй байж.

«Өөрийн төрлөө үл бодогчид, өрөөтийн төрлөөс зовлонг эдлэнэ» гэж, «Ах дүүсийн хооронд гомдол байдаг ч дүрвэх гэж угтуй», «Бүгдээрээ дундаа эzetэй бол буян хишиг дэлгэрнэ» ах дүүс хоорондоо эзегүй бол дүүрэн хишиг алдарна» гэж буюу «Аяны мөр хөөгч аз хишгэнд хурнэ, хэрүүлийн мөр хөөгч хэтдээ зовлонд учирна» гэлцдэг.

Энэ бүхэн нь ичгүүр, нэр төр, сэтгэлийн хат зэрэг нандин чанаруудыг чандлан сахисаных бөлгөө. Бид энэ чанаруудыг алджээ!

Одоогийн хүмүүсийн нэхэрлэл нь-үнэн сэтгэл бусайл хоорондын атаархал амарлингүй сууж чадахаа байсан маш өчүүхэн бодлын үр хөврөл болон хувирчээ.

ДӨЧДӨХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Сонсон хүлцэгч та бүгдээс асуух гэж бодсон нэгэн зүйл бий.

Манай казахуудын үхсэн хүмүүст муу нь байдаггүй, амьд хүмүүст сайн нь байдаггүйн учир юунд вэ? Гайхмаараа.

Хүч харьсан өвгөчүүл нь залуу улстай тохирч сууж чаддаг. Тэгсэн атлаа үеийн олон нөхдөөсөө хагацан сутарч үлдэж буйгаа мэдээд байвч нэг-нэгэндээ тохирч сууж чаддаггүй нь хаашаа вэ?

Харь газарт ёусан махан төрөл үгүй хүмүүстэй ахан дүүс мэт нэгсэж дасдаг ч гэсэн нутагтаа эргэж ирсэн хүмүүсийт дахиж оргож явахаар болгодог нь ямар учир вэ?

Харийн нэг сайн хүнийг харвал «Хөөрхий» гэж хөл алдана, өөрийнхөө нутаг усанд түүнээс илүү сайн хүн байгааг олж хардаггүй нь юун учир вэ?

Нэгэн аянг өөр газар очихул, очсон газраа нутаг усаа магтах гэж баахан худал ярьчихаад эргэж ирээд очсон газраа магтах гэж худал ярьдаг нь юунд вэ?

Аль ч казах хэн нь болов нялх хүүгээ эрхлүүлэн энхрийлж байгаад эргэлдэж яваад, өсөж торnisон хойно нь хүйтэн элэг гаргадаг нь ямар учир вэ?

Ахан дүүс найр наадам, ухэл хагацалтай үед биеншидээ олддоггүй мөртлөө авах, өгөх, зарга шүүлгийн үед олддог нь юунд вэ?

Морь уяж байгаа үед үзэгддэггүй ахан дүүс, хурдан морины байнд булаацаалдаг нь юу вэ?

Дээр үеийн өвгөчүүл: «Тэдэн насанд минь тним хүн, гийм газар эцэж яваа морийг минь сэлгэж нэг хөл залгуулж билээ» гэж ухэн ухтлээ ярьж суудатсан. Одоо үед, жилд унуулсан агт морь маань жил хүрэхгүй мартагдаад байдгийн учир юу вэ?

Баян хүний үр ядуу бол хулгай хийхээс ичиж зовохгүй мөртлөө баян болохоос ичдэг нь ямар учиртай вэ?

Хоёр сайн хүн нэг голд багтаж сууж чадахгүй байтал хоёр муу хүн амархан нийлчихсэн байдгийн учир юунд вэ?

Нэгнийг найз гэж бодоод унаалга морь өгч явахад өөр нэгэн хүн ирж даагаа өгвөл түүнийг дагаад явчидаг нь ямар учиртай эв?

Өдөр бүхэн үгийг минь сонсдогч найзтай байтлаа, нэг өдөр үгийг нь сонссон дайсныг илүүд боддог нь юу и учир вэ?

Зарим хүний сургаал хэлж сонсгох хүнийг олж чаддаггүй. Гэтэл сэтгэл зурхийг нь хялгас сунах мэт сайн мэддэг хүнээс зугтаадаг юу вэ?

Өрөөлийн гэрт зочин ирэлэд тэдний хамаг малыг нь хотонд нь тууж авчирдаг хүний өөрийн гэрт зочин ирэхэд хотноосоо хамаг малаа туутаад явуулчихдат нь ямар учиртай вэ?

Ард түмнийг юунд сэргэлэн хүн толгойлно?

Сэргэлэн хүмүүс юунд цөмөөрөө ядуу байна? Бага хаташ яагаад ихэмсэг байдаг юм? Адайр хүн юунд эр зантай байдаг юм? Ядуу хүн юунд хэдэр зантай байдаг юм. Шуналлаа дарж, сэтгэлээ барьсан хүн муу нэрийг зүүж, шуналд автаж, магтаал дагаж, хэрүүл өдөгч хүн чадвартай тэж хэлүүлдэг учир юунд вэ?

Казахуудын үнэн үгэнд итгэхээсээ ҳалширч зугтаадаг мөртлөө хараалт үт, хэрүүл маргаанд илүү дурлаж, хамаг ажлаа мартан байж эцсээ хүртэл чих тавьж чагиадгийн учир юунд вэ?

ДӨЧИН НЭГ ДЭХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Казах хүнд ухаан зааж зөв мөрт оруулна гэж зүтгэж буй хүнд бээр чухаг хоёр зүйл байдгийн санаж байх нь зүй.

Нэн түрүүнд-чадал бүхий төр засаг, хуулийн эрх мэдлэг сайн удирдагч хэрэгтэй. Томчуулыг айлган сурдуулж, хүүхдүүдийг нь хүчээр булаан авч, сургууль соёлд оруулан өртөнц дэх түмэн төрийн сургуулиудад тарааж «Чи үүнийг сур, чи тэргийг сур» гэж албадан зааж өгч, ард нь үлдсэн аав ээж ард түмэнд нь сурх зардлыг даалгаж охид бусгүйчүүдийг нь ч гэсэн бур арта ядахад мусульман шашини сургуульд явуулж, шашини номыг сайн мэддэг болгож сургавал, сая л тэр залуус мэдлэгт боловсролтой болж, эцэг эх нь өгөлж үг хэлэхээ больсон үед л засарч магад.

Хоёрдугаарт; Тэр хүн хязгаартгүй баян байх хэрэгтэй. Эцэг эх нь хахууль өгч байж хүүхдүүдийг авч, түрүүнд хэлсэн замл оруулан сургаж гэмээ нь сая засрах буюу.

Харамсалтай нь ийм ард түмнийг хүчирхийлэн захирага хүч, тэр олон хүүхэд, түмэн казахыг хээл хахууль өгч сургах хөрөнгө нэг хүнд заяах гэж үгүй юм.

Казахыг айлгаахгүй юмуу, хээл хахууль төгөхгүйгээр юмуу ухаан мэдлэгээр давамгайлж, аргадаан хэлж ямарч юманд зөвшөөрүүлнэ гэвэл худлаа л болно. Маханд нь шингдэж, ясанд нь шингэсэн эцэг дээдсээс нь өвлөгдэж, эхийн сүүгээр бурдсан-харанхуй мунхаглал эдлий хүн чанарыг аль эрт гээтдүүлсэн аж. Өөрснийхөө сурсан зан хов-жив, хоосон хөөрлөөс ондоо сайхан зүйл ертөнцөд байхгүй гэж бодоод түүндээ бүр итгэсэн болохоор ямар ч сайн юмыг ярьж хэллээ ч гэсэн чих тавьж, анхаарал хандуулж сонсдогтүй юм. Сонслоо ч гэсэн сэтгэл зүрхээрээ итгэн үнэмших гэж үгүй

Ийм байдалт бид чинь юу бүтээж, юунд хүрэх бот?!

ДӨЧИН ХОЁРДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Казах хүний муу зуршилд автамтгай байдаг нь ажилгүйдлийн шинж бизээ. Хэрэв тариа тарьж, арилжаа паймаа хийж эхлэвэл сэлтүүцэн зугаацах завгарч, зүгээр сууж чадах гэж үү?

Нэг айлаас нөгөө айлын хооронд айраг цагаа эргүүлээ дэмий давхилдаж, хов жив, хэруул маргаан дамжуулж түүнийгээ амьдралын чухаг зүйл мэт шүнаж, дурсаж явахыг бахархал болгогчдыг яана. Амьдралх гэж амьдрахын тулд хөдөлмөрлөхийт боддог хүнд бол ингэж явахыг «нохой долоо!» гэж үнэн жигшин үзнэ биз дээ? Ажил төрлөө орхиж дэмий сэлгүүцэгүй биз ээ? Малтай нь малаа авгай хүүхэд, малчдал даатгаж, аллах тэнгэрээс өгсөн арав таван мал нь сонирхолгүй харагдаж, нохой шувууны зоог болохыг юманд бодохгүй тэвчих мөртлөө хов жив ярианаас хоцорч, хэдийд ч хамаатуй очиж арга заль хэрэглэн үнэгүй хоол олж, хоног өнгөрөөх зэргээс үлдэхийг харин тэвчихгүй. Учир нь залхуучуудын дадсан зуршил нь юм болохлоор ажилч хичээнгүй, мал маллаж, эд хөрөнгөө арвижуулах авхаалжтай сэргэлэн хүнд ойр тохгүй, өөрөө юмуу өрөөл бусдыг өдөж хэруул маргаан гаргах дуртай, хов яриа хургэхдээ дадсан нэгнийг авьяастай сэргэлэнд тооцож, аль болох тийм хүнтэй ойр байхыг илүүд үздэг.

Тиймээс ч энэ үеийн казахуудаас ажилсаг гэгддэг нь тав арван малаа бусдад нийлүүлчихээд эсвэл «харж хандаж бай» гэж захичихаад сугарч чөлөөтэй болоод ирэхлээрээ нь уг отож, хоол эргүүлэн айл амьтан хэсэх «ажилдаа» ордог.

Өнөө үед эд баялаг ч юм биш, нэр төр, эрдэм ном ч юм биш, өргөдөл өгөх, хуурч мэхлэх л баархал болсон мэт. Энэ хоёрыг чадаж бүхий л хүн ганц морь, хугархай таягтай байлаа ч гэсэн хойморын суудлыг эзэлж, өөхтэй мах, идтэй моринд гар хүргэдэг гээц. Онгирч сагсуурах дуртай баячуудыг «та л хэлбэл би бэлэн» гэж хөөрүүлэн, малаа маллаж, галаа тулэхгүйгээр хувцсаа битүүлэн, сайн морийг нь унаж, шан хэргэм хүртээд л явж чадна.

Мөнөөх баян нь өөрийн амрыг ч мэдэхгүй дэмий л шулуулж буйгаа ч ухаарахгүй. Хүнтэй ярих хэрэг гарвал «энэ золигоор ч яах билээ» гэж нөгөө тэнэгийнхээ үгийг дагаж, түүнтэй л зөвлөлдөнө. Тэр жороо үхэр лүгээ ихэмсэг байдлыг олж, ганцаараа л чадаж байхын хүсэлд хүлэгдэн бас өөр хүн олдвол өөрийн суурь алдараа бодож «Өө зайлцуулаа тиймхэш юмыг мэдэж сөхөөд байх юу байх вэ! Тэр чинь ийм арга, тийм заль шүү дээ! Зүгээр л ингэчихвэл болою!» гэж аль нэг бүтэлгүй хариуг хэлж өгч, арга залинд сургасаар байж эцэст нь мөнөөх баяныг ч хүнд итгэхгүй болгодог. Бас өөр хүнийг ч баянд итгэхийг нь болиулдаг. Баяны өөрийн үт, өөрийн зан төрх бүтэлгүй болоод ирэхлээр нь мөнөөх хүн нь «би хэлээгүй юу, тэр залилах гэж байна гэж анхааруулсаар атал!» гэж баяны өөрийг нь буруутгах, дараагийн удаад үгнээс гарахгүй болгож авдат. Өнөөгийн хүмүүсийн ухаан нь ч, хүсэн хүлээх зүйл нь ч энэ ээ!

ДӨЧИН ГУРАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хүн амин чадал ба (дотоод оюун), бие гэж хоёр юмнаас бүтэх авай. Энэ хоёрын дунд болж буй юмсын аль нь ангид бий болсон зүйл, аль нь хүсэл хөдөлмөрөөр бий болсон зүйл гэдгийг мэдэж байх нь тустай юм. Идэхсэн уухсан гэдэг нь-хүслээс ангид эрхгүй байдаг зүйл. Унтах ч гэсэн үүнтэй адил төстэй юм. Их ч бага ч гэсэн сурхасан мэдэхсэн, үзэхсэн гэсэн нь

хүний хүсэл, зорилго, мөрөөдөл болој. Эдгээрийн ч гэсэн эхлэл нь эрхгүй болдог ангид зүйл.

Ухаан эрдэм-зэрэг нь хөдөлмөрөөр бий болдог зүйл. Нүдээр үзэж, чихээр сонсож, тараар барьж, хэлээр амталж, хамраар үнэрлэж гаднах орчинг мэдэрнэ. Тэрхүү мэдэрч байгаа юмсын аятай нь аятай байдлаар, аягүй нь аягүй байдлаар аливаа юмс өөрийн буй төрх зураглалаараа сэтгэлд тусдат. Мөнөөх сэтгэлд тусгасч таван эрхтэн юмсыг сэтгэлд тусгасны дараа түүнийг сэтгэл өөрийн шүүлтуүрээр ялган салгаж байрлуулдаг, зурагладат байна.

Энэ нь амь буюу дотоод оюуны хүч чадал буюу мартагдашгүй сайн юмнаас сэтгэлд муу юм бий болж байдаг байна. Хүч чадал анхандаа маш өчүүхэн байдаг. Анзаарч хайхарсан хүн түүнийг хөгжүүлэн ихэстэж, хүч чадлын хүчийг нэмэгдүүлэх хийгээд үл хайхарсан хүн тэрхүү хүч чадал ямар хэмжээтэй байсан ч гэсэн устгаж үгүй хийдэг. Эсвэл өчүүхэн жижиг зүйлээс өөр юманд хүрэхээргүй болгодог.

Хэн ч атугай гаднаас сонсож мэдэх, харж мэдэх зэрэг зүйлүүдийг ихэсгэж чадваас, тэрээр ихийг цуглуулсан хүн. Их зүйлэсээ хэрэгтэй, хэрэггүй ялтан салгаж тэдгээрийг өмнө цуглуулсан зүйлүүдтэйгээ харьцуулан салгаж авдаг. Ийнхүү хийж дадсан хүнийг ухаантай гэдэг.

«Аллах тэнгэр ухаан заяснаас хойш яалтай билээ» гэх, «Аллах тэнгэр чи биднийг адилхан заяагаагүй» гэх нь аллах тэнгэрийг хилсдүүлж, өөрийгөө өмгөөлөх гэсэн өчүүхэн явдал юм. Энэ нь-бодлогогүй, авьяастгүй мунхат хүний үйл. Түүнд Аллах тэнгэр битгий үз, битгий сонс, үзэж харсан зүйлээ сэтгэлдээ буу хадгал! гэж хэлсэн гэж үү?! Инээд найр наадам, идэж уух, унтаж хэвтэх, хоосон магтуулах зэрэгт цаг нөхцөөж, дотроо буй баялагaa алдчихаад, адгуус төрхтэй бай гэж хэлээгүй нь үнэн.

Зарим нэт хүний хэлэх нь: «Ухаан эрхгүй ч гэсэн авьяас эрхгүй. Аллахаас авьяас өгсөн хүн ухааныг олно, авьяас өгөөгүй хүн үл олно» гэдэг. Энэ нь буруу ойлголт юм. Авьяас бага хүүхдэд ч байдаг. Дээр хэлсэн шүү дээ-амин чадал буюу дотоод оюун анхандаа маш өчүүхэн байдаг, түүнийг үл хайхарвал устаж үтгүй болж, хайхар, арчиж тордвол хязгааргүй өсдөг. Амин

чадлаар хүний ашиглаж чадсан бүхий л эрдэм нь өдөртөө тогтмол шалгаж байвал өсөж байдаг гэж, Урт хугацаагаар шалгахгүйгээр оржигдүүлсан аваас олж авсан эрдмээ яаж угүй хийснээ бас өөрийгөө өмнөх үеэсээ отг өөр хүн болноо мэдэхгүй хоцорно. Аль алдагдсан эрдэм би алга болох нь ээ олж аваарай гэж анхааруулах вэ дээ! Муу зуршлаас ямагт сэргий-лэн сэтгэлээ толь мэт ариун авч явах явдал юм. Тэтснээр сэтгэлийн толинд туссан зүйлс улам гэтээлэг, улам өнгөлөг болж харагддаг. Ингэж туссан зүйл нь хүний хамаг биеэр тархан хүч өгч, сэтгэлд удаан хадгалагд-

Хэрэв мөнөх дөрвөн зүйлээр сэтгэлээ хиртуулж гэмээж нь зөв бодол санаа эвдэрч, юмыг муруй, будэг болгож харуулдат байна. Тийм байдалд ямарч олигтой юм болохгүй.

Биеийн хүчээр аливаа юмыг гаднаас олж хадгалдаг зүйлийг эд хөрөнгө гэж нэрлэдэг. Үүнд ч гэсэн хэд хэдэн төрөл байдаг. Тиймээс олсон зүйлээ зөв хадгалахын тулд түүний аюул тарих муу гэгдэх чанаруудыг нь сайтар ялгаж мэдэж байх нь зүйтэй юм. Түүн лүгээ дотоод амин хүчээр цутгуулсан зүйлийн нэр нь ухаан, эрдэм хоёр байсан шүү дээ! Түүнд ч гэсэн олон төрлийн аюул тарих муу чанарууд байдаг. Түүнийг мэдэж сэргийлж байхгүй бол бас л алдана. Аливаа сайн юманд хэмжээ хязгаар гэж байдаг ба хэмжээнээсээ хэтэрсэн юм бүхэн аюулд учруулдаа. Сэтгэлийн хэмжээ хязгаарыг мэдэх нь хүн ёсны маш чухал чанар юм. Бодож сэтгэлийн сайн нөлөөнд автсан хүн түүнээсээ салж ядан хүнд бодлынхoo дарамтнаас гарч чадахаа байх явдал байдаг. Уух идэх, өмсөх, инээх, сэтгэл сэргээх, арга ухаантай байх, хууртахгүй байх... гэх мэт бүхий л юманд хэмжээ байдаг. Эдгээрийн аль нэгийг хэтэрч гэмээ нь хор болой.

«Хүн юуг илүү хүснэ, түүний л зовлонг эдэлдэг» гэж эртний гүн ухаантнуудын үг байдаг. Хэлэхгүй орхиж болохгүй дээрх гурван зүйлээс «сша притягательная однородного», «подвижной элемент» гэсэн хоёр зүйл нэгдэн нийлж байж хүнд ач туст бүхий л юмыг бүтээдэг ба хамаг аюул болох зүйлийг ч энэ хоёр төрүүлдэг.

Хэргэм горилюх, магтаал хүсэх, уур уцаартай болох, худал хэлэх үүнлүгээ аливаа согтууралтанд автаж

мэт шуналыг нээж, ухаан алдаруулах бүхэн энэ хоёрроос болдог.

Эдгээрийг гүнзгийрүүлэхдээ нь ямагт сайн сайхан юмаар гүнзгийрүүлж муу зүйлүүд буюу дээр өгүүлсний адил хүн чанарыг алдагдуулж шуналт мөр лүү түлхдэг зүйлүүдээс ямагт сэргэмжлэн эрхтэн биээ таатай авч чаддаг байх нь чухал юм.

Сайн муу хоёрыг ялгагч хүчийг ухаан гэдэг шүү дээ! Гэвч ганц ухааны хүчээр үүнийг тогтоон барьж бас болохгүй. Бүхий л ухаан, бүхий л хүч хийморио гаргаж байж л сая муу зуршилаас ангижирч болно. Энэ хоёр хэнд илүү байх аваас тэрбээр гишгэлт (явдал) сайтай хүлэг адил больюу. Хэрэв энэ хоёр хүч хоёулаа дутуу байж гэмээ нь эсвэл нэг нь байж, нөгөө нь огт байхгүй байвал эмнэг морийг хазаар ногтгүй унасны адил хад чулуу хамаагүй мөргүүлж, усанд ч оруулж, аягүй бол замд тааралдсан хүн үг солихын ч завдалгүй ходорч чамд эрх үгүй, хормой чинь хийсэн тэнгэр шутэж явсаар үхэх газраа журнэ.

ДӨЧИН ДӨРӨВДӨХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Хүмүүний хамгийн муу чанар нь тэмүүлэл үгүй зан. Тэмүүлэлт хүмүүс өхэд хэдэн янз байдаг. Тэмүүлэл ч гэсэн олон янз байдаг. Хүн юунд ч тэмүүллээ гэсэн нэг нь нөгөөгөөсөө илүү тулах тулгууртай байдаг. Хүний үрс тэмүүлэлтэй, тэмүүлэлгүй байлаа ч гэсэн ялгаагүй аль аль нь магтаалын үг хүсэх гэж үгүй. Ямагт зөв ч бай буруу ч бай ямар нэгэн хэлбэрээр магтуулахыг хүсэж байдаг.

Хүн аль замд, ямар тэмцэлд явлаа ч гэсэн тэр тэмцэлд цуг яваа хүнтэйгээ илүү дотно байдаг. Тиймээс өөр замд яваа хүмүүсээс зөв магтаал хүсдэггүй юм. Надад магтаал хэлбэл өөртэй минь цуг тэмцэж яваа хүмүүс л үнэн зөв хэлэх байх гэж боддог.

Тэмүүлэлт хүмүүс ихэнхдээ өөртөө сайн нэрийг бодож, түүний төлөө л тэмүүлдэг. Нэг нь мал хөөж хариулдаг ч бай, хулгайлдаг ч бай ямарч л гэсэн мал цуглувал болов «Буян хураасан хүнд буруу байдаггүй» гэдэгсэн ба «Буянтны нүүр нь бардам» гэхчилэн зүйр үгэнд итгэж олныг царайгаар ялан, нохой ч байсан, мал буянтай хүнийг буруутгаж чадахгүй гэж бодоод, мөнөөх цуглувалсан хэдэн малаа үнэн буян мэт

Үздэг. Үүнийг казах сэтгэцийн хүрээнд бодоход зөв юм. Гэвч хүн чанараар бодолод сэжигт хүрмээр муухай л уйл. Үүн лүгээ зарим хажы ламтан болох гэж, зарим нь баатар болох гэж, зарим нь цэцэн билэгт, овжин залт болох гэж тэмүүлэн явна. Хэн нэгэн казахад байгаасай гэхэд нөгөө нь битгий байгаасай гэж бодоод олсон зүйлээ юманд бодоод ярьж байна.

Энэ нь казахын «судсыг барьж» үзээд «үүнийг авч ирж өгвөл илүү үнээр авах юм байна, бас энэ нэг юм нилээн үнэтэй юм байна» гэж казахын шүүрийг уншиж яваа болохоос номноос уншиж эрдэм сурахын төлөө тэмүүлж буй тэмүүлэл нь нэн түрүүнд сэтгэлийн ариусгалыг олох хэрэгтэй, удаад нь түүнийг дагаж хүлц гэж сургадаг. Казахын шүүрийг харж, түүнээс уншиж мэдсэн тэмүүлэл юм бол, түүнийгээ хийж л бай, сэтгэлээ ариусгах гэж бодсоны хэрэг байхгүй. Түүнийг чинь хэн л үзэв гэж дээ, дотроо олон давхар нугалаа байхгүй бол буян хурахгүй гэдэг шүү!

Уншигч авхай минь үүнийг уншаад ямагт тэмүүлж яваагаа ойлгох бизээ!

ДӨЧИН ТАВДАХЬ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Аллах тэнгэр хамгаас хөдөлшгүй нотолгоо нь хэдэн мяанган жилийн туршид янз бурийн хүмүүс янз бурийн хэлээр ярьдаг ч гэсэн тэд бүгдээрээ л нэг л их тэнгэр бурхан байдаг тэж үзэж ирсэнд буюу.

Нөгөөтэйгүүр тэр олон шашин ном бүгдээрээ л; үнэн сүсэг бишрэлт хайр нь аллах тэнгэрийн таалалд нийцдэг гэж сургаж ирсэн явдал юм.

Бид буй болгогчид биш хийгээд буй болгосон сүүдрийг харж ухаарал авдаг амьтад юм.

Үнэн, хайр хоёрын мөрийг дагаж, аллах тэнгэрийн агуу сургаалыг бие биенээсээ илүү мэдэхийн хирээр мөн чанараа илэрхийлэх зорилготой төрсөн биесүүд билээ. Итгэлт, үнэмшил гэдэг нь-итгүүлнэ, үнэмшүүлийг гэсэн үг биш юм.

Хүн чанарын эх үүдэл нь-хайр ба үнэнч ухаарал юм. Эдгээрт хэрэггүй үе гэж үгүй юм. Энэ нь буй болгогч аллах тэнгэрийн уйл юм. Азарга гүүг элэглэж харамлахад хүртэл-хайрын үүдэл орших аж. Эл үнэн, хайр хоёр нь хэнд илүү аваас тэр хүн-эрдэмт, тэр хүн-номт болох аж. Бид дотоод сэтгэлээсээ ном бүтээж үл

чаднам. Зөвхөн бүтэж, буй болсон зүйлүүдийг сэргж мэдэрч, нүдээр үзэж, ухаанаараа танимой.

* * *

КАЗАХЫН ГАРАЛ ҮҮСЛИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭН БОДОХУЙ

Балар эртний үеэ нүүдэлчдийн гарал үүсэл Дун Гуна «Хүннү» Санба (Сянби) Хөх түрэгээс гаралтай гэдэг. Чухам казахуудын өвөг дээдсээ Арабаас гаралтай гэж хэлүүлэхэд дуртай байдаг нь хачирхалтай. Тэр нь аливаа түүхэн сурвалж тэр зүгээс гарсантай холбоотой хийгээд исламын шашин нь эртний өвөг дээдсийг умартуулан шашинаар төрөлсүүлэхийг бодсоноос буюу хойч үе нь харанхуй мунхаг байсантай холбоотой бизээ.

Бүхэнд тодорхой нь угаасаа хүмүүн төрөлхтөн өн амьдарч буй газар нутагтаяа хоёр их талаас их урстгал болон орж ирсэн явдал. Нэг нь-Энэтхэгийн зүгээс, тэр зүгээс ирсэн ард түмний нэлээхэн хэсэг нь нь эрдэмтэй байж номын шинжлэх ухаанд ойр байж, хаанаас гаралтайгаа бурэн мэдсэн хүмүүс байдаг. Хоёр дахь нь Төв Азийн дээвэрт оршдог Монголын зүгээс, тэд цаг хугацааны ихэнхийг эрдэм номгүйгээр өнгөрүүлж, түүхэн сурвалжаа тэр бүр мэдэхгүй, хоосон хоцорч, эцэг эх, өвгөшүүлийнхээ хэлж ярьснаар, аман сурвалжаар шетаре буюу Монголын «цээжлэх» гэсэн үгнээс гаралтай «шаджира» мэдсэнээ болгож явсан хүмүүс байх юм.

Тэдний нэг буюу тодруулж хэлбэл монголын гаралтай тэдэнд гарал үүсэл маш ойрхон ард түмэн бол манай казахууд юм. Бидний казахын Монголоос гаралтай болох нь бидэнд ичгууртэй бус, бидний мэдлэг боловсрол, эрдэм номгүй улдэх маань л ичгууртэй хэрэг бизээ. Жишээлбэл: Ойрад Монголын Халимагийн дөрвөн өвөгийн нэг нь-Хазар. Тэр Хазараас гурван эцгийн хүү Персийн нутагт үлдсэн Хажар, Афшар, Чишташлы гэж байжээ.

Тэр улаан толгойт ертөнц дэх эртний хаадуудын үлдэпдэл-Хасрай гажамажхайн юм. Манай казахын Амудариягаас айн зугтаж ирээд, Сырдариягийн адагт халимагаас ялагдаж, дүрвэлтийн зовлонг эдэлдэг гунигт түүх нь Амудариягаас зугтааснаас болсон аж. Одоо-

гийн Насариддин шах Хажараас гаралтай хүн. Хэрхүрсэн нь олз атгаж, эрдмээрээ гүйцдэгээс хойш Халимаг өвөгт гэж хэн нь хаалт болном бэ?

Санаанд үлдэмгүй балар эртэд Монголоос Татар нэргэн ард түмэн салан тусгаарлажээ. Хятацу тэднийг «татан» гэж бичдэг. Хятаад «Р» үсэтийг учир Татар Татан болон шаштирт оржээ. Казахын гаралт үүсэл тэдгээр татаруудтай ойр одоо ч гэсэн төрэ овогт казахууд өөрснийгөө татарчууд гэж хэлдэг. Тэр нь бидгадны щагаачид биш, цусан төрөлт, цэвэр удмынхан гэдгээ илэрхийлж байгаа явдал юм. Түүнээс Татарчуудын хэн болохыг мэдэж буйдаа хэлж байгаа нь биш юм даг.

Лалын Ислам шашинд орж амжаагүй Дорно Сибирт одоо ч гэсэн казахуудын ах дүүс байдаг юм. Жишээлбэл Саха (Якут) улс хэл, соёл, зан заншил, өнгө төрхөөс нь төрийн шинж нь бүрэн харагддаг. Ялангуяа Енисейскийн амбан захирагчийн Минусинск хошуунд «Ясашынай татар» гэдэг нэртэй нэгэн ард түмэн байдаг. Казахуудыг их л дотно бодож, ахан дүүгээ гэж хүндэлж үзсэн хүн тэднийг казахтай төрөл гэхэд ясан ч маргаахгүй.

Бас истит туургатан Казах, Киргиз хоёрын уг гарвалд маргах хүн байдаггүй юм. Тэр Киргизүүдиг хятадууд болон харь орныхон «брут» гэж нэрлэдэг авч тэдний түүхэн бичгүүдэд ямар учраас тэгж нэрлэснийг тайлбарласан тайлбарыг бичсэн хүнийг би олж үзсэнгүй.

Манай казахууд Бийск, Кузнецк дэх халимагуудын ойр төрөл Алтайн Тува нарыг «Билетут» гэж нэрлэдэг. Миний бодлоор энэ «билетут», «брут» гэдэг нь нэг лүгнээс гаралтай болов уу? Тэд ч гэсэн Киргизын цусан төрөлт нь байж болзошгүй. Тэр татарууд дайнч анч учир юу бол юуг өмсөж, зүүж, аль тааралдсан болгөнүүг идэж ууж явдаг их л бүдүүлэгдүү ард түмэн байдаг юм. Тэдний ут суурь нь Енисей, Ангар мөрний эхэнд байжээ. Тэрхүү анчдаас сонсож мэдсэн сургаарл өмнө огт үзээгүй нутаг руу байгаагүй магтаал хэлдэг заншлаар өвөл нь богино, зүн нь урт гэж хэлсэнд эртдээс заншсан газар тариалангaa орхиж, мал барьдаг ард түмэн болохоор мал адгуулахад тохиромжтой газар» хэмээн энэ зүг рүү хэд хэдэн удаа хүмүүс

нь нүүж иржээ. Тэдний нэг нь бидний казахууд юм байна. Ямар ямар газар нутгаар дайрч ирсэн нь хэдэн жилд явж ирсэн нь тодорхой бус. Зөвхөн Алатау уулын бэлд нь хурч нутагласан байх юм.

Цаад талд нь эртнээс уйгар гаралт ард түмний суурышин нутаглаж ирсэн газар болохоор тэрлүү зүглэж чадаагүй аж. Тэдгээрийг уйгаруудыг нэгэн цусан төрөлт хэмээн бодоод явж. Эд нар нийллээ гэдэг ч гэсэн цаана нь өштөн дайсан санаж явдаг байжээ. Эхэндээ өөрөө өөрийгөө удирдаж эрх чөлөөтэй асан ард түмэн хаа хамаагүй харийнханд захируулахыг мунд хэцүүд үзсэн байна. Уг нь тэд ч гэсэн монгол гаралтай хэдий ч гэсэн эдэнд элэг ондоо харагддаг байсан аж. Тэр үед Арабаас энэ Дундад Азид Лалын шашыг дэлгэрүүлэгчид юлон цэрэгтэйгээ ирж, хүн ардыг шинэ шашин номд сургаж бүхийд Хутайба нэрт хүн Кашкар хүртэл ирж, хүмүүсийг ислам шашинд оруулахад эд ч гэсэн өөрснийгөө мусульман боллоо гэж үзсэн байна.

Гэвч эртнээс бөө мөргөлд итгэж, гал дөлөнд шүтдэг заншилаараа ислам шашинд тийм ч амархан орж зурхлэхгүй байсан аж. Тэр үед бага сага үсэг тайлсан хүнээ «абыз» «номч-төлөгч» гэж нэрлэдэг байжээ. Тэр «абыз» гэдэг бөгийнхний молла нартаа өгдөг хэргэм байж. Орчлонд юунд ухаан хүрэхгүй бол тэр зүйлийг тэнгэр бүтээн байна гэж сэтгэж биширдэг зан заншил үлдэгдлийг нь зарим газарт бид ч гэсэн үзсэн нь: «Бэр буулгахад их галд тос хийлгэж», «Гал эх, тос эх өршөө!» гэж хэлүүлж мөргүүлэх адил насан өөд болсон хүний сүнс сүлдэд зориулав» гэж зул асаах буюу хаврын эхэнд тэнгэр дуугарахад авгай нар шанагаараа гэр тойруулан цохиж «Сүү арвин, нүүрс ба-га» гэдэг байлаа. Үүн лүгээ адил ёс олон байдагсан. «Тэнгэр өршөө» гэдэг уг нь арилан үгүй болж байх шиг байна.

Тэр Арабууд нүүдэлчин ардыг «Хибай», «Хузаги» гэж нэрийлжээ. «Хибай» гэдэг нь эсгий асраар яватч, «Хузаги» гэдэг нь тэднийд ч гэсэн хузаги гэдэг нүүдэлчин түмэн байдаг аж, түүн лүгээ ойртуулж хэлсэн нь ажээ. (Уг нь дөрвөн янзын нүүдэлчин бий. Түүний сонагодогт Казах, Монгол, Киргиз баттдаг. (Х. И)

Тэр үеийн нэгэн хаан аян замд ирж яваад холбоо-той жингийн тэмээг үзээд «энэ хараа эд нар жинхэнэ Казах юм» гэж зориуд буцаж зэллэсэн галуу шувуутай зүйрлэжээ.

Түүнээс хойш эднийхийг бусад ард түмэн «Казах» гэж нэрлэснийг дагаж өөрснөө ч гэсэн Казах гэж хэлдэг болжээ. Өмнө нь казахууд өөрснийгөө «Улс» гэж нэрлэдэг байжээ. (Монголын «Улс» гэдэг угийг түрэг гарлын ард түмэн «Улыс» гэж бичдэг авч утга адил Х. И)

Тэр үед Наурыз гэдэг хаврын нэгэн баяр болж, наурыз хийнэ гэж хаврын тэргүүн сарын найр наадам хийдэг байжээ. Тэр өдрийг «Улсын их баярын өдөр» (Улсын баяр) гэж нэрлэдэг ажээ.

Энөө үед энэ уг мацаг тавих ёслолын өдөр гэж хэлэгддэг. Шинэ шашин бий болж дэлгэрснээс хойш хот суурин хийгээд газар усны нэрийг хүртэл эвдэж өөрчилжээ. Түүнээс ч болсон байх, ямар ч гэсэн Казах гэдэг нэр бий болжээ. (Казахуудыг монгол тэр-гүүтэй олон улс «Хасаг» гэж нэрийддэг. Гэвч, кавах гэдэг уг одоо болтол тайллагдаагүй Х. И)

Казахууд Алатаутийн бэлд амьдарч буй үедээ тариа тарих, наймаа хийх зэрэг ажилд зэргэлдээ хөршинарынхаа нөлөөтэйгээр суралцаж даджээ. Өөрснийгөө «Бор казах, хар казахууд», «Казах баяны үр сад» гэж хэлдэг нь тухайн үед төлөв томоотой, хүлцэнгүй байсных бөлгөө.

Киргизүүдүүн «Киргиз» хэмээх нэрийг тэр үеийн үйгарын хаад ноёдуудын нэг нь тэгж нэрлэсэн байж магад. Тэдний морин цэргүүд нь толгойлж явдаг «Киргиз» нэр үүсэх шалтгаан болжээ. Энэ нь «алуул, устггуул» буюу дайсныг дарагч гэсэн үгнээс гарчээ. Тэр үед тайван амьдарч номой казахын «Аураг алхсан хүний үйлс тэгшрэхгүй» гэж «Мөрдөж гараад агт шүүрсэн, морин дээрээс нойр шүүрсэн» гэж сайн эрийг магтаж, байсан нь аугаа их эзэн Богд Чингис хаанаас дараагийн үеүдэд гарсан домог бололтой.

Монгол гүрэн байгуулахад Чингис хааныг хаан шинрээнд суух ёслолд, казахуудын элч төлөөлөгч очсон байна. Чухам ямар нэртэй газар хүрсэн нь тодорхой бус гэвч энэ бидний буянт нутаг Чингис гэж нэрийлсэн нь түүхийн сурвалжтай. Түүний цэргүүд харуул то-

лын хөвөөнд саатаж, арван хоёр овгоос арван хоёр хүн очиж Монгол заншлаар «хаан» нэрт өндрийн дээр шагаан эсгийнд Чингисийг суулгаж хаан өргөмжилсөн гэдэг домог бий. Уг уул үүнээс хойш Чингис хэмээн нэрлэгдсэний учир тэр болой.

Тэр арван хоёр хүний нэг нь Казахын Майхы би (монголоор Мэнхө цэцэн) гэдэг хүн байсан аж. «Төгс үгийн төгсгөл-нэг, төгс төгөлдөр эцэг нь-Майхы цэцэн» гэдэг зүйр уг ч байдаг.

Майхы гэдэг нь тэр хүн болой. Чингис аян дайнд мордоход жагсаж гарсан түмэн цэргүүдийн ихэнх нь татарууд байсан гэлцэнэ. Түүний учир нь: Тэр монголчууд өөрснөө татарчууд лугаа халуун, хүйтэн, өлсгөлөнг сайн дааж чадахгүй улс байсантай холбоотой гэнэ. Казахын дайнд чадахуйц эрчүүд нь Чингисийн цэрэгтэй нийлж тэднийг Чингис хааны их хүү Зүчээр удирдуулжээ.

Нэй түрүүвл Гүр хааныг алж, Уйгаруудыг эзэлж, дараагаар Азийн гүнд хүртэл очжээ. Учир нь казахад зүйр уг болж үлдсэн «Могой жилд учирч, морин жилд уралцав, хонин жилд даяараа золголдов», «Самарканы шороон зам, Булнайгийн тортон зам» гэх уг үтнүүл нь бугд Чингисийн аян дайны зураглал болой. Булнай гэж Гималай Кундах хүч буюу Үндүкеш уулнууд Алтайгаас-Чингис хүртэлх өндөр сарьдаг аж. Ямарч атугай ямар нэгэн уулын нэр болох нь үнэн юм. «Булнайгаас өнлөр уул үгүй, Хандгайнаас өндөр амьтан үгүй» гэсэн үгээс тодорхой.

Түүний дараа эд нар Алатаут орхиж Ташкентын ойролцоо уулсыг нутаглажээ. Аль газарт эхэнд пь нутаглаж, алинд нь аль хэр удаан нутагласан эсэх нь тодорхойгүй байдаг. Тэнд очсоны дараа эднийт Чингисийн удаах хүү Цагаадайн үр удам удирдаж байжээ. Цагаадайн хүүгийн үеийн хамгийн том хаал нь Ташкентанд амьдарч, тэр хааны дүү нарын нэг нь удирдаж байжээ. Тэдгээр хаадууд нь эднийт ямарч сайн үйлэнд хөтлөхгүй, үргэлж хөрш зэргэлдээ улсуудын айл амьтныг тонуулж, эхнэр хүүхэд мал сүргийн багтлуулж, байлдаж тулалдуулсаар явж хоног элээж, ард түмэн ямарч эрдэм суралгүй, ядууран доройтож гүйцэн аж. Өнөөдөр нь ялсан дайсандаа маргааш нь ялагдсаар хүн амын тоогоо ч гэсэн цөөрчээ. «Сүр бад-

руулан очиж, сүүлээ хавчин зугатаж» явсаар малаа хүнээ яж хамгаалах ухаанаа ч ололгүй хоцорсон хэрэг. Казахын хүн хамгийн их өссөн үе нь цайвар халимагийн дүрвэсэн үед буюу Сары орхад суурьшсаныаас хойш юм. «Өстнөө дарж, өнгөт гуа охидыг нь авах л байх буюу ахан дүүсээ ч алж, хацар сайтай ахайтнаа авах л байх» гэсэн уг нь түүнээс өмнөх уеийн төрхийг харуулах ажуу.

Ацар Төмөрийн удам Хумар Шанхын хүү, нэрт эзэн хаан Баабарын эх нэгт хоёр дүү нь байжээ. Том нь Ташкентад хаан сууж, бага нь Казахад эзэн суужээ. Эд Цагаалайн удам болох Юнес хааны хүүхдүүд юм. Казахад эзэн суусан хүүг нь Ахмет гэж нэрлэдэг байжээ. Тэрээр эзэн суусныхаа дараа Казахын эрчүүлээс нь шилж сонгоод гурван зуун цэрэг залж зуу зуугаар хороо байгуулац толгойлогч томилжээ. Зуут болгонд харьяалагддаг ард олныг өвөр хоорондоо ахан дүүс лугаа эв зеийг сахиулжээ.

Казахын гурван зууд (гурван гар) хуваагддаг нь ийн учиртай буюу. (Энэ үеэр Казахад Их, дунд, бага жүзд хуваасан байхад Монголд баруун, зүүн гар тухааж, Ойрад Монгол хожим Дзунгар хэмээх нэр авчээ Х.И).

Ахмет Халимаг уруу маш олон удаа дайралт хийж, их хүнийг нь угтажээ. Зювж зүдэрсэн халимагийн «Эд жинхэнэ алагч болой» гэж «алуурч» гэсэн утгатай нэрийлсэн гэдэг. Түүнээс үүдэж Ахмет хаан «Алуурч» буюу Алаша хаан гэж нэрлэгддэг болсон байна. Энэ тухай «Баабарын товчоонд» тодорхой дурьдсан байдаг.

Хаан ийн нэрлэгдэх болонюос хойш «Халимагууд айж сурдсэндээ энэ нэрийг өгөө байлгүй үүнээс хойш та бүхэн давшилтанд орох үедээ-Алашы-Алашы (Алаач) гэж уухай хадуулагтун» гэж зарлиг болсон аж. Хааны зарлигаар цэргүүд нь давшилтанд орохдоо тийн уухай хадуулж тэр нь түмэн цэргийн цуурайд «Алаш-алаш» гэж сонсогдоор өдгөө «Алэш» болж улдсэн байна.

Бас түүнлүгээ «Алаш-алаш» байхад Алашааг хаан байхад халимагууд юу эс үзүүлэв дээ!» гэсэн уг улдэж. Казахууд «Алаш» уухайт болсон учиртай санж, нэг угтэй болж улдсэн нь ийн.

Казахуудыг Зүчийн удам эзэгнэж байхад Цагаа-

дайгийн удам Узбекуудыг толгойлж байсан байна. Тэр Зүйний Сибан буюу Чибан гэдэг хүүхдээс нь удамт Шайбах нэрт эрх хаан гарч Амар Төмөрөөс Ойрат, Бухар, Самарканд хотуудыг эзэлж авч бүхийд түүний өөдөөс Алаша хаан, Ташкентийн Жанке хаан хоёр цэр-гээ жагсаан очиж Оратөбе гэдэг газар байлдан, ялагдаж хоёр хаан эхнэр хүүхэд, үр хүүхдээ хүртэл алуулахад манай Казахууд «Чингис хаан амьд сэргүүндээ бидний Казахуудыг ууган хүү Зүчи хаанд захиж даатгасан билээ. «Чантууг (Уйгарыг хэлж байна Х. И) гаралгаа нь гээ, узбекийг төрөлөө нь тээ» тэж хэлээд Шайбах лүгээ нэгдэн орсон түүх ийм учиртай.

Энэ үг өдгөө хүртэл хадгалагдан үлдجээ. Түүнээс хойшиг Цагаадайн удам толгойлоогүй байна. Харин их эзний ууган хүү Зүйний үр гад биднийг 700 жил удирдан залжээ. Түүнээс хошиг бидний бүхий л хаад, ноёд бүгдээрээ Зүчи хааны удмаас ажтуу. (Казахууд Монгол хаадуудыг огт гадуурхаагүй нь учиртай Х. И)

Гарчиг

Ази тивийн агуу их найратч

3

НЭГ. ЯРУУ НАЙРГИЙН АЙМАГ

1855—1885

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Идэр насандаа эрдэмд эс анхаарчээ...»

7

Орч. Х. Жукел

«Иузи-Сарнай, нүд нь харжан...»

8

«Тунликбайн авгайн нэр Шарип...»

—

«Бурхан тэнгэрт залбирагчдыг...»

9

«Мэдээтэй яваарай Жахслык минь...»

—

«Аяа сэйтэл минь юунд тэгтэл догдолно вэ?...»

10

«Анхны цаснаар бургэдчин анд мордоно...»

11

«Ямархан охинд хүн татах увдис байна вэ...»

14

Орч. Х. Хангайсайхан, Х. Жукел

«Цалин цагаан мөнгө лүгээ өргөн магнайтай...»

15

Орч. Х. Хангайсайхан

«Фзули, Шамси, Сэйхали...»

—

1886 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Сурсан эрдэмгүй байж бардмыг бүү хичээ...»

16

ЗҮН

18

Орч. Х. Жукел

«Агуу их гүрэн, хайран казах түмэн минь ээ...»

20

«Омголон бүргэдийн сойлго таарвал бүхнийг барих атал...»

—

«Гэрэлт ертөнцөд олон хоног харамсалтай өнгөрч...»

21

«Баячууд адуулсан малынхаа буяныг үл эдэлж...»

22

«Эзэн тэнгэртээ залбирнам...»

—

«Хүн бүр зах руу одохыг харж суухал...»

23

«Үгээгүй хөөрхий Көкбай уйлна...»

—

«Хөөрхий дөө, Жамантайн хүү Көжек гэлэг...»

—

«Нас ахиж, гүниг дарж, мөрөөсөл ихсэж...»

24

«Нас ахиж, гүниг нэмэгдэж, нойр сэргэж...»

25

«Эрдэмгүй бүү ташуур...»

26

1887 ОН

Орч. Х. Жукел

«Аллахын ивээлийг..»	27
«Харь газар байвал...»	28
«Ичгүүргүй, тэвчээргүй, залхуу..»	31

1888 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

НАМАР	34
ӨВӨЛ	35
«Салхигүй шөнө сав саруулхан...»	36

Орч. Х. Жукел

«Мушгирадлан байж..»	—
«Үхэл зовлонд нэрвэглэвэл хэн ч тажуудна...»	37

1889 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Залуу насны гал дөл чи хаана байна..»	39
«Амийн сэтгэл минь энэлэн шаналж байна...»	40
«Ухаантны амнаас гарсан үг..»	41
«Ар нуруугаа дагасан турваар дарсан гээзг ..»	42
ХАРХҮҮГИИН ИЛГЭЭСЭН ҮГ	43
ХҮҮХНИЙ ХАРИУ ӨЧИЛ	44
«Үзэгдэх биенээс цаашгүй сэтгэл минь хөбөсөрсон ..»	46

Орч. Х. Жукел

«Цаг хугацаа нэгцөөхийн тулд би шүлэг бичтэггүй..»	47
«Эрдэм номын ухаан тэгч хүйтэн мөсний алил...»	48
«Аяа өл хатгаж, шившилэг тарни уншлаа ч...»	—
«Хар авгай гэгч үнэндээ хар авгай юм даа...»	—
НАЙМАН МӨРТИЙН ХЭЛХЭЭ	49
«Үнэнч нөхөт олдохгүй нээ...»	55
«Хайр дурлал, янаглал хоёр ангид..»	—

1890 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

ХАВАР	56
«Янэ янзын юманд сэтгэл шамдуурч болно...»	58
«Хааяа хөөрхий сэтгэл хөөрөлд автаж...»	59

Орч. Х. Жукел

«Амьдын нас элээж гүйцлээ..»	—
------------------------------	---

1891 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Залуугийн гал дэл ба царч...»	61
«Алаг нүдний хар нь...»	63

Орч. Х. Жүкел

«Залуусын цөс цалгиж, сэтгэл нийлэхгүй нь...»	65
ОНЬСОГО	66

1892 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Хий манан сааралтан бүрхэж...»	67
«Ээ халаг, зурх минь цохилохоо зогс. одоо...»	68

«Цахилан тачигнах аянгын гялбаа...»

Орч. Х. Жүкел

«Өчигдрийн (одсон) Оспан...»	69
------------------------------	----

1893 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«За, би итгэе дээ, итгэе...»	70
------------------------------	----

Орч. Х. Жүкел

«Халуун, хүйтэн бүхэнд...»	71
----------------------------	----

1894 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Сэрэл мэдрэмжээр хэн хэндээ...»	72
----------------------------------	----

«Элдэв юмаар бүү чамирх...»	—
-----------------------------	---

«Энэ биссийг минь ганц сэтгэл...»	73
-----------------------------------	----

Орч. Х. Жүкел

«Өчигдрийн Оспан хүү...»	74
--------------------------	----

«Хонин бор, хүнлэг ноомой Бакен...»	75
-------------------------------------	----

«Хэл минь чамд өчье, би...»	76
-----------------------------	----

1895 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Хүүхэл нас чинь өнгөрлөө. чи мэtsэн үү?...»	78
--	----

Орч. Х. Жүксэл

«Амьсгал хураатал хөөрхий минь дээ...»	79
--	----

«Ай даа, аллах тэнгэр минь...»	80
--------------------------------	----

«Үйлсан хүнийг аргадаж...»	83
----------------------------	----

«Олдохгүй одсон үрээ хөө...»	85
------------------------------	----

«Зөрүү уг хэлдэгтгүй...»	86
--------------------------	----

«Бодол ухаан нь тэгширсэн...»	87
-------------------------------	----

«Авьяасын хүлэг эмээллэж...»	87
«Хорин долоон насандаа...»	88
«Хорвоогоос хальсан эр Абиш...»	90
«Хажы хэргэмт эцэгтэй...»	—
«Байгаль юмс мөхдөг ч, хүн үхэхгүй...»	91

1896 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Борхон үүл сарнин...»	92
«Хайрлах нөхөрлөхийн цагт...»	—
«Төрүүлсэн эх эцэг угүй...»	93
«Хулэг морин дэллээрээ тайхуулиа...»	—
«Хааны зари хөөрхөн бүсгүй байсад юм гэнэ...»	94

Орч. Х. Жукел

«Цагийн цохилт гэдэг цэнгэл биш ээ...»	95
--	----

1897 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Хайлт минь би чинийхээ...»	96
«Чийртэй хоосон бахираан....»	—
«Урьхан хавар дэлбээлсэн өнчин яргуй...»	97
«Олиы хөөргөсөн магтаалд битгий итгэ...»	—
«Сайхан дуу, эгшиг аялгуу...»	98

1898 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Өдрийн араас өдөр ирнэ...»	99
«Энэрэлгүй хорвоо цөлмөж байна, аргалах аргатай юу?...»	—
«Хөндүүр зүрх аяар аяархан цохилно...»	100

Орч. Х. Жукел

«Алс хэтний зорих чинь зориггүй бол...»	101
«Сульсан цээжинд намуухан булгилж...»	102

1899 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

«Сэтгэл омголон эрх дураар явсан...»	103
«Нэгэнтээ гөлөт тэжээж нохой болготол...»	—
«Алаг хорвоогийн зовлонгоос болоод..»	104
«Янаг дурлалт гэж бүү дэмийр...»	—

Орч. Х. Жукел

«Хүн гэгч баас тээсэн байсны хүүдий...»	105
«Гүнитгүй ихэмсэг нэгэн сэтгэлээр...»	—
«Гэрэлт тэнгэрт дурлаж өссөн, чи...»	106

1900 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

Чарыг цаг хугацаа түлдэж...» 107

Орч. Х. Жукел

Хар сүүдэр уртсаж...» 108

1901 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

Утга төгс хэлийг чинь...» 109

Чавч нь онгосон хуучин горьтогоор...» —

Часан залуудаа бүү баярла...» 110

Орч. Х. Жукел

Чинж зовох тэгч сэтгэлийн юм шүү...» —

1902 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

Гран тоть шувуу шиг эрвээхэй...» 111

Орч. Х. Жукел

Зүрх гэгч-далай, жаргал гэгч эрднийн чулуу...» —

Ллах ч үнэн, мэргэдийн хэлсэн сургаал ч үнэн...» 112

1903 ОН

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

Эрөө би чамд мэндийн захидал бичлээ...» 114

ОН ТАВИГДААГҮЙ ШҮЛГҮҮД

Орч. Д. Нямаа, Б. Монголхүү

Лан тэнгэрт нар сарны гэрэл ээлжлэвч...» —

А нар намайг дууриах гэж...» —

Ээмтэй зэмтэйгээ ухааран...» 115

ҮХЭД НАС 116

АРЦАГА, БОЛЖМОР ХОЁР 117

Орч. Х. Жукел

Энэг хүн номтныг үл дийлнэ...» 118

Ариа тарьсан хүн нэг хожно...» —

ХОЁР, СУРГААЛ УГСИЙН АЙМАГ

Орч. Х. Ислам

Нэг дэх эргэцүүлэл	123
Хоёрдахь эргэцүүлэл	124
Гуравдахь эргэцүүлэл	125
Дөрөвдэх эргэцүүлэл	128
Тавдахь эргэцүүлэл	129
Зургаадахь эргэцүүлэл	130
Долоодохь эргэцүүлэл	131
Наймдахь эргэцүүлэл	132
Есдэх эргэцүүлэл	134
Аравдахь эргэцүүлэл	—
Арван нэг дэх эргэцүүлэл	137
Арван хоёрдахь эргэцүүлэл	138
Арван гуравдахь эргэцүүлэл	—
Арван дөрөвдэх эргэцүүлэл	139
Арван тавдахь эргэцүүлэл	141
Арван зургаадахь эргэцүүлэл	142
Арван долоодохь эргэцүүлэл	—
Арван наймдахь эргэцүүлэл	144
Арван есдэх эргэцүүлэл	—
Хорьдох эргэцүүлэл	145
Хорин нэг дэх эргэцүүлэл	146
Хорин хоёрдохь эргэцүүлэл	—
Хорин гуравдахь эргэцүүлэл	148
Хорин дөрөвдэх эргэцүүлэл	149
Хорин тавдахь эргэцүүлэл	—
Хорин зургаадахь эргэцүүлэл	151
Хорин долоодохь эргэцүүлэл	152
Хорин наймдахь эргэцүүлэл	155
Хорин есдэх эргэцүүлэл	156
Гучдахь эргэцүүлэл	157
Гучин нэг дэх эргэцүүлэл	158
Гучин хоёрдахь эргэцүүлэл	—
Гучин гуравдахь эргэцүүлэл	160
Гучин дөрөвдэх эргэцүүлэл	161
Гучин тавдахь эргэцүүлэл	162
Гучин зургаадахь эргэцүүлэл	163
Гучин долоодохь эргэцүүлэл	164
Гучин наймдахь эргэцүүлэл	166

учин есдэх эргэцүүлэл	183
өчдэх эргэцүүлэл	185
ечин нэг дэх эргэцүүлэл	186
ечин хоёрдахь эргэцүүлэл	187
ечин гурав дахь эргэцүүлэл	188
ечин дөрөвдэх эргэцүүлэл	191
ечин тавдахь эргэцүүлэл	192
азахын гарал үүслийн тухай эргэцүүлэн бодохуй	193

**ХҮНАНБАЙН АБАЙ
ТҮҮВЭР ЗОХИОЛ**

Орчуулагчил Д. Нямаа, Б. Монголхүү, Х. Ислам, Х. Жукел
Х. Хангайсайхан
Редактор Х. Ислам, Д. Нямаа
Хэвлэлийн уран сайхны редактор Т. Етекбай
Зураач Ц. Байды
Техник редактор Ж. Оюунхүү
Хянагч Б. Монголхүү

400

Өрөлтөнд 1995 оны 7 сард Хэвлэлтэнд 8 сард
Цаасны хэмжээ 84x108 1/32 За № 41
Цэргийн Хэвлэлийн «Шувуун саарал» компанийд хэвлэв
Улаанбаатар Нашагдоржийн гудамж 17